

# *Хутагт Алтангэрэлт*

*буюу Судрын аймгийн дээд эрхэт хаан хэмээх*

*Их хөлөн судар оршвой*

*(Алтангэрэл судар)*

Арьяа Суварна прабха сутгама сутрэндра ража махаяана сутра

༄༅ །འཕགས་པ་གསེར་འོད་དམ་པ་མདོ་སྡེའི་དབང་པོའི་རྒྱལ་པོ་

ཞེས་བྱ་བ་ཐེག་པ་ཆེན་པོའི་མདོ།།

29 *бүлэгт*

## Тарчиг

Удиртгал	5
Хутагт Алтангэрэлт буюу Судрын аймгийн дээд эрхэт хаан	9
Анхдугаар бүлэг: Тэргүүлэн өгүүлэхүй	11
Хоёр дугаар бүлэг: Түүнчлэн залрагсдын насан сүүдрийн хэмжээг үзүүлэхүй	19
Гуравдугаар бүлэг: Гурван лагшинг ялгаж үзүүлэхүй	37
Дөрөвдүгээр бүлэг: Зүүдэнд наминчлахуй	50
Тавдугаар бүлэг: Үйлийн түйтгэрийн үргэлжлэлийг таслагч	64
Зургаадугаар бүлэг: Газрыг нэн тэтгэгч	82
Долдугаар бүлэг: Өнгөрсөн, ирээдүй ба эдүгээ заларсан үнэнхүү төгсгөсөн бурханы орон бүгдийг магтсан	101
Наймдугаар бүлэг: Алтат нэрт тогтоол	107
Есдүгээр бүлэг: Хоосон чанар	110
Аравдугаар бүлэг: Хоосон чанарт шүтээд санаагаа бүрэн гүйцээх	115
Арван нэгдүгээр бүлэг: Их дөрвөн хаан тэнгэр болон хүмүүнд нэн харсан	124
Арван хоёрдугаар бүлэг: Дөрвөн их хаан бээр орон улсыг бүрэн тэтгэх	127
Арван гуравдугаар бүлэг: Тачаал үгүй тогтоол	151
Арван дөрөвдүгээр бүлэг: Хүслийг хангагч эрдэнийн тогтоол	154
Арван тавдугаар бүлэг: Сарасвати охин тэнгэр	158
Арван зуравдугаар бүлэг: Шри охин тэнгэр	175
Арван долдугаар бүлэг: Их охин тэнгэр Шри бээр эдийг огоот аривдуулах	177
Арван наймдугаар бүлэг: Газрын Охин тэнгэр Дрда	180
Арван есдүгээр бүлэг: Ягчисын хаан Самжная	186

Хорьдугаар бүлэг: Хааны шастир ‘Тэнгэрийн эрхэтийн тангараг’	190
Хорин нэгдүгээр бүлэг: Сусамбава	201
Хорин хоёрдугаар бүлэг: Ягчисын орон хэмээгч бүхэнд сахих	206
Хорин гуравдугаар бүлэг: Тэнгэрийн хөвүүнд эш бошгийг үзүүлсэн	217
Хорин дөрөвдүгээр бүлэг: Өвчин бүгдийг машид амирлуулан үйлдсэн	221
Хорин тавдугаар бүлэг: Жалавахана-гий номхруулсан загасны урьдын цадиг	226
Хорин зуравдугаар бүлэг: Эм баранд биеэ огоот өгсөн нь	234
Хорин долдугаар бүлэг: Бодьсдва бүгдээр магтсан	252
Хорин наймдугаар бүлэг: Түүнчлэн заларсан бурхад бүгдийг магтсан	254
Хорин есдүгээр бүлэг: Төгсгөлийг хураасан	256

*Наму Буддаяя*  
*Наму Дармаяя*  
*Наму Сангаяя*

## *Тэрицүн хэсэг*

### *I бүлэг: Тэрицүүлэн өгүүлэхүй*

Өнгөрсөн, ирээдүй, эдүгээ цагт заларсан хамаг бурхад, бодьсадва хийгээд хутагт брадигабуд, шарвага нарт мөргөмүй.

Ийн хэмээн миний сонссон нэгэн цагт Ялж төгс нөгчсөн бурхан бээр Ражагриха (*мон: Хааны ордон*) хотын маш ариун, гүн номын чанарт, түүнчлэн залрагсадын дээд ариун орон болсон Гридракута (*мон: Тасын цогцост*) уулын тагтнаа аяга тахимлагүүдийн ихэс хуврагууд зэрэг есөн түм найман мянган аяга тахимлагүүд лүгээ хамт нэгнээ заларсан бөлгөө. Тэд бүгдээр их архад, заан сүргийн манлай мэт машид амирлангуй, цувирааа барсан, нисваанис үгүй, машид тийн гэтэлсэн сэтгэлт, машид тийн гэгээрсэн билигт, үйлээ үйлдсэн, үүргээ үүрсэн, өөрийн тусыг даган олсон, сансарт барилдуулахыг огоот тасалсан, дээд эрхтийн манлайг олсон, асар ариун шагшаабадад сайтар оршсон, арга билгээр сайтар зохиосон, найман тийн гэтлэхүйг илтэд болгоож гагцхүү чинад хязгаарт хүрэгсэд бөлгөө.

Тэдгээр болох насан гавъяат, бүхнийг мэдэгч Каундиня, насан гавъяат Ашважит, насан гавъяат Вашпа, насан гавъяат Маха-наман, насан гавъяат Бадрика, насан гавъяат Маха-кашяапа, насан гавъяат Урувилва Кашяапа, насан гавъяат Гаяа Кашяапа, насан гавъяат Нади Кашяапа, насан гавъяат Шарипутра, насан гавъяат Махамаудгалаяана, Нанда тэргүүтэн эдгээр их шарвага нар үдшийн цагт тус тусдаа дотоод үнэмлэхүй бясалгалаасаа босож, Ялж төгс нөгчсөн бурхан хаана буй тэр зүгт одож, Ялж төгс нөгчсөний өлмийд оройгоороо мөргөж, гурвантаа эргэж нэгэн зүгт суувай.

Басхүү зуун мянган голди бодьсадва махасадва нар ч тэнд суух бөлгөө. Тэдгээр бодьсадва нар нь лусын их хаад мэт цог хийгээд

сүр жавхлангаараа бүхэнд алдаршсан, өглөг хийгээд ариун шагшаабадыг үргэлжид сахихыг хүсэгчид, тэвчихүй хийгээд хичээнгүйг түрвэлгүй галвуудад үйлдэгчид, дияан бүхнээс хэтэрч дурьдахуйг илт болгосон, билгүүний үүдийг тийн нээж, уран аргыг машид бүтээгсэд, дээд эрхээр тийн цэнгэж, илт мэдэл дээдийг эрхшээн, их тогтоолыг ологсон, барагдашгүй самбаат, нисваанис хийгээд ойрын нисваанис бүгдийг тэвчсэнээр даруйд хамаг зүйлийг мэдэгчийн билэг билгийг олж, шулмас хийгээд тэрсүүдийн өмгийг дарагч, номын их хэнгэргийг дэлдсэнээр хамаг тэрсүүдийг номхотгож машид сүжигт сэтгэлийг үүсгэж үйлдсэн, дээд номын хүрдийг эргүүлсэнээр тэнгэр хүмүүн олныг гэтэлгэн үйлдэгч, арван зүгийн бурханы орон бүхнийг чимэн үйлдэгч, зургаан зүйлд оршсон амьтанд дээд тусыг хүргэсэн, их билэг хотол төгссөн, их тэвчээр төгс, асрахуй төгс, их нигүүлсэнгүй сэтгэлд оршсон, баттай их хүч төгөлдөр, хамаг бурханыг хүндлэн үйлдсэн, гаслангаас огоот хэтрэлгүй ирээдүйн хязгааргүйд оршихуй дор тангаргийг барьсан, олон бурханд арилсан шалтгааныг үүсгэж, гурван цагийн ном төрөх үгүйд тэвчээрийг олж, брадигабуд, шарвагуудын явдлаас машид хэтэрсэн, их мэргэн аргаар ертөнцийг удирдагч, бурхадын айлдсан гүн нарийн номын утгыг тайлбарлахдаа мэргэн, хоосон чанарт илтэд болсноор тээнэгэлзээг огоот тасалсан бөлгөө.

Тэдгээр болох Торолтгүй номын хүрдийг эргүүлэгч бодьсадва, Үргэлжид номын хүрдийг эргүүлэхэд сэтгэл үүсгэгч бодьсадва, Нитяодяукта (*Үргэлжид хичээгч*) бодьсадва, Бхадрапала (*Хичээлийг үл орхигч*) бодьсадва, Майтрея бодьсадва, Манжушри бодьсадва, Авалокитешвара (*эрхэт Жанрайсэг*) бодьсадва, Дхарани-швараража (*Тогтоолын эрхэт хаан*) бодьсадва, Ратнабхадра (*Их оюуны самбаагаар байгуулагч хаан*) бодьсадва, Меруража (*Уулын хаан*) бодьсадва, Гүн далайн хаан бодьсадва, Ратна-кету (*Их эрдэнийн охь*) бодьсадва, Махаратнакету (*Аугаа их эрдэнийн охь*) бодьсадва, Чити-гарба (*Газрын зүрхэн*) бодьсадва, Акаша-гарба (*Огторгуйн зүрхэн*) бодьсадва, Ратн-ендра-пани (*Мутартаа чандмань эрдэнэт*) бодьсадва, Важра-пани (*Очирваань*) бодьсадва, Рати-бала (*Баясгалангийн хүчит*) бодьсадва, Их номын хүчит бодьсадва, Машид гэрэл зохиогч бодьсадва, Суварнапрабха (*Алтангэрэл ихэд*

цаируулагч) бодьсадва, Ви-шудда-шила (*Ариун шагшаабадат*) бодьсадва, Насад дияанч бодьсадва, Су-ви-шудда-будди (*Машид ариун оюунт*) бодьсадва, Дрида-вирия (*Чин хичээнгүйт*) бодьсадва, Акашават (*Огторгуй мэт сэтгэлт*) бодьсадва, Аниракрита-маха-праниди (*Их ерөөлийг үл орхигч*) бодьсадва, Эм хайрлагч бодьсадва, Нисваанисын өвчнийг арилгагч бодьсадва, Вайдяя-ража (*Оточийн хаан*) бодьсадва, Баясгалангаар цэнгэсэн хаан бодьсадва, Дээд бошгийг олсон бодьсадва, Маха-мега-вишудда-праба (*Их үүлэн ариун гэрэлт*) бодьсадва, Маха-мега-дарма-дара (*Их үүлэн номыг баригч*) бодьсадва, Их үүлэн алдар баясгалант бодьсадва, Их үүлэн хязгаарлашгүй алдрыг үзүүлэгч бодьсадва, Маха-мега-синха-нада (*Их үүлэн арслан дуут*) бодьсадва, Их үүлэн сүргийн манлай дуут бодьсадва, Маха-мега-мангала (*Их үүлэн өлзий хутагт*) бодьсадва, Маха-мега-ратна-шри (*Их үүлэн эрдэнэ цогт*) бодьсадва, Маха-мега-суряа-гарба (*Их үүлэн нарны зүрхэн*) бодьсадва, Маха-мега-чандра-гарха (*Их үүлэн сарны зүрхэн*) бодьсадва, Маха-мега-жяотиш-праба (*Их үүлэн одны гэрэл*) бодьсадва, Маха-мега-жваланакара (*Их үүлэн галын гэрэл*) бодьсадва, Их үүлэн гилбэлгээний гэрэл бодьсадва, Маха-мега-гаржита (*Их үүлэн луун дуут*) бодьсадва, Их үүлэн билгүүн бүхэнд тодорсон бодьсадва, Их үүлэн ариун хурын хаан бодьсадва, Маха-мега-пушпа-вригча-ража (*Их үүлэн цэцэг модны хаан*) бодьсадва, Маха-мега-утпала-ганда (*Их үүлэн удвалын үнэрт*) бодьсадва, Их үүлэн эрдэнийн зандангийн сэрүүн үнэрт лагшинт бодьсадва, Их үүлэн харанхуйг гийгүүлэгч бодьсадва, Их үүлэн бүрэлзэлгээг арилгагч бодьсадва тэргүүтэн хэмжээлшгүй тоолшгүй бодьсадва, махасадва эдгээр буюу тэд тус тусдаа үдшийн цагт дотоод үнэмлэхүй бясалгалаасаа босож, Ялж төгс нөгчсөн бурхан хаана бүхий тэр зүгт одож, Ялж төгс нөгчсөний хоёр өлмийд оройгоороо мөргөж, гурвантаа тойрч нэгэн зүг дор суувай.

Мөн тэнд Лигчавигийн залуус буюу Синха-праба (*Арслангийн гэрэл*) орь залуу, Синха-будди (*Арслан оюунт*) орь залуу, Дармада (*Номыг өгөгч*) орь залуу, Индрада (*Эрх өгөгч*) орь залуу, Маха-праба (*Их гэрэл*) орь залуу, Маха-шри (*Их цогт*) орь залуу, Будда-палита (*Бурхан сахихуй*) орь залуу, Дарма-пала (*Ном сахихуй*) орь залуу, Санга-пала (*Хувраг сахихуй*) орь залуу, Важра-пала (*Очир сахихуй*)

орь залуу, Акашапала (*Огторгуй сахихуй*) орь залуу, Огторгуйн нөхөр орь залуу, Ратна-гарба (*Эрдэнийн зүрхэн*) орь залуу, Дээд өлзийт зүрхэн орь залуу тэргүүтэн таван бум найман мянган дээр үгүй үнэнхүү туулсан бодь хутаг дор амгалан оршсон, их хөлгөнд машид сүжиглэгч тэд бүгдээр тус тусдаа үдшийн цагт Ялж төгс нөгчсөн бурхан хаана бүхий тэр зүгт одож, Ялж төгс нөгчсөн бурханы өлмийд оройгоороо мөргөөд, гурвантаа тойрч нэгэн зүгт суувай.

Басхүү эдгээр тэнгэрийн хөвгүүд буюу, Үзвээс баясгалант нэрт тэнгэрийн хөвгүүн, Прахаршита (*Маш баясгалант*) нэрт тэнгэрийн хөвгүүн, Сурья-праба (*Наран гэрэлт*) нэрт тэнгэрийн хөвгүүн, Чандра-шика (*Сарны шанхат*) нэрт тэнгэрийн хөвгүүн, Тодорхой билгүүнт нэрт тэнгэрийн хөвгүүн, Акашави-шудда-прагяа (*Тийн ариун огторгуйн билгүүнт*) нэрт тэнгэрийн хөвгүүн, Нисваанисын өвчнийг арилгагч нэрт тэнгэрийн хөвгүүн, Мангала (*Өлзийт*) нэрт тэнгэрийн хөвгүүн тэдгээр тэргүүтэн дөрвөн түмэн хоёр мянган тэнгэрийн хөвгүүд ч их хөлгөнийг сахиад, үнэн номыг даган барьж, үргэлж тасралтгүй үйлдэхүйд агуу их ерөөлийг тавьсан тэд бүгдээр үдшийн цагт Ялж төгс нөгчсөн бурхан хаана бүхий тэр зүгт одож, Ялж төгс нөгчсөн бурханы өлмийд оройгоороо мөргөж, гурвантаа тойрч нэгэн зүг дор суувай.

Басхүү лусын хаад эдгээр буюу, Падма (*Бадмаа*) нэрт лусын хаан, Елпатра (*Элэйн навч*) нэрт лусын хаан, Махабала (*Их хүчит*) нэрт лусын хаан, Маха-гоша (*Их дуун*) нэрт лусын хаан, Өчүүхэн долгион нэрт лусын хаан, Ваюу-дара (*Мөрөн Салхи баригч*) нэрт лусын хаан, Алтан нүүрт нэрт лусын хаан, Мансвий (*Жавхлант*) нэрт лусын хаан тэргүүтэн хоёр түм найман мянган лусын хаад бүгдээр их хөлгөний номыг баригч, барихуйяа бишрэгч, огоот дэлгэрүүлэх, сахихын сэтгэлийг ямагт үүсгэсэн бөгөөд тэд бүгдээр тус тусдаа үдшийн цагт Ялж төгс нөгчсөн бурхан хаана бүхий тэр зүгт одож, Ялж төгс нөгчсөн бурханы өлмийд оройгоороо мөргөж, гурвантаа тойрч нэгэн зүгт суувай.

Басхүү ягчисын хаан Вайшраванийн хөвгүүн тэргүүтэн гурван түм зургаан мянга эдгээр буюу, Амара хүсэгч нэрт ягчис, Амара

баригч нэрт ягчис, Лянхуан гэрлийн зүрхэн нэрт ягчис, Падма-мука (*Лянхуан нүүрт*) нэрт ягчис, Брикути (*Хилэнт*) нэрт ягчис, Маха-баяа-дешака (*Их аюулыг үзүүлэгч*) нэрт ягчис, Газар хөдөлгөгч нэрт ягчис, Идээ булаагч нэрт ягчис тэргүүтэн ягчис тэдгээр түүнчлэн ирсэний үнэхээр ариун номд сүслээд сахихад ямагт хичээгчид бөлгөө. Тэд бүгдээрээ үдшийн цагт Ялж төгс нөгчсөн бурхан хаана бүхий тэр зүгт одож, Ялж төгс нөгчсөн бурханы өлмийд оройгоороо мөргөж, гурвантаа тойрч нэгэн зүгт суувай.

Басхүү гарьдын хаан, Хүжийн их зааны хүчит хаан тэргүүлэн дөрвөн түм есөн мянга хийгээд басхүү үнэр идэшт, асур, киннара миамжи, махорага (*газрын эзэн дон-их Дочэ*) тэргүүтэн, уул, ой цэцэрлэг, мөрөн гол, далайн тэнгэрийн арш нар хийгээд, их хаад хийгээд тэдний нөхөд, хатан, хөвгүүд хийгээд язгуурын хөвгүүд ба язгуурын охид, тэнгэр хүмүүн тэргүүтэн тэд бүгдээр дээр үгүйн их хөлгөнийг урьж, уншиж, тогтоож, цээжилж, бичиж, дэлгэрүүлж, сахиж, аварсугай хэмээн ерөөлийг огоот тавьсан тэд бүгдээрээ үдшийн цагт Ялж төгс нөгчсөн бурхан хаана бүхий тэр зүгт одож, Ялж төгс нөгчсөн бурханы өлмийд оройгоороо мөргөж, гурвантаа тойрч нэгэн зүгт суувай.

Тэр мэт шарвага хийгээд бодьсадва нар, тэнгэр, хүмүүн, асур, гарьд тэргүүтэн тэдгээр найман аймаг үүл мэт чуулагсад нэгэн үзүүрт сэтгэлээр алгаа хамтатгаж нүдээ анилгүйеэ Ялж төгс нөгчсөн бурханы нигуурыг үзэж, дээдийн номыг номлохуйяа бишрэнгүйгээр соёрхол талбиваа.

Тэгээд Ялж төгс нөгчсөн бурхан үдшийн цагт дияанаасаа босож, чуулсан олон нөхдийг болгоож, эдгээр шүлгүүдийг номловой:

Судрын аймгийн эрхэт хаан  
Сонсвоос машинд нарийн хийгээд  
Сайтар шинжвээс гүнзгий утгат  
*Дээд Алтангэрэлт* үүнийг номлосугай!

Дөрвөн зүгийн бурхад бээр  
Дээд адистэдээр адисласан  
Дорно зүгт Акшобья,

Өмнө зүгт Ратнакету,  
Өрнө зүгт Амитаба,  
Умар зүгт Дундубисвара

Хамаг хилэнцийг арилгах учир  
Ханьцашгүй дээд өлзийт номлол буюу  
Хилэнцэт үйлийг баран үйлдэгч,  
Хамаг жаргаланг өгөн үйлдэгч,  
Хамаг зовлонг эвдэн үйлдэгч,  
Хамгийг болгоогч ямагтын суурийг  
Хамаг цогоор сайтар чимээд  
Хамаг адистэдийг оршоож өгүүлсүгэй!

Аливаа амьтны эрхтэн доройтсон,  
Амьдрах нас нь барагдсан бас доройтсон,  
Хотол төгс бус алин халдсан,  
Хамгаалах тэнгэрүүд араараа зүглэсэн,  
Хайрт садан төрлүүд үзэн ядсан хийгээд  
Халамжлах боол, эхнэр тэргүүтэн хөнөөх,  
Харилцан эсрэг тэсрэг үл зохилдох,  
Хураасан эд хомсдож хөнөөгдөх,  
Халуун зовлонгоор алжаах, нэрвэгдэх,  
Хөнөөх аюул, үгүйрэл хоосрол болон  
Од гариг ба хараал зүхэл хийгээд  
Огоот дуусашгүй адаар энэлэн хохирсон,

Хатуу гашуун зовлонд эвэршээж,  
Хилэнцэт муу зүүдийг зүүдлэх болохноо ч  
Тэд бүгдээр машид угаагдан ариусах больюу.  
Тиймээс судрын дээд үүнийг сонсож үйлд!

Аливаа буянт сайн сэтгэл төгс байж  
Ариун хувцас дээлээр сайтар гоёж,  
Агуу гүн бурханы мэдлийн орон  
Авралт судар үүнийг сонсож үйлдвээс  
Авралт судар үүний сүр хүчээр  
Амьтан бүгдийн хорлол, зэтгэр

Асар дуусашгүй зовлон энэ адилууд  
Алин тэдгээр ашид амирлах больюу.

Ертөнцийг сахигч эзэн хаад ба  
Эрх дархат түшмэдийн чуулган сэлт  
Олон голди тоот ягчисууд бээр  
Онцолж тэдгээр бүгдийг сахьюу  
Их охин тэнгэр Сарасвати ба  
Ниранзана мөрөнд оршигч нар,  
Ад шулам, булаагч эх ба  
Газрын охин тэнгэр Васудари,  
Эсрэнгийн хаад ба Хурмаст тэнгэр,  
Их хүчит лусын хаадууд,  
Эрхэт Миамжи ба Асурын эрхэт,  
Энэ мэтчилэн Гарьдын хаадууд,  
Өмөг садан, хүчин чадал, хүлэг морьтойгоо  
Үлдэлгүй тэд бүгдээр тэнд цуглаж  
Өдөр, шөнө бүгдэд алгасралгүй  
Өнөд тэднийг сахин үйлдюу.  
Бурханы гүн явдлын орон  
Бурхан бүгдийн нууц нь болсон  
Голди тоот галвуудад ч олохуйяа бэрх  
Гол судрыг сайтар номлосугай.

Хэн нэгэн энэ судрыг сонсох ба  
Хэн нэгэн бусаддаа сонсгох ба  
Хэн нэгэн даган баясах ба  
Хэн нэгэн тахиж үйлдэх,  
Тэднийг тэнгэр хийгээд лусууд  
Түүнчлэн хүн ба миамжи нар  
Тэнгэр бус ба ягчис нар бээр  
Тэднийг тоолшгүй олон галвуудад тахих больюу.

Бас буян үйлдэгч амьтдын  
Бултаараа хураасан буяны цогц нь  
Буйн хязгаар үгүй, тоо үгүй хийгээд  
Бүхний сэтгэлд багташгүй больюу.

Арван зүгийн туулсан бурхад ба  
Алин түүнчлэн гүн нарийн явдалтан,  
Хамаг бодьсадва тэд бүгдээр ч  
Харилтгүй сайтар дэмжих больюу.

Ариун дээлийг сайтар өмсөж,  
Анхилуун үнэрт хувцсыг авч,  
Асрахуй сэтгэлийг ойр агуулаад,  
Алгасрал үгүйгээр тахиж үйлд.

Өөрийн сэтгэлийг хир үгүй  
Агуу дэлгэр сайтар болгож,  
Сэтгэлээ машид тунгалаг болгоод,  
Судар аймгийн дээдийг сонсогтун.

Хэн нэгэн судар үүнийг сонсвоос  
Тэдгээр хүмүүний дотор сайтар ирнэ,  
Хүмүүний төрлийг сайтар олно,  
Амжиргаа амгалангаар амьдрах больюу.

Хэн нэгний чихний нүхэн дотор ч  
Энэхүү номлол дуурсах болбоос,  
Буяны үндсийг тэд судалсан болно  
Бурхан бүгд бээр машид сайшаана.

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлгөн судраас*

*"Тэргүүлэн өгүүлэхүй" хэмээх тэргүүн бүлэг болой.*

\* \* \*

## II бүлэг: Түүнчлэн залрагсдын насан сүүдрийн хэмжээг үзүүлэхүй

Тэр цагийн тэр үед Ражагриха их хотод Ручира-кету (*мон: Үзэсгэлэнгийн охь*) хэмээгч бодьсатвамахазадва урьдын бурханд үлэмж бүтээлийг үйлдэн буяны ёзоорыг үүсгэсэн, зуун мянган түг түмэн голди бурханд өргөл хүндлэлийг үйлдсэн нэгэн сууж байжээ. Тэр бээр ийн хэмээн бодвой, “Ялж төгс нөгчсөн Шагжамуни бурхан ямар учир, ямар шалтгаанаар энэ мэт нас сүүдэр ахар наяхан наслах болов?”. Бас ийн хэмээн бодов: “Ялж төгс нөгчсөн бурхан бээр ч ‘Хоёр учир шалтгаанаар урт наслах болой. Хоёр нь аль вэ? хэмээвээс, энэ мэт амь таслахыг тэвчих хийгээд амны идээг машид өгөх болой’ хэмээн зарлигласан бөлгөө. Ялж төгс нөгчсөн Шагжамуни бурхан нь тоолшгүй олон зуун мянган түг түмэн голди галавт амь таслахыг тэвчих болоод арван буяны үйлийн мөрийг хүртэл үнэнхүү аван оршиж байсан. Амны идээг, мөн гадна дотны эд зүйлсээ амьтдад огоот өгчээ. Улмаар өөрийн биеийн мах хийгээд цус, яс, чөмгөөрөө ч өлссөн амьтдыг цэнгүүлэн зохиосон атал эглийн идээ, бусдыг хэлэх юу байх вэ”.

Тэгээд дээд төрөлхтөн тэр бээр Бурханы талаар бодсон бодлоосоо энэ мэтийн ёсыг санаж, эдгээрийг сэтгэвээс түүний гэр нь уужим хийгээд агуу, хөх биндэрьяагаас бүтсэн, тэнгэрийн эрдэнэ олноор чимэглэгдсэн, Түүнчлэн заларсан бээр өнгийг нь урвуулж, тэнгэрийн эдээс ч хэтэрсэн үнэртнээр түгэх болов. Түүний гэрийн дөрвөн зүгээс тэнгэрийн эрдэнийн дөрвөн ширээ гарч ширээ тэдгээрээс ч тэнгэрийн эдээр урласан эрдэнийн цэмбэн дэвсгэр гарсан. Ширээ тэдгээр ч тэнгэрийн цэцэг, их эрдэнийн лянхуа олноор чимэглэгдэж, Түүнчлэн заларсан бээр өнгийг нь хувилгасан нугууд болсон. Лянхуа тэдгээрээс ч Ялж төгс нөгчсөн дөрвөн бурхан гарсан болой. Зүүн зүгээс нь Түүнчлэн заларсан Акшобья гарав; өмнө зүгээс Түүнчлэн заларсан Ратнакету гарав; баруун зүгээс Түүнчлэн заларсан Амитаба

гарав; хойд зүгээс Түүнчлэн заларсан Дундубисвара гарав. Арслант ширээ тэдгээрээс Ялж төгс нөгчсөн бурхан тэдгээр гармагц тэр цагт Ражагриха хот их гэгээгээр түгэв. Тэрхүү гэрэл нь гурван мянган их ертөнцийг хүртэл мөн арван зүг бүхэн дэх хийгээд Ганга мөрний элсний тооны төдий ертөнцийн орон хүртэл түгэх болов. Түүнчлэн тэнгэрийн цэцгийн хур ч бууж, тэнгэрийн хөгжмийн дуу ч гарав. Бурханы хүчээр гурван мянган их ертөнцийн орон энд амьтан бүгд нь ч тэнгэрийн амгалан лугаа төгөлдөр болж; эрхтэн дутуу амьтад нь эрхтэн бүгд нь төгөлдөр болж; харалган сохор амьтад нь нүдээрээ дүрсийг үзэж; чих дүлий амьтад нь чихээрээ дуу сонсож; ухаан мунхарсан амьтад нь ой санамжаа тус тус олж; сэтгэл нь нэн алгасарсан амьтад нь сэтгэл нь нэн алгасрал үгүй болж; үгээгүй ядуу амьтад нь хувцсыг өмсөх болж; өлссөн амьтад нь ч ходоод нь цаггалан болж; ундаасал амьтдын ундаассан нь арилж; өвчинд нэрвэгдсэн амьтдын өвчин нь эдгэж; эрхтэн доройтсон амьтад нь эрхтэн бүрэн болж; ертөнцөд машид гайхамшигтай юмс агуу их гарсан байна.

Тэгээд Ручира-кету бодьсадва бээр Ялж төгс нөгчсөн бурхан тэдгээрийг үзээд машид гайхан алмайраад, цэнгэн биширч баяссан хийгээд машид баясаад, баясгалан хийгээд сэтгэлийн амгалан төрж, Ялж төгс нөгчсөн бурхан тэдгээр хаана буй тэр зүгт алгаа хавсран сөгдөөд, Ялж төгс нөгчсөн бурхан тэдгээрийг даган дурдав. Тэгээд Ялж төгс нөгчсөн Шагжамунийн эрдмийг даган санаж, Ялж төгс нөгчсөн Шагжамуни бурханы нас сүүдрийн хэмжээнд эргэлзэж, “Ялж төгс нөгчсөн Шагжамуни бурхан энэ мэт ная наслах бөгөөд нас сүүдэр нь ахархан энэ мэт нь юу нэг вэ?” хэмээн сэтгэн суув.

Түүний санааг Ялж төгс нөгчсөн бурхан тэдгээр болгоон мэдэж, Ручира-кету хэмээх бодьсадвад ийн хэмээн зарлиглав: “Язгуурын хөвгүүн та, ‘Ялж төгс нөгчсөн Шагжамуни бурхан энэ мэт нас сүүдэр ахархан болой’ хэмээн ийн бүү сэтгэгтүн! Тэр юуны тулд хэмээвээс язгуурын хөвгүүнээ, Түүнчлэн заларсан, дайсныг дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхадаас өөр тэнгэр нар, шулмас нар, эсрэн тэнгэр, буяныг судлаачид, бярмангийн төрөлхтөн зэрэг ертөнцөд тэнгэр, хүн, асур сэлт Ялж төгс нөгчсөн, түүнчлэн заларсан Шагжамуни

бурханы нас сүүдрийн хэмжээ хязгаар, сүүлийн хязгаар төгсгөлийг ч эд бээр хэн нь ч мэдэж чадахгүй”.

Ялж төгс нөгчсөн бурхан тэдгээр бээр Түүнчлэн заларсаны нас сүүдрийн хэмжээг номлохыг өгүүлмэгц тэр даруйд бурханы хүчээр хүсэл эдлэгч тэнгэрийн хөвгүүд хийгээд дүрс эдлэгч тэнгэрийн хөвгүүд, тэнгэр, лус, ягчис, үнэр идэшт, асур, гарьд, миамжи, их дочэ, олон зуун мянган голди түг түмэн бодьсатва хураад, Ручиракету бодьсатвын гэрт цуглавай. Тэгээд Түүнчлэн заларсан тэдгээр бээр бүгд төгөлдөр нөхөд тэдэнд Ялж төгс нөгчсөн Шагжамуни бурханы нас сүүдрийн хэмжээг номлосон шүлгийг товчлон зарлигласан болой.

Хамаг далайн ус бүгдийн  
Дусал бүрийг тоолж чадахнаа ч  
Харин Шагжамунийн насны хэмжээг  
Хэн бээр ч тоолж үл чадъя уу!

Хамаг Сүмбэр уул бүхэнд буй  
Хамгаас нарийн тоосыг тоолж чадавч  
Харин Шагжамунийн насны хэмжээг  
Хэн бээр ч тоолж үл чадъя уу!

Хамаг газарт алин байгаа  
Хамгаас нарийн тоос хэдий чинээ  
Хамаг бүгдийг тоолж чадах байлаа ч  
Харин бурханы насны хэмжээг чадахгүй

Хэрэв зарим бээр огторгуйг  
Хэмжээс нэгээр жишихийг хүсэвч  
Харин Шагжамунийн насны хэмжээг  
Хэн бээр ч тоолж үл чадъя уу!

Гэгээрсэн бурхан өдий чинээ оршино  
Галвууд нь төдий чинээ нэг  
Галав голди, зуу болой хэмээн  
Тоогий нь олж үл болох болой

Учир нь түүний үйлдэхийн шалтгаан хоёр,  
Уг шалтгаан ч хоёр янз гэж зарлигласан  
Аливаа бусдыг хөнөөхийг тэвчих хийгээд  
Амны идээ олныг өгөх болой

Тиймийн тул их мөн чанарт түүний  
Нас сүүдрийн тоо хэмжээг олохгүй бөгөөд  
Галав өдий чинээ нэг хэмээх юм уу  
Тоолшгүй нь ч бас түүн шиг болой

Тиймээс эргэлзэх үгүй болно  
Өчүүхэн ч бүү эргэлзэгтүн  
Туулсан бурханы нас сүүдрийн хэмжээний  
Эцсийн тоо нь хаана ч байхгүй болой.

Тэгээд Ручира-кету бодьсадва бээр Ялж төгс нөгчсөн бурхан Шагжамунийн нас сүүдрийн хэмжээний номлолыг сонсоод Ялж төгс нөгчсөн бурхан тэдгээрт ийн хэмээн айлтгав: “Ялж төгс нөгчсөн Шагжамуни, Түүнчлэн заларсан мөн атал яагаад тэр мэт нас сүүдрийн хэмжээг ахархан гэж үзүүлэх болов” хэмээсэнд Ялж төгс нөгчсөн тэдгээр бурхад бээр бодьсадва Ручира-кету -д ийн хэмээн зарлиглав: “Түүнчлэн заларсан, Ялж төгс нөгчсөн Шагжамуни тэрээр таван цөвүүн цагийн ертөнцөд төрөлхтөн бүгдийн насны хэмжээ нь зуун жил хүрч чадах үест мэндлээд, сүжиг бишрэл муутай амьтан, буяны ёзоор хийгээд сүжиг багатай тэдгээр амьтанд миниймхийлэн үзэх, амьтанд үзэх, амин дор үзэх, амьдарч байна гэж үзэх, бодгалд үзэх, буруугаар үзэх ба би хийгээд миниймхийлэн баригч нар ба мөнхөд хийгээд тасархайд үзэх тэргүүтэн нялхас эгэл төрөлхтөн нарт туслах, басхүү тэрсүүд нарт үнэнхүү үзлийг төрүүлж түргэн тэнцэшгүй бодийг олуулж үйлдэхийн тулд түүнчлэн заларсан Шагжамуни тэр бээр нас сүүдрийн хэмжээгээ ахархан болгож үзүүлсэн болой.”

“Басхүү Язгуурын хөвгүүнээ, Түүнчлэн заларсан тэр гаслангаас нөгчигсөнийг үзүүлснээр бурхадтай уулзан учрахад ховор бэрхийн хуран мэдэл хийгээд бэрхшээл зовлонгийн хуран мэдлийг амьтан тэдэнд үүсгэснээр Ялж төгс нөгчсөн бурханы зарлигласан судар эдгээрийг түргэн барих, хадгалах, унших, бүгдийг ойлгож ухаарах,

бусдад ч агуу ихээр үнэнхүү зааж өгвөл хочлол талбих зэрэг байхгүй болох учраас, тэдгээрийн тулд Түүнчлэн заларсан бээр нас сүүдэр ахарханыг үзүүлсэн болой. Тийнхүү Түүнчлэн заларсан ертөнцөд мөнхөд оршиж гаслангаас эс гэтэлвээс амьтан бишрэл үгүй болж уулзахад бэрхтэйн хуран мэдэл төрөхгүй учраас Түүнчлэн заларсан бээр зарлигласан судар эдгээрийг түргэн барих, хадгалах, унших, бүгдийг ойлгон ухаарах, бусдад ч агуу ихээр үнэнхүү үзүүлж заахгүй болой. Тэр юуны тулд хэмээвээс тэр нь Ялж төгс нөгчсөн мөнхөд ертөнцөд оршино гэж бодсоны тулд болой.”

“Язгуурын хөвгүүнээ, жишээлбэл, зарим нэгний эцэг эхэд нь олон овоолготой их эрдэнэ байгааг үзвээс эрдэнэ гэдэг ховор хийгээд гайхамшигтайн хуран мэдэл түүнд төрөхгүй болой. Тэр юуны тулд хэмээвээс эцэг эхийн эрдэнэ, эд баялаг үргэлжид байхын хуран мэдэл төрсний тулд болой. Түүн шиг Ялж төгс нөгчсөн үргэлжид гаслангаас үл хэтэрвээс түүнийг ховор агаад учрахуйяа бэрх гэж хуран мэдэл төрөхгүй болой.

Язгуурын хөвгүүнээ, бас үлгэрлэвээс, эцэг эх нь ядуу, эд таваараар хомс нэгэн бээр хаан юмуу, их түшмэл нэгний гэрт очоод тэдгээрийн гуу сан, эд таваар, их эрдэнэ тэргүүтэн дэлгэрэнгүй олныг үзвээс, түүнд ховор хийгээд олохуйяа бэрхийн хуран мэдэл төрж ядуу тэр бээр эд эрэхийн аргыг бүтээхэд хичээж үйлдэх болой. Тэр нь ядуу зүдүүг тэвчиж, амгалан хийгээд дорвижилгоог бүтээхийг хүсэхийн тулд болой.”

“Язгуурын хөвгүүнээ, тэр мэт Түүнчлэн заларсан гаслангаас хэтрэхийг үзвээс тэрээр ховор, учрахуйяа бэрх хэцүү гэх зэргийн гаслан зовлонгийн хуран мэдэл ч төрөх бөлгөө. Ялж төгс нөгчсөн, түүнчлэн заларсан ертөнцөд гарах нь ч тоолшгүй галавт хааяа нэг гардаг. Үлгэрлэвээс удамбар цэцэг хааяа, ганц нэг удаа гардагтай адил. Амьтад түүнийг ховор хийгээд учрахуйяа бэрх хуран мэдлийг үүсгэснээр Ялж төгс нөгчсөн түүнд бишрэл төрөх болно. Нигуураас нь зарлигласан судруудад ч үнэний хуран мэдэл хийгээд гүйцэд барихын хуран мэдлийг үүсгэх хийгээд хоч талбиж үйлдэхгүй болой.”

“Язгуурын хөвгүүнээ, тиймээс Түүнчлэн заларсан тэрээр уг тэрхүү учир шалтгаан түүний тулд ертөнцөд өнө удаан орших үгүй, түргэн гаслангаас гэтлэн зохиосноор Түүнчлэн залрагсад мэргэн арга хотол чуулган тэр мэтээр амьтдыг огоот гэтэлгэн зохиодог болой.”

Тэгээд түүнчлэн заларсан дөрвөн бурхан тэдгээр ч үл үзэгдэх болов. Тэгээд бодьсадва махасадва Ручира-кету хийгээд хэмжээлшгүй зуун мянган бодьсадва хийгээд бас хэмжээлшгүй зуун мянган голди амьтад хамтран Гридракута уул хаана буй тэнд очоод Ялж төгс нөгчсөн Шагжамуни түүнчлэн заларсанд оройгоороо мөргөөд нэгэн зүгт суувай. Тэгээд Ручира-кету бодьсадва бээр ямар мэт болсон тэдгээрийг айлтгав. Тэгтэл түүнчлэн заларсан бурхан тэр дөрөв бээр ч Тасын цогцост ууланд Ялж төгс нөгчсөн Шагжамуни оршиж байгаагийн дэргэд заларч, тус тусын зүгийн суудлын дээр оршоод бодьсадва нөхөддөө зарлиглав: “Язгуурын хөвгүүн одогтун! Ялж төгс нөгчсөн Шагжамуни бурханд хорлол хийгээд зүдрэл бага буюу? Явдал хөнгөн үү? Амгалантай оршиж байна уу? хэмээн айлтгагтун! Бас Ялж төгс нөгчсөн, Түүнчлэн заларсан Шагжамуни бурханд *Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан* маш гүнзгий үүнийг амьтан бүгдэд туслах хийгээд ган зудын аюулыг огоот арилгаад бүгдийг амгалантай болгохын тулд үзүүлсэн нь сайн байна. Даган баясан зохиох болой хэмээн айлтгагтун!”. Тэгээд тус тусын дэргэд байсан бодьсадва тэдгээр бээр Ялж төгс нөгчсөн Шагжамуни бурхан хаана буй тэнд хүрч очоод Ялж төгс нөгчсөний өлмийд оройгоороо мөргөөд Ялж төгс нөгчсөн дөрвөн бурхан тэдгээрийн ямар мэт зарлигласан түүнчлэн айлтгавай. Тэгээд Ялж төгс нөгчсөн, түүнчлэн заларсан, дайсныг дарсан, үнэнхүү туулсан Шагжамуни бурхан бээр бодьсадва тэдгээрт, сайн болой хэмээн зарлиглаад сайн болой, сайн болой. Түүнчлэн заларсан дөрвөн бурхан бээр ч амьтан бүгдэд туслах хийгээд амгалангийн тусад дээдийн ном үүнийг номлохыг надад сануулан зохиосноор тэр цагт Ялж төгс нөгчсөн бээр шүлэг эдгээрийг номлосон болой.

Тасын цогцост ууланд би оршоод

Их эрдэнэ судар үүнийг номлон зохиосон ч

Олон төрөлхийтэн эдгээрийг гэтэлгэхийн тулд  
Огоот гаслангаас гэтлэхийг ч үзүүлэн зохионо

Үзэл буруудсан эгэл нялхас тэд  
Эдүгээ миний шажинд сүжиглэж эс үйлдсэн  
Орчлонгоос тэдгээр бүгдийг гэтэлгэхийн тул  
Огоот гаслангаас гэтлэхийг ч үзүүлэн зохионо

Тэгээд тэр цагт нөхдийн дунд хэмээгч хийгээд олон мянган  
бярмангууд Ялж төгс нөгчсөнд тахилыг үйлдээд, Түүнчлэн  
заларсан, огоот их гаслангаас гэтлэгчдийн дууг сонсоод, даруй  
уйлж Ялж төгс нөгчсөний хоёр өлмийд сөгдөн бошго үзүүлэгч,  
багш бярман Каундиня Ялж төгс нөгчсөн бурханд айлтгав: “Хэрвээ  
Ялж төгс нөгчсөн бурхан амьтан бүгдийг энэрэн таалж, төгөлдөр  
их нигүүлсэнгүйгээр туслахыг хүссэн, амьтан бүгдэд эцэг эх мэт  
тэнцүү бусыг ч тэнцүүд үзэх, сар мэт гийгүүлэн зохиож, билгүүн  
хийгээд их билгүүний нарыг ургуулах мэт байдаг бөгөөд хэрвээ та  
амьтан бүгдийг Рахула (*түвд: Дажинзинба*) шиг болгоодог л бол  
надад дээд нэгийг хайрлан соёрх.”

Бурхан багш юу ч үл зарлиглан суувай.

Тэндээс бурханы хүчээр нөхдийн дотроос орь залуу Лигчави  
Сарва-лога-прия-даршана (*монгол: Амьтан бүгд бээр үзвээс  
баясахуй*) хэмээгч тэр бээр самбаа төрөөд багш, эш үзүүлэгч бярман  
Каундиня-д ийн хэмээн өгүүлрүүн: “Их бярман та Ялж төгс нөгчсөн  
бурханаас дээд нэг юуг айлтгав. Би бээр танд дээдийг өгөх болно.”

Бярман бээр өгүүлэв, “Орь залуу Лигчави, Би Ялж төгс нөгчсөн  
бурханыг тахих тул чандарын үнс хэрэгтэй байна. Ялж төгс нөгчсөн  
бурханы юнгарын үр төдий чандарыг нэгийг шүтэхийг хүсэж  
байна. Юнгарын үр төдий чандар түүнийг илтэд тахиваас Гучин  
гурван тэнгэрийн орны эзэн ямагтыг олно хэмээн алдаршсан. Аяа  
орь залуу Лигчави, *Дээдийн Алтангэрэлт* судар шарвага хийгээд  
брадигабуд бүгдээрээ мэдэхэд бэрхтэй, дотроо багтаахад бэрх,  
тэр мэтийн билэг чанар хийгээд эрдэм төгөлдөр дээд Алтангэрэлт  
судрыг номлоно хэмээн алдаршсаныг сонсогтун! Аяа орь залуу  
Лигчави, *Дээдийн Алтангэрэлт* судар энэ нь тэр мэт мэдэхэд

бэрхтэй хийгээд оноход бэрхтэй учраас алс хол газрын бярман бид нар, алин түүнийг хадгалваас амьтан бүхнээ түргэнээ Гучин гурван тэнгэрийн орны эзэн болох юнгарын үр төдий чандарыг эрдэнийн хайрцагт хийж хадгалж ч болох болой. Аяа орь залуу Лигчави, та юу болохноо ч Түүнчлэн заларснаас юнгарын үр төдий чандарыг айлтгаад, чандарыг эрдэнийн хайрцагт хадгалснаар алив амьтныг Гучин гурван тэнгэрийн орны эзний төрлийг олуулахыг хүсэхгүй байна уу? Аяа орь залуу Лигчави, би бээр дээд тэр мэтийг айлтгаж байна.”

Тэгээд орь залуу Лигчави Сарва-лога-прияа-даршана тэрбээр эшийг үзүүлэгч багш бярман Каундиняа-д шүлэглүүдийг дахин өгүүлэв:

Хэзээ нэгэн цагт “Ганга”-ын урсгалаас  
Хээрийн цэцгүүд төрөх ба  
Хэрээ улаан болох хийгээд  
Хөхөө дун мэт өнгөтэй болох,  
Замбуу модонд далийн үр тогтох  
Зовлонт модонд амараан жимс ургах  
Тэр цагт юнгарын үр төдий  
Чандарыг хайрлах болно буй заа.

Хэзээ нэгэн цагт яст мэлхийн үсээр  
Хувцсыг сайтар нэхэх болоод  
Өвлийн хүйтнийг арилгаж үйлдэх  
Тэр цагт чандар байх буй заа.

Хэзээ нэгэн цагт батганын гар хөлөөр  
Тулах баганыг сайтар үйлдэхүйд,  
Хөдөлшгүй хийгээд маш бат болвоос  
Тэр цагт чандар байх буй заа.

Хэзээ нэгэн цагт лянхуй хорхой бүхний  
Шүд нь цайран ургах болоод  
Хурц хийгээд их болох  
Тэр цагт чандар байх буй заа.

Өндөр язгуурт авирахын тулд  
Өдгөө нэгэн цагт туулайн эврүүдээр  
Өгсөх шатыг сайтар үйлдэх болох  
Тэр цагт чандар байх буй заа.

Нэгэн цагт шат түүгээр авираад  
Нялхас бээр сарыг идэх хийгээд  
Түүнчлэн Рахад ч гэсэн хорлож үйлдэх  
Тэр цагт чандар байх буй заа.

Тосгонд нисэх зөгий бээр  
Баартай архийг шимэн суугаад  
Байшин гэртээ тухлан үйлдэх  
Тэр цагт чандар байх буй заа.  
Хэзээ нэгэн цагт илжиг хөөрхөн болж  
Хошуу нь улаан бимба жимс мэт болоод  
Дуу, бүжигт мэргэн болох  
Тэр цагт чандар байх буй заа.

Хэзээ нэгэн цагт шар шувуу, хэрээ хоёр  
Хээр уулзаад энхрийлэлдэх хийгээд  
Харилцан зохилдох болох болбоос  
Тэр цагт чандар байх буй заа.

“Балаша”-гийн навч нугууд  
Гурван эрдэнийн шүхэр болоод  
Буух хураас халхалж чадах болох  
Тэр цагт чандар байх буй заа.

Хэзээ нэгэн цагт далайн их онгоц  
Хүрд хийгээд дарвуулнуудаа  
Талд дэрвүүлээд одох болбоос  
Тэр цагт чандар байх буй заа.

Хэзээ нэгэн цагт хэрээ, шар шувуунууд  
Гандамадана (*монгол: Хүжийн үнэр анхилуулсан*) уулыг  
Хошуундаа зуугаад нисэх болох  
Тэр цагт чандар байх буй заа.

Эшийг үзүүлэгч багш, бярман Каундиня бээр эдгээр шүлгүүдийг сонсоод орь залуу Лигчави Сарва-лога-прия-даршана түүнд шүлэг эдгээрээр хариу өгүүлэв:

Сайн болой, сайн болой, залуу эрхэм!  
Бурханы хөвгүүн их сургаалт,  
Баатарлаг хийгээд мэргэн аргат,  
Бошгийг үзүүлэхийн дээдийг олсон,

Ертөнцийн итгэл аврал болсон  
Түүнчлэн заларсаны эрдэм ямагтаас  
Ер санаанд багташгүйг дараачлан  
Залуу бээр надад сонсгож үйлдлээ.

Бурханы эрдэм санаанд багташгүй  
Түүнчлэн залрагсад тэнцэл үгүй.  
Бурхан бүгд үргэлжид амирласан.  
Бурхан бүгд үнэнхүү гарсан.  
Бурхан бүгд өнгө тэнцүү.  
Энэ нь бурханы мөн чанар мөн болой.

Ялж төгссөн нь засвартай бус.  
Ямарчлан заларсан үл эвдрэх учир  
Очир мэтийн бат лагшин  
Хувилгааны лагшинг төрүүлэн зохиосон  
Тиймээс их аршийн чандар нь  
Юнгарын үр төдий хэмээх үгүй.

Түүний лагшинд яс, цус үгүй болбоос,  
Чандар байна гэж хаанаас болох вэ?  
Амьтан тэдэнд туслахын тул  
Аргаар чандарыг агуулан зохиодог.

Туулсан бурханы номын лагшин,  
Түүнчлэн заларсан номын чанар  
Номыг үзүүлэн зохиох ямар адил  
Ялж төгс нөгчсөний лагшин ч тэр мэт

Би бээр үүнийг сонсож мэдээд  
Би бээр дээдийг соёрхон айлтгав  
Зөвхөн тэр ямагтыг эш үзүүлэхийн тулд  
Зөвлөн өгүүлэхийг би бээр үйлдэв.

Тэгээд гурван түм хоёр мянган тэнгэрийн хөвгүүн бээр Түүнчлэн заларсаны нас сүүдрийн хэмжээг үзүүлсэн гүнзгий энэ мэтийг сонсоод, бүгдээрээ тэнцэшгүй үнэнхүү төгс бодь сэтгэлийг үүсгээд бодол бүхэндээ машид баясаад, дуу хоолойгоо нийлүүлэн шүлэг эдгээрийг өгүүлэв:

Бурхан мөнх бусыг огоот үзүүлэх бус;  
Бурханы ном нь ч балрах бус;  
Олон амьтныг төгс боловсруулан зохиохын тулд,  
Огоот газлангаас гэтлэхүйг заан үзүүлэх.

Ялж төгссөн бурхан санаанд багташгүй;  
Түүнчлэн заларсан мөнхийн лагшин,  
Амьтан бүхэнд туслахын тулд  
Адилгүй лагшин элдвийг үзүүлдэг.

Тэгээд Ручира-кету бодьсадва махасадва бээр Ялж төгс нөгчсөн бурхан тэдгээр хийгээд дээд төрөлхтөн тэр хоёроос, Ялж төгс нөгчсөний нас сүүдрийн хэмжээг өгүүлэхийг сонсоод суудлаасаа босоод алгаа хавсран мөргөөд ийн хэмээн айлтгав: “Ялж төгс нөгчсөөн, тэр мэт Ялж төгс нөгчсөн бурхан тэдгээр нь мөнх бусыг үл үзүүлсэн болбоос, чандар нь ертөнцөд агуулж болохгүй биш үү? Юуны тулд судрын аймгуудаас бурхан мөнх бусыг үзүүлэх хийгээд чандар нь ертөнцөд байхад тэнгэр хийгээд хүмүүн бээр бишрэх, хүндэтгэх зэргээр үйлдэх ба эрт цагийн бурхан Ялж төгс нөгчсөн нарын чандар ертөнцөд байхад тэнгэр хийгээд хүмүүн ертөнцийн тахилаар тахиваас буян хэмжээлшгүй олох болой хэмээн зарлигласан ба өнөөдөр энд тэдгээрийг үгүй болой хэмээн зарлиглаж байгаа энэ нь ч ямар мэт юм бэ? Ялж төгс нөгчсөн бурхан нигүүлсэнгүйгээр сайтар ялган номлон соёрх.”

Тэгээд Ялж төгс нөгчсөн бурхан бээр Ручира-кету бодьсадва махасадва тэргүүтэн хурсан нөхөд тэдгээрт зарлиглавай: “Ялж

төгс нөгчсөн гаслангаас хэтрээд чандараа ертөнцөд үлдээнэ хэмээн зарлигласан нь тааллын утганд үзүүлсэн гэж мэдэж үйлдээрэй. Язгуурын хөвгүүн бодьсатва махасатваа, эдгээр Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхан бээр үнэмлэхүй үнэний ёсонд арван зүйл их гаслангаас гэтэлсэн байдаг гэж мэдээрэй. Арав алин хэмээвээс энэ мэт юм:

- (1). Түүнчлэн заларснууд нисваанисын түйтгэр хийгээд мэдэгдхүүний түйтгэрийг огоот тэвчсэнээр гаслангаас хэтэрсэн хэмээсэн,
- (2). Түүнчлэн заларсан бурхад бээр бодгалын би үгүй хийгээд номын би үгүйг илтэд болгоосноор гаслангаас хэтэрсэн,
- (3). биений орон хийгээд номын орон болсноор гаслангаас хэтэрсэн хэмээсэн,
- (4). амьтдыг номхотгохын зохиол нь зөнгөөрөө бүтсэн учир гаслангаас хэтэрсэн хэмээх,
- (5). үнэмлэхүй ямагтыг илтэд болгоосноор билэг чанар тус тусдаа үгүй учраас номын лагшинг тэнцүүлсний тул гаслангаас хэтэрсэн хэмээсэн,
- (6). орчлон хийгээд нирвааны мөн чанар хоёр үгүйг илтэд болгоосноор гаслангаас гэтэлсэн хэмээсэн,
- (7). юм бүгдийн мөн чанарыг мэдсэнээр нэн арилсныг илтэд болгоосны тул гаслангаас хэтэрсэн хэмээсэн,
- (8). юм бүгд төрөх хийгээд эвдрэх үгүй бүтэхэд мэрэгжсэн тул гаслангаас хэтэрсэн хэмээсэн,
- (9). түүнчлэн ямагт, номын мөн чанар хийгээд үнэмлэхүй хязгаарыг тэгшитгэсэн билгүүнийг олсоны тул гаслангаас хэтэрсэн хэмээсэн,
- (10). юм бүгдийн түүнчлэн ямагт хийгээд гаслангаас гэтэлсний түүнчлэн ямагтад ялгаа үгүйг болгоосон учраас гаслангаас хэтэрсэн хэмээсэн болой.”

“Бас язгуурын хөвгүүн бодьсадва махасадва, арван ном эдгээрээр нь Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхан бээр үнэмлэхүй хийгээд үнэний ёсонд их гаслангаас гэтэлсэн байдаг гэж зарлигласан болой. Арав алин хэмээвээс, энэ мэт нисваанис бүгдийн суурь нь шунал хүсэл бөгөөд алин дор тэмүүлсэн түүндээ шунал төрөх болой.

- (1). Бурхан ялж төгс нөгчсөн нь шунал хийгээд хүслээс хагацсаны тул гаслангаас хэтэрсэн хэмээсэн,
- (2). Түүнчлэн залрагсад нь шунал хийгээд хүсэл бүгдээс хагацаад ном алиныг ч үл авсаны тул барих үгүй, одох, ирэх, авах үгүй, тиймийн тул гаслангаас хэтэрсэн хэмээсэн,
- (3). одох, ирэх, авч үйлдэх байхгүй тэр нь номын лагшин бөгөөд төрөх хийгээд хаагдах үгүй болой. Төрөх хийгээд хаагдах үгүй тэр ямагт нь гаслангаас хэтэрсэн хэмээсэн,
- (4). төрөх хийгээд хаагдах үгүй тэр нь үгээр өгүүлшгүй, үгийн мөрнөөс тасарсаны тул гаслангаас хэтэрсэн хэмээсэн,
- (5). би үгүй ба бодгал үгүй хийгээд төрөх ба хаагдахын юм төдийгөөс орших юүлэхийг олсоны тул гаслангаас хэтэрсэн хэмээсэн,
- (6). нисваанис хийгээд ойрын нисваанис нугуудыг зуурдын зүйлд болгоосон хийгээд алин номын чанар тэр нь орших буюу одох ба ирэх үгүй гэж бурхан Ялж төгс нөгчсөн бээр илтэд болгоосны тул гаслангаас хэтэрсэн хэмээсэн,
- (7). үнэмлэхүй нь үнэн бөгөөд тэрнээс бусад нь худал болой. Алин үнэн тэр ямагт нь үнэмлэхүй бөгөөд үнэмлэхүй ямагт нь Түүнчлэн заларсан ямагт учраас түүнийг гаслангаас хэтэрсэн хэмээсэн,
- (8). үнэмлэхүйн хязгаар ямагт нь цацралт үгүй, Түүнчлэн заларсан ганцаараа үнэмлэхүйн хязгаарыг илтэд болгоосон хийгээд цацралыг чухал амирлуулсан тэр ямагтыг гаслангаас хэтэрсэн хэмээсэн,

- (9). төрөх үгүй нь үнэн төрөх нь худал учраас нялхас эгэл төрөлхтөнүүд нь орчлонгийн шаварт шигдсэн, Түүнчлэн заларсаны лагшин нь үнэн үнэмлэхүй бус бишийн тул гаслангаас хэтэрсэн хэмээсэн,
- (10). үнэмлэхүй бус юм нь шалтгаанаас төрсөн, үнэмлэхүй үнэн юм нь шалтгаанаас төрсөн биш, Түүнчлэн заларсаны номын лагшин нь ч үнэмлэхүй үнэн ямагт мөн учраас түүнийг гаслангаас хэтэрсэн хэмээсэн болой.”

“Бас язгуурын хөвгүүн бодьсадва махасадва, ийм арван номоор Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхад бээр үнэмлэхүй хийгээд үнэний ёсыг мэдсэнээр их гаслангаас гэтэлсэн гэж мэдэх болно. Арав алин хэмээвээс энэ мэт юм:

- (1). Түүнчлэн заларсан бээр өглөг хийгээд өглөгийн үрийг би хийгээд миниймхийлэн үйлдэлгүйгээр машинд мэдсэн учраас өглөг тэр ба түүний үрд буруу нэн атгаглахыг огоот тэвчсэн учраас гаслангаас гэтэлсэн хэмээсэн,
- (2). Түүнчлэн заларсан бээр шагшаабад хийгээд шагшаабадын үрийг би хийгээд миниймхийлэн үйлдэлгүйгээр машинд мэдсэн учраас шагшаабад тэр ба түүний үрд буруу нэн атгаглахыг огоот тэвчсэн учраас гаслангаас гэтэлсэн хэмээсэн,
- (3). Түүнчлэн заларсан бээр тэвчээр хийгээд тэвчээрийн үрийг би хийгээд миниймхийлэн үйлдэлгүйгээр машинд мэдсэн учраас тэвчээр тэр ба түүний үрд буруу нэн атгаглахыг огоот тэвчсэн учраас гаслангаас гэтэлсэн хэмээсэн,
- (4). Түүнчлэн заларсан бээр хичээнгүй хийгээд хичээнгүйн үрийг би хийгээд миниймхийлэн үйлдэлгүйгээр машинд мэдсэн учраас хичээнгүй тэр ба түүний үрд буруу нэн атгаглахыг огоот тэвчсэн учраас гаслангаас гэтэлсэн хэмээсэн,
- (5). Түүнчлэн заларсан бээр дияан хийгээд дияаны үрийг би хийгээд миниймхийлэн үйлдэлгүйгээр машинд мэдсэн учраас дияан тэр ба түүний үрд буруу нэн атгаглахыг огоот тэвчсэн учраас гаслангаас гэтэлсэн хэмээсэн,

- (6). Түүнчлэн заларсан бээр билгүүн хийгээд билгүүний үрийг би хийгээд миниймхийлэн үйлдэлгүйгээр машид мэдсэн учраас билгүүн тэр ба түүний үрд буруу нэн атгаглахыг огоот тэвчсэн учраас гаслангаас гэтэлсэн хэмээсэн,
- (7). Түүнчлэн заларсан бээр амьтан хийгээд амьтан үгүйг машид болгоосон хийгээд юм бүгдийн мөн чанар үгүйд буруу нэн атгагласныг огоот тэвчсэн учраас гаслангаас гэтэлсэн хэмээсэн хийгээд алин шуналын мөн чанартай нь мэдэрхүйд шамдан үйлдэх болой. Мэдэрхүйд шамдан үйлдсэний эрхээр зовлон элдэв янзыг амсах болой.
- (8). Түүнчлэн заларсан бурхад нь би хийгээд миниймхийлэн барихыг огоот тасалсан хийгээд мэдрэхүйг үл эрхшээсэн учраас гаслангаас гэтэлсэн хэмээсэн
- (9). хуран үйлдсэн юм бүгд нь тоо хийгээд хэмжээ байх дор хуран эс үйлдсэн юмс нь тоо хийгээд хэмжээ бүгдээс хагацсан бөгөөд бурхан бээр хуран үйлдсэн юмыг тэвчсэн хийгээд хуран эс үйлдсэн юмыг илтэд зохион тоо хийгээд хэмжээ үл эрхшээсэн тул гаслангаас хэтэрсэн хэмээсэн,
- (10).Түүнчлэн заларсан бээр амьтан хийгээд юмсын мөн чанар бүхэн хоосон хийгээд хоосон түүнээс бусад нь ч байгаа бус хийгээд хоосон мөн чанартай тэр ямагт үнэнхүү номын лагшин мөн учраас тиймийн тул түүнд гаслангаас хэтэрсэн хэмээсэн буюу Язгуурын хөвгүүнээ арван ном тэдгээрээр нь гаслангаас хэтэрсэн хэмээсэн болой.”

“Бас язгуурын хөвгүүнээ, Түүнчлэн заларсан гаслангаас хэтрээгүй тэр ямагт их гайхамшигтай биш. Бас гайхамшигтай үйлдвэр арван ном байдаг. Тэр нь Түүнчлэн заларсан бурхадын явдал болой. Арав алин хэмээвээс энэ мэт:

- (1). Орчлон нь гэм лугаа төгөлдөр нирваан нь амирлангуй хийгээд аглаг мөн болбоос орчлон хийгээд нирваан тэр хоёрыг тэнцүү мэдсэн учраас орчлонд ч үл орших, нирваанд ч үл орох бөгөөд

алин амьтдын тусад үл уйсах тэр нь Түүнчлэн заларсан бурхадын явдал болой.

- (2). Түүнчлэн заларсан бурхад бээр эгэл нялхсын чанх буруу явдал хийгээд элдэв нисваанисаар эзлэгдсэнийг болгоосон ч эдгээрийг нэн гэтэлгэж үйлдэх болой хэмээн үл бодох боловч урьдын нигүүлсэнгүй хийгээд буяны ёзоорын хүчээр амьтан эдгээрийн тус тусын ухаан хийгээд мөн чанар ба санаа юунд дурласныг, атгагийг үл эрхшээн зөнгөөрөө бүтэхийн ёсоор сүүлчийн хязгаарт тулах үгүйгээр тус хүргэх хийгээд номыг үзүүлдэг тэр нь Түүнчлэн заларсан бурхадын явдал болой.
- (3). Түүнчлэн заларсан бурхад бээр амьтан бодгалд эрхэм зарлиг арван хоёр гишүүнийг дэлгэрэнгүй үзүүлсэнээр тус хүргэх болой хэмээн таалахгүй боловч урьдын нигүүлсэнгүй хийгээд буяны ёзоорын хүчээр амьтан эдгээрт эцэс хойдод тулах үгүйгээр номыг дэлгэрэнгүй үзүүлсэн тэр нь Түүнчлэн заларсан бурхадын явдал болой.
- (4). Түүнчлэн заларсан бурхад хот, тосгон, сууринд заларсан хийгээд хаан ба түшмэл, бярман, хааны язгуур, ноёдын язгуур, доод язгуур тэргүүтний гэрт бинаваадыг авах болой хэмээн таалаагүй боловч урьдын лагшин, зарлиг, тааллын явдлыг бясалгасны хүчээр зөнгөөрөө бүтсэн бинаваадад морилох хийгээд тус хэргийг зохиосон тэр нь Түүнчлэн заларсан бурхадын явдал болой.
- (5). Түүнчлэн заларсан бурхадын лагшин өлсөх хийгээд ундаасахыг ч үл эрхшээсэн, өтгөн, шингэнээс лагшин нь энэлж доройтохыг ч үл эрхшээн бинаваадыг авах нь үзэгдсэн ч түүнд соёрхох нь ч үгүй, түүний нэн атгаг нь ч үл эрхшээсэн боловч амьтанд туслахын тулд бинаваадыг соёрхож үзэгдэж байгаа тэр нь Түүнчлэн заларсан бурхадын зөнгөөрөө бүтсэн явдал болой.
- (6). Алин Түүнчлэн заларсан бээр амьтан эдгээрийн ухаан дээд, дунд, адаг ямар мэт номыг үзүүлэх болой хэмээн таалахгүй боловч Ялж төгс нөгчсөн бурхан бээр тус тусын ухаан хийгээд сав ямар мэт болохыг атгагийг эрхшээлгүй машид болгоох

хийгээд тэдгээрт номыг үзүүлэх тэр нь Түүнчлэн заларсан бурхадын явдал болой.

- (7). Түүнчлэн заларсан бурхад бээр амьтан эдгээр нь бишрэлгүй, үргэлжид ширүүн үгээр мууг өгүүлдэг мөн учраас эдгээртэй хамт өгүүлэхгүй болой, амьтан эдгээр нь надад үргэлжид биширч үйлдэх магтах хийгээд яруу өгүүлдэг мөн учраас эдгээртэй хамт өгүүлж үйлдэх болой хэмээн Түүнчлэн заларсан бээр таалахгүй бөгөөд асрахуй ба нигүүлсэнгүйгээр хоёр үгүй тэгшид таалах тэр нь Түүнчлэн заларсан бурхадын явдал болой.
- (8). Ялж төгс нөгчсөн бурхад асран уурлах, омог, хүсэл, харам тэргүүтэн нисваанис эрхшээгээгүй боловч Түүнчлэн заларсан бурхад нь үргэлжид аглагт баясах хийгээд хуран үймээн бүгдийг тэвчээд, хүсэл багыг сайшаан зохиодог тэр нь Түүнчлэн заларсан бурхадын явдал болой.
- (9). Түүнчлэн заларсан бурхад нь зарим нэг ном төдийг үл мэдсэн бус буюу таалалдаа багтаагаагүйг эрхшээгээгүй хийгээд орон бүгдэд толь мэт билгүүнийг илтэд болгосон учраас нэн атгаг үгүй боловч Түүнчлэн заларсан бээр амьтан эдгээрийн үйл хийгээд явдлыг болгоогоод тэдгээрийн санаанд зохилдон найруулснаар аргаар татах хийгээд орчлонгоос гэтэлгэх тэр нь Түүнчлэн заларсан бурхадын явдал болой.
- (10). Түүнчлэн заларсан бурхад бээр амьтан алин баян хийгээд идэрхэнийг болгоохноо ч баясал үл төрж, гутарсан хийгээд доройтсоныг болгоохноо ч гутарлыг үл зохиох боловч Түүнчлэн заларсан бурхад амьтан тэдгээрийн үнэнхүү явдал бүтээлийг болгоогоод торолтгүй их нигүүлсэнгүйгээр авран зохиодог болой, зарим амьтдын буруу явдлыг болгоохноо ч тачаах үгүй их нигүүлсэнгүйгээр аврах хийгээд барьдаг тэр нь Түүнчлэн заларсан бурхадын явдал болой.”

“Язгуурын хөвгүүнээ, энэ нь Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхадын үнэмлэхүй явдал хязгааргүйг үзүүлсэн хийгээд гаслангаас хэтэрсэн үнэмлэхүй үнэний билэг чанарт хуран мэдэж үйлдэгтүн! Бусад үест гаслангаас хэтрэх хийгээд чандарыг

ертөнцөд орхино хэмээн үйлдсэн тэр нь мэргэн аргыг үзүүлсэн бөгөөд амьтан төрөлхтөний тахил, өргөл хүндлэлийг үйлдэх тэдгээр нь ч Түүнчлэн заларсаны нигүүлсэнгүй хийгээд буяны ёзоорын хүч мөн гэж мэдэж үйлдээрэй! Түүнд зарим нэгэн тахиж хүндэлж үйлдсэн тэр нь ирээдүй цагт найман чөлөөгүйг огоот тэвчээд Түүнчлэн заларсан бурхадтай учрах, буяны садантай төгөлдөр байх, бодь сэтгэлийг үл орхих, буян хэмжээлшгүй арвижих, орчлонгоос түргэн гэтлэх, орчлонгийн хүлээсээр хүлэгдэхгүй дээд явдал энэ мөн учраас чи бээр шамдан бүтээж алгасралгүй үйлдээрэй!”

Тэгээд Ручира-кету бодьсадва бээр Ялж төгс нөгчсөн гаслангаас үл гэтлэхийн утга хийгээд гүнзгий тэвчээрийг үзүүлэхэд, Ялж төгс нөгчсөнөөс илтэд сонсоод алгаа хавсран сөгдөөд, ийн хэмээн айлтгавай: “Өнөөдөр би бээр Түүнчлэн заларсан их багшаас гаслангаас үл гэтлэх хийгээд чандарыг ертөнцөд орхих болон амьтан нугуудад агуу их тусыг зохиох үүнийг мэдээд бие, сэтгэл минь баясан гайхан бишрэх болбой.”

Түүнчлэн заларсаны нас сүүдрийн хэмжээ үүнийг үзүүлбээс тоолшгүй, хэмжээлшгүй, хязгаарлашгүй амьтан тэдгээр бүгд тэнцэшгүй үнэнхүү төгс бодь сэтгэлийг үүсгэвэй. Түүнчлэн заларсан бурхан тэдгээр ч үл үзэгдэх болоод Ручира-кету бодьсадва ч суудлаасаа босоод Ялж төгс нөгчсөний өлмийд мөргөөд дахин өөрийн орон тэр ямагтад суувай.

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлгөн судраас*

*“Түүнчлэн заларсдын насан сүүдрийн хэмжээг үзүүлэхүй”  
хэмээх хоёрдугаар бүлэг болой.*

\* \* \*

### *III бүлэг: Турван лагинг ялгаж үзүүлэхүй*

Тэгээд Акаша-гарба (*Огторгуйн зүрхэн хурсан*) хэмээх бодьсадва махасадва тэдний дотроос суудлаасаа босоод, номт хувцсаа нэг мөрөндөө буулгаад, баруун өвдгөө газарт хатгаад, алгаа хавсраад Ялж төгс нөгчсөний хоёр өлмийд мөргөөд алт хийгээд их эрдэнийн цэцэг, их эрдэнийн дуаз, шүхрийн дээдээр тахиж үйлдээд Ялж төгс нөгчсөн бурханд ийн хэмээн айлтгавай: “Бодьсадва махасадва, Түүнчлэн заларсан бурхадын таалал машид гүнзгий түүнийг ёсчлон ямар мэт бүтээн үйлдэх вэ?”

Ялж төгс нөгчсөн бурхан бээр зарлиглав: “Язгуурын хөвгүүнээ, сайтар машид сонсож, сэтгэлдээ баригтун! Чамд түүний утгыг сайтар ялгаад үзүүлж үйлдье! Язгуурын хөвгүүнээ, Түүнчлэн заларсан бүгд гурван лагинг эрхшээсэн байдаг бөгөөд гурав нь аль вэ? хэмээвээс, хувилгааны лагшин, төгс жаргалангийн лагшин, номын лагшин болой. Энэ мэтийн гурван лагшин нь зөнгөөрөө бүтсэн учраас тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодийг барьсан хэн бээр түүнийг илтэд болгосон тэрбээр хорвоогоос гарч үйлдэх болой. Түүн дор ямар мэт бодьсадва бээр хувилгааны лагшинг мэдэж үйлдэх вэ? хэмээвээс, язгуурын хөвгүүнээ, тэр нь Түүнчлэн заларсан урьд газар мөрийг нэн судалж байх үедээ төрөлхтөн бүгдийн тулд элдэв янзын номыг бүтээсэн болой. Тэр мэт явдлыг судалснаар бүтээлийн эцэст хүрсэн болой. Бүтээл түүний хүчээр их авшгийг олсон болой. Их авшгийн хүчээр төрөлхтөний санаа ямар мэт, явдал ямар мэт хийгээд орон ямар мэтчилэн бүгдийг илт болгоод цагт нь таалаагүй, цагаас нь хэтрээгүй, оронтой зохилдсон, цагтай зохилдсон, явдалтай зохилдсон, номыг номлоход ч зохилдож элдэв янзын лагинг үзүүлсэн түүнийг хувилгааны лагшин хэмээн үйлдэх болой.

“Язгуурын хөвгүүнээ бодьсадва бээр төгс жаргалангийн лагинг ямар мэт мэдэж үйлдэх вэ? хэмээвээс, Түүнчлэн заларсан бүгд бээр

бодьсадва нарт торолт үгүйг олж үйлдэхийн тулд үнэмлэхүй үнэнийг үзүүлсэн бөгөөд орчлон хийгээд нирваантай хамт нэг гэж мэдэж үйлдээд, эвдрэхийн чуулганд үзэхийг арилгаад, аймшигт амьтан бүхнийг баясуулж үйлдэх хийгээд бурханы ном хязгаарлашгүйн уг болох учраас үнэн ямагт хийгээд түүнчлэн ямагтын билгүүнтэй зохилдож, урьдын ерөөлийн хүчээр лагшин түүнийг үзүүлэх болох буюу гучин хоёр бэлэг хийгээд наян үлгэрээр чимэглэгдсэн гэрэлт лагшинд орчлонд бүтсэн тэр нь төгс жаргалангийн лагшин хэмээж үйлдэх болой.

“Язгуурын хөвгүүнээ, бодьсадва махасадва бээр номын лагшинг ямар мэт мэдэж үйлдэх вэ? хэмээвээс, нисваанисын түйтгэр бүгдээс хагацаж төгсгөсний тул хоосон чанар хийгээд үнэмлэхүй билгүүн төдийд орших тэр нь номын лагшин хэмээж үйлдэх болой. Урьдах хоёр лагшин тэр нь нэрийтгэлийн төдий болой. Номын лагшин нь үнэмлэхүй бөгөөд тэр хоёр лагшны суурийг үйлдэх болой. Тэр ямар учраас вэ? хэмээвээс, номын лагшин нь түүнчлэн ямагт хийгээд нэн үл атгаглахын билгүүнээс тусдаа бурханы ном алин ч байхгүйн тулд болой. Түүнчлэн заларсан бурхад нь билгүүн хотол чуулган болж, нисваанис бүгдийг тэвчсэний тул эцэст хүрсэн учраас бурханы нэн арилсаныг олсоны тул номын хоосон чанар хийгээд үнэмлэхүй билгүүний бурханы ном нугуудыг огоот барьсан болой. Бас язгуурын хөвгүүнээ, бурхан бүгд нь өөр хийгээд бусдын тусыг эцэст нь хүргэсэн бөгөөд түүн дор номын түүнчлэн ямагтаар өөрийн тусыг зохиож, түүнчлэн ямагтын билгүүнээр бусдын тусыг зохиосон болой. Өөр бусдад тусыг зохиоход эрхийг олсон тул хязгаарлашгүй элдэв зохиол нь зөнгөөрөө бүтсэн болой. Тийм учраас бурхан бүгдийн ном хэмжээлшгүй, хязгаарлашгүй элдэв олныг ялгамжаатай үзүүлэх болой.

“Язгуурын хөвгүүнээ, үлгэрлэвээс нэн атгаглахын сэтгэлд шүтээд нисваанис олон янз, үйл олон янз, үр олон янзыг үзүүлдэг түүн шиг номын мөн чанар хийгээд түүнчлэн ямагтын билгүүн дор шүтээд бурханы ном элдэв янз, брадигабудын ном элдэв янз, шарвагын ном элдэв янз олныг үзүүлдэг болой. Номын мөн чанар хийгээд түүнчлэн ямагтын билгүүн дор шүтээд бурхан бүгдийн номонд

хотол чуулганы эрхийг олсон тэр нь дээд, жишихэд бэрхтэй болой. Үлгэрлэвээс огторгуйд зураг зураад чимгийг үйлдэх тэр нь жишихэд бэрхтэй болой. Түүнчлэн үнэмлэхүй ном хийгээд үнэмлэхүй билгүүн дор шүтээд бурханы ном бүгдийг бүтээх нь ч жишихэд бэрхтэй мөн болой.

“Язгуурын хөвгүүнээ, ямар адил болбоос номын түүнчлэн ямагт хийгээд түүнчлэн ямагтын билгүүн дор нэн атгагийг үл эрхшээсэн хийгээд үйлс дор эрхшээлийг олсон мөн хэмэвээс, язгуурын хөвгүүнээ, үлгэрлэвээс Түүнчлэн заларсан гаслангаас хэтэрсэн ч ерөөлд эрхшээлийг олсон учраас үйлсийн байдал бүгдийг ч зохиодог. Түүнчлэн ямагт хийгээд түүнчлэн ямагтын билгүүн дор хэрэг бүгдийг бүтээхэд эрхшээлийг зохиосон ч тэр мэт болой. Бас бодьсатва махасатва саматид тэгш оршоноос урьдын ерөөлийн эрхээр дияан түүнээс босоод хэрэг, үйлс бүгдийг зохиодог мэт юмс байдал хоёрт ч нэн атгаглах үгүй хэрэг бүгдийг зохиоход эрхшээлийг олсон болой.

“Язгуурын хөвгүүнээ, үлгэрлэвээс нар хийгээд саранд ч нэн атгаглах үгүй, ус хийгээд толинд ч нэн атгаглах үгүй, үзэгдэл дор ч нэн атгаглах үгүй боловч гурвуул хуралдсанаас дүрс гарах болой. Тэр мэт номын түүнчлэн ямагт хийгээд түүнчлэн ямагтын билгүүн дор ч нэн атгаг үгүй боловч ерөөлийн эрхээр хувьтай амьтан болгонд төгс жаргалангийн лагшин хийгээд хувилгааны лагшинг ч нар сарны дүрс мэт уг хийгээд шалтгаан хурсанаас гарах болой.

“Язгуурын хөвгүүнээ, бас үлгэрлэвээс, хэмжээлшгүй, тоолшгүй ус хийгээд толь зэрэг нь үзэгдэл дор шүтээд хоосон дүрс билэг чанар тусдаа олон үзэгдэх болой. Хоосон хэмээх нь билэг чанар үгүй болой. Язгуурын хөвгүүнээ, тэр мэт төгс жаргалангийн лагшин хийгээд хувилгааны лагшингаар нөхөд шавь нарт номын лагшингийн дүрсийг үзүүлэх ерөөлийн эрхээр тэр хоёр лагшин үзэгдээд тэмдэг элдэв янзад үзэгдэхнээ ч номын лагшингийн оронд билэг чанар тус тусдаа үгүй болой. Язгуурын хөвгүүнээ, лагшин тэр хоёрт оршоод Ялж төгс нөгчсөн бурхадыг ‘цогцосын үлдэгдэл сэлттэй гаслангаас гэтэлсэн’ хэмээн зарлигласан. Номын лагшинг таалаад ‘цогцосын үлдэгдэлгүй гаслангаас гэтэлсэн’ хэмээн зарлигласан болой. Тэр

юуны тулд хэмээвээс тэр нь юм бүгдийг барахын эцэст болсон учраас лагшин энэ гуравт шүтээд Ялж төгс нөгчсөн бурхад ‘үл оршихын гаслангаас гэтэлсэнд’ оршино хэмээн номлосон болой. Хоёр лагшинг гаслангаас гэтэлсэн хэмээн зарлиглаагүй учир нь номын лагшингаас өөр бурхан үгүй тул болой. Яагаад хоёр лагшинд гаслангаас гэтэлсэн хэмээн үл үйлдэв хэмээвээс тэр хоёр лагшин нь үнэмлэхүй бус нэрийн төдий учраас агшин нэгд төрөх хийгээд эвдрэх, үргэлжид үл орших, дахин дахин гарах учраас магадлал үгүй мэт бөгөөд номын лагшин нь тэр адил бус болой.

[Хоёрдугаар хэсэг]

“Тиймийн тулд тэр хоёр лагшин нь гаслангаас гэтэлсэн хэмээн үл үйлдэх болой. Номын лагшин ч тэр хоёр үгүй тул, гаслангаас гэтэлсэнд орших үгүй учраас, тэр гурван лагшин дор шүтэж үл орших тул, гаслангаас гэтэлсэн хэмээн зарлигласан болой. Язгуурын хөвгүүнээ, түүн дор нялхас эгэл төрөлхтөнүүд гурван билэг чанарын тул хүлэгдэх хийгээд түйтгэрлэгдэх байгаа учраас гурван лагшингаас хол байдаг болно. Ямар гурав хэмээвээс бүхэн нэрийтгэлийн билэг чанар, бусдын эрхийн билэг чанар хийгээд огоот бүтэхийн билэг чанар болой. Билэг чанар тэдгээрийг мэдэх хийгээд хорих хийгээд ариусгах болоогүй тиймийн тул гурван лагшинг эс олсон болой. Тэр мэтийн билэг чанар гурвыг мэдэх хийгээд хорих хийгээд ариусгаснаар Ялж төгс нөгчсөн бурхад гурван лагшинг огоот гүйцээсэн болой.

“Язгуурын хөвгүүнээ, нялхас эгэл төрөлхтөн нар тийн мэдэл гурвыг эс тэвчсэний тул гурван лагшингаас хол байдаг болно. Гурав алин бэ? хэмээвээс, бодитойд орохын тийн мэдэл, бүхний сууринд оршихын сэтгэл, бүхний суурийн тийн мэдэл болой. Мөрийг судлахад оршнооор орохын тийн мэдлийг ариусгах болой. Таслахын мөрд оршнооор бүхний сууринд оршсон сэтгэлийг ариусгах болой. Дээд ялгуулсаны мөрд оршнооор бүхний суурийн тийн мэдлийг ариусгах болой. Орохын тийн мэдлийг ариусгаваас хувилгааны лагшинг олох болой. Бүхний сууринд оршсон сэтгэлийг ариусгаваас төгс жаргалангийн лагшинг үзүүлэх болой. Бүхний суурийн тийн мэдлийг ариусгаснаар номын лагшинг олох буюу.

Тэр мэт болбоос Түүнчлэн заларсан бүгд гурван лагшинг зөнгөөрөө бүтсэн хэмээн үйлдсэн болой. Язгуурын хөвгүүнээ, бурхан бүгдийн хувилгааны лагшин нь бурхан бүгдийн явдал зохилдох болой. Төгс жаргалангийн лагшин нь бурхан бүгдийн таалал зохилдох болой. Номын лагшин нь бурхан бүгдийн лагшин зохилдох болой.

“Язгуурын хөвгүүнээ, бурханы хувилгааны лагшин нь эгэл төрөлхтөний сэтгэл лугаа зохилдон олон байдлаар элдэв бэлэг шинжийг үзүүлдэг тулолон хэмээн үйлдсэн болой. Төгс жаргалангийн лагшин нь нөхөд шавь нарын сэтгэл нэг учраас бэлэг чанар нэгийн тул бэлэг чанар нэг хэмээн үйлдсэн болой. Номын лагшин нь элдэв бэлгээс үнэнхүү гэтэлсэн бэлэгт барихын явдлын орон биш бөгөөд тийм учраас нэг бүхэл ч биш тус тусдаа ч биш хэмээн үйлдсэн болой. Язгуурын хөвгүүнээ, хувилгааны лагшин нь төгс жаргалангийн лагшинд шүтээд илтэд үзэгдэх болой. Төгс жаргалангийн лагшин нь номын лагшинд шүтээд илтэд үзэгдэх болой. Номын лагшин нь үнэмлэхүй бөгөөд юунд ч үл орших болой. Язгуурын хөвгүүнээ, тэр гурван лагшинг мөнх гэж номлосон ч байдаг, мөнх бус гэж номлосон ч байдаг болой. Хувилгааны лагшин нь мэргэн аргаар байдал бүгдэд зоригдол ямар мэт үргэлжид тасралтгүй номын хүрдийг эргүүлдэг тул мөнх хэмээх болой. Түүнийг сууринд болоогүйгээр их зохиол хотол чуулганыг илтэд үзүүлдэггүй тул мөнх бус хэмээх болой. Төгс жаргалангийн лагшин нь тэргүүлшгүй цагаас үргэлжлэл нь үл тасрах бөгөөд бурхан бүгдийн ном хольцоо үгүй учраас огоот барих хийгээд хураахын тул, амьтан барагдашгүй учраас явдал нь ч үл барагдах бөгөөд тиймийн тул мөнх хэмээх болой. Түүнийг ч бас сууринд болгоогүйгээр их зохиол хотол чуулганыг илтэд үл үзүүлэх учраас мөнх бус хэмээх болой. Номын лагшин нь хуран үйлдэхийн ном бус билэг тус тусдаа үгүй үндэс хийгээд суурь болсон тул огторгуй ямар мэт учраас түүнийг мөнх хэмээсэн болой. Язгуурын хөвгүүнээ, нэн үл атгаглах билгүүнээс тусдаа хутагтын билгүүн үгүй болой. Түүнчлэн ямагтын номын мөн чанараас ч илүү явдлын орон үгүй болой. Тэр нь номын түүнчлэн ямагт хийгээд билгүүний түүнчлэн ямагт хийгээд түүнчлэн ямагт тэр хоёрын түүнчлэн ямагт нь нэг бүхэл ч бус, тус тусдаа ч бус учраас тиймийн тул номын

лагшин нь билгүүн нэн арилсан хийгээд тэвчил нэн арилсан хоёрын тул номын лагшин нь нэн арилсан хотол чуулган хэмээх болой.

“Язгуурын хөвгүүнээ, бас энэ гурван лагшны ялгаа нь ч дөрвөн янз бөгөөд хувилгааны лагшин мөн боловч төгс жаргалангийн лагшин биш нь ч байна. Төгс жаргалангийн лагшин мөн боловч хувилгааны лагшин биш нь ч байна. Хувилгааны лагшин мөн хийгээд төгс жаргалангийн лагшин мөн болох нь ч байна. Хувилгааны лагшин биш хийгээд төгс жаргалангийн лагшин биш нь ч байна. Хувилгааны лагшин мөн боловч төгс жаргалангийн лагшин биш нь алин хэмээвээс, Түүнчлэн заларсан бурхад гаслангаас хэтэрсэн боловч ерөөлийн эрхээр ямар мэт хувьд нь тааруулан тус хүргэдэг нь хувилгааны лагшин хэмээх тэр болой. Төгс жаргалангийн лагшин мөн боловч хувилгааны лагшин биш нь алин хэмээвээс, газрын урьдах лагшин болой. Хувилгааны лагшин мөн хийгээд төгс жаргалангийн лагшин мөн тэр нь алин хэмээвээс үлдэгдэл сэлттэй гаслангаас гэтэлсэн лагшин болой. Хувилгааны лагшин ч биш хийгээд төгс жаргалангийн лагшин ч биш тэр нь номын лагшин болой.

“Язгуурын хөвгүүнээ, номын лагшин тэр нь ном хоёр үгүй илтэд болсон болой. Хоёр алин бэ? хэмээвээс номын лагшин түүнд бэлэг чанар хийгээд бэлэг чанарын суурь хоёул үгүй буюу. Буй ч бус, буй бус ч бус. Нэг бүхэл ч бус, тус тусдаа ч бус, тоолох ч бус, тоологдох ч бус, гэгээ ч бус, харанхуй ч бус буюу. Тэр мэт түүнчлэн ямагтын билгүүн дор бэлэг чанар хийгээд бэлэг чанарын суурь ч үгүй буюу. Буй болон буй бус нь ч үл тухайлагдах, бүхэл хийгээд тус тусдаа ч үл тухайлагдах, тоолох ч үл тухайлагдах, тоологдох нь ч үл тухайлагдах, гэгээ хийгээд харанхуй ч үл тухайлагдах буюу. Энэ мэтийн явдлын орон нэн хийгээд билгүүн нэн ариун тэр ялгаа үгүй, завсар үгүй хорих хийгээд мөрийн суурь болсон бөгөөд тиймийн тул номын лагшин тэр нь Түүнчлэн заларсаны элдэв зохиолыг илтэд үзүүлнэ. Язгуурын хөвгүүнээ, энэ лагшин нь уг хийгээд шалтгаан, явдлын орон, орон хийгээд үр дагавар, суурь ямагтад шүтдэг санаанд багташгүй бөгөөд утга түүнийг илтэд мэдвээс лагшин тэр ямагт нь их хөлгөн болой. Тэр ямагт Түүнчлэн заларсаны мөн чанар

болой. Түүнчлэн заларсаны зүрхэн шим бөгөөд лагшин түүн дээр шүтээд сэтгэлийг анхлан үүсгэх хийгээд газрыг огоот судлахын сэтгэл илтэд гарсан бөгөөд газраас эргэн үл буцахын сэтгэл ч илтэд болсон хийгээд нэгэн төрлөөр тулсан сэтгэл хийгээд очир мэтийн самади хийгээд Түүнчлэн заларсаны таалал ч илтэд болж, Түүнчлэн заларсаны дээдийн ном хэмжээлшгүй тоолшгүй бүгд ч илтэд гарах болно. Номын лагшин дор шүтээд санаанд багташгүй их самадийг ч илтэд болгох болно. Номын лагшин энэ дор шүтээд их билгүүн бүгдийг ч үзэх болно. Тийм учраас хоёр лагшин нь самади хийгээд билгүүн дор шүтээд гарсан болой. Номын лагшин энэ нь өөрийн мөн чанар дор шүтсэн учраас мөнх хэмээх болой. Би хэмээх болой. Их самадид шүтсэн учраас амгалан хэмээх болой. Их билгүүнд шүтсэн учраас нэн ариун хэмээх болой. Тиймийн тул Түүнчлэн заларсан үргэлжид амгалан хийгээд нэн ариунд эрхшээлийг олсон хийгээд орших болой. Их самади дор шүтээд, баатарлаг одохын самади тэргүүтэн самади бүгд хийгээд ойр агуулах номын дурьдал тэргүүтэн ойр агуулах дурьдал бүгд, их асрахуй хийгээд их нигүүлсэнгүй хийгээд тогтоол бүгд, илт мэдэл бүгд, авшиг бүгд, тэгш ямагтын ном бүгдийг барих тэргүүтэн бурханы ном бүгд илтэд гарах болно. Их билгүүн дор шүтсэн учраас арван хүч, дөрвөн аймшиг үгүй хийгээд тус тусад нь үнэнхүү ухаарах дөрөв тэргүүтэн хольцоо үгүй ном зуун ная, гайхамшигтай бүгд хийгээд санаанд багташгүй ном бүгдийг илтэд болгох болой. Үлгэрлэвээс хүслийг хангагч их эрдэнэ дор шүтээд элдэв янз хэмжээлшгүй тоолшгүй их эрдэнэ бүгд гарах болой. Түүн шиг их самадийн их эрдэнэ хийгээд их билгүүний их эрдэнэд шүтвээс бурхан бүгдийн дээдийн ном элдэв янз хэмжээлшгүй тоолшгүй илтэд гарах болой.

“Язгуурын хөвгүүнээ, тэр мэт номын лагшин, самади, билгүүн нь билэг бүгдээс үнэмлэхүй хэтэрсэн, билгээр халдаагдаагүй, нэн атга үгүй мөнх ч бус, тасархайтах нь ч бус бөгөөд тэр нь төв мөрийг бүтээх хэмээх болой. Нэн атгагтай мэт үзэгдэвч мөн чанартаа нэн атгаг ч үгүй, гуравт тоолох байгаа боловч бодьтой гуравт ч үгүй болой. Арвижих хийгээд хомсдох үгүй тэр нь зүүд хийгээд илбэ мэт бөгөөд баригдахуун ч бус, баригч ч бус болой. Номын мөн чанарын түүнчлэн ямагт нь нэн гэтэлгэхийн орон мөн бөгөөд үхлийн эзний

явдлын орноос нэн гэтэлсэн, орчлонгийн харанхуйгаас илтэд гэтэлсэн, төрөлхтөн бүгд бээр бүтээж үл чадах эцэст нь хүргэж үл чадах бурхан хийгээд бодьсадва бүгдийн оршиж үйлдэхийн орон болой. Язгуурын хөвгүүнээ, үлгэрлэвээс алин нэгэн алтыг хүсээд орон бүхэнд эрээд алтны хэсгийг олоод хэсэг түүнийг нягт ажиглаад шимийг нь хайлуулах хийгээд ариусгаснаар нэн ариун болох ба алт түүнийг бугуйвч тэргүүтэн чимэг элдэв янзыг сэтгэлчлэн урвуулаад эдлэхнээ ч алтны мөн чанар ямагт нь үл урвах болой.

“Язгуурын хөвгүүнээ, бас язгуурын хөвгүүн юмуу язгуурын охин алин ертөнцийн буяныг эдлэхийг дурласан тэрбээр Түүнчлэн заларсан юмуу Түүнчлэн заларсаны нөхөд тэдгээрийг үзээд ойр шадарлаад түүнд ийн хэмээн айлтгах болой: ‘Ялж төгс нөгчсөөн, буян нь аль, нүгэл нь аль вэ? Үнэмлэхүй бүтээл алинг үйлдсэнээр нэн ариун явдлыг олох болох вэ?’.

Ялж төгс нөгчсөн бурхад хийгээд түүний нөхдүүд тийн хэмээн асуухад ийн буй хэмээн таалаад: “Язгуурын хөвгүүн хийгээд язгуурын охин эдгээр нь дээдийн номыг сонсохыг хүссэн хийгээд нэн судлахыг хүссэн бөгөөд эдгээрт үнэнхүү номыг үзүүлэх болой” хэмээх болой. “Түүнийг сонсоод ч ёсчлон сэтгэлдээ үйлдэх бөгөөд шамдангуйгаар санан бодох төрөх хийгээд хичээсний хүчээр залхуугийн түйтгэр хийгээд хилэнц нүглийн ном бүгдийг арилгаад суртгаалын орон бүгдэд машид бишрэн орших хийгээд сэтгэлийн живэл ба догшролыг арилгаад ‘анхны газарт орох’ болой. Анхны газрын сэтгэлд шүтээд олон амьтны тусад хичээхэд түйтгэрлэхийг тэвчсэнээр ‘хоёрдугаар газарт орох’ болой. Тэр газраас нисванисын түйтгэрийг тэвчээд ‘гуравдугаар газарт орох’ болой. Тэр газраас сэтгэлийг нэн судлахад түйтгэрлэхийг тэвчээд ‘дөрөвдүгээр газарт орох’ болой. Тэр газраас мэргэн аргын түйтгэрийг тэвчээд ‘тавдугаар газарт орох’ болой. Тэр газраас үнэмлэхүй ба янагуухад зорьсон түйтгэрийг тэвчээд ‘зургадугаар газарт орох’ болой. Тэр газраас бэлэг үзэгдэл хийгээд явдалд зорьсон түйтгэрийг тэвчээд ‘долдугаар газарт орох’ болой. Тэр газраас бэлэг үзэгдлийг хорихыг ч үл зорихын түйтгэрийг арилгаад ‘наймдугаар газарт орох’ болой. Тэр газраас бэлэг үзэгдэлд төрөхөд ч үл зорих түйтгэрийг

тэвчээд ‘есдүгээр газарт орох’ болой. Тэр газраас зургадугаар илт мэдлийн түйтгэрийг тэвчээд ‘аравдугаар газарт орох’ болой. Тэр газраас мэдэгдхүүний түйтгэр хийгээд бүхний суурь тийн мэдлийг тэвчсэнээр ‘Түүнчлэн заларсаны газарт орох’ болой.

“Түүнчлэн заларсан бурханы газар нь гурван нэн арилсан бүрдсэн тул машид нэн арилсан хэмээдэг юм. Тэр гурав нь аль вэ? хэмээвээс, энэ мэт юм. Нэгдүгээрт, ‘нисванис нэн арилсан’. Хоёрдугаарт, ‘зовлон нэн арилсан’. Гуравдугаарт, ‘бэлэг үзэгдэл нэн арилсан’ буюу. Ямар мэт сайн алтыг хайлгах хийгээд номхотгоод судлахад тоос ба хирээр дахин халдахгүй хийгээд мөн чанар нь нэн ариуссан алт ямагтад үзэгдэх бөгөөд алтны мөн чанар нэн ариуссан ч үгүй болох үгүй тэр мэт болой. Үлгэрлэвээс булингартай усыг тунгаах хийгээд нэн тунгаагаад усны мөн чанар ямагт тодрох билээ. Ус өөрөө үгүй болох нь ч үгүй болой. Тэр мэт номын лагшин нь ч нисванис хийгээд зовлон элдэв хурсаныг тэвчээд авьяасыг хоцролгүй арилгаад бурханы мөн чанар нэн ариун ямагт үзэгдэх болмой. Бодит чанар нь үгүй болох ямагт нь биш болой. Бас үлгэрлэвээс, огторгуй утаа, үүл, тоос, манан будангаар халхлагдах үгүй болбоос огторгуйн орон тэр нэн ариун болсон болохоос огторгуй тэр үгүй болж байгаа биш болой. Түүн шиг номын лагшин нисванис бүгд барсаны тул нэн ариун хэмээх лагшин үгүй болж байгаа биш болой. Бас үлгэрлэвээс зарим нэгэн нойронд автсан зүүдэнд их усаар автаад бие хийгээд хөл гар нь хүчлээд бие ба сэтгэлийн шамдлаар цаад захад нь хүрч байгааг зүүдлэх болой. Зүүд түүнээс сэрэх хийгээд ус ба наад, цаад эрэг тус тусдаа байгааг үзэх үгүй ч сэтгэл ямагт байхгүй биш болой. Орчлонд нэн атгаглах барагдсан ч оюун нэн ариун бөгөөд ариусан дэлгэрэх нь байхгүй биш болой. Түүн шиг номын мөн чанарт нэн атгаглах бүгд үл төрөх тул нэн арилсан хэмээсэн бөгөөд бурхан бүгдийн үнэмлэхүй лагшин нь байхгүй биш болой.

“Бас Язгуурын хөвгүүнээ, номын лагшин нь нисваанисын түйтгэр нэн арилсанаар төгс жаргалангийн лагшин үзэгдэх болно. Үйлийн түйтгэр нэн арилсанаар хувилгааны лагшин үзэгдэх болно. Билгүүний түйтгэр нэн арилсанаар номын лагшин үзэгдэх болно. Үлгэрлэвээс, хоосон огторгуйд шүтээд гялбаа гарах болой. Гялбаанд

шүтээд гэрэл гарах болой. Тэр мэт номын лагшинд шүтээд төгс жаргалангийн лагшин гарна. Төгс жаргалангийн лагшинд шүтээд хувилгааны лагшин гарах болой. Түүнд мөн чанар нэн арилсаны тул номын лагшин гарах болой. Билгүүн нэн ариуссанаар төгс жаргалангийн лагшин гарах болой. Самади нэн ариуссанаар хувилгааны лагшин гарах болой. Тэр гурав нэн ариуссан нь номын түүнчлэн ямагт хийгээд бусад бишийн түүнчлэн ямагт хийгээд нэгэн амтын түүнчлэн ямагт хийгээд нэн гэтлэхийн түүнчлэн ямагт хийгээд хязгаараас хэтэрсэн түүнчлэн ямагтын тул бурхан бүгд нь лагшин тус тусдаа бус болой. Язгуурын хөвгүүн ба язгуурын охин алин Түүнчлэн заларсан нь миний их багш болой хэмээн өгүүлэх хийгээд бодох тэр нь Түүнчлэн заларсаны лагшин хоёр үгүйг санасан төдийгөөр мэдэх болно.

“Язгуурын хөвгүүн ээ, тиймийн тул явдлын орон бүгдэд үнэмлэхүй бишийн атгагийг огоот арилгаснаар юмс тэдгээрт бэлэг чанар хоёр үгүй хийгээд нэн атгаг үгүй хутагт нарын бүтээн үйлдэх түүн дор ямар адил ямар мэт хоёр үгүйн ёсоор үнэнхүү бүтээснээр тэр адил тэр мэт түйтгэр бүгдийг арилгах болой. Хэдий чинээ түйтгэрийг арилгах болно төдий чинээ номын түүнчлэн ямагт хийгээд түүнчлэн ямагтын билгүүн нэн ариун дээдийг олох болно. Хэдий төдий номын мөн чанар хийгээд түүнчлэн ямагт хийгээд үнэмлэхүй билгүүн нэн ариусах тэр төдий авшиг хотол чуулган бүгдийг ч барих хийгээд огоот гүйцээх болно. Түйтгэр бүгд ч арилах болно. Түйтгэр бүгд нэн арилсан тул тэр нь үнэмлэхүй ямагт хийгээд үнэмлэхүйн билгүүн хийгээд үнэний бэлэг чанарт үзвээс түүнийг үнэмлэхүй хэмээнэ. Хутагтын болгоолт хэмээнэ. Үнэмлэхүй үнэний ёсонд бурханыг үзсэн хэмээх болой. Тэр юуны тулд хэмээвээс ёсчлон хоосон чанарыг үзсэний тул бурхад бээр ч Түүнчлэн заларсан бүгдийг илтэд болгоосон хэмээх болой. Тэр юуны тулд хэмээвээс шарвага хийгээд брадигабуд гурван орноос илтэд гарсан хийгээд үнэмлэхүйн хязгаараас хэтэрсэн учраас хутагт бодгал тэр адил бээр үзэж чадахгүй болой. Тэр эс үзсэн учраас нялхас эгэл төрөлхтөнгүүд бүгд нь ч чанх буруугаар буртаглагдсан нэн буруу атгагласан учраас мэдэж чадахгүй бөгөөд үлгэрлэвээс машид хүч багатай ‘туулайн чинээ тулмаар’ бээр далайг үл гаглах мэт нялхас эгэл төрөлхтний мэдэл

бээр номын түүнчлэн ямагтыг илтэд мэдэж чадахгүй болой. Гэвч Түүнчлэн заларсан нэн атгаг үгүйгээр юм бүгдэд их авшгийг олсон нэн ариун билгүүн гүнзгий лугаа төгөлдөр өөрийн явдлын орон мөн бөгөөд бусад лугаа нийгэд болохгүй болой. Тиймийн тул Ялж төгс нөгчсөн бурхад нь хэмжээлшгүй тоолшгүй галавт бие хийгээд амиа хайрлалгүй хатуужлыг эдэлсэнээр машинд дээд тэнцэшгүй санаанд багташгүй үг хийгээд өгүүлэхийн орноос хэтэрсэн, машинд амирлангуй, аймшиг бүгдээс хагацсан лагшин түүнийг олсон болой.

“Язгуурын хөвгүүн ээ, тэр мэтийн номын хоосон чанарыг мэдэх хийгээд үзэх нь төрөх, хөгшрөх, өвдөх, үхэх үгүй учраас өнө удаан амьдрах болой. Нойронд автах хийгээд өлсөх ба цангах үгүйгээр сэтгэл нь үргэлж самадид оршоод хөдлөх хийгээд цацрах үгүй болой. Алин нэгэн Түүнчлэн заларсанд цацралт сэтгэлийг үүсгэвээс тэрбээр Түүнчлэн заларсаныг үзэж чадахгүй. Алин нэгэн Түүнчлэн заларсан бурхан бээр номлосон энэ нь тустай бөгөөд хэн бээр судар үүнийг сонссон тэр араатан хийгээд хэрцгий бүгд хийгээд аймшигтай төрөлхтөнтэй уулзахгүй болно. Ном үүнийг сонссоны үр нэн боловсрох нь ч барагдахгүй болно. Түүнчлэн заларсан бурхад нь эш үл үзүүлсэн хийгээд орон бүгдэд болгоон таалсаны утгыг үл эрхшээх болой. Орчлон хийгээд нирваанд тусдаа таалахыг үл эрхшээх болой. Түүнчлэн заларсанд үл ажигласан эш үзүүлэхийг үл эрхшээх болой. Ялж төгс нөгчсөн бурхан нь дөрвөн янзын явдлын мөрд билгүүнээр үл барьсан нь үгүй болой. Юм бүгдийг нигүүлсэнгүйгээр үл барьсан нь үгүй болой. Амьтан бүгдэд туслах хийгээд амгалангаар үл барьсан нь үгүй болой. Язгуурын хөвгүүн юмуу язгуурын охин алин нэгэн бээр *Дээд Алтангэрэлт буюу судрын аймаг* үүнийг сонсоод сүжиглэвээс тэрээр, там, адгуус, бирд, асурын оронд хэзээ ч унахгүй болой. Үргэлжид тэнгэр хийгээд хүний оронд төрөөд, доодод үл төрөх хийгээд үргэлжид Ялж төгс нөгчсөн бурханд өргөл хүндлэлийг үйлдэх, дээдийн номыг сонсон барих хийгээд бурханы нэн арилсан оронд ч төрөх болох бөгөөд тэр юуны тулд хэмээвээс тэр хүн маш гүнзгий үүнийг сонссоны тул болой.

“Язгуурын хөвгүүн, язгуурын охин тэдгээрийг түүнчлэн заларсан бээр тэнцэшгүй үнэнхүү төгс бодь сэтгэлээс эргэн үл буцахыг ч

болгоох хийгээд эшийг ч үзүүлэх болой. Алин язгуурын хөвгүүн юмуу язгуурын охин хэн нэгэн бээр машид гүнзгий дээдийн ном энэ чихэнд нь нэг удаа төдий сонсохноо ч тэр нь Түүнчлэн заларсанд эргэлзэх үгүй болно. Дээдийн номыг үл муулна. Хутагт нарт үл хочилно. Төрөлхтөн бүгдийн буяны ёзоор төрөөгүй нь төрж үйлдэнэ. Төрсөн буяны ёзоор нь арвижих хийгээд огоот боловсорч үйлдэх хийгээд ертөнцийн оронд амьтан хэдийчинээ байна тэдгээрт чанадад хүрэх явдлыг үзүүлж үйлдэх болой.”

Тэгээд Огторгуйн зүрхэн хэмээх бодьсатва хийгээд Хурмаст тэнгэр, Эсрэн тэнгэр, Дөрвөн махранз тэргүүтэн тэнгэр нар суудлаасаа босоод, дээдийн хувцсаа мөрөндөө тохоод алгаа хавсран сөгдөөд, машид бишрэнгүйгээр Ялж төгс нөгчсөн бурханы өлмийд оройгоороо мөргөөд Ялж төгс нөгчсөн бурханд ийн хэмээн айлтгав: “*Судрын аймгийн дээд эрхэт хаан буюу Хутагт Алтангэрэлт* үүнийг номлосон орон тэдгээрт тус эрдэм дөрвөн янз эдгээр гарах болно. Дөрөв алин бэ? хэмээвээс, тэр оронд хаад нь эсэргүүцэх дайсан хийгээд өмөг цэргээр үл хөнөөгдөх хийгээд өвчин бүгд арилах хийгээд урт настай өлзий хутаг болоод амгалангаар үнэнхүү номыг үзүүлж үйлдэх болой. Хатан, хүү, охин хийгээд түшмэлүүд нь ч эвтэй хийгээд тэмцэл үгүй таарамжтай, башраар амьдрахыг тэвчсэн учраас хаан бээр өршөөлтэй хийгээд хүндэтгэлтэй болох, буянтай бөгөөд бярман тэргүүтэн дээдийн номыг үйлдэх хийгээд өвчин үгүй, амгалангаар гэнэт үхэх үгүй, буяны чуулган бүгдийг бүтээх хийгээд огоот барих, алин цаг бүхэнд дөрвөн их махбод үл таарах үгүй хийгээд үргэлжид тэнгэр нар сахих, аврах, асрах, нигүүлсэнгүй тэнцүүгээр хорлох үгүй хийгээд хөнөөхийн сэтгэл үгүй, амьтан бүгд чухаг дээд гуравт авралыг одуулан бодьсатвын явдлыг бүтээхээр ерөөл талбих болой. Ялж төгс нөгчсөн бурхаан, бид ч гэсэн үргэлжид судрын аймаг үүнийг дэлгэрүүлж үйлдэхийн тул судрын аймаг үүнийг барьсан бодгал хэн түүний оронд орших хийгээд тусыг хүргэж үйлдэх болой” хэмээн айлтгасанд Ялж төгс нөгчсөн бурхан бээр сайн болой хэмээн зарлиглаад: “Сайн болой, сайн болой! Язгуурын хөвгүүнээ, тэр мэт түүнчлэн та бээр ч судрын

аймгийн хаан дээд үүнийг ертөнцөд өнөд удаан оршуулж үйлдэхийн тул арвижуулах хийгээд дэлгэрүүлж үйлдэхэд хичээхтүн.”

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлгөн судраас*

*”Турван лагшинг ялгаж үзүүлэхүй” хэмээх гуравдугаар бүлэг болой.*

\* \* \*

## *IV бүлэг: Зүүдэнд наминчлахуй*

Тэндээс Ручира-кету (*мон: Үзэсгэлэнгийн охь*) бодьсадвын зүүдэнд, үлгэрлэвээс нарны хот мандал адил машид гэрэлтсэн алтан хэнгэрэг нэгэн үзэгдвэй. Зүг бүхэнд ч Ялж төгс нөгчсөн тоолшгүй, хэмжээлшгүй бурхад их эрдэнийн модны өмнө, их эрдэнийн биндэрьяа ширээнд залрах бөгөөд олон зуун мянган нөхдөөр огоот хүрээлэгдээд, өмнөөс нь хараад номыг үзүүлэхийг үзсэн болой. Тэндээс бас бярман төрөлхтөнгийн дүрст мэт нэгэн хэнгэрэг түүнийг дэлдэхийг үзэж, хэнгэргийн дуу түүнээс үзүүлсэн шүлэг энэ мэтүүд гарсаныг сонссон болой.

Тэгээд бодьсадва Ручира-кету сэрэнгүүтээ үзүүлсэн шүлэг эдгээрийг эргэн санасан болой. Эргэн санаад ч тэр шөнийг барагдангуут Ражагриха их хотоос гараад, олон мянган амьтантай хамт Тасын цогцост уул хаана буй хийгээд Ялж төгс нөгчсөн хаана буй тэнд хүрч очоод, Ялж төгс нөгчсөний өлмийд оройгоороо мөргөөд, Ялж төгс нөгчсөнийг гурван удаа эргээд нэгэн зүгт суувай. Нэгэн зүгт суугаад Ручира-кету бодьсадва бээр Ялж төгс нөгчсөн хаана буй түүнд алгаа хавсран сөгдөөд, зүүдэнд хэнгэргийн дуунаас үзүүлсэн шүлэг алин сонссон тэдгээрийг соёрхвой:

Урьд шөнө, алгасрал үгүй,  
Учирт зүүдийг би зүүдэлсэн нь:  
Үзэсгэлэнт их хэнгэргийг үзэхүй  
Бүгдэд алтан гэрэл нь  
Нар ямар мэт бадарч,  
Бүхэнд нэн тодорхой бөгөөд  
Арван зүгүүдийг гийгүүлэх болов.

Бүхэнд их эрдэнийн модны өмнө  
Биндэрьяа эрдэнийн ширээнүүдэд  
Бурхад нугууд залран оршоод

Булт олон зуун мянган  
Нөхдийн дунд өмнөөс харсаныг үзэв.

Бярман адил дүрт нэг  
Их хэнгэргийг машид дэлдэхийг үзэв;  
Тэрбээр түүнийг дэлдэх лугаа  
Шүлэг номлол эдгээр гарав:

Дээд алтан гэрэлт их хэнгэргийн дуугаар  
Гурван мянган ертөнц, гурван ертөнц энд  
Муу заяаны зовлон, эрлэгийн зовлон хийгээд  
Хоосрохын зовлон, зовлон амирлах болтугай.

Их хэнгэргийн дуу хэл үүгээр  
Энэ ертөнцийн мунхаг бүгд амирлах болтугай.  
Ямар мэт чадагчийн эрхт аймшиггүй, аймшгийг  
амирлуулсан мэт  
Амьтан аймшиггүй, аймшиг лугаа хагацах болтугай.

Ямар мэт орчлонд Бүхнийг болгоогч чадагчийн эрхт  
Ялгуулсан хутагтын эрдэм бүхэн лугаа төгөлдөр тэр мэт,  
Төрөлхтөн бүгд самади, бодийн гишүүний  
Эрдэм төгс хийгээд эрдмийн далай больюу.

Их хэнгэргийн дуу хэл үүгээр,  
Эгэл амьтад эсрэнгийн дуу төгөлдөр болж;  
Бурхан бодийн дээдэд хүрэх болтугай;  
Буян номын хүрдийг эргүүлэх болтугай.

Санаанд багташгүй галавт орших болтугай;  
Амьтанд туслахын тулд номыг ч үзүүлэх болтугай;  
Нисванисийг дарж зовлонг арилгах болтугай;  
Хүсэл тачаал уур мунхагийг амирлуулах болтугай.

Ямарваа амьтад алин муу заяаны газарт оршоод,  
Яс биенд нь галын оч машид бадарсан,  
Тэдгээр их хэнгэргийн дууг сонсох болтугай;  
Тэсэшгүй зовлон бүгд нь машид амирлах болоод,  
“Бурханд мөргөх болой” хэмээх үгийг сонсох болтугай.

Амьтан бүгдээр төрөл олон зуу хийгээд  
Мянган голди насанд төрлөө санах болтугай;  
Чадагчийн эрхтийг үргэлжид санах болтугай;  
Тэдгээрийн агуу их зарлигийг сонсох болтугай.

Их хэнгэргийн дуу хэл үүгээр нь  
Бурхад лугаа үргэлжид нөхөрлөх болж,  
Хилэнцийн үйлүүдийг нэн тэвчих болтугай;  
Хичээж буяны үйлүүдийг үйлдэх болтугай.

Тэнгэр хүн хийгээд амьтан бүгд,  
Тэдгээрийн санаа ба ерөөл алин  
Тэрхүү их хэнгэргийн дуу үүгээр  
Тэдгээрийн горил бүхэн төгсөх болтугай.

Амьтан алин нугууд барагдашгүй тамд төрж,  
Биенд нь галын оч машид бадарсан  
Аврал үгүй гаслант хийгээд огоот тэнүүчилсэн  
Хүмүүн тэдгээр нь машид амирлах болтугай.

Амьтны там бирд хүний ертөнцөд  
Амьтны зовлон барагдашгүй хатуу алин  
Тэрхүү их хэнгэргийн дуу үүгээр  
Тэдгээрийн зовлон бүхэн амирлах болтугай.

Шүтээн үгүй, өмөг садан үгүй хийгээд  
Шүтэх аврал үгүй болсон нугууд,  
Тэдгээрийг аврах хийгээд өмөг садан,  
Тэтгэх шүтээний дээд нь би болох болтугай.

Бурхан хоёр хөлтний дээд нугууд,  
Энэрэл нигүүлсэнгүй төгөлдөрийн таалал,  
Алин арван зүгийн ертөнцөд заларсан  
Авралт бурхад намайг болгоон соёрх.

Би бээр урьд хилэнцийн үйл  
Машид барагдашгүй алин үйлдсэнийг  
Арван хүчийн мэлмийн өмнө би  
Сөгдөөд тэдгээр бүгдийг наминчлан үйлдье.

Эцэг эх нугуудыг үл хүндлэх хийгээд  
Бурхад нугуудыг үл бишрэх хийгээд  
Буян нугуудыг үл барих зэрэг  
Би бээр хилэнц алиныг үйлдсэн;

Баярхах ба омгоор дээрэлхэх хийгээд  
Язгуур ба төгс эдлэлээр омгорхох хийгээд  
Залуугийн омгоор дээрэлхэх зэрэг  
Би бээр хилэнц алиныг үйлдсэн;

Гэмийг санаж, гэмтэйг өгүүлсэн хийгээд  
Гэмтэй үйлдсэн үйл нугууд хийгээд  
Гэмийн зоригдолд үл харсанаар  
Би бээр хилэнц алиныг үйлдсэн;

Эглийн оюунаар орох хийгээд  
Мэдэхгүйн харанхуй санаа болон  
Хилэнцийн нөхрийн эрхэнд орох ба  
Нисванисийг нэн хямруулахын санаа;  
Тоглоом баяслын эрхэнд орох хийгээд  
Гаслан ба өвчний эрхэнд орох болон  
Эдээр үл ханасны гэмээр  
Би бээр хилэнц алиныг үйлдсэн;

Эгэл төрөлхтөнийг хорлох болон  
Атаа, харам бач хийгээд  
Башир хийгээд хоосорсоны гэмээр  
Би бээр хилэнц алиныг үйлдсэн;

Хоосрох зовлон гарахын цагт  
Хүсэл нугуудын аюулын уг хийгээд  
Баян бус ядуу болсоноор  
Би бээр хилэнц алиныг үйлдсэн;

Башир сэтгэлийн эрхэнд болох хийгээд  
Хүсэл хийгээд уурын эрхэнд болох  
Өлсөх цангахаар хохирсоны эрхээр  
Би бээр хилэнц алиныг үйлдсэн;

Бие хийгээд хэл, сэтгэлийн хилэнц  
Гэмт явдал гурван янзыг хурааж,  
Энэ мэтийн ёсоор алин үйлдсэн  
Тэдгээр бүгдийг би наминчилмой.

Бурхан бүгд ба ном бүгд хийгээд  
Түүнчлэн шарвага нугууд дор ч  
Бишрэл байхгүй алин үйлдсэн  
Тэдгээр бүгдийг би наминчилмой.

Бас алин брадигабуд нугууд  
Бодийн сэтгэлтэн нугууд дор ч  
Бишрэл байхгүй үйлдсэн нугууд  
Тэдгээр бүгдийг би наминчилмой.

Дээдийн номыг өгүүлэгч нугууд дор ч  
Бишрэл байхгүйг үйлдсэн хийгээд  
Номд ч бас биширч эс үйлдсэн  
Тэдгээр бүгдийг би наминчилмой.

Би бээр үргэлжид мэдэхгүй учраас  
Дээдийн номыг тэвчсэн хийгээд  
Эцэг эх нугууд дор эс биширсэн  
Тэдгээр бүгдийг би наминчилмой.

Тэнэг хийгээд нялхас хийгээд  
Хүсэл шунал уур мунхаг болон  
Омог дээрэнгүйгээр түйтгэрлэгдэн үйлдсэн  
Тэдгээр бүгдийг би наминчилмой.

Би арван зүгийн ертөнцөд  
Арван хүчтэн бүхнийг тахих болтугай.  
Би бээр арван зүгийн ертөнц бүгдийг  
Зовлон бүхнээс гаргах болтугай

Амьтан санаанд багташгүй бүгдийг  
Арван газар нугуудад байгуулах болтугай.  
Арван газар нугуудад орших болоод ч  
Алин бүгдээр бурхан болох болтугай.

Хэдийг хүртэл зовлонгийн далайгаас  
Тэднийг гэтэлгэн үйлдэж чадахыг хүртэл  
Амьтан нэг бүрийн тулд ч  
Олон галавт хичээх болтугай.

*Дээд Алтангэрэлт* хэмээн нэрийдэх  
Үйл бүгдийг арилган үйлдэгч  
Гүнзгий нугуудыг үзүүлсэн үүнийг  
Амьтан тэдгээр номлох болтугай.

Алин хэн бээр мянган галавт  
Машид барагдашгүй хилэнцийг үйлдсэн,  
Агшин нэгд сайтар наминчилснаар  
Тэдгээр бүгд арилах болно.

Алин бээр үйлийн түйтгэр нугуудыг  
Ашид түргэн үнэнхүү барах  
*Дээд Алтангэрэлт* буян номын  
Наманчилгаа эдгээрээр наминчилснаар  
Их эрдэнэ гарахын орон дээд арав  
Арван газарт орших болтугай.  
Бурханы эрдмийг үзэх болтугай.  
Орчлонгийн далайгаас гэтлэх болтугай.

Бурхан-далай мөрөн хийгээд  
Эрдэм-далай гүнзгий тэр  
Бурханы эрдэм хязгаарлашгүйгээр  
Бүхнийг болгоож төгсгөх болтугай.

Зуун мянган самади хийгээд  
Санаанд багташгүй тогтоолууд ба  
Эрх хүч бодийн гишүүнээр  
Арван хүчийн дээдэд болох болтугай.

Тааллын сэтгэлээр бурхад нугууд  
Надад нэн болгоон соёрх.  
Нигүүлсэнгүй төгөлдөр сэтгэлээр  
Эндүүрлийг машид барин соёрх.

Би бээр зуун галав нугуудад  
Урьд хилэнц алинг үйлдсэн,  
Тиймийн тулд би гаслангийн сэтгэл  
Харамсах хийгээд гаслан айдсаар нэрвэгдэв.

Хилэнцийн үйлнээс айж үйлдсэн  
Сэтгэл минь үргэлжид доодод болов.  
Хаана хийгээд хаана одон үйлдсэн  
Би бээр алинд ч баясах байхгүй.

Бурхан бүгд нигүүлсэнгүй төгөлдөр  
Бүх амьтны аюулыг арилгаснаар  
Эндүүрлийг машид барин соёрх  
Аймшиг нугуудаас намайг гэтэлгэн зохио.

Миний нисванисын үйл нугуудын  
Хирийг Түүнчлэн заларсан бээр арилга.  
Бурхан нугууд бээр намайг  
Нигүүлсэнгүйн усаар угаан соёрх.

Хилэнц бүгдийг наминчилж үйлдье:  
Урьд би бээр алин үйлдсэн ба  
Одоо би бээр хилэнцийг үйлдсэн,  
Тэдгээр бүгдийг би наминчилъя.

Эндүүрч үйлдсэн үйл бүгдийг  
Дахин давтахгүй боомтилж үйлдье.  
Хорлож би бээр алин үйлдсэн  
Хилэнц түүнийг нууж үл үйлдмой.

Биений үйл гурван янз хийгээд  
Хэлний үйл дөрвөн янз болон  
Бас сэтгэлийн үйл гурван янз  
Тэдгээр бүгдийг би наминчилмой.

Аливаа бие ба хэлээр үйлдсэн,  
Сэтгэлээр нэн санасан болон  
Арван үйлүүдийг үйлдсэн нугууд  
Тэдгээр бүгдийг би наминчилмой.

Арван хар нүглийг тэвчээд  
Арван буяныг шүтэж үйлдээд,  
Арван газарт би орших хийгээд  
Арван хүчийн дээдэд болох болтугай.

Миний хилэнцийн үйл алин тэдгээр  
Муу хүсэшгүй үрийг олгогч бөгөөд  
Бурханы мэлмийн өмнө суугаад  
Бүгдийг сайтар наминчлан үйлдмой.

Энэ замбуу тивд алин хэн нугууд  
Өөр ертөнцийн бусад оронд ч  
Аливаа буяны үйлийг үйлдсэн  
Алин бүгдэд даган баясмой.

Бие, хэл, сэтгэлээрээ ч  
Би бээр буян алинг бүтээсэн,  
Миний буяны үндэс түүгээр  
Дээд бодид хүрэх болтугай.

Орчлонд буурах, бадрах эглийн оюунаар  
Машид эс барагдах хилэнц алинг үйлдсэнээ,  
Тэнцэшгүй арван хүчтэний мэлмийн өмнө одоод,  
Тэр бүх хилэнцийг тус тусад нь наминчилъя.  
Төрлийн доройтол, сансарын доройтол хийгээд  
Ертөнцийн доройтол, башир сэтгэлийн доройтол  
Биеийн явдал элдвээр буурсан зэргээр  
Би бээр хилэнц алинг хураасан түүнийг наминчилмой.

Нялхас мунхарч үйлдсэн, нисванисын доройтол ба  
Хилэнцийн нөхөр лугаа уулзсан доройтол хийгээд  
Сансарын доройтол, шуналын доройтол болон  
Уур мунхагийн харанхуйн доройтол хийгээд  
Алжаахын доройтол, цагийн доройтол хийгээд  
Буян бүтээхэд тотгор учруулахын доройтол бүхнийг  
Тэнцэшгүй ялгуусаны өмнө илтэд суугаад  
Тэр бүх хилэнцийг тус тусад нь наминчилж үйлдье.

Алтан өнгөт сүмбэр уул мэт бурхан  
Эрдэмийн далай адилд мөргөх болой.  
Ялгуусан тэдгээр нугуудад авралыг одуулья  
Ялгуусан тэдгээр бүгдэд оройгоор мөргөө.

Хир үгүй алтан өнгөт алтан гэрэлт лагшин,  
Хир үгүй тийн ариун биндэрьяа гишүүн мэлмий,  
Бурхан наран цог алдар гарахын орон  
Нигүүлсэнгүйн гэрэл ариунаар мунхагийн харанхуйг  
арилгагтун.

Гишүүн машид хир үгүй, машид сайн байдалт үзэсгэлэнтэй  
Бурхан наран гишүүн хир үгүй алт адилаар түгсэн;  
Нисванисын галаар энэлсэн сэтгэлтэн бадарсан гал адилд  
Чадагч сарны гэрэл адилаар цэнгүүлэн зохио.

Лагшин найргийн гучин хоёр эрхтэн гишүүн  
үзэсгэлэнтэй;

Үлгэр найргийн сайн гишүүнээр нэн үзэсгэлэнтэй,  
Цог жавхлан, буян бадран мэндэлсэн гэрлэн тороор  
Гурван ертөнцөд харанхуйн дотор нар мэт оршино.

Хир үгүй агуу их өнгө элдэв биндэрьяа,  
Хар, шар, улбар ба мөнгө хийгээд улаан болор мэт гишүүн  
Элдэв янзын гэрлийн тороор сайтар чимэглэгдсэн  
Их чадагч та наран тэр адил үзэсгэлэнтэй.

Гаслангаар хямралдсан, өглөхийн давалгаатай, үхлийн устай  
Зовлонгийн их мөрөн, хоосорч ядуурахын гол мөрөнд унах  
Машид ширүүн, хүчтэй, хатуу уст зовлонгийн далайг  
Амгалан заларсаны нарны олон гэрлээр хатаана.

Гишүүн нь алтны өнгөнд нэн үзэгдэхүй,  
Билэг билгүүн гарахын орон гурван ертөнц бүхний дээд;  
Машид үзэсгэлэнтэй бэлгээр үе гишүүн нь чимэглэгдсэн  
Бурханы бадарсан алтан лагшинд мөргөмүй.

Ямар мэт далайн ус нь хэмжээлшгүй хийгээд  
Ямар мэт газарт хумхийн тоос хязгаарлашгүй ба

Ямар мэт сүмбэр ууланд чулуу хязгааргүй байх  
Ямар мэт огторгуйн хязгаар нь хязгаарлашгүй.  
Түүнчлэн бурханы эрдэм нь хязгаарлашгүй бөгөөд  
Амьтан бүхэн бээр мэдэж үл чадах болой  
Олон галавт бодон санах болохноо ч  
Эрдмийн хязгаарыг мэдэж үл чадах болой.

Усыг үсний үзүүрийн хэмжээ төдий хийгээд  
Чулуу сэлт, уул ба далай сэлтийг нь  
Галваар тоолбоос мэдэж чадах байвч  
Бурханы эрдмийг мэдэж чадахгүй болой.

Эрдэм өнгө, яруу алдар хийгээд  
Буяны билгээр чимэглэгдсэн лагшин,  
Сайн найраг нааяр чимсэн тэр мэт  
Амьтан бүгд тэр адил болох болтугай.

Миний буяны үйл эдгээрээр  
Ертөнцөд удалгүй бурхан болох болтугай.  
Амьганд туслахын тулд номыг ч үзүүлэх болтугай.  
Амьтан олон зовлонд нэрвэгдсэнийг гэтэлгэх болтугай.

Хүчтэй өмөгтэй шулмасаас ялах болтугай.  
Буян номын хүрдийг эргүүлэх болтугай.  
Санаанд багташгүй галавт орших болтугай.  
Рашааны усаар амьтдыг цэнгүүлэх болтугай.

Урьдын бурхад ямар мэт төгсгөсөн адил  
Чанадад хүрэх зургааг тэнцэшгүй төгсгөх болтугай.  
Нисваанисыг дарах хийгээд зовлонг арилгах болтугай.  
Шунал, уур, мунхагийг амирлуулах болтугай.

Зуун төрөл хийгээд голди мянган төрөлд  
Би бээр үргэлжид төрлөө дурьдах болтугай.  
Чадагчийн эрхэтийг үргэлжид санах болтугай.  
Тэдгээрийн зарлигийг агуу их сонсох болтугай.

Хичээж үйлдсэн миний буян эдгээрээр  
Үргэлжид бурхантай нөхөрлөхийг олох болтугай.



Аливаа зовлонг мэдрэхүйгээр [амссанаар] хорлол үл болж  
Амьтан бүгд харваас үзэсгэлэн гуа хийгээд  
Дүрс сайн үзэсгэлэнтэй хийгээд өнөд өлзийт болтугай.  
Үргэлжид амгалан олныг хураах болох болтугай.

Сэтгэлийн идээ ундаа, машид учрал буян нугуудыг  
Санасан даруйд тэдгээр бүхэн бүтэх болтугай.  
Их хэнгэрэг, дамар, хуурын яруу дуу хийгээд  
Бялхсан булаг хийгээд бүрд цөөрөм нугууд  
Алтан лянхуа, удвал цэцгүүд хийгээд  
Идээ ундаа, хувцас, сувд эрдэнэ, эд таваар,  
Алтан чимэг, элдэв янзын эрдэнэ биндэрьяа,  
Тэдгээр бүгд санасан даруйд бүтэх болтугай.

Ертөнц алинд ч зовлонгийн дуу эс гарч  
Амьтан нэг нь ч үл зохилдохыг бүү үзэх болтугай.  
Тэдгээр бүгд өнгө агуу их хийгээд  
Харилцан бие биесээ гийгүүлж үйлдэх болтугай.

Хүний ертөнцөд хотол чуулган алин байгаа  
Тэд бүгд санахуйд төрөх бүгд болж,  
Санаа бүгдийг санасан даруйд ч  
Буяны үр нь огоот гүйцэх болтугай.

Хүж хийгээд цэцгийн эрхэсүүд түрхлэг ба  
Хувцас хийгээд чихмэл болон элдэв цэцэг,  
Галбирваасан модноос гурван цагт буух болтугай.  
Амьгад тэдгээрийг аван баясах болтугай.

Түүнчлэн заларсан хязгааргүй бүгд хийгээд  
Туулсан бодийн сэтгэлтэн шарвага хийгээд  
Тоосноос хагацсан хиргүй сургаал номонд ч  
Арван зүг нугуудад тахилыг үйлдэх болтугай.

Доорд амьтан бүгдийг тэвчих болтугай.  
Чөлөөгүй найм нугуудаас гэтлэх болтугай.  
Дээд чөлөө, учралын хааныг олох болтугай.  
Үргэлжид бурхантай нөхөрлөх болтугай.

Үргэлжид өндөр язгуурт төрөх болтугай.  
Эд таваар хийгээд үр тарианы гуу сангаар баялаг болох  
болтугай.

Яруу алдар хийгээд дүрс өнгө нугуудаар  
Олон галавт сайтар чимэглэгдэх болтугай.

Эмэгтэй бүгд үргэлжид эрэгтэй болоод  
Баатарлаг хийгээд эрэмгий мэргэн болох болтугай.  
Тэд бүгд үргэлжид бодийн тулд явах болж,  
Чанадад хүрэх зургаад хичээх болтугай.

Арван зүг нугуудад эрдэнийн модны эрхэтийн өмнө  
Бурхан амгалан заларч, биндэръяа эрдэнийн  
Ширээнд заларсаныг би үзэх болтугай.  
Ном номлохыг нь ч тэдгээр сонсох болтугай.

Би бээр хилэнцийн үйл нугуудыг бүтээсэн нь  
Аюулт ертөнцөд урьд алиныг бүтээсэн;  
Тэднээс хүсэшгүйн үр алин нугууд гарах  
Тэдгээр бүгд хоцрол үгүй барагдах болтугай.

Аливаа амьтад орчлонд хүлэгдэн оршсон бүгд,  
Орчлонгийн цалам дээсээр чанга хүлэгдсэнийг  
Билгүүний гараар хүлээсийг тайлах болтугай.  
Зовлон нугуудаас гэтлэхийг олох болтугай.

Аливаа амьтад энэхүү замбуу тив хийгээд  
Аливаа ертөнцийн орон бусад нугуудад  
Элдэв буян гүнзгий нугуудыг үйлдсэн  
Тэдгээр бүгдэд даган баясч үйлдмой.

Бие ба хэл, сэтгэлээр бүтээсэн  
Би бээр даган баяссан буян түүгээр  
Миний ерөөл бүтэж, үр нь боловсрох болтугай.  
Тоосноос хагацсан тэнцэшгүй бодийг олох болтугай.

Алин нугууд үргэлжид хирээс хагацсан хийгээд  
Хиргүй сэтгэлээр мөргөж тахисан хийгээд

Огоот зориулан өгүүлсэн үүгээр  
Жаран галавт муу заяаг огоорох болтугай.

Эдгээр шүлгийг өгүүлсэнээр  
Эрэгтэй, эмэгтэй, бярман хааны язгуураас  
Алгаа хавсран суугаад бурханыг магтсан алин  
Нас бүхэндээ төрлөө санах болж,

Эрхтэн гишүүн бүгдээр үнэнхүү чимэглэгдэж,  
Элдэв эрдэм, буян нугуудаар төгөлдөр болж,  
Хүний эрхэт хаан бээр үргэлжид түүнийг тахиад,  
Тэр хийгээд тэдгээр бүгд нь тэр адил болтугай.

Алин нугуудын чихэнд наминчилгаа энэ нь дуурсах болох,  
Тэдгээр нь нэг бурханы дэргэдээс буяныг үйлдсэн биш,  
Хоёр биш, дөрөв биш, тав биш, арав биш,  
Тэр мэт мянган бурханы дэргэдээс буяныг үйлдсэн мөн болой.

Тэр цагт Ялж төгс нөгчсөн бээр шүлэг тэдгээрийг сонсоод бодьсадва Ручира-кету-д ийн хэмээн зарлиглавай: “Сайн болой, сайн болой! Язгуурын хөвгүүн чиний зүүдэнд алтан хэнгэрэгнээс Түүнчлэн заларсаны үнэмлэхүй эрдмийг сайшаасан хийгээд хилэнцийг наминчилсан эдгээрийг алин бээр сонссон тэд бүгд буяны цогц агуу их лугаа төгөлдөр болж, олон төрөлхтөнд туслах хийгээд амгалангаар цэнгүүлэн үйлдэж, түйтгэр бүгдийг арилгах болохыг мэдэж үйлдэхтүн. Энэ мэтийн явдал ялгамжаа төгөлдөр эдгээр бүгд нь урьдын өнгөрсөн цагт Түүнчлэн заларсан нугуудыг магтсан хийгээд агуу их ерөөлийг тавьсны шалтгаан болон Түүнчлэн заларсаны адистэдээр тэдгээрийг сонсох болсон мөн болой” хэмээн зарлиглав. Чингээд хурсан нөхөд тэдгээр бүгдээр Ялж төгс нөгчсөний зарлигийг илтэд магтсан болой.

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлгөн судраас*

*”Зүүдэнд наминчлахуй” хэмээх дөрөвдүгээр бүлэг болой.*

\* \* \*

## *ᠮ бүлэг: Үйлийн түйтгэрийн үргэлжлэлийг таслагч*

Тэгээд Ялж төгс нөгчсөн бурхан Үнэнхүү нэн ялгасан хэмээх нэрт машид гүнзгий дээд болсон самадид оршсон даруйд лагшингийн шар үсний нүх бүрээс нь элдэв янзын өнгөтэй мянга түмэн гэрэл хэмжээлшгүй гарахуйяа, Ганга мөрний элсний тоогоор ч үлгэрлэх ба хэмжин жишиж чадашгүй арван зүгийн бурханы орон бүгд тэр гэрлийн дотор тодрон үзэгдэх болбой. Таван цөвүүн цагийн ертөнцийн орон гэрэл түүгээр гийх болохуйд амьтан тэдгээр нь арван хар нүглийн мөр болон завсаргүй тавыг үйлдсэн ба чухал дээд гурвыг хочлон муулсан, багш болон садан төрөлдөө ачлал багатай, багш хийгээд бяраманд хүндлэл үл үйлдэгч нар болон мөн там, адгуус, бирдийн төрөлд унасан амьтад тэдгээрийн оронд тэр гэрэл бээр хүрэлцсэн даруйд дор бүрнээ жаргалыг амсах болбой.

Алин бээр гэрэл түүнийг үзсэн болон тэр гэрлийн хүчээр бүгд амгалан хийгээд баясгалантай, өнгө ба дүрс сайны дээдийг олсоноор билиг хотол чуулган болж, буян хийгээд билгүүний чуулганаар чимэглэгдсэнээр Түүнчлэн заларсан бурхадыг үзэх болбой. Тэр үед Хурмаст тэнгэрийн хаан олон тэнгэрийн чуулган хийгээд Гангадеви (*Гангын-Лхаму*) тэргүүтэй хурсан нөхөд тэдгээрт билиг болсон гэрэл түүгээр хөтлөгдөж Ялж төгс нөгчсөн бурхан хаана буй тэнд хүрч очоод Ялж төгс нөгчсөн бурханыг гурван удаа эргээд нэгэн зүгт суувай. Тэгээд насан гавьяат Шарипутра суудлаасаа босоод, дээдийн хувцсыг нэгэн мөрөндөө буулгаад, баруун өвдгөө газарт хатгаад, Ялж төгс нөгчсөн хаана буй тэр зүгт алгаа хавсран сөгдөөд Ялж төгс нөгчсөн бурханд ийн хэмээн соёрхвой: “Ялж төгс нөгчсөн бурхаан, язгуурын хөвгүүн буюу язгуурын охин, шарвагын хөлгөнд үнэнхүү оршсон юмуу, брадигабудын хөлгөнд үнэнхүү оршсон, их хөлгөнд үнэнхүү оршсон, амьтан бусдууд ч юмуу тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодийг илтэд гүйцээж бурхан болохыг хүссэнээр үйлийн түйтгэр олныг ямар мэт тус тусад нь наминчилж үйлдэх вэ?”

Ийн хэмээн соёрхсон хийгээд Ялж төгс нөгчсөн бээр насан гавъяат Шарипутрад ийн хэмээн зарлиглавай: “Шарипутра, үүнд язгуурын хөвгүүн буюу язгуурын охин, шарвагын хөлгөнд үнэнхүү оршсон юмуу, брадигабудын хөлгөнд үнэнхүү оршсон, их хөлгөнд үнэнхүү оршсон, амьтан бусдууд ч юмуу тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодийг илтэд гүйцээж бурхан болохыг хүссэнээр өдөр гурав, шөнө гурван удаа дээдийн хувцсыг нэгэн мөрөндөө буулгаад, баруун өвдгөө газарт хатгаад, алгаа хавсраад, үг ийн хэмээнэ: ‘Олон төрөлхийтөнд эмч оточ болж, олон төрөлхийтөнд амгалан ба ертөнцөд нигүүлсэнгүй болон ихэнх төрөлхийтөн, тэнгэр хүмүүсийн тус, эм, амгалангийн тулд Ялж төгс нөгчсөн бурхан алин тэдгээр одоо арван зүгийн ертөнцөд тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодийг илтэд гүйцээж бурхан болоод номын хүрдийг машид эргүүлж, номын хүрдийг машид үзүүлж, номын ёсыг машид барьж, номын өглөгийг машид зохиож, номын зулыг машид бадраан зохиож, номын хурыг машид буулгаж, номын хэнгэргийг машид дэлдэж, номын их хэнгэргийг машид дэлдэж, номын лавайг машид үлээж, номын амин модыг машид босгож, амьтан бүгдийг номын өглөгөөр цэнгүүлэн зохиосон алжаалгүй явдалд орсон Ялж төгс нөгчсөн бурхан тэдгээрт би мөргөх болой.

[Гуравдугаар хэсэг]

‘Ялж төгс нөгчсөн бурхан тахилын орон, мөргөл үйлдэхийн орон хүндэтгэл үйлдэхийн орон, айлдал болсон, мэлмий болсон, гэрч болсон, шалгадаг болсон, айлдал лугаа төгөлдөр, болгоол лугаа төгөлдөр тэдгээрт би тэргүүн хийгээд хэл, сэтгэлээр мөргөх болой.

‘Эхлэл хийгээд төгсгөл үгүй орчлонд эргэлдэхийн цагт би шуналаар нэрвэгдсэн юмуу, уураар нэрвэгдсэн юмуу, мунхагаар нэрвэгдэж бие, хэл, сэтгэлээрээ үйлийн түйтгэр алиныг илтэд хурааж үйлдсэн, бурханд мэдээгүй, номд мэдээгүй, хуврагт мэдээгүй, буян хийгээд нүгэлд мэдээгүй болон Түүнчлэн заларсанаас муу сэтгэлээр цус гаргасан, дээдийн номыг тэвчсэн, хуврагийн хагарлыг үйлдсэн, гэлэн архадыг алсан, эцэг эхийг алсан хийгээд биений гурван янз, хэлний дөрвөн янз, сэтгэлийн гурван янз буюу арван хар нүглийг үйлдсэн, үйлдэхэд оруулсан, үйлдэхэд даган баяссан хийгээд

зарим нэгэн амьтанд ширүүн үгийг өгүүлсэн, хочилсон, жинлүүрт башрыг үйлдсэн, хэмжээнд башрыг үйлдсэнд хийгээд орчлонд зургаан амьтанд эргэхдээ эцэг эхийг үл баясгаж үйлдсэн, бодгалын юмуу, суварганы юмуу, хуврагийн юмуу, дөрвөн зүгийн хуврагийн, аяга тахимлагийн хуврагийн эдийг хулгайлсан хийгээд ямар мэт суртгаалын суурийн хууль нугуудын номхотголтой харшлан үйлдсэн, хамба ба ловон бээр сургасныг үл сонссон, шарвагын хөлгөнд үнэнхүү оршсон юмуу, брадигабудын хөлгөнд үнэнхүү оршсон, их хөлгөнд үнэнхүү оршсон тэрнээс бусад амьтдад яруу бусыг үйлдсэн, зэмлэх, зодох, тэдгээрт хэрцгий хийгээд уурыг үүсгэсэн болон атаа ба хармаас гарсан сэтгэлээр Ялж төгс нөгчсөн бурхадад ширүүн үгийг өгүүлсэн, дээдийн номонд ном биш хэмээн үйлдсэн, ном бусыг дээдийн хэмээн үйлдсэн тэдгээрийг Ялж төгс нөгчсөн бурхан айлдал болсон, мэлмий болсон, гэрч болсон, шалгадаг болсон, айлдал лугаа төгөлдөр, болгоол лугаа төгөлдөр тэдгээрийн мэлмийн өмнө тус тус наминчилмой, гэмшмой, үл нуумой, хойшид үл үйлдмой.

‘Би үйлийн түйтгэр алинаар түйтгэрлэгдээд, амьтны там болон адгуусны төрлийн орон, бирдийн орон, асурын чуулганы дотор одох болох, бурхан ном хуврагийг баясгаж үйлдээгүй, чөлөөгүй нүгүүдэд төрүүлэх үйл түүнийг бие энэ ямагтад нэн боловсруулаад бусдад үл амсах болгогтун. Түүнийг ч Ялж төгс нөгчсөн бурхан айлдал болсон, мэлмий болсон, гэрч болсон, шалгадаг болсон айлдал лугаа төгөлдөр, болгоол лугаа төгөлдөр тэдгээрийн мэлмийн өмнө тус тус наминчилмой, гэмшмой, үл нуумой, хойшид үл үйлдмой.

‘Ямар мэт урьдын бодьсадва махасадва нар урьд бодийн тулд шамдахдаа үйлийн түйтгэр нүгүүдийг тус тусад нь наминчилсан хийгээд үл нуусан түүнчлэн би бээр ч үйлийн түйтгэр тэдгээрийг тус тус наминчилмой, гэмшмой, үл нуумой, хойшид үл үйлдмой. Ямар мэт ирээдүй цагийн бодьсадва, махасадва тэдгээр бодьсадвын явдлаар явахдаа үйлийн түйтгэр нүгүүдийг тус тусад нь наминчлах болох хийгээд үл нуух болох түүнчлэн би бээр ч үйлийн түйтгэр тэдгээрийг тус тус наминчилмой, гэмшмой, үл нуумой, хойшид үл үйлдмой. Ямар мэт одоо цагт арван зүгийн ертөнцөд бодьсадва,

махасадва ихэс нугууд бодийн тулд хичээхдээ үйлийн түйтгэр нүгүүдийг тус тусад нь наминчилсан хийгээд үл нуусан түүнчлэн би бээр ч үйлийн түйтгэр нүгүүд эдгээрийг тус тус наминчилмой, гэмшмой, үл нуумой, хойшид үл үйлдмой. Ямар мэт өнгөрсөн, ирээдүй, одоо гарсан бодьсадва, махасадва нар бодьсавдын явдалд хичээхдээ үйлийн түйтгэр нүгүүдийг тус тусад нь наминчилсан хийгээд тус тусад нь наминчлах хийгээд тус тусад нь наминчлах болох түүнчлэн би бээр ч үйлийн түйтгэр тэдгээрийг тус тус наминчилмой, гэмшмой, үл нуумой, хойшид үл үйлдмой хэмээн өгүүлж үйлдэх болой.

“Шарипутра, тэр адил болбоос, язгуурын хөвгүүн юмуу, язгуурын охин юм бүгдэд түйтгэр үгүй нэн арилсаныг олохыг хүсвээс үүнчлэн үйлийн түйтгэр нүгүүдыг тус тусад нь наминчилж үйлдэх болой. Үл нууж үйлдэх болой, хойшид ч үл үйлдэх болой. Хэн бээр их хүжний мод мэт баялаг эд ихтэй, төгс эдлэл их, шижир алт хийгээд эд таваар олон, машид жаргалтай, их унааг эдэлдэг хааны язгуурт төрөхийг хүссэн тэрбээр ч үүнчлэн үйлийн түйтгэр тэдгээрийг тус тусад нь наминчилж үйлдэх болой. Үл нууж үйлдэх болой, хойшид ч үл үйлдэх болой.

“Хэн бээр их хүжний мод мэт бярмангийн язгуурт хийгээд их хүжний мод мэт баялаг эд ихтэй төгс эдлэл их, шижир алт хийгээд эд таваар олон машид жаргалтай их унааг эдэлдэг гэрийн эзний язгуурт төрөхийг хүсвээс үүнчлэн үйлийн түйтгэр тэдгээрийг тус тусад нь наминчилж үйлдэх болой. Үл нууж үйлдэх болой, хойшид ч үл үйлдэх болой.

“Хэн дөрвөн махранзын язгуурын тэнгэр нүгүүдийн дүр байдалтай ижилхэн төрөхийг хүссэн тэрбээр ч үүнчлэн үйлийн түйтгэр тэдгээрийг тус тусад нь наминчилж үйлдэх болой. Үл нууж үйлдэх болой хойшид ч үл үйлдэх болой. Хэн гучин гурван тэнгэр нүгүүдийн дүр байдалтай ижилхэн төрөхийг хүссэн тэрбээр ч үүнчлэн үйлийн түйтгэр тэдгээрийг тус тусад нь наминчилж үйлдэх болой. Үл нууж үйлдэх болой, хойшид ч үл үйлдэх болой.

“Түүнчлэн хэн тэмцлээс хагацсан, төгс баясгалант, хувилахад баясгалант, бусдын хувилгааныг эрхэнд үйлдэгч, эсрэнгийн язгуур, эсрэнгийн түшмэл, эсрэнгийн бүх нөхөр, их эсрэн, бага гэрэлт, хэмжээлшгүй гэрэлт, тодорхой гэрэлт, бага буянт, хэмжээлшгүй буянт, буян дэлгэрэгч, үүл үгүй, буян төрөх, үр ихт, хуран мэдэл үгүй амьтан, элбэг үзэгдэлт, машинд үзэхүй, их үгүй, энэлэл үгүй, доор бусын (*агнистын*) тэнгэр нарын дүр байдал лугаа ижилхэн төрөхийг хүссэн тэрбээр ч үүнчлэн үйлийн түйтгэр нугуудыг тус тусад нь наминчилж үйлдэх болой. Үл нууж үйлдэх болой, хойшид ч үл үйлдэх болой.

“Хэн дүрс үгүй орны огторгуй хязгааргүй төрөн тухайлахад чухал одогч, тийн мэдэл хязгааргүй төрөн тухайлахад чухал одогч, юу ч үгүйн төрөн тухайлахад чухал одогч, хуран мэдэл үгүй, хуран мэдэл үгүй бусын төрөн тухайлахад чухал одогч тэнгэр нарын дүр байдал лугаа ижилхэн төрөхийг хүссэн тэрбээр ч үүнчлэн үйлийн түйтгэр тэдгээрийг тус тусад нь наминчилж үйлдэх болой. Үл нууж үйлдэх болой, хойшид ч үл үйлдэх болой.

“Хэн үргэлжид оршихын үр, түр нэг эргэн ирэхийн үр, эргэн үл ирэхийн үр, дайснаа дарагч ямагтыг илтэд үйлдэхийг хүссэн тэрбээр ч үүнчлэн үйлийн түйтгэр тэдгээрийг тус тусад нь наминчилж үйлдэх болой. Үл нууж үйлдэх болой, хойшид ч үл үйлдэх болой.

“Хэн гурван ухаан юмуу, илт мэдэл зургаа юмуу, хүч нугууд юмуу, эрхтэн нугууд юмуу, шарвагын чанадад хүрэх юмуу, шарвагын эрх ихэд алдарших юмуу, брадигабудыг илтэд үйлдэхийг хүссэн тэрбээр ч үүнчлэн үйлийн түйтгэр тэдгээрийг тус тусад нь наминчилж үйлдэх болой. Үл нууж үйлдэх болой, хойшид ч үл үйлдэх болой. Хэн бүхнийг болгоогчийн билгүүн, нэн арилсан билгүүн, санаанд багташгүй билгүүн, адил үгүй билгүүн, үнэнхүү төгсгөсөн бурханы билгүүнийг илтэд бүтээхийг хүссэн тэрбээр ч үүнчлэн үйлийн түйтгэр тэдгээрийг тус тусад нь наминчилж үйлдэх болой. Үл нууж үйлдэх болой, хойшид ч үл үйлдэх болой. Тэр юуны тулд вэ? хэмээвээс, Шарипутра, Түүнчлэн заларсан бээр юм бүгд нь шүтэн барилдаж гарсан болой хэмээн зарлигласны тулд бөгөөд уг болон шалтгаан, бусад хийгээд бусдаар өөр нэгэн төрөх болой, өөр нэгэн

хаагдах болой. Түүнд өнгөрсөн юмс алин мөн тэдгээр нь хаагдах, барагдахаас хагацсан нэн болох бөгөөд тэдгээрт ч үйлийн түйтгэр өчүүхэн ч үгүй болой. Одоо хуран үйлдсэн алин мөн тэдгээр ч буй бусаас гарсан бөгөөд тэдгээрт ч үйлийн түйтгэр өчүүхэн ч үгүй болой. Тэр юуны тулд вэ? хэмээвээс, Шарипутра, Түүнчлэн заларсан бээр юм бүгд хоосон, амьтан үгүй, амь үгүй, бодгал үгүй, үл төрсөн, үл хаагдсан, хуран эс үйлдсэн хэмээн зарлигласны тулд болой. Шарипутра, юм бүгд би-гээс гарсан ч би ч байгаа бус болой. Шарипутра, язгуурын хөвгүүн юмуу, язгуурын охин алин нэгэн энэ мэт амьтан үгүй хязгаарын номын ёс үүнд орсон энэ нь үйлийн түйтгэрийн үргэлжлэлийг таслагч хэмээх бөгөөд Шарипутра, энэ нь тус тусад наминчлал болой.”

Тэгээд бас Ялж төгс нөгчсөнд насан гавъяат Шарипутра бээр ийн хэмээн айлтгавай: “Ялж төгс нөгчсөөн, язгуурын хөвгүүн юмуу язгуурын охин шарвагын хөлгөнд үнэнхүү оршсон юмуу, брадигабудын хөлгөнд үнэнхүү оршсон, их хөлгөнд үнэнхүү оршсон, бусад амьтад ч юмуу тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодийг илтэд гүйцээж, бурхан болохыг хүссэнээр ямар мэт буяны ёзоор нугуудад даган баясч үйлдэх вэ?”.

Тийн хэмээн айлтгасан хийгээд Ялж төгс нөгчсөн бээр насан гавъяат Шарипутра-д ийн хэмээн зарлиглавай: “Шарипутра, энд язгуурын хөвгүүн юмуу язгуурын охин бээр өдөр гурван удаа, шөнө гурван удаад дээдийн хувцсыг нэг мөрөндөө буулгаж, баруун өвдгөө газарт хатгаад, алгаа хавсарч үг ийн хэмээнэ: ‘Арван зүгийн ертөнцөд амьтан алин нугууд өглөгөөс гарсан буяны үйл бодитой хийгээд шагшаабадаас гарсан болон бясалгалаас гарсан буяны үйл бодитой, илтэд хуран үйлдсэн тэдгээр бүгдэд ч даган баясахын дээдээр даган баясах болой. Даган баясахын дээд хийгээд эрхэм хийгээд ялгамжаат, машинд, туйл, гайхамшигт, дээд тэнцэшгүй дээр үгүй, адил үгүй тэнцэшгүй лугаа тэнцүүгээр даган баясах болой. Арван зүгийн ертөнцийн оронд алин амьтад өглөгөөс гарсан буяны үйл бодитой хийгээд шагшаабадаас гарсан болон бясалгалаас гарсан буяны үйл бодитой, илтэд хуран үйлдэх болох тэдгээр бүгдэд ч даган баясахын дээдээр даган баясахаас даган баясах тэнцэшгүй лугаа

тэнцүү хүртэлхээр даган баясах болой. Арван зүгийн ертөнцийн оронд алин амьгад өглөгөөс гарсан буяны үйл бодьтой хийгээд шагшаабадаас гарсан болон бясалгалаас гарсан буяны үйл бодьтой илтэд хуран үйлдсэн тэдгээр бүгдэд ч даган баясахын дээдээр даган баясахаас даган баясах тэнцэшгүй лугаа тэнцүү хүртэлхээр даган баясах болой.

‘Бодьсадва нар одоо цагт сэтгэлийг анхлан үүсгэсэн тэдгээрийн анхлан бодид сэтгэл үүсгэсэн лугаа төгөлдөр буяны ёзоор алин байгаа, зуун галваар гарсан бодьсадва нарын буяны цогц алин байгаа, үл төрөхийн номонд тэвчээрийг олсон бодьсадва нарын буяны цогц алин байгаа, эргэн үл буцагч нарын буяны цогц алин байгаа, нэгэн төрлөөр торогч бодьсадва нарын буяны цогц алин байгаа тэдгээр бүгдэд ч даган баясахын дээдээр даган баясахаас даган баясах тэнцэшгүй лугаа тэнцүү хүртэлхээр даган баясах болой. Бодьсадва махасадва тэдгээр урьд бодьсадвын явдалд хичээхдээ чанадад хүрэх зургаад төгөлдөр буяны ёзоор илтэд хураан үйлдсэн тэдгээр бүгдэд ч даган баясахын дээдээр даган баясах болой. Даган баясахын дээд, эрхэм, ялгамжаат, машид, туйл, гайхамшигт, дээд тэнцэшгүй дээр үгүй, адил үгүй тэнцэшгүй лугаа тэнцүүгээр даган баясах болой. Ирээдүй цагийн бодьсадва махасадва тэдгээр бодьсадвын явдалд хичээхдээ чанадад хүрэх зургаад төгөлдөр буяны цогцосыг илтэд хураан үйлдсэн тэдгээр бүгдэд ч даган баясахын дээдээр даган баясах болой. Даган баясахын дээд, эрхэм хийгээд ялгамжаат, машид, туйл, гайхамшигт, дээд тэнцэшгүй дээр үгүй, адил үгүй тэнцэшгүй лугаа тэнцүүгээр даган баясах болой. Бодьсадва, махасадва эдүгээ цагт арван зүгийн ертөнцөд тэдгээр бодьсадвын явдалд хичээхдээ чанадад хүрэх зургаад төгөлдөр буяны цогцосыг илтэд хураан үйлдсэн тэдгээр бүгдэд ч даган баясахын дээдээр даган баясах болой. Даган баясахын дээд, эрхэм хийгээд ялгамжаат, машид, туйл, гайхамшигт, дээд тэнцэшгүй дээр үгүй, адил үгүй тэнцэшгүй лугаа тэнцүүгээр даган баясах болой.

‘Олон төрөлхийтөнд эм, олон төрөлхийтөнд амгалан ба ертөнцөд нигүүлсэнгүй, ихэнх төрөлхийтөн ба тэнгэр, хүмүүсийн тус хийгээд эм, амгалангийн тулд урьдын Түүнчлэн заларсан, дайснаа

дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхан тэдгээр бээр тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодийг илтэд гүйцээж, бурхан болоод номын хүрдийг машид эргүүлж, номын хүрдийг машид үзүүлж, номын ёсыг машид барьж, номын өглөгийг машид зохиож, номын зулыг машид бадраан зохиож, номын хурыг машид буулгаж, номын хэнгэргийг машид дэлдэж, номын их хэнгэргийг машид дэлдэж, номын лавайг машид үлээж, номын амин модыг машид босгож, амьтан бүгдийг номын өглөгөөр цэнгүүлэн зохиосон алжаалгүй явдалд орсон алин байгаа хийгээд түүн дор шарвагын хөлгөнтөн юмуу брадигабудын хөлгөнтөн юмуу, бодьсадвын хөлгөнтөн юмуу, тэрнээс бусад амьтад бээр буяны ёзоорыг үүсгэсэн алин байгаа тэдгээр бүгдэд ч даган баясахын дээдээр даган баясахаас даган баясах тэнцэшгүй лугаа тэнцүү хүртэлхээр даган баясах болой. Олон төрөлхийтөнд эм, олон төрөлхийтөнд амгалан ба ертөнцөд нигүүлсэнгүй, ихэнх төрөлхийтөн ба тэнгэр хүмүүсийн тус хийгээд эм, амгалангийн тулд ирээдүй цагийн Ялж төгс нөгчсөн бурхан тэдгээр тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодийг илтэд гүйцээж, бурхан болоод номын хүрдийг машид эргүүлэх болохыг хүртэлх нугууд алин байгаа хийгээд түүн дор шарвагын хөлгөнтөн юмуу барадигабудын хөлгөнтөн юмуу, бодьсадвын хөлгөнтөн юмуу, тэрнээс бусад амьтад бээр буяны ёзоорыг үүсгэх болох алин байгаа тэдгээр бүгдэд ч даган баясахын дээдээр даган баясахаас даган баясах тэнцэшгүй лугаа тэнцүү хүртэлхээр даган баясах болой. Олон төрөлхийтөнд эм, олон төрөлхийтөнд амгалан ба ертөнцөд нигүүлсэнгүй, ихэнх төрөлхийтөн ба тэнгэр хүмүүсийн тус хийгээд эм, амгалангийн тулд одоо цагт арван зүгийн ертөнцөд Ялж төгс нөгчсөн бурхад тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодийг илтэд гүйцээж, бурхан болоод номын хүрдийг машид эргүүлж, номын хүрдийг машид үзүүлж, номын ёсыг машид барьж, номын өглөгийг машид зохиож, номын зулыг машид бадраан зохиож, номын хурыг машид буулгаж, номын хэнгэргийг машид дэлдэж, номын их хэнгэргийг машид дэлдэж, номын лавайг машид үлээж, номын амин модыг машид босгож, амьтан бүгдийг номын өглөгөөр цэнгүүлэн зохиосон алжаалгүй явдалд орсон алин байгаа хийгээд түүн дор шарвагын хөлгөнтөн юмуу, брадигабудын хөлгөнтөн юмуу, бодьсадвын хөлгөнтөн юмуу,

тэрнээс бусад амьтад бээр буяны ёзоорыг үүсгэсэн алин байгаа тэдгээр бүгдэд ч даган баясахын дээдээр даган баясахаас даган баясах тэнцэшгүй лугаа тэнцүү хүртэлхээр даган баясах болой хэмээн өгүүлж үйлдэх болой.’

“Шарипутра, энэ нь даган баясахын буяны цогц болой. Язгуурын хөвгүүн юмуу, язгуурын охин даган баясахын буяны цогц үүгээр даган баясваас буяны цогц олон тоолшгүй хэмжээлшгүйг үүсгэх болой. Шарипутра, гурван мянган их мянган ертөнцийн орны амьтнаас ертөнцийн орон Ганга мөрний элсний тоотой амьтан хэдийчинээ тэдгээр бүгд дайснаа дарагч, нисванисаа барагч болсонд язгуурын хөвгүүн юмуу, язгуурын охин алин нэгэн бээр тэдгээрт хэдий амьдрахыг хүртэл хувцас, идээ, өвчнийг анагаах эм болон эд зүйлээр хүндэлж үйлдсэнээс алин нэгэн даган баясах үүгээр даган баясваас энэ нь түүнээс ихэд олон тоолшгүй хэмжээлшгүй буянг төрүүлэх болой. Шарипутра, тийм учраас язгуурын хөвгүүн юмуу язгуурын охин тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодийг илтэд гүйцээж бурхан болохыг хүсвээс даган баясах үүгээр даган баясч үйлдээрэй. Эхнэр, эрэгтэйн төрлийг олохыг хүссэн хийгээд эмэгтэй төрлийг солихыг хүссэн бээр ч даган баясах үүгээр даган баясч үйлдээрэй.”

Тийн хэмээн зарлигласан хийгээд Ялж төгс нөгчсөн бурханд насан гавъяат Шарипутра бээр ийн хэмээн айлтгавай: “Ялж төгс нөгчсөөн, ирээдүйн бодьсадва, махасадва нарт хайрлаж үйлдэх хийгээд одоо цагийн бодьсадва нарт сүжгийг үүсгэх, сануулахын номын цогцыг ч соёрхоо” хэмээн айлтгасан хийгээд Ялж төгс нөгчсөн бээр насан гавъяат Шарипутра-д ийн хэмээн зарлиглавай: “Шарипутра, үүн дор язгуурын хөвгүүн юмуу язгуурын охин, шарвагын хөлгөнд үнэнхүү оршсон юмуу, брадигабудын хөлгөнд үнэнхүү оршсон юмуу, их хөлгөнд үнэнхүү оршсон юмуу, бусад амьтад ч болохноо тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодийг илтэд гүйцээж бурхан болохыг хүссэн бээр өдөр, шөнө гурав гурван удаа дээдийн хувцсыг нэг мөрөндөө буулгаж, баруун өвдгөө газарт хатгаад, алгаа хавсраад үг ийн: ‘Одоо цагт арван зүгийн ертөнцийн оронд тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодийг илтэд гүйцээж бурхан болсон тэдгээрт мөргөх болой. Ялж төгс нөгчсөн бурхан тэдгээрт мөргөөд номын хүрдийг машид

эргүүлэхийг сануулсанаар Ялж төгс нөгчсөн бурхан тэдгээр бээр олон төрөлхийтөнд эм, олон төрөлхийтөнд амгалан ба ертөнцөд нигүүлсэнгүй хийгээд ихэнх төрөлхийтөн ба тэнгэр хүмүүсийн тус, эм, амгалангийн тулд номын хүрдийг машид эргүүлэн соёрх, номын хүрдийг машид үзүүлэн соёрх, номын ёсыг машид барин соёрх, номын өглөгийг машид зохион соёрх, номын зулыг машид бадраан зохиож соёрх, номын хурыг буулган соёрх, номын хурыг талбин соёрх, номын хэнгэргийг машид дэлдэн соёрх, номын их хэнгэргийг машид дэлдэн соёрх, номын лавайг машид үлээн соёрх, номын амин модыг машид босгон соёрх' хэмээн өгүүлвэй.

“Шарипутра, бас язгуурын хөвгүүн юмуу, язгуурын охин, шарвагын хөлгөнд үнэнхүү оршсон юмуу, брадигабудын хөлгөнд үнэнхүү оршсон юмуу, их хөлгөнд үнэнхүү оршсон юмуу, бусад амьтад ч болохноо өдөр шөнө гурав, гурван удаа дээдийн хувцсыг нэг мөрөндөө буулгаж, баруун өвдөгөө газарт хатгаад, алгаа хавсраад үг ийн: ‘Одоо цагт арван зүгийн ертөнцийн оронд нас сүүдрийн хуран үйлдлийг орхисон Ялж төгс нөгчсөн бурхан тэдгээрт мөргөх болой. Ялж төгс нөгчсөн бурхан тэдгээрт мөргөөд соёрхлыг талбиснаар Ялж төгс нөгчсөн бурхан тэдгээр бээр олон төрөлхийтөнд эм, олон төрөлхийтөнд амгалан ба ертөнцөд нигүүлсэнгүй, ихэнх төрөлхийтөн ба тэнгэр, хүмүүсийн тус хийгээд эм, амгалангийн тулд номын хүрдийг машид эргүүл, номын зулыг машид бадраан зохио, номын хурыг буулга, номын хурыг талби, номын хэнгэргийг машид дэлд, номын их хэнгэргийг машид дэлд, номын лавайг машид үлээ, номын амин модыг машид босго, номын зулыг тухайлан зохио, амьтан бүгдийг номын өглөгөөр цэнгүүлэн зохио, алжаал үгүй явдалд орох хийгээд түр нэг оршин соёрх. Соёрхолыг талбихын цогц энэ нь ч тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодид огоот зориулаад ямар мэт тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодид огоот зориулсан түүнчлэн үүнийг огоот зориулах’ хэмээн өгүүлж үйлдэх болой.

“Шарипутра, энэ нь соёрхолыг талбихын цогц бөгөөд язгуурын хөвгүүн юмуу, язгуурын охин соёрхолыг талбихын цогц үүгээр соёрхолыг талбиваас, олон тоолшгүй хэмжээлшгүй буяныг үүсгэх болой. Шарипутра, язгуурын хөвгүүн юмуу, язгуурын охин алин

нэгэн бээр гурван мянган их мянган ертөнцийн орон хэдийчинээ тэдгээрийг долоон янзын их эрдэнээр дүүргээд, Түүнчлэн заларсан бурхадад өргөснөөс алин бээр Түүнчлэн заларсан тэдгээрт номын хүрдийг эргүүлэхийг сануулбаас тэр нь түүнээс ихэд олон тоолшгүй хэмжээлшгүй буянг үүсгэх болой. Шарипутра, гурван мянган их мянган ертөнцийн орон бүү хэл Шарипутра, ертөнцийн орон Ганга мөрний элсний тоотой тэнцүү хэдийчинээ тэдгээрийг язгуурын хөвгүүн юмуу, язгуурын охин алин нэгэн бээр долоон янзын их эрдэнээр дүүргээд Түүнчлэн заларсан бурхадад өргөснөөс алин бээр Түүнчлэн заларсан тэдгээрт соёрхолыг талбиваас тэр нь түүнээс ихэд олон тоолшгүй хэмжээлшгүй буянг үүсгэх болой. Тэр юуны тулд хэмээвээс Шарипутра, би бээр урьд бодьсадвын явдалд хичээхдээ Түүнчлэн заларсан бурхадад номын хүрдийг эргүүлэхэд соёрхолыг талбиад буяны ёзоор түүгээр надад хурмаст тэнгэрийн хаан хийгээд тэсэшгүй ертөнцийн эзэн эсрэн бээр Ялж төгс нөгчсөн бурхан олон төрөлхийтөнд эм, олон төрөлхийтөнд амгалан, ертөнцөд нигүүлсэнгүй хийгээд ихэнх төрөлхийтөн, тэнгэр хүмүүсийн тус хийгээд эм, амгалангийн тулд номын хүрдийг машид эргүүлэн соёрх хэмээн номын хүрдийг машид эргүүлэхэд соёрхолыг талбисан болой. Шарипутра, би бээр урьд бодийн тулд явдалд хичээхдээ Түүнчлэн ажирсан нугуудад өнөд оршихыг айлтгаад буяны ёзоор түүгээр аймшиггүй дөрөв, Түүнчлэн ажирсаны арван хүч, бурханы ном хольцоогүй арван найм, тус тус үнэнхүү ухаарсан дөрөв, их асрахуй, их нигүүлсэнгүй, огоот гаслангаас гэтлэхийг олсон бөгөөд миний дээдийн ном ч өнөд удаан орших болсон болой.”

Ийн хэмээн зарлигласан хийгээд Ялж нөгчсөн бурханд насан гавъяат Шарипутра бээр бас ийн хэмээн айлтгавай: “Ялж төгс нөгчсөөн, язгуурын шарвагын хөлгөнд үнэнхүү оршсон юмуу, брадигабудын хөлгөнд үнэнхүү оршсон юмуу, их хөлгөнд үнэнхүү оршсон юмуу, бусад амьтад ч болохноо тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодийг илтэд гүйцээж бурхан болохыг хүссэнээр бүхнийг болгоогч ямагт болж үйлдэхийн тулд буяны ёзоорыг ямар мэт зориулж үйлдэх вэ?”. Тийн хэмээн айлтгасан хийгээд Ялж төгс нөгчсөн бурхан бээр насан гавъяат Шарипутра-д ийн хэмээн зарлиглавай: “Шарипутра, энд язгуурын хөвгүүн юмуу, язгуурын охин, шарвагын хөлгөнд үнэнхүү оршсон

юмуу, брадигабудын хөлгөнд үнэнхүү оршсон, их хөлгөнд үнэнхүү оршсон, бусад амьтад ч юмуу тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодийг илтэд гүйцээж бурхан болохыг хүссэнээр өдөр шөнө гурав, гурван удаа үг ийн: “Эхлэл хийгээд төгсгөл үгүй орчлонд эргэлдэхийн цагт би бээр буяны ёзоор илтэд хураан үйлдэх, бурхан болон ном, хувраг, бодгал, адаглаваас адгуусны төрөлд төрсөн юмуу, бусад амьтанд ч болохноо үмх гурил нэг төдийг хайрлах, хийгээд наминчилсан алин байгаа, соёрхол талбисан алин байгаа, авралыг одуулсан алин байгаа, суртгаалын суурь лугаа төгөлдөр буяны ёзоор алин байгаа, тус тус наминчилсан лугаа төгөлдөр буяны ёзоор алин байгаа, даган баясах лугаа төгөлдөр буяны үйл бодитой алин байгаа, соёрхолыг талбих лугаа төгөлдөр буяны ёзоор алин байгаа, тэдгээр бүгдийг нэгд хурааж хэмжээг нь нийлүүлээд сэтгэлийг номхотгох хийгээд нэн гэтэлгэх хийгээд барих үгүйгээр амьтан бүгдэд хайрлах болой. Ямар мэт буяны ёзоорыг амьтан бүгдэд талбиж үйлдсэн Ялж төгс нөгчсөн бурхад бээр бурханы билгүүн торохыг үл эрхшээсэн бээр ямар мэт болгоосон тэр адилаар би бээр буяны ёзоор түүнийг өгөх бөгөөд амьтан бүгд мутартаа их эрдэнэ төгөлдөр болох болтугай. Огторгуйн гуу хийгээд төгс эдлэл барагдашгүй, буян барагдашгүй, ном барагдашгүй, билгүүн барагдашгүй, самбаа барагдашгүй, тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодийг илтэд гүйцээж бурхан болсон, бүхнийг болгоогчийн билгүүнийг олох болтугай.

Би бээр буяны ёзоор үүнийг амьтан бүгдэд хайрласнаас гарсан буян алин мөн тэдгээр бүгдийг нэгд хурааж хэмжээг нь нийлүүлээд тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодид огоот зориулах болой. Буяны ёзоор үүгээр би хийгээд амьтан бүгд тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодийг илтэд гүйцээж бурхан болох болтугай. Бүхнийг болгоогчийн билгүүнийг ч олох болтугай. Ямар мэт урьдын бодьсадва махасадва тэдгээр бээр бодийн тулд хичээхдээ тэр бүхнийг болгоогч ямагтад болж үйлдэхийн тулд буяны ёзоор нугуудыг огоот зориулсан тэр мэт би бээр ч бүхнийг болгоогч болж үйлдэхийн тулд буяны ёзоор нугуудыг огоот зориулах болой. Буяны ёзоор үүгээр би хийгээд амьтан бүгд тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодийг илтэд гүйцээж бурхан болох болтугай. Бүхнийг болгоогчийн билгүүнийг ч олох болтугай. Ямар мэт ирээдүй цагийн бодьсадва, махасадва тэдгээр

бээр бодийн тулд хичээхдээ бүхнийг болгоогч ямагтад болж үйлдэхийн тулд буяны ёзоорыг огоот зориулах болох тэр мэт би бээр ч бүхнийг болгоогч болж үйлдэхийн тулд буяны ёзоор бүхнээ огоот зориулах болой. Буяны ёзоор үүгээр би хийгээд амьтан бүгд тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодийг илтэд гүйцээж бурхан болох болтугай. Бүхнийг болгоогчийн билгүүнийг ч олох болтугай. Ямар мэт тэр адил болбоос одоо гарсан бодьсадва махасадва тэдгээр бээр бодийн тулд хичээхдээ бүхнийг болгоогч ямагтад болж үйлдэхийн тулд буяны ёзоор бүхнээ огоот зориулсан тэр мэт би бээр ч бүхнийг болгоогч болж үйлдэхийн тулд буяны ёзоор бүгдийг огоот зориулах болой. Буяны ёзоор үүгээр би хийгээд амьтан бүгд тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодийг илтэд гүйцээж бурхан болох болтугай. Бүхнийг болгоогчийн билгүүнийг ч олох болтугай. Ямар мэт Ялж төгс нөгчсөн, түүнчлэн заларсан Шагжамүни тэрбээр бодийн зүрхэнд оршоод, бурханы самади санаанд багташгүй хиргүй машид цагаанд оршоод, хилэнцэт шулмасыг дараад, мэдэж үйлдэх хийгээд харж үйлдэж, бодож үйлдэж, илтэд гүйцээж бурхан болж үйлдэх алин юу болохноо ч тэр бүгд огторгуйн үүр хаяарахын цагт нэгэн агшин лугаа төгөлдөр билгүүнээр рашааныг олоод үхэшгүй явахын мөрийг илтэд гүйцээж бурхан болсон тэр мэт би хийгээд амьтан бүгд ч тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодийг илтэд гүйцээж бурхан болох болтугай. Бүхнийг болгоогчийн билгүүнийг ч олох болтугай. Ямар мэт Ялж төгс нөгчсөн, Түүнчлэн заларсан Амитаба (*түвд: Одбагмэд*), Одчог, Одгэ, Пунаяба (*түвд: Соднамод*), Акчобья (*түвд: Минтүгва*), Синха (*түвд: Сэнгэ*), Шата-рашми (*түвд: Одсэржава*), Одсэртова, Рашмижала (*түвд: Оджидаважан*), Ратна-арчи (*түвд: Ринчэндопро*), Жяоти-жвалана (*түвд: Одвар*), Нанвижалбо, Вибушита (*түвд: Шиндүжан*), Ратнакету (*түвд: Ринчэндог*), Дарма-дважа (*түвд: Чойжижанцан*), Уттаманга (*түвд: Янлагчог*) хэмээх Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгссөн бурхан тэдгээр хийгээд Ялж төгс нөгчсөн бурхан бусад бээр ч тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодийг илтэд гүйцээж бурхан болоод юу төдий олон төрөлхийтөнд эм, олон төрөлхийтөнд амгалан, ертөнцөд нигүүлсэнгүй, ихэнх төрөлхийтөн тэнгэр хүмүүсийн тус хийгээд эм, амгалангийн тулд номын хүрдийг машид эргүүлсэн тэр мэт би

хийгээд амьтан бүгд ч тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодийг илтэд гүйцээж бурхан болоод олон төрөлхийтөнд эм, олон төрөлхийтөнд амгалан, ертөнцөд нигүүлсэнгүй, ихэнх төрөлхийтөн тэнгэр хүмүүсийн тус хийгээд эм, амгалангийн тулд номын хүрдийг машид эргүүлэх болтугай’ хэмээн өгүүлж үйлдээрэй.

“Шарипутра, энэ нь огоот зориулахын цогц бөгөөд буяны цогц өмнөх бээр огоот зориулахын цогц үүний зууны хувьд ч ойртон одохгүй бөгөөд үлгэрийг хүртэл ч барагдашгүй болой. Шарипутра, язгуурын хөвгүүн юмуу, язгуурын охин алин нэгэн судар үүнийг авах юмуу бүхнийг багтааж үйлдэх юмуу, барих юмуу, унших юмуу бусдад ч агуу их үнэнхүү машид үзүүлбээс тэр нь буяны цогц түүнээс ихэд олон тоолшгүй хэмжээлшгүйг үүсгэх болой. Шарипутра, гурван мянган их мянган ертөнцийн орны амьтан хэдий чинээ байгаа тэдгээр бүгд урд, хойд үгүй хүний биеийг олох болох бөгөөд урд хойд үгүй хүний биеийг олоод ч өөрөө бодийг олох болоод тэдгээрт язгуурын хөвгүүн юмуу, язгуурын охин алин нэгэн бээр хүндлэх, тахиж үйлдэхийн тулд хувцас ба идээ, дэвсгэр, өвчнийг анагаах эм, эд зүйлээр хэдий амьдрахыг хүртэл өргөж шүтэж үйлдээд, хүндлэн үйлдэхэд түр нэг төдий ч их эрдэнийн цогц сүмбэр уулын чинээ их эрдэнэсийг огоот баран үйлдэхэд огоот гаслангаас гэтлэхнээ ч тэдгээрийн суварга, долоон янзын их эрдэнэ бөгөөд алт, мөнгө, сувд, биндэрьяа, болор, цагаан шүр, улаан сувднаас өргөөшөө арван бээрийг бүтээж тэдгээрт шүхэр хийгээд жанцан, дуаз, нарийн дузаар тахиж үйлдвээс Шарипутра, үүнийг юу гэж бодож байна, язгуурын хөвгүүн юмуу язгуурын охин суурь түүнээс буян олныг үүсгэх үү?”

Шарипутра: “Ялж төгс нөгчсөн бурхан минь олон буй заа, Түүнчлэн заларсан минь олон болой.” хэмээн айлтгав. Зарлиглав: “Шарипутра, язгуурын хөвгүүн юмуу, язгуурын охин алин судар үүнийг барих юмуу, бүгдийг багтааж үйлдэх юмуу, уншлаганд үйлдэх юмуу уншиж, олон төрөлхтөнд үнэнхүү машид үзүүлж, тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодид ерөөл тавибаас тэр нь түүнээс буян их олныг үүсгэх болой. Буяны цогц өмнөх бээр буяны цогц үүний зууны хувьд ч ойртон очихгүй бөгөөд үлгэрийг хүртэл

ч тэсэшгүй болой. Тэр юуны тулд вэ? хэмээвээс, Шарипутра, энэ мэт язгуурын хөвгүүн юмуу, язгуурын охин энэхүү бүтээлд оршоод арван зүгийн ертөнцийн орны Ялж төгс нөгчсөн бурхадад номын хүрдийг эргүүлэхийг сануулсаны тулд болой. Шарипутра, өглөгүүдийн дотроос энэ мэт номын өглөг нь дээд хэмээн би бээр номлосон билээ.”

Тэгээд нөхдийн дундаас түмэн амьтан суудлаасаа босоод дээдийн хувцсыг нэгэн мөрөндөө буулгаад баруун өвдгөө газарт хатгаад Ялж төгс нөгчсөн бурхан хаана буй тэр зүгт алгаа хавсран сөгдөөд Ялж төгс нөгчсөн бурханд ийн хэмээн айлтгавай: “Ялж төгс нөгчсөн бурхаан, бид нар судар үүнийг шүтэж үйлдье. Бусдад ч агуу ихээр үнэнхүү үзүүлж үйлдье. Бүтээлд оршиж үйлдье. Тэр юуны тулд вэ? хэмээвээс, Ялж төгс нөгчсөн бурхаан, бид нар нь буяны ном тэдгээрээр тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодийг илтэд гүйцээж бурхан болохыг хүссэн юм”. Тэгээд тэнгэрийн хаан хурмаст бээр Ялж төгс нөгчсөн бурхан хийгээд номын тийн тоо үүнд тэнгэрийн цэцэг мандарваагаар илтэд тахивай. Илтэд тахиад ч үг ийн хэмээн Ялж төгс нөгчсөн бурхаан, номын тийн тоо энэ нь бодьсатва нарын буяны үндсийг бүтээх хийгээд үйлийн түйтгэрийн үргэлжлэлийг таслахын эрхэм үйл байна.”

Ялж төгс нөгчсөн бээр зарлиглавай: “Тэр тийм болой. Каушика, тэр тийм бөгөөд тэр юуны тулд хэмээвээс, Тэнгэрийн хаанаа, би бээр илтэд мэдэх бөгөөд эндээс тоолшгүйгээс ч их тоолшгүй галав болоход Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхан Маха-арчи-сканда (*Их гэрлийн цогц*) хэмээгч ухаан хийгээд өлмий төгөлдөр, амгалан заларсан, ертөнцийг болгоосон, төрөлхийтнийг номхотгохын амыг жолоодогч, тэнцэшгүй тэнгэр хийгээд хүмүүсийн багш Ялж төгс нөгчсөн бурхан ертөнцөд гарах болно. Тэнгэрийн хаанаа, Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхан Маха-арчи-сканда түүний нас сүүдрийн хэмжээ нь жаран голди жил хүрэх болно. Түүний шарвагын анхдугаар чуулган нь буман голди байх бөгөөд бүгд дайснаа дарсан, нисванисыг барсан ямагт байна. Түүний шарвагын хоёрдугаар чуулган нь зуун голди ерэн найман мянга байх бөгөөд бүгд дайснаа дарсан, нисванисыг

барсан ямагт байх болой. Түүний шарвагын гуравдугаар чуулган нь зуун голди ерэн есөн мянга байх бөгөөд бүгд дайснаа дарсан, нисванисыг барсан ямагт байх болой.

“Тэнгэрийн хаанаа, тэндээс Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхан Маха-арчи-сканда тэр тэнгэр сэлтийн ертөнц хийгээд эсрэн сэлт ба буяныг судлаач бярман сэлтийн төрөлхийтөн бүгдийн тусын тулд явах болой. Тэнгэрийн хаанаа, тэр цагт Гангадеви (*Гангын лхамо*) гэгч нэгэн эхнэр хурсан нөхөд тэдгээрийн дотор багтаж суусан тэрбээр номын тийн тоо үүнийг Ялж төгс нөгчсөн, түүнчлэн заларсан Маха-арчи-сканда-гаас илтэд сонсож дотроо багтааж аваад олон төрөлхийтөнд үнэнхүү номлосон бөгөөд тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодид үнэнхүү орших болов. Тэгээд тэр үхэн егүүдээд эхнэрийн биеийг тэвчиж, эрэгтэй төрлийг олоод, үргэлжид тэнгэр хүмүүсийн дотор төрөөд найман түм дөрвөн мянган удаа загарвардын хаанд төрөөд Түүнчлэн заларсан Ратна-арчи (*Их эрдэнийн гэрэл цацруулагч*) хэмээгч болов.

Каушика эндээс зүүн зүгт бурханы орон зуун мянган голдид ном номлож байгааг би бээр одоо ч харж байна. Каушика, хэн Ялж төгс нөгчсөн, түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхан Ратна-арчи түүний нэрийг сонссон тэдгээр бүгд магадтай огоот газлангаас гэтлэх болно. Бүсгүй алин нэгэн бээр Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхан Ратна-арчи түүний нэрийг сонсох юмуу үхэхийн цагт илтэд үйлдвээс тэр нь түүний эмэгтэй төрлийн эцсийнх мөн болой. Язгуурын хөвгүүнээ, *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн хаан* үүний тус эрдэм элдэв янз гарах болох бөгөөд бодийн буяны ном огоот дэлгэрэх болох бөгөөд үйлийн түйтгэрийн үргэлжлэл бүхэн тасрах болох болой. Бас гэлэн буюу гэлэнмаа буюу гэнэн буюу гэнэнмаа алин нэг бээр *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн хаан* үүнийг номлох хийгээд үзүүлэх орон ба эргэн тойронд тус эрдэм энэ дөрвөн янз гарах болно. Дөрөв алин бэ? хэмээвээс, Тэр орны хаан өвчин үгүй хийгээд хорлол бүгдээс хагацах болох ба нас урт, барцад гарахгүй хийгээд дайсан ба чанадын цэргийн чуулганаар дарагдахгүй болох хийгээд амгалан амьдарч дээдийн номыг огоот дэлгэрүүлж үйлдэх

тэр нь хүний хаан түүнд хурмаст эсрэн ертөнцийг тэтгэгч дөрөв ягчисын эзэн тэргүүтэн бээр огоот сахисны тулд болой.”

Тэгээд Ялж төгс нөгчсөн бээр тэнгэрийн нөхөд тэдгээрт: “Язгуурын хөвгүүдээ, тэр, тэр адил мөн үү” хэмээн зарлигласан хийгээд Хурмаст хийгээд эсрэн тэргүүтэн хэмжээлшгүй нөхөд тэдгээр тус тусдаа үг ийн хэмээн айлтгавай: “Тэр тийм байна. Ялж төгс нөгчсөн бурхаан, орон алинд судрын аймгийн хаан үүнийг унших хийгээд уншлага ба үзүүлсэн түүний хаан хийгээд орон нутаг тэнд оршоод, түүнд бид нар бээр үргэлжид сахиж, хамт оршиж үйлдээд хаан түүний чанадын дайсан хийгээд хорлол барцад өвчин гаслан тэргүүтэн бүгдийг үгүй болгож үйлдэх болой. Урт нас, амгалан, өлзий хутаг төгөлдөр хийгээд санаа бүгдийг бүтээх учраас үргэлжид баясгалант сэтгэлийг ч үйлдэх болой. Хааны нөхөд түүний цэргүүд ч баатарлаг хийгээд эрэмгий болно”. Тийн хэмээн айлтгасан хийгээд Ялж төгс нөгчсөн бурхан бээр сайн болой хэмээн зарлиглаад “Сайн болой, сайн болой! Язгуурын хөвгүүдээ, ямар мэт өгүүлсэн тэр мэт бүтэх болтугай. Хаан тэр номчлон явсанаар түүний албат нар ч хаан шигээ номчлон явах болно. Түүнд чиний хүч хийгээд өнгө хотол чуулганаар эзлэгдэх хийгээд тус дээдээр орших хийгээд нөхөд тэргүүтний гэрэлтүүлж үйлдэгтүн. Тэгээд хурмаст хийгээд эсрэн тэргүүтэн бээр ч Ялж төгс нөгчсөн бээр ямар мэт зарлигласны дагуу үйлдэх болой” хэмээн айлтгавай.

Тэгээд бас Ялж төгс нөгчсөн бээр зарлиглав: “Алин судрын аймгийн хаан үүнийг заах хийгээд дэлгэрүүлж үйлдсэн орон улс тэнд хааны түшмэд нарт дөрвөн янзын тус эрдэм энэ гарах болно. Дөрөв алин бэ? Нэг нэгэндээ бишрэлтэй хийгээд садангийн сэтгэлтэй болох ба үргэлжид хаан бээр зөвшөөрөх хийгээд буяныг судлаач ба бярман бага хаад тэргүүтэн бээр ариунд итгэмжлэх хийгээд дээдийн номыг хүсэж ашиг хонжоо алдар нэрийг үл эрсэнээр их алдар нь зүг бүхэнд дэлгэрэх хийгээд бүгдээр магтаж, урт настай амгаланг эдлэх болох эдгээр дөрөв болой. Бас дээдийн ном үүнийг үзүүлсэн орон түүний буяныг судлаач ба бярман нарт дөрвөн янзын тус эрдэм энэ гарах болно. Дөрөв алин бэ? Хувцас, бинаваад, дэвсгэр, эм тэргүүтнээр үл хоосрох болно. Тэдгээр бүгд ч үзэх, уншихын санаагаар сэтгэл

нь амгалантай болно. Уул болон ой цэцэрлэг тэргүүтэнд оршихноо ч амгалан суух болно. Алин санаж үйлдсэн санаа түүнийгээ огоот гүйцээх болох эдгээр дөрөв болой. Бас судар үүнийг уншсан орон түүний төрөлхтөн тэдгээр өвчин үгүй ба амгалан арвидаж, таваар ба эд зүйл, их эрдэнэ тэргүүтэн бүтээхэд түргэн бүтэх хийгээд буян арвижих тэргүүтэн зэрэг тус эрдэм тэдгээр нь төгөлдөр болох болой”.

Тэгээд Хурмаст ба Эсрэн, дөрвөн Махаранз тэргүүтэн нөхөд тэдгээр бээр ийн хэмээн айлтгав: “Ялж төгс нөгчсөн бурхан минь ээ, гүнзгий утгыг үзүүлсэн судрын аймаг үүнийг хэдий чинээ ертөнцөд оршихыг хүртэл бодийн зүгийн ном болох гучин долоон эрдмүүд ч орших болно. Судрын аймаг энэ хэзээ үл орших болох тэр цагт дээдийн ном бусад ч үгүй болох юмуу?” хэмээн айлтгасанд Ялж төгс нөгчсөн бурхан бээр зарлиглав: “Тэр тийм юм. Язгуурын хөвгүүдээ, тийм учраас та нар *Дээд Алтангэрэлт судар* үүнээс адаглаад нэг үг юмуу, нэг шүлэг ч юмуу, нэг бүлэг ч юмуу, судрыг бүтнээр нь ч юмуу үнэнхүү уншиж үйлд, цээжилж үйлд, санаж үйлд, огоот бүтээж үйлдээрэй. Олон амьтны ашдын хэрэг хийгээд тус, амгалангийн тулд бүхэнд номлох хийгээд дэлгэрүүлж үйлдвээс тэр нь буяны цогц хэмжээлшгүй төгөлдөр болно” хэмээн зарлигласан хийгээд Ялж төгс нөгчсөн бурханы зарлигийг илтэд магтвай.

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлгөн судраас*

*“Үйлийн түйтгэрийн үргэлжлэлийг таслагч”  
хэмээх тавдулаар бүлэг болой.*

\* \* \*

[Дөрөвдүгээр хэсэг]

## *VI бүлэг: Тазрын нэн тэтгэлч*

Тэгээд Ачяая-мати (*мон: Барагдашигүй Оюунт*) бодьсадва махасадва суудлаасаа босоод, дээдийн хувцсыг нэг мөрөндөө буулгаад, баруун өвдгөө газарт хатгаад, Ялж төгс нөгчсөн бурхан хаана буй тэр зүгт алгаа хавсран сөгдөөд, Ялж төгс нөгчсөн бурханд элдэв янзын их эрдэнийн цэцгэн шүхэр ба цэцгийн чихмэлээр тахиад, Ялж төгс нөгчсөн бурханд ийн хэмээн айлтгав: “Ялж төгс нөгчсөн бурхаан, Бодь сэтгэлтэн бодь сэтгэлийг хэрхэн үйлдэх вэ? Ялж төгс нөгчсөөн, юу төдий үйлдвээс бодьсадва бодийн сэтгэл төгөлдөр болох вэ? Ялж төгс нөгчсөн бурхаан, бодийн сэтгэл гэж юу байна? Ялж төгс нөгчсөн бурхаан, бодь хутагт зорих буюу бодьсадвад зорих нь үгүй. Зорих нь ч үгүй, зоригдох нь ч үл болох болой. Бодиос буцлаа ч бодь сэтгэл үл тухайлагдах буюу. Бодь нь өгүүлж болшгүй, сэтгэл нь дүрс үгүй, үзүүлж болшгүй, торж тулах үгүй, нэн мэдрэгдэх үгүй хийгээд бодьсадва ч үл тухайлагдах болвоос, Ялж төгс нөгчсөн бурхаан, яаж эдгээр номын утгыг мэдэж үйлдэх юм бэ?”

Ялж төгс нөгчсөн бурхан бээр зарлиглав: “Язгуурын хөвгүүнээ, энд бодь нь дохио юмуу, нэр юмуу, томёололд үл зоригдох хийгээд бодиос тусдаа бодийн сэтгэл ч үл зоригдох дор, бодь нь өгүүлж болшгүй сэтгэл нь дүрс үгүй, үзүүлж болшгүй, торж тулах үгүй, нэн мэдрэх үгүй хийгээд сэтгэлтэн ч үгүй болой. Тэр юуны тулд хэмээвээс бодь нь өгүүлшгүй бөгөөд бодь ямар адил сэтгэл нь ч тийм болой. Сэтгэл ямар адил бодь ч тийм болой. Бодь хийгээд сэтгэл ямар адил сэтгэлтэн ч тийм болой. Сэтгэлтэн та нар ямар адил өнгөрсөн ба ирээдүй хийгээд эдүгээ цагийн юм бүгд ч тийм болой. Язгуурын хөвгүүнээ, тийм болохоор бодьсадва, махасадва нар бодьсадвын нэрийг олсон юм. Юм бүгдийг даган одсон сэтгэл тэр нь бодийн сэтгэл хэмээх болой. Бодь нь өнгөрсөн ба ирээдүй хийгээд эдүгээ гарсан ч биш бөгөөд сэтгэл ч тийм болой. Юм бүгд үл

зоригдох тул энд юу ч олдохгүй бөгөөд бодь ч үгүй, бодид нэрийдэх нь ч үгүй, амьтан ч үгүй, амьтанд нэрийдэх нь ч үгүй. Шарвага ч үгүй, шарвагад нэрийдэх нь ч үгүй, брадигабуд ч үгүй, брадигабудад нэрийдэх нь ч үгүй, бодьсатва ч үгүй, бодьсатвад нэрийдэх нь ч үгүй, бурхан ч үгүй, бурханд нэрийдэх нь ч үгүй, хуран үйлдсэн ч үгүй, хуран үйлдэхэд нэрийдсэн ч үгүй, хуран эс үйлдсэн ч үгүй, хуран эс үйлдэхэд нэрийдэх нь ч үл зоригдох, зоригдох нь үл болох болой.”

“Язгуурын хөвгүүнээ, гэвч үлгэрлэвээс Сүмбэр уулын ёсонд буяны ёсоор бүгдээр, ‘үнэнхүү хутагтын анхны сэтгэл’ төрөх бөгөөд түүний уг шалтгаан нь өглөгийн чанадад хүрэх юм. Хоёрдугаар сэтгэлийг үүсгэх нь юм бүгдийн үйлдвэрийн орны ёсоор газар мэт үзэх бөгөөд түүний уг шалтгаан нь шагшаабадын чанадад хүрэх юм. Гуравдугаар сэтгэлийг үүсгэх нь аймшиг үгүй, жигээрэмших үгүй, эмээх үгүйн ёсоор гөрөөсний хаан зогдорт арслангийн хүч мэт үзэх бөгөөд түүний уг шалтгаан нь тэвчээрийн чанадад хүрэх болой. Дөрөвдүгээр сэтгэлийг үүсгэх нь эргэн үл буцахын ёсоор шунал үгүй тэнгэрийн хөвгүүний хүч хийгээд чадал, шударга, хичээл, номхотгол мэт үзэх бөгөөд түүний уг шалтгаан нь хичээлийн чанадад хүрэх болой. Тавдугаар сэтгэлийг үүсгэх нь буянаар ханан үл мэдэхийн ёсоор элдэв янзын буянаар үнэнхүү үлэмж мэт үзэх бөгөөд түүний уг шалтгаан нь дияаны чанадад хүрэх юм. Зургадугаар сэтгэлийг үүсгэх нь шөнийн түнэр харанхуйг арилгахын ёсоор нарны хот мандлын тодорхой гэрэл мэт үзэх бөгөөд түүний уг шалтгаан нь билгүүний чанадад хүрэх юм. Долдугаар сэтгэлийг үүсгэх нь сартваахь их сангаар баялаг мэт орчлонгийн бөглүү тосгоноос гэтлэхийн ёсоор санаа бүгдийг огоот гүйцээж үйлдсэнээр түүн дор сайтар чимэг мэт үзэх бөгөөд түүний уг шалтгаан нь мэргэн аргын чанадад хүрэх юм. Наймдугаар сэтгэлийг үүсгэх нь шинийн сарны хот мандал нэн ариуны үлгэрийн ёсоор түйтгэр бүгдийг нэн ариуссаныг огоот гүйцээж үйлдсэн мэт үзэх бөгөөд түүний уг шалтгаан нь ерөөлийн чанадад хүрэх болой. Есдүгээр сэтгэлийг үүсгэх нь огоот ариун бурханы орны эрдмийн чимгийг байгуулсан бүгдийн хот мандалын ёсоор санаа бүгдийг огоот гүйцээж үйлдэх мэтэд үзэх бөгөөд түүний уг шалтгаан нь хүчний чанадад хүрэх

болой. Аравдугаар сэтгэлийг үүсгэх нь эрдэм хийгээд билгүүн ба юм бүгдэд эрхэнд урвуулах авшгийг хүртээхийг олох учраас хүрдээр орчуулагчийн билигийн үлгэрийн ёсоор огторгуй лугаа адил мэтэд үзэх бөгөөд түүний уг шалтгаан нь билиг билгүүний чанадад хүрэх болой. Язгуурын хөвгүүнээ, бодьсатва нарын сэтгэлийг үүсгэх нь эдгээр арав мөн бөгөөд эдгээрт төгөлдөр учраас бодьсатва хэмээн нэрийдсэн юм. Үнэмлэхүй утгандаа ийнхүү бодь ч үгүй, бодьсатва ч үгүй, бодийн сэтгэл ч үгүй болой.”

“Язгуурын хөвгүүнээ, тийнхүү бодьсатва нарын өглөгийн чанадад хүрэхийн өмнө одуулах арван янзын ном буй. Арав алин бэ? хэмээвээс, энэ мэт буюу. Өмнө одуулах сүжгийн эрхтэн, өмнө одуулах санаа, өмнө одуулах үлэмжийн санаа, өмнө одуулах чанадад хүрэхүй, өмнө одуулах их асрахуй, өмнө одуулах их нигүүлсэхүй, өмнө одуулах амьтны шүтээн, өмнө одуулах хураангуй зүйл, өмнө одуулах бурханы номын хүсэл, өмнө одуулах бүхнийг болгоогчийн билиг билгүүний хүсэл эдгээр бөлгөө. Язгуурын хөвгүүнээ! Энэ нь бодьсатва нарын өглөгийн чанадад хүрэхүй үүний өмнө одуулах арван янзын ном болой.”

“Язгуурын хөвгүүнээ, тийнхүү бодьсатва нарын шагшаабадын чанадад хүрэхийн өмнө одуулах арван янзын ном байдаг. Арав алин бэ? хэмээвээс, энэ мэт буюу: өмнө одуулах биений үйл огоот ариуссан, өмнө одуулах хэлний үйл огоот ариуссан, өмнө одуулах сэтгэлийн үйл огоот ариуссан, өмнө одуулах нэн үл хөнөөхүй, өмнө одуулах муу заяа бүгдийг нэн тэвчихүй, өмнө одуулах чөлөөгүй наймыг нэн тэвчихүй, өмнө одуулах шарвага ба брадигабудын газраас гэтэлсэн, өмнө одуулах бурханы эрдэм дор байгуулах, өмнө одуулах санааг огоот гүйцээх, өмнө одуулах ерөөлийг огоот гүйцээх эдгээр бөгөөд язгуурын хөвгүүнээ энэ нь бодьсатва нарын шагшаабадын чанадад хүрэхийн өмнө одуулах арван янзын ном болой.”

“Язгуурын хөвгүүнээ, тийнхүү бодьсатва нарын тэвчээрийн чанадад хүрэхийн өмнө одуулах арван янзын ном байдаг. Арав алин бэ? хэмээвээс, энэ мэт буюу: өмнө одуулах даган тачаахыг тэвчихүй, өмнө одуулах уурыг тэвчихүй, өмнө одуулах биенд үл харахуй, өмнө одуулах аминдаа сэтгэл үл тушаах, өмнө одуулах

сүжиг, өмнө одуулах амьтдыг огоот боловсруулж үйлдэхүй, өмнө одуулах асрахуйн хүч, өмнө одуулах гүнзгий номонд итгэх тэвчээр, өмнө одуулах агуу ихэд сүжиглэхүй, өмнө одуулах үл мэдэхийг арилгахуй эдгээр бөгөөд язгуурын хөвгүүнээ энэ нь бодьсадва нарын тэвчээрийн чанадад хүрэхүй үүний өмнө одуулах арван янзын ном болой”.

“Язгуурын хөвгүүнээ, мөнхүү бодьсадва нарын хичээнгүйн чанадад хүрэхийн өмнө одуулах арван янзын ном байдаг. Арав алин бэ? хэмээвээс, энэ мэт буюу: өмнө одуулах амьтан бүгдийн үйл юу байна хэмээхүй, өмнө одуулах бие, хэл, сэтгэлийн буяныг илтэд бүтээхэд даган баясахуй, өмнө одуулах мятрашгүй, өмнө одуулах эргэн үл буцахын газарт хурахыг олон үйлдэхүй, өмнө одуулах үнэнхүү хичээл, өмнө одуулах дурьдлыг чухал агуулах, өмнө одуулах нисваанисын дайсныг номхотгохуй, өмнө одуулах бүх юмсаар аглагдахуй, өмнө одуулах амьтдыг огоот боловсруулж үйлдэхүй, өмнө одуулах бүхнийг болгоогчийн билиг билгүүнийг үнэнхүү бүтээх эдгээр бөгөөд язгуурын хөвгүүнээ энэ нь бодьсадва нарын хичээнгүйн чанадад хүрэхүй үүний өмнө одуулах арван янзын ном болой.”

“Язгуурын хөвгүүнээ, мөнхүү бодьсадва нарын дияаны чанадад хүрэхийн өмнө одуулах арван янзын ном байдаг. Арав алин бэ? хэмээвээс, энэ мэт буюу: өмнө одуулах буяны номонд оршихуй болон, өмнө одуулах самади, өмнө одуулах тэгш оршихуй, өмнө одуулах үнэнхүү гүйцээсэн бодь, өмнө одуулах дияан ба нэн гэтлэхүй, өмнө одуулах самадийн эрхэт, өмнө одуулах самадийн хүч, өмнө одуулах амьтан бүгдийн нисваанисыг тэвчихүй, өмнө одуулах самадийн цогцыг огоот гүйцээж үйлдэхүй, өмнө одуулах дээдийн номыг огоот сахихуй эдгээр бөгөөд язгуурын хөвгүүнээ энэ нь бодьсадва нарын дияаны чанадад хүрэхүй үүний өмнө одуулах арван янзын ном болой.”

“Язгуурын хөвгүүнээ, тийнхүү бодьсадва нарын билгүүний чанадад хүрэхийн өмнө одуулах арван янзын ном байдаг. Арав алин бэ? хэмээвээс, энэ мэт буюу: өмнө одуулах цогцод мэргэжихүй, өмнө одуулах махбодын оронд мэргэжихүй, өмнө одуулах төрөн

тухайлахад мэргэжихүй, өмнө одуулах шүтэн барилдаж гарахуйд мэргэжихүй, өмнө одуулах үнэнд мэргэжихүй, өмнө одуулах буруу үзэл болсон бүгдийг арилгахуй, өмнө одуулах билгүүний эрхэт, өмнө одуулах үл төрөхийн номонд итгэлийн тэвчээр, өмнө одуулах бурханы ном бүгдийг огоот гүйцээж үйлдэхүй, өмнө одуулах түйтгэр үгүй билгүүнийг үзэхүй эдгээр бөгөөд язгуурын хөвгүүнээ энэ нь бодьсадва нарын билгүүний чанадад хүрэхүй үүний өмнө одуулах арван янзын ном болой.”

“Язгуурын хөвгүүнээ, тийнхүү бодьсадва нарын мэргэн аргын чанадад хүрэхийн өмнө одуулах арван янзын ном байдаг. Арав алин бэ? хэмээвээс, энэ мэт буюу: өмнө одуулах амьтны санаа хийгээд явдалд орохуй, өмнө одуулах амьтны шүтээн болохуй, өмнө одуулах асрахуй ба их нигүүлсэхүй, өмнө одуулах амьтныг огоот боловсруулж үйлдэхэд үл уйсахуй, өмнө одуулах бурханы ном бүгдэд орохуй, өмнө одуулах ялгамжаатай билиг билгүүнийг үзэн мэдэхүй, өмнө одуулах чанадад хүрэхүйг огоот судалж үйлдэх ба огоот боловсруулж үйлдэхүй, өмнө одуулах юмсыг ямар мэтчилэн огоот атгаглахуй, өмнө одуулах сэтгэлийн хүчийг чухал бүтээхүй, өмнө одуулах эргэн үл буцахын газрыг гүйцэд олж үйлдэхүй эдгээр бөгөөд язгуурын хөвгүүнээ, энэ нь бодьсадва нарын мэргэн аргын чанадад хүрэхүй үүний өмнө одуулах арван янзын ном болой.”

“Язгуурын хөвгүүнээ, тийнхүү бодьсадва нарын ерөөлийн чанадад хүрэхийн өмнө одуулах арван янзын ном байдаг. Арав алин бэ? хэмээвээс, энэ мэт буюу: өмнө одуулах амьтан бүгдийн сэтгэлийн явдал далд чухал гүйгчийг мэдэх, өмнө одуулах амьтан бүгдийн нисваанисын далд чухал гүйгчийг мэдэх, өмнө одуулах амьтан бүгдийн эрхтэн далд чухал гүйгчийг мэдэх, өмнө одуулах амьтан бүгдийн санаа хийгээд сүжиг далд чухал гүйгчийг мэдэх, өмнө одуулах амьтан бүгдийн санаа хийгээд үлэмжийн санаа ба сүжиг далд чухал гүйгчийг мэдэх, өмнө одуулах өөр өөр ертөнцийн орон хийгээд гурван орны далд чухал гүйгчийг мэдэх, өмнө одуулах амьтан бүгдийн санаа хийгээд далд шургалсан далд чухал гүйгчийг мэдэх, өмнө одуулах амьтан бүгдийн үхэн егүүтэх хийгээд төрөл далд чухал гүйгчийг мэдэх, өмнө одуулах амьтан бүгдийн гурван цогцод

нэн агуулах далд чухал гүйгчийг мэдэх, өмнө одуулах эрхтэн үл уйсах амьтныг огоот боловсруулж үйлдэхүй эдгээр бөгөөд язгуурын хөвгүүнээ энэ нь бодьсадва нарын ерөөлийн чанадад хүрэхүй үүний өмнө одуулах арван янзын ном болой.”

“Язгуурын хөвгүүнээ, тийнхүү бодьсадва нарын хүчний чанадад хүрэхийн өмнө одуулах арван янзын ном байдаг. Арав алин бэ? хэмээвээс, энэ мэт буюу: юм бүгд анхнаасаа гарах үгүйг өмнө одуулах, юм бүгд анхнаасаа билиг чанар үгүйг өмнө одуулах, юм бүгд анхнаасаа төрөх үгүйг өмнө одуулах, юм бүгд анхнаасаа буй бусыг өмнө одуулах, юм бүгд анхнаасаа тачаах үгүйг өмнө одуулах, юм бүгд орох үгүйг өмнө одуулах, юм бүгд буцах үгүйг өмнө одуулах, юм бүгд бодитой үгүйн мөн чанартайг өмнө одуулах, юм бүгд эхэн болон дунд, адагт тэнцүү ямагтыг өмнө одуулах, юм бүгд түүнчлэн ямагтад орохын атгаг хийгээд нэн атгаг үгүйг өмнө одуулах эдгээр бөгөөд язгуурын хөвгүүнээ энэ нь бодьсадва нарын хүчний чанадад хүрэхүй үүний өмнө одуулах арван янзын ном болой.”

“Язгуурын хөвгүүнээ, тийнхүү бодьсадва нарын билиг билгүүний чанадад хүрэхийн өмнө одуулах арван янзын ном байдаг. Арав алин бэ? хэмээвээс, энэ мэт буюу: юм бүгд нэн ялгахад машид сайтар шинжлэхүйг өмнө одуулах, цагаан зүгийн номыг машид огоот гүйцээхийг өмнө одуулах, бодийн чуулганыг хэмжээлшгүй хураахыг өмнө одуулах, буян хийгээд билгүүний чуулган огоот ихийг барихыг өмнө одуулах, их нигүүлсэнгүй уужмыг дотоод сэтгэлдээ үүсгэхийг өмнө одуулах, ертөнцийн орныг нэн ялгахын зэргийг мэдэхийг өмнө одуулах, амьтны махбодын орон хийгээд нисваанисын явдалд орохыг өмнө одуулах, Түүнчлэн заларсаны явдлын оронд орох хийгээд даган одохыг мэдэж бодож үйлдэхийг өмнө одуулах, арван хүч хийгээд үл айх ба бурханы ном хольцоогүйд үлэмж зорих болон бүхнийг мэдэж үйлдэхийг өмнө одуулах, байдал бүгдийн дээд лугаа төгөлдөр бүхнийг болгоогчийн билгүүнд авшигийг хүртээхийн газрыг олохыг өмнө одуулах эдгээр бөгөөд язгуурын хөвгүүнээ, энэ нь бодьсадва нарын билиг билгүүний чанадад хүрэхүй үүний өмнө одуулах арван янзын ном болой.”

“Түүнд чанадад хүрэхийн утга алин мөн бэ? хэмээвээс, явдлын ялгамжааг огоот гүйцээж үйлдэхийн утга нь чанадад хүрэхийн утга болой. Билгүүн гүнзгий хийгээд огоот гүйцээж үйлдэхийн утга нь чанадад хүрэхийн утга болой. Хуран үйлдэх хийгээд хуран эс үйлдсэнд тачаах үгүйн утга нь чанадад хүрэхийн утга болой. Орчлонгийн гэмийг ямар мэтчилэн мэдэхийн утга нь чанадад хүрэхийн утга болой. Үл мэргэжсэн төрөлхийтөн нарыг дотроо багтааж үйлдэхийн утга нь чанадад хүрэхийн утга болой. Номын гуу сан барагдашгүйг үнэнхүү үзүүлэхийн утга нь чанадад хүрэхийн утга болой. Түйтгэр үгүй нэн гэтлэхийг огоот гүйцээж үйлдэхийн утга нь чанадад хүрэхийн утга болой. Амьтны махбодын оронг машинд мэдэж үйлдэхийн утга нь чанадад хүрэхийн утга болой. Өглөг тэнцүү ямагтыг даган мэдэхийн утга нь чанадад хүрэхийн утга болой. Шагшаабад тэнцүү ямагтыг огоот гүйцээж үйлдэхийн утга нь чанадад хүрэхийн утга болой. Тэвчээр тэнцүү ямагтыг огоот гүйцээж үйлдэхийн утга нь чанадад хүрэхийн утга болой. Хичээнгүй тэнцүү ямагтыг огоот гүйцээж үйлдэхийн утга нь чанадад хүрэхийн утга болой. Дияан тэнцүү ямагтыг огоот гүйцээж үйлдэхийн утга нь чанадад хүрэхийн утга болой. Билгүүний чанадад хүрэхүйд мэдэн мэргэжихийг огоот гүйцээж үйлдэхийн утга нь чанадад хүрэхийн утга болой. Юм бүгдийг машинд мэдэж үйлдэхийн утга нь чанадад хүрэхийн утга болой. Үл төрөхийн номонд тэвчээрийг огоот гүйцээж үйлдэхийн утга нь чанадад хүрэхийн утга болой. Эргэн үл буцахын газрыг үнэнхүү олж үйлдэхийн утга нь чанадад хүрэхийн утга болой. Бурханы орныг огоот судлахын утга нь чанадад хүрэхийн утга болой. Амьтан бүгдийг огоот боловсруулж үйлдэхийн утга нь чанадад хүрэхийн утга болой. Бодийн шимд бурханы билгүүнийг огоот гүйцээж үйлдэхийн утга нь чанадад хүрэхийн утга болой. Шулмас бүгдийг номхотгож үйлдэхийн утга нь чанадад хүрэхийн утга болой. Орчлон хийгээд гаслангаас хэтрэх хоёр үгүй гэж үзүүлэх хийгээд гэтэлгэхийн утга нь чанадад хүрэхийн утга болой. Эрдэм бүгдийн чанадад одохын утга нь чанадад хүрэхийн утга болой. Чанадын эсэргүүцэгч бүгдийг эцэслэн таслахын утга нь чанадад хүрэхийн утга болой. Арван хүч хийгээд аймшиггүй болон бурханы ном хольцоо үгүй арван наймыг огоот гүйцээж үйлдэхийн утга нь

чанадад хүрэхийн утга болой. Бурханы ном бүгдийг огоот гүйцээж үйлдэхийн утга нь чанадад хүрэхийн утга болой. Тэнцэшгүй үнэнхүү төгссөн бодийг илтэд гүйцээж гэгээрч үйлдэхийн утга нь чанадад хүрэхийн утга болой. Номын хүрдийг арван хоёр янзаар эргүүлэхийн утга нь чанадад хүрэхийн утга болой.”

“Язгуурын хөвгүүнээ, мөнхүү бодьсадва, махасадва нарын бодьсадвагийн анхдугаар газрын урьдчилсан шинж тэмдэг нь гурван мянган их мянган ертөнцийн орон гуу сан түг түмэн зуу мянган голдиор огоот дүүрсэнийг үзэх болой. Язгуурын хөвгүүнээ, тийнхүү бодьсадва, махасадва нарын бодьсадвын хоёрдугаар газрын шинж нь алин гурван мянган их ертөнцийн орон алганы толио мэт болсонд их эрдэнэ түг түмэн зуун мянган голди олноор сайтар чимэглэгдсэнийг үзэх болой. Язгуурын хөвгүүнээ, тийнхүү бодьсадва, махасадва нарын бодьсадвын гуравдугаар газрын шинж нь өөр ямагт баатар хийгээд зэр зэвсэг болон хатуу чанга хөө хуягийг өмсөөд чанадын эсэргүүцэгч бүгдийг номхтгохыг үзэх болой. Язгуурын хөвгүүнээ, тийнхүү бодьсадва, махасадва нарын бодьсадвын дөрөвдүгээр газрын шинж нь дөрвөн зүгээс дөрвөн хийн хот мандалаар бүгд лугаа төгөлдөр их газрын хот мандалд элдэв янзын цэцгээр илтэд цацахыг үзэх болой. Язгуурын хөвгүүнээ, тийнхүү бодьсадва, махасадва нарын бодьсадвын тавдугаар газрын шинж нь чимэг бүгдээр чимэглэсэн бүсгүйн оройд замбага цэцгийн эрхисийг зүүхийг үзэх болой. Язгуурын хөвгүүнээ, тийнхүү бодьсадва, махасадва нарын бодьсадвын зургадугаар газрын шинж нь жирийсэн дөрвөн шат төгөлдөр алтан элс тогтуун, булингар үгүй хийгээд тунгалаг найман гишүүн төгөлдөр усаар огоот дүүрсэн удвал, гүмүда, цагаан лянхуа цэцгээр чимэглэгдсэн усыг үзэх бөгөөд түүнд өөрөө тоглон баясах хийгээд огоот эдэлж байхыг үзэх болой. Язгуурын хөвгүүнээ, тийнхүү бодьсадва махасадва нарын бодьсадвын долдугаар газрын шинж нь баруун, зүүн хоёр зүгт тамын амьтны халил газрыг үзэх бөгөөд тэндээс өөрөө унаж доройтолгүй эргэн буцахыг үзэх болой. Язгуурын хөвгүүнээ, тийнхүү бодьсадва, махасадва нарын бодьсадвын наймдугаар газрын шинж нь хоёр мөрөндөө гөрөөсний хаан зогдорт арслангийн титмийг зүүж араатан нарийн бүгдийг айлган үйлдэх хийгээд сууж байгааг үзэх болой. Язгуурын хөвгүүнээ,

тийнхүү бодьсадва махасадва нарын бодьсадвын есдүгээр газрын шинж нь загарвардын хаан болоод түг түмэн зуун мянган олон голди төрөлхийтнээр огоот хүрээлэгдэх хийгээд өмнөөс нь харж толгой дээрээ элдэв янзын их эрдэнээр чимэглэгдсэн цагаан шүхэр барихыг үзэх болой. Язгуурын хөвгүүнээ, тийнхүү бодьсадва, махасадва нарын бодьсадвын аравдугаар газрын шинж нь Түүнчлэн заларсаны лагшинг олоод алтан өнгийн гэрэл алд дүүрэн цацарч, түг түмэн зуун мянган олон голди эсрэнгээр огоот хүрээлэгдэж, өмнөөс нь хараад ном заахыг үзэх бөгөөд язгуурын хөвгүүнээ, эдгээр арав нь бодьсадва, махасадва нарын бодьсадвын арван газрын шинж мөн болой.”

“Тийнхүү язгуурын хөвгүүнээ, юуны тулд анхдугаар газрыг ‘машид баясахуй’ хэмээн нэрлэв хэмээвээс тэр нь анхлан ертөнцөөс хэтэрсэн сэтгэл урьд олоогүй түүнийг олоод их хэргийн санаа хотол чуулган болсон тул машид их баясгалан төрөх учраас анхдугаар газрыг ‘машид баясахуй’ хэмээсэн болой. Нарийн уналын хир хийгээд шагшаабадын гэм бүгд нэн ариуссан тул, хоёрдугаар газрыг ‘хир үгүй’ хэмээсэн болой. Хэмжээлшгүй билгүүн хийгээд самадийн билгүүн гэрэл үзэгдэл тэр хөдөлгөж чадашгүй хийгээд алины ч сүрээр дарагдашгүй, үл мартагын тогтоолд оршсоны тул, гуравдугаар газрыг ‘гэрэлтүүлэгч’ хэмээсэн болой. Билгүүний галаар нисванис бүгдийг түлэх хийгээд бодийн зүгийн номыг бясалгасны галын гэрэл нь ихэд цацрах болсон учраас дөрөвдүгээр газрыг ‘гэрэл цацруулагч’ хэмээсэн болой. Түүнийг бясалгахын арга хийгээд дээдийн билгүүн дор эрхэнд урвуулахад бэрхтэй хийгээд үзэхүй болон бясалгахын мөрөөр тэвчсэн нисванис номхотгоход бэрхтэйг номхотгосны тул тавдугаар газрыг ‘машид судлахад бэрх’ хэмээсэн болой. Хуран үйлдэхийн ном саадгүй илт болоод тэмдэг үгүй сэтгэлдээ үйлдсэн бүгдийг илтэд үйлдсэн учраас зургадугаар газрыг ‘илтэд болох’ хэмээсэн болой. Цувиралт үгүйн ном нугуудад саадгүй хийгээд тэмдэг үгүйг сэтгэлдээ бясалгаснаар, нэн гэтлэх самадийг өнө удаан бясалгаснаар газар тэр нь нэн ариун хийгээд торолтгүй тул, долдугаар газрыг ‘өнөд одсон’ хэмээсэн болой. Тэмдэг үгүйг сэтгэлдээ үйлдэх бясалгалд эрхийг олоод нисванисуудаар үл хөдлөх болох учраас наймдугаар газрыг ‘үл хөдлөх’ хэмээсэн болой.

Байдал бүгдэд номыг үзүүлэхдээ эрхийг олсон учраас амлашгүй нүгэл байхгүй хийгээд оюун нь машид уужим торолтгүйг олсоны учир есдүгээр газрыг ‘сайн оюун’ хэмээсэн болой. Номын лагшин огторгуй мэтэд их билгүүний үүл мэтээр түгэн бүрхсэний тул аравдугаар газрыг ‘номын үүл’ хэмээсэн болой.”

“Түүнд язгуурын хөвгүүнээ, ном хийгээд бодгалд тэмдэгт илтэд шунахын мунхрал хийгээд орчлон ба муу заяаны нисванисаар айх мунхрал энэ хоёроор анхдугаар газарт түйтгэрлэх болой. Нарийн уналын эндүүрэлд мунхрах хийгээд үйл болон явдал элдэв янзыг илтэд үүсгэхийн мунхрал ба мунхрал энэ хоёроор хоёрдугаар газарт түйтгэрлэх болой. Олоогүйг олохыг хүсэхийн мунхрал болоод дээдсийн дээд тогтоолыг олоход мунхарсан хийгээд мунхрал энэ хоёроор гуравдугаар газарт түйтгэрлэх болой. Тэгш бясалгахын амтанд баясан шунахын мунхрал хийгээд нэн ариун номд шунахын мунхрал ба мунхрал энэ хоёроор дөрөвдүгээр газарт түйтгэрлэх болой. Орчлонд машид уйсахын мунхрал хийгээд гаслангаас гэтлэхүйд илтэд шунахын мунхрал ба мунхрал энэ хоёроор тавдугаар газарт түйтгэрлэнэ. Хуран үйлдэхийн гүйдэл илтэд болохын мунхрал хийгээд бүдүүн тэмдэг илтэд болохын мунхрал ба мунхрал энэ хоёроор зургадугаар газарт түйтгэрлэнэ. Нарийн тэмдэг илтэд болохын мунхрал хийгээд тэмдэг үгүйг сэтгэлд үйлдэхийн мунхрал ба мунхрал энэ хоёроор долдугаар газарт түйтгэрлэнэ. Тэмдэг үгүйд тухайлан хичээхийн мунхрал хийгээд тэмдэгт барихад эрхийг олохын мунхрал ба мунхрал энэ хоёроор наймдугаар газарт түйтгэрлэнэ. Алин номыг үзүүлэх нь хэмжээлшгүй хийгээд үг ба үсэг хэмжээлшгүйд мэргэн үл болохын мунхрал болон самбаанд эрхийг үл олохын мунхрал ба мунхрал энэ хоёроор есдүгээр газарт түйтгэрлэнэ. Илт мэдэл ихэд эрхэнд урвуулахыг үл олохын мунхрал хийгээд хэрэг ба үйл нарийн нууцад мэргэн үл болохын мунхрал ба мунхрал энэ хоёроор аравдугаар газарт түйтгэрлэнэ. Машид нарийн явдлын орон бүгдэд мэдэгдэхүүний түйтгэрийн мунхрал хийгээд машид нарийн нисванисын муу орны авалд мунхрах ба мунхрал энэ хоёроор бурханы газарт түйтгэрлэх болно.”

“Язгуурын хөвгүүн ээ, тийнхүү бодьсадвын анхдугаар газарт оршсон бодьсадва нь өглөгийн чанадад хүрэхийг үлэмж болгох болой. Бодьсадвын хоёрдугаар газарт нь шагшаабадын чанадад хүрэхийг үлэмж болгоно. Гуравдугаар газарт нь тэвчээрийн чанадад хүрэхийг үлэмж болгоно. Дөрөвдүгээр газарт нь хичээнгүйн чанадад хүрэхийг үлэмж болгоно. Тавдугаар газарт нь дияаны чанадад хүрэхийг үлэмж болгоно. Зургадугаар газарт нь билгүүний чанадад хүрэхийг үлэмж болгоно. Долдугаар газарт нь мэргэн аргын чанадад хүрэхийг үлэмж болгоно. Наймдугаар газарт нь ерөөлийн чанадад хүрэхийг үлэмж болгоно. Есдүгээр газарт нь хүчний чанадад хүрэхийг үлэмж болгоно. Аравдугаар газарт нь билиг билгүүний чанадад хүрэхийг үлэмж болгоно.”

“Язгуурын хөвгүүнээ, тийнхүү бодьсадва, махасадва нарын анхдугаар сэтгэлийг үүсгэх нь их эрдэнэ үнэнхүү үлэмж самадигаар гүйцэд бариад төрөх болой. Хоёрдугаар сэтгэлийг үүсгэх нь орших үгүйн самадигаар огоот бариад төрөх болой. Гуравдугаар сэтгэлийг үүсгэх нь машид хөдөлшгүй самадигаар огоот бариад төрөх болой. Дөрөвдүгээр сэтгэлийг үүсгэх нь эргэн үл буцахын самадигаар огоот бариад төрөх болой. Тавдугаар сэтгэлийг үүсгэх нь их эрдэнийн цэцгийн самадигаар огоот бариад төрөх болой. Зургадугаар сэтгэлийг үүсгэх нь нарны гэрлийн сүр жавхлангийн самадигаар огоот бариад төрөх болой. Долдугаар сэтгэлийг үүсгэх нь хэрэг бүгдийг бүтээхийн самадигаар огоот бариад төрөх болой. Наймдугаар сэтгэлийг үүсгэх нь одоо цагийн бурхан илтэд оршихын самадигаар огоот бариад төрөх болой. Есдүгээр сэтгэлийг үүсгэх нь билэг билгүүний зулын самадигаар огоот бариад төрөх болой. Аравдугаар сэтгэлийг үүсгэх нь баатарлаг одохын самадигаар огоот бариад төрөх бөгөөд язгуурын хөвгүүнээ, эдгээр нь бодьсадва, махасадва нарын сэтгэлийг үүсгэх арав болой.”

“Язгуурын хөвгүүн ээ, мөнхүү бодьсадва, махасадва нарын бодьсадвын анхдугаар газарт ‘ялгамжаатайгаар адислагч’ хэмээх тогтоол энэ төрөх бөгөөд тогтоол тэр нь ‘ТАДЯАТА ПУРНА МАНОРАТЭ ДҮХҮ ДҮХҮ ДҮХҮ ЯАВАТ СУРЯА АВАБА САДА

ЯВАТ ЧАНДРА ДАУДАНДЭ ТАВАТ РАГЧА МАНА ДАНАДА  
ПАРИ ХАРАМА ГҮРҮ СУХА’.

Язгуурын хөвгүүнээ, энэ тогтоолыг нэгэн Ганга мөрний элсний тооноос илүү Ялж төгс нөгчсөн бурхад бээр анхдугаар газрын бодьсадваг сахихын тулд зарлигласан бөгөөд хэн нэгэн энэхүү тогтоол тарнийг унших хийгээд цээжилбээс аймшиг бүгдээс аврагдах болно. Тэр нь ч энэ мэт бар ба арслан зэрэг аймшигт араатны язгуур хийгээд бүх бирдүүд ба хүн болон хүн бус тэргүүтэн дайсан, хулгайч, гариг, муу сэтгэлүүд хийгээд таван янзын түйтгэрээс нэн гэтлэх болж анхдугаар газрыг даган дурьдах болой.”

“Язгуурын хөвгүүнээ! бодьсадва, махасадва нарын хоёрдугаар газарт ‘бусад бээр үл дийлэх’ хэмээх тогтоол энэ төрөх болой. Тогтоол тэр нь ‘ТАДЯАТА УДАДОЛИ ЧИРИ ЧИРИ УДАДО РАДОРАНАМА ШАНТО ШАНТО УДАДОЛИ ХҮЛҮ ХҮЛҮ СУХА’. Язгуурын хөвгүүнээ, энэ тогтоолыг хоёр Ганга мөрний элсний тооноос илүү Ялж төгс нөгчсөн бурхад бээр хоёрдугаар газрын бодьсадваг сахихын тулд зарлигласан болой. Хэн нэгэн энэхүү тогтоол тарнийг унших хийгээд цээжилбээс аймшиг бүгдээс нэн аврагдах бөгөөд тэр нь аймшигт араатан ба аймшигт бирд, хүн болон хүмүүн бус тэргүүтнээр хөнөөгдөх хийгээд гадны дайсан, гариг, муу сэтгэл, зовлон болон таван янзын түйтгэрээс нэн гэтлэх болж хоёрдугаар газрыг даган дурьдах болой.”

“Язгуурын хөвгүүн ээ, гуравдугаар газарт оршсон бодьсадва, махасадва нарт ‘машид оршсон’ хэмээх тогтоол энэ төрөх болой. Тогтоол тэр нь ‘ТАДЯАТА ДАНАТИКА ВАНАТИКА КАРАТА КАУРАТИ КЕЙЮУРЭДАНА ДИЛИ СУХА’. Язгуурын хөвгүүнээ, энэ тогтоолыг гурван Ганга мөрний элсний тооноос илүү Ялж төгс нөгчсөн бурхад бээр гуравдугаар газрын бодьсадваг сахихын тулд зарлигласан болой. Хэн нэгэн энэхүү тогтоол тарнийг цээжлэх хийгээд уншсан тэрбээр аймшиг бүгд хийгээд аймшигт араатан, аюулт ад, хүн хийгээд хүмүүн бусуудаар хөнөөгдөх ба гариг, гадаадын дайсан, элдэв янзын зовлон болон таван янзын түйтгэрээс нэн гэтлэх болж гуравдугаар газрыг даган дурьдах болой.”

“Язгуурын хөвгүүн ээ, дөрөвдүгээр газарт оршсон бодьсадва, махасадва нарт ‘номхотгоход бэрх’ хэмээх тогтоол энэ төрөх болой. Тогтоол тэр нь ‘ТАДЯАТА ШИРИ ШИРИ ДЭМИ ДЭМИНИ ДАРИ ДАРИНИ ШЭРИ ШЭРИНИ ПИШАЛА ПИШАЛА ПАША ПАШАНИ ВАНАДАНИЮЭ СУХА’. Язгуурын хөвгүүнээ, энэ тогтоолыг дөрвөн Ганга мөрний элсний тооноос илүү Ялж төгс нөгчсөн бурхад бээр дөрөвдүгээр газрын бодьсадваг сахихын тулд зарлигласан болой. Хэн нэгэн энэхүү тогтоол тарнийг унших хийгээд цээжилбээс тэр нь аймшиг бүгд ба догшин араатан, аюулт бирд, хүн хийгээд хүмүүн бус тэргүүтэн чанадын дайсан, олон зовлонгоор хөнөөгдөх хийгээд гариг болон таван янзын түйтгэрээс нэн гэтлэх болж дөрөвдүгээр газрыг даган дурьдах болой.”

“Язгуурын хөвгүүн ээ, тавдугаар газарт оршсон бодьсадва, махасадва нарт ‘эрдэм элдвээр байгуулагдсан’ хэмээх тогтоол энэ төрөх болой. Тогтоол тэр нь ‘ТАДЯАТА ХАРИ ХАРИНИ ЧЭРИ ЧЭРИНИ КАРИМАНИ САДА КАРИМАНИ САМАПАСАНИ ЖАМПАНИ СТАМБАНИ МОХАНИ СВАЯМАБУГА СУХА’. Язгуурын хөвгүүнээ, энэ тогтоолыг таван Ганга мөрний элсний тооноос илүү Ялж төгс нөгчсөн бурхад бээр тавдугаар газрын бодьсадваг сахихын тулд зарлигласан болой. Хэн нэгэн энэхүү тогтоол тарнийг унших хийгээд цээжилбээс аймшиг бүгд хийгээд догшин араатан, аюулт бирд, хүн хийгээд хүмүүн бус тэргүүтэн, гадны дайсан ба элдэв янзын зовлонгоор хөнөөгдөх хийгээд гариг болон таван янзын түйтгэрээс нэн гэтлэх болж тавдугаар газрыг даган дурьдах болой.”

“Язгуурын хөвгүүн ээ, зургадугаар газарт оршсон бодьсадва, махасадва нарт ‘билгүүний хот мандлын зул’ хэмээх тогтоол энэ төрөх болой. Тогтоол тэр нь ‘ТАДЯАТА ВИТОРИ ВИТОРИ МАРИНИ КАЛИ КАЛЭ ВИДО ХАНАТЭ ЛУЛҮ ЛУЛҮ ЧҮЛҮ ЧҮЛҮ ТОЛУ ВАТОЛУВА ШАША ШАНЧА ВАРИША СВАСТИ САРВА САТАНАНАНА СИДДЯАНТУ МАМА МАНТРА ПАДИНИ СУХА’. Язгуурын хөвгүүнээ, энэ тогтоолыг зургаан Ганга мөрний элсний тооноос илүү Ялж төгс нөгчсөн бурхад бээр зургадугаар газрын бодьсадваг сахихын тулд зарлигласан болой. Хэн нэгэн энэхүү

тогтоол тарнийг унших хийгээд цээжилбээс аймшиг бүгд хийгээд догшин араатан, аюулт бирд, хүн хийгээд хүмүүн бус тэргүүтэн, гадны дайсан ба элдэв янзын зовлонгоор хөнөөгдөх хийгээд гариг болон таван янзын түйтгэрээс нэн гэтлэх болж зургадугаар газрыг даган дурьдах болой.”

“Язгуурын хөвгүүн ээ, долдугаар газарт оршсон бодьсадва, махасадва нарт ‘ялгамжаатай илүү’ хэмээх тогтоол энэ төрөх болой. Тогтоол тэр нь ‘ТАДЯАТА ЖАХА ЖАХАРУ ЖАХА ЖАХА ЖАХАРУ ВАЙЛУКЭ ВАЙЛУКЭ АМРИТАГАНЭ ПУРУШАНЭ ВЭРУТИКЭ ВАРУВАДДЭ БИДИХЭКЭ ВИНАДА ВИЛИНИ АМАМРИ ЛҮТИКГЭ ВАЙЖУЮУ СУХА’. Язгуурын хөвгүүнээ энэ тогтоолыг долоон Ганга мөрний элсний тооноос илүү Ялж төгс нөгчсөн бурхад бээр долдугаар газрын бодьсадваг сахихын тулд зарлигласан болой. Хэн нэгэн энэхүү тогтоол тарнийг унших хийгээд цээжилбээс аймшиг бүгд хийгээд догшин араатан, аюулт бирд, хүн хийгээд хүмүүн бус тэргүүтэн, гадны дайсан ба элдэв янзын зовлонгоор хөнөөгдөх хийгээд гариг болон таван янзын түйтгэрээс нэн гэтлэх болж долдугаар газрыг даган дурьдах болой.”

“Язгуурын хөвгүүн ээ, наймдугаар газарт оршсон бодьсадва, махасадва нарт ‘булинггар үгүй бодол’ хэмээх тогтоол энэ төрөх болой. Тогтоол тэр нь ‘ТАДЯАТА ШИРИ ШИРИ ШИРИНИ МИТЭ МИТЭ КАРИ КАРИ ХЭРУ ХЭРУ ЧУРУ ЧУРУ БАНДАНИ СУХА’. Язгуурын хөвгүүнээ, энэ тогтоолыг найман Ганга мөрний элсний тооноос илүү Ялж төгс нөгчсөн бурхад бээр наймдугаар газрын бодьсадваг сахихын тулд зарлигласан болой. Хэн нэгэн энэхүү тогтоол тарнийг унших хийгээд цээжилбээс аймшиг бүгд хийгээд догшин араатан, аюулт бирд, хүн хийгээд хүмүүн бус тэргүүтэн, гадны дайсан ба элдэв янзын зовлонгоор хөнөөгдөх хийгээд гариг болон таван янзын түйтгэрээс нэн гэтлэх болж наймдугаар газрыг даган дурьдах болой.”

“Язгуурын хөвгүүн ээ, есдүгээр газарт оршсон бодьсадва, махасадва нарт ‘үүд хязгаараас үргэлжлэх’ хэмээх тогтоол энэ төрөх болой. Тогтоол тэр нь ‘ТАДЯАТА ХАРИ ЧАНАДАЛИКЭ КУЛА МАБАТЭ ТОРАШИ ПАДА ПАДАСИ ШИРИ ШИРИ ГАШИРИ ГАВИ ШИРИ

СВАСТИ САРВА САТВАНАНАНА СУХА'. Язгуурын хөвгүүнээ, энэ тогтоолыг есөн Ганга мөрний элсний тооноос илүү Ялж төгс нөгчсөн бурхад бээр есдүгээр газрын бодьсадваг сахихын тулд зарлигласан болой. Хэн нэгэн энэхүү тогтоол тарнийг унших хийгээд цээжилбээс аймшиг бүгд хийгээд догшин араатан, аюулт бирд, хүн хийгээд хүмүүн бус тэргүүтэн, гадны дайсан ба элдэв янзын зовлонгоор хөнөөгдөх хийгээд гариг болон таван янзын түйтгэрээс нэн гэтлэх болж есдүгээр газрыг даган дурьдах болой.”

Язгуурын хөвгүүнээ, аравдугаар газарт оршсон бодьсадва махасадва нарт ‘барагдашгүй эрдэнэ’ хэмээх тогтоол энэ төрөх болой. Тогтоол тэр нь ‘ТАДЯАТА СИДДЭ СУ-СИДДЭ МОЧАНИ МОКЧАНИ ВИМУГАТЭ АМАЛЭ ВИМАЛЭ ДАМАЛЭ МАНГАЛЭ ХАРАНЯА ГАРБЭ САМАНТА БАДРЭ САРВА САРВА АРЯА САДАНИ МАНАСИ МАХА МАНАСИ АБУТЭ АРАЖЭ ВИРАЖЭ АЧУТЭ АРЭЖЭ ВИРАЖЭ БРАХМА БРАХМА САРЭ ПУРАНИ ПУРАНА МАНОРАТЭ СУХА’. Язгуурын хөвгүүнээ, энэ тогтоолыг арван Ганга мөрний элсний тооноос илүү Ялж төгс нөгчсөн бурхад бээр аравдугаар газарт оршсон бодьсадваг сахихын тулд зарлигласан болой. Хэн нэгэн энэхүү тогтоол тарнийг унших хийгээд цээжилбээс аймшиг бүгд хийгээд догшин араатан, аюулт бирд, хүн хийгээд хүмүүн бус тэргүүтэн, гадны дайсан ба элдэв янзын зовлонгоор хөнөөгдөх хийгээд гариг болон таван янзын түйтгэрээс нэн гэтлэх болж аравдугаар газрыг даган дурьдах болой.”

Тэгээд Арслангийн охийн гэрэл үзэгдэл торолтгүй хэмээгч бодьсадва махасадва бээр Ялж төгс нөгчсөн бурхан бээр эдгээр тогтоолыг номлохыг сонсоод суудлаасаа босож, дээдийн хувцсыг нэг мөрөндөө буулгаад, баруун өвдгөө газарт хатгаж, алгаа хавсран сөгдөөд, өлмийд нь мөргөөд шүлэг үүгээр магтвай:

Гүнзгий, бэлэг чанар үгүй номонд  
Төрөлхтөн мэдэл доройтсон нугууд  
Ялж төгссөн ганцаар гэтэлгэн зохиосон  
Үлгэрлэшгүй тан дор мөргөх болой.

Түүнчлэн заларсаны билгийн мэлмий  
Номын бэлэг чанар нэгийг үл болгоов  
Үнэнхүү номын мэлмийгээр  
Бүхнийг тодруулсан нь санаанд багташгүй  
Аль ч юм төрөх үгүй бөгөөд  
Хаагдах нь ч бас үл болох болой.

Тэр мэт тэгшид болгоосноор  
Тэнцэшгүй оронд орших болов  
Орчлон нугууд ч үл эвдрэх дор  
Гаслангаас гэтлэх нь ч үл орших хийгээд  
Хоёр хязгаарт үл орших бөгөөд  
Тиймийн тул гаслангаас хэтрэхийг олов.

Арилсан хийгээд үл арилсан зүг дор ч  
Нэн ялгал үгүйн тул  
Ялж төгссөн нэг мөн чанартайд болгоосон тул  
Нэн арилсаны дээдийг олсон болой.

Ялж төгс нөгчсөний хэмжээлшгүй лагшин бээр  
Нэг үгийг үзүүлэх байхгүй боловч  
Эдгээр олон нөхөд бүгдэд  
Номын хураар цэнгүүлэн зохиов.

Амьтан эдгээр бүгдийн  
Бэлэг чанарыг нэн болгоох үгүй ч  
Нисванис зовлон бүгдээс  
Ялж төгссөн үргэлжид авран зохиодог.

Амгалан хийгээд зовлон, мөнх, мөнх бус  
Би хийгээд би үгүй тэргүүтэн  
Нэг хийгээд тус тусдаа бус  
Төрөх үгүй хийгээд хаагдах үгүй  
Тэр адилын утгын байдал дор  
Нэн ялгах хийгээд үзүүлэн зохиов.

Үлгэрлэвээс хоосон хадны цуурай  
Түүний утгыг бурхад бээр болгоосон

Юмсын мөн чанар нь ялгалт үгүй учир  
Ул зохилдох хөлгөн бусад үгүй бөгөөд  
Амьтдыг гэтэлгэхийн тулд  
Гуравт нэн ялган зохиов.

Тэгээд Эсрэнгийн хаан Их эрхт баялагт бээр суудлаасаа босоод дээдийн хувцсыг нэг мөрөндөө буулгаад, баруун өвдгөө газарт хатган, алгаа хавсран сөгдөж, Ялж төгс нөгчсөний өлмийд оройгоор мөргөөд Ялж төгс нөгчсөн бурханд ийн хэмээн айлтгав: “*Дээд алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* энэ машид ховор хийгээд жишихэд бэрхтэй, анхандаа ч буян, завсарт нь ч буян, эцэстээ ч буян, утга сайн, үг сайн, хольцоогүй огоот гүйцэд, бурханы ном бүгдийг хотол чуулган болгон зохиосон үүнийг алин нэгэн хадгалах хийгээд барьсан тэр Ялж төгс нөгчсөн бурхадын зохиолыг урласан мөн болой.”

Тийн хэмээн айлтгасан ба Ялж төгс нөгчсөн бурхан бээр зарлиглав: “Язгуурын хөвгүүн ээ, ямар мэт өгүүлсэн тэр мэт бөгөөд язгуурын хөвгүүн алин *судрын аймаг* үүнийг сонсож үйлдэх нь тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодиос эргэн үл буцах болой. Тэр юуны тулд вэ? хэмээвээс, язгуурын хөвгүүн ээ, энэ бээр газраас эргэн үл буцах бодьсадва нарын буяны үндэс дээдэд боловсрон үйлдэх хийгээд номын дээд тамга мөн ба судар аймаг бүгдийн хаан болох бөгөөд тиймийн тулд сонсох хийгээд цээжлэх, унших болон уншлаганд үйлдэх болой. Тэр нь ч язгуурын хөвгүүн буяны үндэс үл төрөх хийгээд буяны үндэс огоот үл боловсрох ба олон бурханд өргөл хүндлэлийг үл үйлдсэн амьтан тэдгээр бээр дээдийн ном үүнийг сонсож үл чадах болой. Язгуурын хөвгүүн ээ, номын тийн тоо үүнийг сонссон төдийгөөр язгуурын хөвгүүн юмуу язгуурын охид үлэмжийн санаа огоот ариусах хийгээд бурханыг үзэх лугаа үл хагацах болой. Дээдийн номыг сонсох лугаа үл хагацах болно, хуврагуудыг хүндлэн тахиж үйлдэх лугаа үл хагацах болно. Далайн тамга барагдашгүйг илтэд бүтээхийн тогтоол лугаа үл хагацах болно, амьтны санаа хийгээд явдал болон дуунд орохын тогтоол лугаа үл хагацах болно, нарны охийг үзэхийн тогтоол лугаа үл хагацах болно, сарны охийг үзэхийн тогтоол лугаа үл хагацах

болно, бүхнээс боссон бүгдийг нэн дарахыг бүтээхийн тогтоол лугаа үл хагацах болно, очир мэт хатуу хийгээд багтай уулыг нэн дарах тогтоол лугаа үл хагацах болно, өгүүлшгүй утгыг үзүүлэхэд үнэнхүү хичээсэн тогтоол лугаа үл хагацах болно, үг ба явдал болон дуу бүгдэд орох тогтоол лугаа үл хагацах болно, огторгуйн хот мандал хир үгүйг бүтээхийн тамгаар талбисан тогтоол лугаа үл хагацах болно, бурханы лагшин хязгаарлашгүйг огоот гүйцээж бүтээхийн тогтоол лугаа үл хагацах болно.”

“Тэнгэрийн хөвгүүнээ, эдгээр тогтоолыг олсоноор бодьсадва нар арван зүгийн бурханы оронд бурханы лагшинг илтэд хувилгаад номыг номлох болой. Номын чанараас ч үл хөдлөх бөгөөд одох ч үгүй, ирэх ч үгүй болой. Амьтдыг огоот боловсруулж үйлдэхнээ ч амьтанд зоригдох нь ч үгүй болой. Номыг үзүүлэхнээ ч үсэг тэнцүү ямагтаас үл хөдлөх болой. Үхэн егүүтэх хийгээд төрөхийг үзүүлэхнээ ч үхэх нь ч үгүй, төрөх нь ч үгүй болой. Юм бүгдэд нэн атгаг үгүйн тул хуран үйлдсэн бүгд хаана ч одох үл болно. Хаанаас ч ирэх үл болно.”

Номын тийн тоо үүнийг номловоос гурван мянган бодьсадва бээр үл төрөхийн номонд итгэх тэвчээрийг олов гэнэ. Хэмжээлшгүй бодьсадва нар бээр бодийн сэтгэлээс эргэн үл буцах болов. Хэмжээлшгүй гэлэн хийгээд гэлэнмаа нар бээр номонд номын нүд нэн арилсаныг олов. Цаглашгүй олон амьтан бээр тэнцэшгүй үнэнхүү төгссөн бодид сэтгэлийг үүсгэх болсон хийгээд тэгээд тэр цагт Ялж төгс нөгчсөн бурхан бээр шүлэг үүнийг зарлиглав:

Орчлонгийн үргэлжлэлийг таслах дээдийн энэ ном  
Ойлгоход гүнзгий хийгээд нарийн үзэхэд бэрхтэй  
Тачаал хүслээр халхлагдсан харалган нугууд  
Түүнийг үл мэдсэнээр зовлонг авмуй.

Тэгээд тэдгээр хурсан нөхөд суудлаасаа босоод Ялж төгс нөгчсөн бурханы өлмийд оройгоороо мөргөөд ийн хэмээн айлтгавай: “Ялж төгс нөгчсөн бурхаан, *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхт хаан* үүнийг унших хийгээд уншлага болгох ба үзүүлсэн болон оршсон тэнд бид бүгд байгаад номыг үзүүлэхийн нөхөрт үйлдээд

түүнд туслах хийгээд амгаланг хайрлаж, бие сэтгэлийг амирлуулж үйлдэнэ. Бид нар бээр нэгэн үзүүрт сэтгэлээр тахиж үйлдэнэ. Сонсогч нөхдүүдийг ч амгалангаар цэнгүүлж үйлдэнэ. Хааны орон тэнд ч чанадын дайсны аюул ба хөнөөл хийгээд ган зудаар зовох байхгүй хийгээд олон төрөлхийтөн бээр дэлгэрүүлэх хийгээд огоот түгээж үйлдэнэ. Энэ номыг номлосон орны хот мандал үүнийг тэнгэр ба хүн, асур тэргүүтэн бүгд хийгээд амьтан бүгд бээр үл чадагдах хийгээд ариусгаж үйлдэх болой. Тэр юуны тулд хэмээвээс номыг номлосон орон тэр нь суварга болсоны учир шүхэр хийгээд дуаз, цэцэг, хүж, туузаар огоот тахиж үйлдэх болой. Бид нар бээр ч үргэлжид сахих хийгээд аварч үл доройтуулан үйлдмой.”

Тэгээд Ялж төгс нөгчсөн бурхан бээр хурсан нөхөд тэдгээрт зарлиглав: “Язгуурын хөвгүүн ээ, та бээр судрын аймгийн дээд үүнийг бүтээхэд хичээж үйлдэхтүн. Дээдийн ном энэ нь энэ ертөнцөд өнө удаан орших болно.”

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлгөн судраас*

*“Тазры нэн тэтгэгч” хэмээх зургадугаар бүлэг болой.*

\* \* \*

[Тавдугаар хэсэг]

*‘VII бүлэг: Өнгөрсөн, ирээдүй, эдүгээ цагт заларсан  
Үнэнхүү төгссөн бурханы орон бүгдийг магтсан.*

Тэгээд Ялж төгс нөгчсөн бурхан бээр Язгуурын охин тэнгэр Бодьсадва-самукчаяа-д (мон: *Бодийг үнэнхүү хураахуй*) ийн хэмээн зарлиглав: “Язгуурын охин тэнгэр ээ, тэр үеийн тэр цагт Суварна-бужен-дра (мон: *Алтан мутарын эрхт*) хэмээгч хаан тэр бээр Түүнчлэн заларсан бүгдийн магтаал ‘Лянхуа гарахын орон’ хэмээх үүгээр өнгөрсөн, ирээдүй, эдүгээ цагийн Ялж төгс нөгчсөн бурхадыг илтэд магтсан болой:

Аливаа урьд заларсан бурхад хийгээд  
Арван зүгийн ертөнцөд амьдарч буй алин  
Ялгуугсан тэдгээр бүгдэд мөргөж үйлдээд,  
Ялгуугсан тэдгээр бүгдийг би бээр магтмой.

Чадагчийн эрхэт нь амирлангуй, машид амирласан, нэн  
ариун.

Лагшин нь алтан өнгөтэй машид бадарсан.  
Эгшиг дуу бүгдээс бурханы зарлиг яруу,  
Эсрэн тэнгэрийн аялгуу машид дуурссан зарлиг.  
Шаргалтах зөгий, тогос, хөх удвал мэт тэргүүн,  
Шанх үснэр нь хар хөх заша өвс адил.

Шинэхэн цас, дун мэт машид цагаан шүд  
Шижири алт мэт үргэлжид маш үзэсгэлэнтэй байна.  
Хиргүй бөгөөд урт, тунгалаг мэлмий нь  
Хөх удвал машид дэлгэрсэн мэт.

Хэл нь их бөгөөд улаан лянхуан өнгөтэй  
Лянхуа мэт үзэгдэх лянхуан хүйс адил.

Магнайн гуу сан үс нь лянхуан үндэс, дунгийн хээ мэт  
Машид үзэсгэлэнт биндэрьяан өнгөтэй зөв тийш эрчилсэн.

Чадагчийн лагшин нь сарны дүрс мэт бөгөөд  
Саран адил тунгалаг мэлмий нь зөгий мэт.  
Нигуур өндөр, хамар нь үргэлжид илхэн бөгөөд  
Зөөлөн хийгээд газрын алт мэт сайн өнгөтэй.

Үргэлжид бурхан бүгд бээр амтын дээд  
Зөөлөн хийгээд дээдийн дээд машид үлэмж.  
Үсний нүхнээс нь нэг нэг төрж  
Үснүүд төрсөн зөв тийш эргэсэн бөгөөд

Гялалзсан, огторгуй мэт хөх үснэр нь  
Тогосны гуа хоолой мэт хөхрөх нь үзэсгэлэнтэй.

Мэндэлсэн даруйдаа лагшингаараа гийгүүлж үйлдсэн,  
Арван зүгийн ертөнц бүгдийг дүүргэсэн,  
Гурван ертөнцөд зовлон даяарыг амирлуулсан,  
Амгалан бүхнээр амьтан бүгдийг ч цэнгүүлсэн.

Амьтны тамд төрсөн болон адгуусанд төрсөн хийгээд  
Бирд ба тэнгэрийн орон, хүний төрөлд төрөгсөд,  
Амьтан тэдгээр бүгд амгалангаар цэнгэж,  
Муу заяанд төрөгсөд бүгд амирласан.

Сайн өнгөтэй алт лугаа адил гэрэлт,  
Шижир алт мэт машид гэрэлтсэн лагшинт,  
Сайтар заларсан машид хиргүй сар мэт нигуурт,  
Мишээсэн нэн үзэсгэлэнтэй машид тунгалаг нигуур.

Нялх залуу мэт бие лагшин гишүүн нь зөөлөн;  
Арслан адил хүчээрээ дарахын дээд.  
Урт мутарт бөгөөд мутар нь машид урт тэнийх  
Салын бургас салхиар хөдлөх мэт.

Алд дүүрэн гэрэл бадарсан, гэрэл машид гарсан  
Мянган нар мэт машид ив илхэн.

Чадагчийн эрхэтийн хиргүй дээд лагшин  
Хязгааргүй орон бүгдийг машид гийгүүлнэ.

Бурханы гэрэл нь нэн ив илхэнээр  
Хязгаарлашгүй зуун мянган оронд түгэх ба  
Сайхан царайт олон нар сар  
Тэдгээр бүгд гэрэл үгүй больюу.

Наран бурхад ертөнцийн зул бөгөөд  
Зуун мянган тоот наран бурхад нь  
Хязгаарлашгүй зуун мянган оронд залрах ба  
Түүнчлэн заларсан тэднийг амьтад үзнэ.

Зуун мянган тоот буян төгөлдөр лагшин,  
Эрдэм бүгдээр машид чимэглэсэн лагшин.  
Ялгуулсаны мутар нь их эрхэт зааны хошуу адил,  
Мутар, өлмийн гэрэл нь машид үзэсгэлэнтэй агаад хиргүй.

Газрын дээрх тоосны тоотой адил  
Нарийн тоосны тоотой сацуу өнгөрсөн бурхад алин хийгээд  
Алин нарийн тоосны тоотой сацуу ирээдүйн бурхад;  
Алин нарийн тоосны тоотой сацуу залран буй.

Бурхан тэдгээрт машид сүжиглэн  
Бие, хэл, сэтгэлээр цэцэг өргөх хийгээд  
Хүжсийг өргөх ба магтаал олон хийгээд  
Буяны сэтгэлээр ч бурхадад мөргөх болой.

Бурханы эрдэм буян болсон алин бүгд,  
Машид дээд шим элдэв олон бөгөөд  
Би бээр мянган галавт хэлээ зуу хувилгаад ч  
Бурханы эрдмийг өгүүлж гүйцэшгүй болой.

Ганцхан бурханы эрдэм чадлыг  
Хэлээ мянга хувилгаад ч өчүүхэн өгүүлж үл барах,  
Тиймээс би бээр бурхад бүгдийн  
Ганцхан эрдмийг ч дэлгэр өгүүлж хаанаас чадах вэ?

Тэнгэр сэлтийн ертөнц бүгд далайд автаад  
Орчлонгийн үзүүрээс доош усаар дүүрсэнийг  
Үсний үзүүрээр хэмжиж болох ч  
Амгалан залрагсадын ганц эрдмийг ч тийн чадахгүй.

Бие ба хэл, сэтгэл машид сүжиглэснээр  
Бурхан бүгдийг би бээр сайшаан магтсанаар  
Би бээр буяны үр дээдийг хураасан алин  
Түүгээр амьтад ялгуугсанаа хүрэх болтугай.

Тэр мэт хаан бээр бурхадыг магтаад, энэ мэт ерөөл талбисан нь:

Ирээдүйн хязгаарлашгүй галвуудад ч  
Алин ба алинд би төрвөөс,  
Зүүдэндээ энэ адилаан хэнгэргийг үзэх хийгээд  
Тэр нь наминчилгаа энэ адилаан сонсох болтугай.  
Ялгуулсаны магтаал Лянхуа гарахын хаан энэ адил  
Төрөл заяа тэр хийгээд тэр бүхэнд олох болтугай.

Бурханы эрдэм хязгаарлашгүй, тэнцэшгүй хийгээд  
Алин мянган галавт ч олоход бэрхтэй,  
Тэдгээрийг зүүдэндээ ч сонсох болтугай.  
Өдөр болохын цагт ч тэдгээрийг үзүүлэх болтугай.

Амьтныг зовлонгийн далайгаас гэтэлгэх болтугай.  
Чанадад хүрэх зургааг төгсгөж үйлдээд,  
Хойшид тэнцэшгүй бодийг олох болтугай.  
Миний орон нь ханьцашгүй болох болтугай.

Хэнгэргийг өргөсний нэн боловсрохын үр хийгээд  
Бурхан бүгдийг ч магтсаны шалтгаанаар  
Шагжамуни бурханыг илтэд үзэх болтугай.  
Тэнд би бээр эш үзүүлэхийг олох болтугай.  
Канака-бужендра (*мон: Алтан гарны эрхэт*) хийгээд  
Канака-прабха (*мон: Алтан гэрэл*),

Миний хүү алин мөн энэ хоёр ч  
Тэнд хөвгүүн эдгээр хоёулаа ч  
Тэнцэшгүй бодид эш үзүүлэхийг олох болтугай.

Амьтан алин нугууд орон үгүй, шүтээн үгүй хийгээд  
Аврал лугаа хагацаад хоосон болсон бүгд  
Тэдгээрт ч ирээдүй цаг бүхэнд  
Аврагч ба өмөг садан, аврал болон шүтээн болох болтугай.

Зовлон гарахын шалтгааныг баран үйлдэх болтугай.  
Амгалан бүгд гарахын орон болох болтугай.  
Өмнийн хязгаар өнгөрсөн тэдгээр хэдий чинээ  
Ирээдүйн галавт бодийг эдлэх болтугай.

*Дээд Алтангэрэлтийн* наминчилгаагаар,  
Миний хилэнцийн нуур хатах болтугай.  
Миний үйлийн далай барагдах болтугай.  
Миний нисванисын далай ширгэх болтугай.  
Миний буяны далай дүүрэх болтугай.

Хиргүй билгүүний дээд гэрлээр  
Миний билгүүний далай нэн ариусахтун.  
Эрдэм бүгдийн далай болох болтугай  
Бодийн эрдмийн их эрдэнийн эрдэм төгсөх болтугай.  
*Дээд Алтангэрэлтийн* наминчилгааны хүчээр  
Миний буян машид гийх болтугай.

Миний бодийн гэгээ нэн ариун болж,  
Хиргүй билгүүний дээд гэгээгээр  
Миний биений гэрэл нь гийх болтугай.  
Буяны гэгээг илхэн үйлдэхийн тулд  
Гурван ертөнцөд ялгамжаатай илүү болох болтугай.  
Буяны хүч лугаа үргэлжид төгөлдөр болох болтугай.

Зовлонгийн далайгаас гэтлэх хийгээд  
Амгалан бүгдийн далай адилаар  
Ирээдүйн галавт  
Бодийг эдэлж үйлдсүгэй.

Урьд хэдий чинээ гурван ертөнцөд зарарсан,  
Бурхадын орон дэлхийд тэдгээр бүгдийн

Хязгаарлашгүй ялгамжаатай эрдэм юу адил оршсон  
Хязгаарлашгүй эрдэм тэдгээр нь миний орон дэлхийд  
Ирээдүй цагт тэр мэтээр болох болтугай.

Ручира-кету бээр мэдэж үйлд,  
Хаан Суварна-бужендра (*Алтан гарын эрхэт*) бээр  
Урьд цагт ерөөл үүнийг тавьсан бөгөөд  
Тэр ямагт одоо чи мөн юм.

Урьд цагийн хоёр хүү нь  
Суварна-бужа (*Алтан гарт*) ба Суварна-прабха  
(*Алтангэрэлт*)  
Тэр ямагт Рупяа-кету (*Мөнгөн охьт*), Рупяа-прабха  
(*Мөнгөнгэрэлт*) хэмээн  
Би бээр тэр цагт эш үзүүлсэн болой.

Тэдгээр олон нөхөд үүнийг сонсоод  
Бүгдээр бодийн сэтгэлийг үүсгэв.  
Одоо, ирээдүй цаг нугуудад  
Үргэлжид наминчилга үүнийг үйлдэгтүн

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлгөн судраас*

*"Өнгөрсөн, ирээдүй, эдүгээ цагт заларсан Үнэнхүү төгссөн бурханы орон  
бүгдийг магтсан" хэмээх долдугаар бүлэг болой.*

\* \* \*

*VIII бүлэг: Алтат нэрт тогтоол  
(тарни)*

Тэгээд Ялж төгс нөгчсөн бурхан тэдгээр нөхдийн дундаас Прасвасата (*мон: Амгалан оршигч*) бодьсадва махасадва-д ийн хэмээн зарлиглав: “Язгуурын хөвгүүн ээ, ‘Алтат’ хэмээх тогтоол үүнийг алин язгуурын хөвгүүн юмуу язгуурын охин хэн нэгэн бээр өнгөрсөн, ирээдүй, одоо цагийн бурхан бүгдийг илтэд тахих хийгээд хүндлэн үйлдэхийг хүссэнээр сэтгэлдээ хадгалан барьж үйлдээрэй. Тэр юуны тулд хэмээвээс энэхүү тогтоол нь өнгөрсөн, ирээдүй, одоо цагийн Ялж төгс нөгчсөн бурхан бүгдийн эх мөний тулд юм. Энэхүү тогтоолыг сэтгэлдээ бариваас буяны чуулган агуу ихээр арвидах болно. Өнгөрсөн цагийн хэмжээлшгүй Ялж төгс нөгчсөн бурхад буяны үндсийг үүсгэгч нар барих ба хадгалах болой. Шагшаабад нэн ариун эс доройтсон хийгээд гэм үгүй нар номын тийн тоо машид гүнзгий үүнд орж чадах болой.”

Тэгээд Ялж төгс нөгчсөн бээр зарлиглав: “Тогтоол тарнийг бүтээх зан үйлийн урьд нь Ялж төгс нөгчсөн бурхан хийгээд бодьсадвын алдар эдгээрийг өгүүлэн нэгэн үзүүрт сэтгэлээр мөргөөд тэгээд тарни үүнийг уншиж үйлдээрэй.”

“Арван зүгийн бурхан бүгдэд мөргөмүй. Бодьсадва махасадва нарт мөргөмүй. Шарвага, брадигабуд ба хутагт бүгдэд мөргөмүй. Шагжамуни бурханд мөргөмүй. Зүүн зүгийн Акчобхья (*Минтүгва*) бурханд мөргөмүй. Өмнө зүгийн Ратнакету (*Их эрдэнийн охь*) бурханд мөргөмүй. Баруун зүгийн Амиитаба (*Хэмжээлшгүй гэрэлт*) бурханд мөргөмүй. Хойд зүгийн Дундуби-свара ража (*Хэнгэрэгийн дууны хаан*) бурханд мөргөмүй. Дээд зүгийн Вишала-шри (*Уужим цог*) бурханд мөргөмүй. Доод зүгийн Үзэгдэл дээдийн цог бурханд мөргөмүй. Ратна-гарба (*Их эрдэнийн зүрх*) бурханд мөргөмүй. Саманта-прабха (*Бүхэнд гэрэлтэгч*) бурханд мөргөмүй. Саманта-

алока (*Бүхэнд үзэгдэгч*) бурханд мөргөмүй. Су-ганда-кута-ража (*Хүжийн дээдийг давхарласны хаан*) бурханд мөргөмүй. Падмавара (*Цэцгийн дээд*) бурханд мөргөмүй. Тэгш болгоогч бурханд мөргөмүй. Ратна-шикхин (*Их эрдэнийн үснэрт*) бурханд мөргөмүй. Ратнагүрү (*Их эрдэнийн дээд*) бурханд мөргөмүй. Ратнапрабха (*Их эрдэнийн гэрэл*) бурханд мөргөмүй. Хиргүй гэрэл үзэгдэл бурханд мөргөмүй. Самбаагаар байгуулан таалагч бурханд мөргөмүй. Чандрапрабха-вишудди-кирти-кету (*Сарны гэрэл нэн ариун алдарын охийн хаан*) бурханд мөргөмүй. Кусума-прабха-виюуха (*Цэцэг гэрэл байгуулагч*) бурханд мөргөмүй. Гэрэл гэгээний хаан бурханд мөргөмүй. Пунья-вимала-кирти-ража (*Буяны гэрэл хир үгүй алдарын хаан*) бурханд мөргөмүй. Авалокитешвара-абаяа (*Мэлмийгээрээ болгоогчийн эрхт үл айгч*) бурханд мөргөмүй. Абаяа-кирти (*Аймшиг үгүйн алдар*) бурханд мөргөмүй. Правара-ража (*Маш дээд хаан*) бурханд мөргөмүй. Бодьсадва махасадва Авалокитешвара-д (*Жанрайсиг*) мөргөмүй. Бодьсадва махасадва Читигарба (*Саян нянбуу*) - д мөргөмүй. Бодьсадва махасадва Акашагарба (*Намхай нянбуу*) – д мөргөмүй. Бодьсадва махасадва Манжушри - д мөргөмүй. Бодьсадва махасадва Ваджра-пани - д мөргөмүй. Бодьсадва махасадва Саманта-бадра (*Гүндсамбуу*) - д мөргөмүй. Бодьсадва махасадва Ачаяа-мати (*Барагдашгүй оюунт*)-д мөргөмүй. Бодьсадва махасадва Махастана-прапта (*Их хүчийг олсон*) - д мөргөмүй. Бодьсадва махасадва Майтреяа-д мөргөмүй. Бодьсадва махасадва Саду-мати (*Сайн оюунт*)- д мөргөмүй “.

Тэдгээрт мөргөөд тогтоол үүнийг уншиж үйлдээрэй:

НАМУ РАТНА ТРАЯАЯ ТАДЯАТА КУТИ КУТИНИ  
ИМИРИТО КОШАНИ ИЮИРАНИ ИРИ СУХА”

Тэгээд Бурхан багш бээр бодьсадва Амгалан оршигч-д зарлиглав: “Энэ тогтоол нь гурван цагийн бурхадын эх мөн тул язгуурын хөвгүүн юмуу язгуурын охин хэн нэгэн тогтоол үүнийг хадгалах хийгээд бариваас буяны чуулган хэмжээлшгүй, жишишгүй арвижих болно. Тоолшгүй бурхадад хүндэтгэл хийгээд тахил, өргөл, сайшаалыг үйлдсэн болно. Тэдгээр бурхад ч дээр үгүй үнэнхүү төгсгөсөн бодид тэдгээрийг эш бошгийг үзүүлэх болно. Амгалан

оршигчоо, хэн нэгэн тогтоол тарни үүнийг хадгалагч тэр бээр хувцас хийгээд өдрийн зоог, их эрдэнэ, олонтаа сонсох хийгээд мэргэн, өвчин үгүй урт настай тэргүүтнийг сэтгэлчлэн олоод буян нь машид олноор арвижмуй. Юу хийгээд юу хүссэн тэр хийгээд тэд бүгд бүтэх болно. Амгалантай оршоод тарни үүнийг сэтгэлдээ хадгалах хийгээд бариваас дээр үгүй үнэнхүү төгсгөсөн бодийг олохыг хүртэл үргэлжид бодьсадва Суварна-нагара-парвата (*Алтан хот уул*) хийгээд Майтреяа бодьсадва, Сагара (*Далай*) бодьсадва, Авалокитешвара (*Бүхэнд мэлмийгээр болгоогчийн эрхт баялаг*) бодьсадва, Манзушри бодьсадва, Маха-видгала (*Их бингала*) бодьсадва тэргүүтэн лугаа хамт оршоод бодьсадва тэдгээр бээр сахин үйлдэх болой.

“Амгалан оршигч оо, энэхүү тогтоолыг бүтээх зан үйл нь энэ хэмээн мэдэж үйлд. Анхлан урилга тарнийг нэг түм найман тоог дүүртэл уншиж бүтээн үйлдэх болно. Дараа нь аглаг зэлүүд байшингийн дотор хот мандалыг хийгээд арван зургааны өдөр угаал үйлдэж шинэ хувцас өмсөөд хүж, цэцэг, олон янзын амны идээ тэргүүтнээр тахил өргөж, хот мандалын дотор суугаад, эхлээд урьд өгүүлсэн бурхад болон бодьсадва нарын алдарыг өгүүлээд, бишрэнгүйгээр мөргөх хийгээд нүгэл хилэнцээ наминчлаад, баруун өвдгөө газарт сөхрөөд, тэрхүү тарнийг нэг мянга найман тоог дүүртэл уншина. Тэгээд биеэ цэх болгон суугаад юу хүссэн түүнийгээ санаандаа бодоорой. Нар ургахаас өмнө хот мандалын дотор ариун амны идээг нэг суудал дээр иднэ. Ийнхүү арван тав хоног болоод сая хот мандалын дотроос гарах бөгөөд хүмүүн тэр нь буян болон сүр хүч санаанд багташгүй лугаа төгөлдөр болж, санасан санаа бүгд бүрэн гүйцэх болно. Хэрвээ санаа эс бүтэхнээ ч хот мандал тэнд сууваас санаа бүрэн гүйцэх болох учраас тэрнээс хойш ч үргэлжид даган дурьдаж үйлдээрэй.”

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлгөн судраас*

*"Алтат нэрт тогтоол" хэмээх наймдугаар бүлэг болой.*

\* \* \*

## IX бүлэг: Хоосон чанар

Бурхан багш тэрхүү тогтоолыг зарлиглаж дуусаад мөн бас тэр цагт бодьсатва махасатва нар ба тэнгэр, хүн тэргүүтэй хурсан нөхөд тэдгээрт туслах хийгээд амгаланд хүргэхийн тул үнэмлэхүй үнэн хоосон чанарыг үзүүлсэн шүлэг эдгээрийг зарлиглавай:

Хосгүй гайхамшигт бусад судруудад  
Хоосон чанарыг дэлгэрэнгүй номлосон тул  
Харин судрын дээд *Алтангэрэл* үүнд  
Хоосон чанарыг товчхон төдий номлоё.

Ухаан өчүүхэн амьтад нэн мунхарсан тул  
Ухаж юмс бүгдийг мэдэж үл чадмуй.  
Учир иймийн тул судрын дээд үүнд  
Үнэмлэхүй хоосон чанарыг товч төдий номлоё.

Амьтан бүгд хожим мэдэх болох  
Ирээдүйн тэдэнд нигүүлсэнгүй сэтгэлийн эрхээр,  
Арга ёс шалтгаан бусад бүгдээр  
Эрхт дээд судар үүнийг номлоё.

Энэхүү бие нь хоосон хот мэт бөгөөд  
Эрхтэнүүд нь цэрэг дээрэмчин хулгайч адил  
Хамаг бүгд нэгэн балгасанд оршивч  
Харилцан бие биенээ нэн үл мэдмой.

Нүдний эрхтэн өнгө дүрсэнд шохоорхож,  
Чихний эрхтэн дууг нэн сонсоно.  
Хамрын эрхтэн элдэв үнэрт тачааж,  
Хэлний эрхтэн үргэлжид амтанд ташуурна.  
Биений эрхтэн хүрэлцэхүйн тулд гүйж,  
Сэтгэлийн эрхтэн юмсыг нэн ажиглана.

Эдгээр зургаан эрхтэн янагш чанагш  
Өөр өөрийн орондоо машид орж үйлдэнэ.  
Дотоод сэтгэл нь илбэ мэт хөдлөх,  
Тэдгээр зургаан эрхтэн орныг нэн мэдрэх,  
Хоосон тосгонд хэн нэгэн гүйх хийгээд  
Хулгайч дээрэмчин цэргүүд орших мэт.

Ямар мэтээр мэдрэх зургаан оронд орших бөгөөд  
Эрхтэний явдлын орнуудыг ч машид мэдэх;  
Тэр мэт сэтгэл нь орон, орших сэлт хийгээд  
Эрхтэний явдлын орнуудыг ч машид мэдмүй.

Аливаа дүрс, дуу мөн үнэр хийгээд  
Амт хүрэлцэхүй бас мэдлийн орон юмс,  
Алин зургаан эрхтэн бүгдэд бидний сэтгэл,  
Автаж эрхэнд орсон мэт хөдлөх болно.  
Эрхтэн алин хаана оршин буй  
Эрхтэн тэр нь мэдлийн мөн чанартай

Энэ бие нь хөдлөх үгүй, үйлдвэр үгүй ба,  
Эцэстээ шимгүй шалтгаанаас гарсан мөн.  
Үнэмлэхүй бус бодол сэтгэлээс гарсан,  
Үйлийн эндүүрэгт хоосон балгас мэт.

Үүсгэгч шороо, гал, ус, хийнүүд  
Өөр өөр зүгийн балгасанд оршино.  
Үлгэрлэвээс хорт могойнууд нэг үүрэнд цуглаваас,  
Үргэлжид харилцан үл зохилдох мэт.

Үзтэл махбодын дөрвөн могой тэдгээр нь ч  
Хоёр нь өөдөө, хоёр нь уруу тэмүүлмой.  
Дөрвөн зүг зовхист хоёр хоёр бөгөөд  
Дөрвөн махбодын могой тэд эвдрэх болно.

Шороон могой ба усны могой хоёр,  
Шууд доош сувиран барагдах болно.  
Галын могой ба хийн могой хоёр,  
Гарцаагүй дээш огторгуйд одох мөн.

Урьд үйлдсэн үйл тэдгээрийн эрхээр  
Ухамсар, сүнс бүгд орноосоо явмой.  
Тэнгэр, хүн, гурван муу заяа зэрэг  
Тэр мэт үйлдсэн үйлийн сансарт төрмүй.

Бадгана, хий, шар нь барагдах болбоос,  
Баас, шээс, бөөлжсөөр бие нь дүүрч,  
Хэн ч үл баясах хорхойн цогцос болж,  
Хүүрийн дотор орхигдож мод мэт хатна.

Охин тэнгэр чи бээр эдгээр жам ёсыг хар.  
Орчлон энд амьтан хэн нэгэн байхнаа ч,  
Юмс үзэгдэл тэд бүгд хоосон чанартай.  
Мунхаг сэтгэлийн шалтгаанаас гарсан мөн юм.

Их махбод эдгээр нь ихээс гарах бус,  
Үл гарахаас гарсан, гарах нь үгүй болой.  
Алины тул гарсан ч бус, эс гарсан ч бус  
Тиймийн тул их махбод хэмээн би өгүүлсэн.  
Байгаа бус ба, хэзээ ч байгаа бус.  
Мунхаг сэтгэлийн шалтгаанаас гарсан мөн.

Мунхаг энэ нь байгаа бус бөгөөд  
Тиймээс би мунхаг үүнийг номлосон.  
Хуран үйлдсэн, тийн мэдэл, нэр, дүрс сэлт  
Хамаг төрөн түгэхүй, хүрэлцэхүй, мэдрэхүй хийгээд  
Тачаахуй, хүсэхүй түүнчлэн сансар хийгээд  
Төрөх, хөгшрөх, үхэх гаслан хорлол бүгд

Орчлонгийн зовлон санаа сэтгэлд багташгүй  
Орчлонгийн хүрд ямар мэт оршсон бүгд  
Эс гарсанаас гарсан ба үл гарсан хийгээд  
Ёс бусын сэтгэлээр нэн ажиглах хийгээд

Би-д барих үзлийг тасалж үйлд;  
Билгүүний илдээр нисванисын торыг тасал;  
Гутамшгийн оронд хоосон болохыг үз;  
Гэгээрлийн эрдэм агуу ихийг мэдэж үйлд.

Рашааны их хотын үүдийг ч би нээмүй  
Рашааны дуслын савыг ч бүхэнд үзүүлмүй.  
Рашааны их хот түүнд би ормуй.  
Рашааны дуслаар өөрийгөө би цэнгүүлмүй.

Дээд номын их хэнгэргийг би дэлдмүй.  
Дээд номын цагаан лавайг ч би үлээмүй.  
Дээд номын зулыг би бадраамуй.  
Дээд номын хурыг би буулгамуй.

Нисванисын дайсны чуулганыг би ялна.  
Номын дуаз дээдийг би өргөнө.  
Гутамшигт орчлонгийн далайгаас амьтныг машид гэтэлгэж,  
Гурван муу заяаны мөрүүдийг би хаамуй.

Өөдгүй нисванисын галаар энэлсэн амьтад,  
Өмөг садан үгүй, шүтээн үгүй болсон бүгдийг  
Амьтад нисванисын галаар энэлсэнийг амирлуулж,  
Рашааны сэрүүн дуслаар цэнгүүлж би үйлдмүй.

Сэтгэшгүй олон галвын тэртээгээс би,  
Санаанд багташгүй олон сартваахийг тахин үйлдэж,  
Номын лагшин түүнийг бүрнээ эрэн хайж,  
Номхон журамт явдлаар бодийн тулд хичээв.

Гар, нүд, хөлөө болон  
Гишүүний дээд ба үзэсгэлэнт охин, хөвгүүнээ,  
Эд, эрдэнэ, сувдан чимэг ба алт,  
Элдэв их эрдэнэ, биндэрьяа бүхнийг өргөсөн.

Олон мянган найлзуур мод бүгдийг  
Өвс ногоо ургамал бүгдийг  
Ой цэцэрлэг ба шимт газраас  
Ургасан бүгдийг таслан хумиад,

Тэд бүгдийг нухлан буталж  
Тун нарийн тоос мэт болгож  
Огторгуйн хот мандал хэдий төдийд

Үйрмэгийн цогцыг хураан цогцлоож  
Үүнийг гурван хувь хувааж чадмуй.

Газарт байгаа тоосонцор бүгд  
Гурван мянган ертөнц бүгдийн  
Тоосны орон санаанд багташгүй.

Амьтан бүгдийн мэдэл алин  
Түүнийг нэгэн амьтан болгож  
Аливаа мэдэл түүгээр тооснуудын  
Үйрмэгийг тоолж үйлдэх аваас,  
Бүх амьтдаас үлэмж илүү  
Билиг ухаан төгөлдөр хүмүүс бээр  
Бүгдийг тоолж чадах байхнаа ч  
Бурханы ухааныг үл чадмуй.

Онцгой их чадагчийн билгүүн  
Үтэр түргэн сэтгэх боловч  
Олон голди галавын турш  
Алинд ч тоолж үл чадмуй.

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлгөн судраас*

*"Хоосон чанар" хэмээх есдүгээр бүлэг болой.*

\* \* \*

*Х бүлэг: Хоосон чанарт шүтээд  
санаагаа бүрэн үйцээх*

Тэгээд Ратна-арчи (мон: *Гэрэл цацруулсан их эрдэнэ*) нэрт охин тэнгэр машид гүнзгий ном айлдвар түүнийг сонсоод баясал бишрэл төрж, хурсан нөхөд түүний дотроос суудлаасаа босоод, номт хувцсыг нэг мөрөндөө буулгаж, баруун өвдгөө газарт хатгаж, Ялж төгс нөгчсөн бурхан хаана буй тэр зүгт алгаа хавсран сөгдөөд, гүнзгий сургаал үүнийг ямар мэт бясалгахыг асуухын тул бурхан багшид ийн шүлэглэн айлтгав:

Хоёр хөлтөний эрхэм ялгуулсан,  
Хорвоо ертөнц бүхнийг гийгүүлэгч,  
Бодийн замнал үнэнхүү ёсыг  
Бидэнд нигүүлсэнгүйгээр номлон соёрх.

Язгуурын охин тэнгэрт: “Чамд эргэлзээ юу байна, асуух зүйлээ айлтгагтун. Сайтар ялган номлож үйлдье” хэмээн зарлиглав.

Тэгээд Язгуурын охин тэнгэр бээр Бурхан багшид дахин ийн айлтгав:

Өөр болон бусдад туслахын тул  
Их бодьсадва нар бүгдээр  
Орчлон болон нирваанаас хагацсан  
Бодийн явдлыг хэрхэн үйлддэг вэ?

хэмээхүйд Бурхан багш бээр язгуурын охин тэнгэрт ийн хэмээн зарлиглав: “Охин тэнгэрээ, номын чанарт оршоод бодийн явдалд хичээснээр тэгш ямагтад шамдаж үйлдээрэй.”

Тийн зарлиглахад язгуурын охин тэнгэр бээр Бурхан багшид ийнхүү айлтгав: “Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, хэрхэн номын чанарт оршоод бодийн явдалд хичээх хийгээд тэгш ямагтад шамдаж үйлдэх вэ?”

Бурхан багш зарлиглав: “Охин тэнгэрээ, тэр нь таван цогцосыг номын чанар хэмээн нэрийдсэн бөгөөд номын чанар нь таван цогцос ямагт болой. Таван цогцос нь ч өгүүлшгүй, таван цогцос бус нь ч өгүүлшгүй бөгөөд номын чанар тэр нь таван цогцос мөн болбоос тасрахын хязгаарт унамуй. Хэрвээ таван цогцсоос тусдаа гэж үзвээс мөнхийн хязгаарт унах болно. Хоёр бэлэг хагацсан, хоёр хязгаарт үл оршсон, үзэл үгүй, үзэгдэхүүнээс хэтэрсэн нэр ба бэлэг үгүй тэр нь номын чанар хэмээн өгүүлсэн юм. Язгуурын охин тэнгэрээ, таван цогцсыг номын чанарт хэрхэн нэрийдэв хэмээвээс таван цогцос тэр нь уг ба шалтгаанаар эс үүссэн бөгөөд тэр нь ч хэрвээ уг хийгээд шалтгаанаас төрсөн мөн болбоос төрсөнөөс төрөв үү, эс төрсөнөөс төрөв үү хэмээнэ. Хэрвээ төрсөнөөс төрвөөс уг хийгээд шалтгаан ч хэрэггүй. Хэрвээ эс төрсөнөөс төрвөөс төрөх үгүй болно. Тэр ямар учраас хэмээвээс, аливаа эс төрсөн юмс нь эс орших мөн тул нэр үгүй, бэлэг үгүй, мэдэх, жиших, үлгэрлэхээр өгүүлшгүй бөгөөд уг хийгээд шалтгаанаар үүсгэгдэхүүн бус болой. Язгуурын охин тэнгэрээ, үлгэрлэвээс хэнгэргийн дуу нь мод ба шир, гарын хөдөлгөөнд шүтээд дуу гарсан мөн боловч хэнгэргийн дуу тэр нь өнгөрсөнд ч хоосон, ирээдүйд ч хоосон, одоо орших нь ч хоосон бөгөөд тэрхүү хэнгэргийн дуу нь модноос гараагүй, шир ба гарын хөдөлгөөнөөс ч гараагүй, гурван цагт үл үүссэн тул эс төрсөн бөгөөд аливаа эс төрсөн тэр нь үл эвдрэх мөн. Аливаа үл эвдрэх тэр нь хаанаас ч үл ирмүй. Хаанаас ч үл ирэх тэр нь хаашаа ч үл одмуй. Хаашаа ч үл одох тэр нь мөнхрөх болон тасрах бус тул, нэгдмэл ч биш, тус тусдаа ч биш болой. Түүний учир юу хэмээвээс, хэрвээ нэгдмэл мөн болбоос номын чанараас тусдаа биш болох тул эгэл жирийн төрөлхтөнүүд ч үнэмлэхүй үнэнийг илтэд мэдэрч, гаслангаас гэтэлсэн дээд амгаланг олох болно. Гэтэл тийм бус учраас тэр нэгдмэл биш юм. Хэрвээ тэр тус тусдаа мөн болбоос бурхан ба бодьсдва нарын онож мэдсэн нь ч зөвхөн бэлэг түүнийг барьсан мөн болох тул нэн гэтлэх нь ч үл болох бөгөөд нисванисын хүлээснээс үл хагацах учраас дээр үгүй үнэнхүү төгсгөсөн бодид илтэд үл гэгээрсэн болно. Тэр ямар учраас хэмээвээс, хутагт нар нь хуран үйлдсэн хийгээд хуран эс үйлдсэн хоёр үнэмлэхүй мөн чанарт нэгдмэл тул, тус тусдаа биш болой. Тийм учраас таван цогцос тэр нь оршин байгаа ч биш, эс оршихуй

ч биш, уг хийгээд шалтгаанаар үүссэн ч биш, уг хийгээд шалтгаан үгүйгээр үүссэн ч биш, үгээр онож үл өгүүлэгдэх, нэр ба бэлэг үгүй, уг ба шалтгаан үгүй, үлгэрээр үзүүлшгүй, эхэн адаг үгүй, өөрийн аяндаа хоосон. Учир үүнийг нь хутагт нар бээр болгоон үйлдсэн мөн бөгөөд өөр бусдын мэдлийн орон биш юм. Тиймээс таван цогцсыг номын чанарт үзүүлсэн болой. Бас язгуурын охин тэнгэрээ! Аливаа язгуурын хөвгүүн юмуу язгуурын охин хэн нэгэн бээр дээр үгүй үнэнхүү төгсгөсөн бодь үнэмлэхүй хийгээд янагуух, бусад ба бусад бус хэмээн үздэг тэр нь жишихэд бэрхтэй бөгөөд хутагт болон эгэл төрөлхтөний мэдлийн орон нь нэгдмэл болон тус тусын мөн чанар биш бөгөөд янагуухийг ч үл тэвчиж, үнэмлэхүйгээс ч үл хагацах тэр нь номын чанарт оршсон бодьсадын явдалд хичээсэн мөн.”

Тэр цагт бурхан багш ийн зарлигласан хийгээд, язгуурын охин тэнгэр тэр машид баясан сэтгэлийн амгалан төрөөд суудлаасаа босож, оройгоороо мөргөөд, дээд хувцсыг нэг мөрөндөө буулгаад, баруун хөлөө газарт сөхрөөд, алгаа хавсран бөхийж Ялж төгс нөгчсөн бурханд ийн хэмээн айлтгав: “Бурхан багшаа, ямар мэт Ялж төгс нөгчсөн бээр зарлигласан бодьсадвын явдал түүнд би шамдан суралцмуй.”

Мөн тэр үед хурсан нөхдийн дунд сууж байсан “Тэсэшгүй” ертөнцийн эзэн Их Эсрэн тэрбээр язгуурын охин тэнгэр Ратна-арчи-гаас ийнхүү асуув: “Охин тэнгэрээ, бүтээхэд машид бэрхтэй бодьсадын явдалд чи хэрхэн бясалгаж эрхийг олов?”

Түүний хариуд язгуурын охин тэнгэр бээр Их Эсрэн тэнгэрт ийн өгүүлэв: “Эсрэнгийн их хаантаан, Ялж төгс нөгчсөн бээр ямар мэт зарлигласан тэрхүү утга нь машид гүнзгий учраас эгэл төрөлхтөн бүгд түүний утгыг үл мэдэх бөгөөд хутагт нарын мэдлийн орон учраас хамгаас нарийн мэдэхэд бэрхтэй болой. Би энэ номыг бясалгаж амгалан оршихуйг олсон билээ. Хэрвээ энэхүү үг үнэн болбоос, таван цөвүүн цагийн эдгээр ертөнцийн хэмжээлшгүй, тоолшгүй, жишишгүй амьтан тэдгээр бүгд алтан өнгөтэй болоод гучин хоёр бэлгэ төгөлдөр, эрэгтэй ч бус, эмэгтэй ч бус ямагт болоод их эрдэнийн цэцгэн суудалд сууж, хэмжээлшгүй амгаланг эдлэх хийгээд тэнгэрийн гайхамшигт цэцгийн хур бууж, тэнгэрийн

яруу аялгуу ба цохиур чавхдасгүй өөрөө гарсан хөгжмийн тахил тэр бүгдээр төгөлдөр бологтун” хэмээн өгүүлсэн даруйд таван цөвүүн цагийн ертөнцийн орон бүгдэд амьтан хэдий чинээ байгаа тэдгээр бүгд алтан өнгөтэй, их төрөлхтөний бэлгэ төгөлдөр, эрэгтэй ч бус, эмэгтэй ч бус болоод их эрдэнийн цэцгэн суудалд сууж, хэмжээлшгүй амгаланг эдлэх болов. Адилтгаваас, “Бусдын хувилгааныг эрхэнд үйлдэгч” хэмээх тэнгэрийн сэтгэшгүй харшид муу заяа бүгд үгүй болж элдэв янзын их эрдэнийн галбирвасан мод цэцгэлж, долоон янзын их эрдэнийн цэцгээр ертөнцийн орон түгэж, долоон их эрдэнэ хийгээд тэнгэрийн цэцгийн хур бууж, элдэв янзын тэнгэрийн хөгжмийг сонсон цэнгэж суух мэт болов. Тэгээд язгуурын охин тэнгэр Ратна-арчи өөрөө эмэгтэй биенээсээ эсрэн тэнгэрийн биед хувиран суув.

Эсрэнгийн Хаан бодьсадва Ратна-арчи-гаас ийн хэмээн асуув: “Ариун санваартаан, та хэрхэн бодьсадын явдлаар замнасан бэ?”

Өгүүлэв: “Эсрэнгийн их хаантаан, усанд туссан сар адилд бодож бодийн явдалд хичээх зэргээр би ч бодийн явдалд хичээсэн. Зүүд адилд бодож бодийн явдалд хичээх мэт би ч бодийн явдалд хичээсэн. Зэрэглээ адилд бодож бодийн явдалд хичээх мэт би ч бодийн явдалд хичээсэн. Цуурай адилд бодож бодийн явдалд хичээх мэт би ч бодийн явдалд хичээсэн болой.”

Тийнхүү номлохыг Их Эсрэн бээр сонсоод бодьсадвагаас ийнхүү асуув: “Ариун санваартаан, та утга алинд оршоод үг үүнийг өгүүлэв?”

Охин тэнгэр бээр өгүүлэв: “Эсрэнгийн хаантаан, ямар ч юмс уг болон шалтгаанд шүтэж бүтсэн учир, үнэн мөн чанараараа эс бүтсэн мөн.”

Эсрэнгийн хаан бээр: “Хэрэв тийм болбоос эгэл төрөлхтөн бүгд ч дээр үгүй үнэнхүү төгсгөсөн бодид илтэд гэгээрсэн бурхан болох нь ээ?” хэмээн өгүүлэв.

Өгүүлэв: “Төрөлхийтөн та юуны тулд тийнхүү өгүүлнэ вэ. Эгэл нялхас ч өөр, мэргэн нь ч өөр, бодь ч өөр, бодь бус ч өөр, нэн гэтлэхүй

ч өөр, нэн гэтлэхүй бус нь ч өөр мөн гэсэн боловч, Их Эсрээн, тэдгээр бүгд нь номын чанарт тэнцүү тул тус тусдаа бус, үнэнхүү ялгал үгүй, завсар үгүй, арвижих хийгээд хомсдох үгүйд илтэд тачаан барьсан болой. Эсрэнгийн хаантаан, үлгэрлэвээс, илбэчин юмуу түүний шавь илбэ хувилгаанд мэргэжсэн, судалсан нэг бээр, замын уулзварт шороо, элс, мод, өвс, навч тэргүүтнийг нэгэн дор хураагаад илбэ болгон хувилгах, жишээлбээс, адуу үхрийн чуулган хийгээд цэрэг ба морин тэрэг тэргүүтний чуулган, долоон янзын их эрдэнийн цогц, гуу сан тэргүүтэн элдэв янзыг бүхэнд үзүүлэх цагт, учир үл мэдэх эгэл амьтад тэднийг үзээд илбэ хувилгаан гэж мэдэхгүй, адуу, их заан, тэргүүтэн үзэгдэж сонсогдсон эдгээр нь ‘үнэхээр байгаа мөн’ бөгөөд бусад нь худал хэмээн санах ба хожим нь ч түүнийг нягтлан ажиглаж үйлддэггүй. Харин учрыг мэдэгч мэргэд бээр, тэдгээрийг тэр мэт биш бөгөөд илбэ хувилгаан мөн гэдгийг мэдэж, үзэгдэж сонсогдсон тэдгээрт ийн хэмээн бодох буюу адуу их заан тэргүүтэн миний үзсэн эдгээр нь ‘үнэнхүү бус’ илбэдэн хувилгаж бусдын нүдийг хуурсан бөгөөд адуу, их заан, гуу сан тэргүүтэн эдгээр нь тэдгээрт үзэгдэх төдий, миний үзсэн сонссончлон үнэн бус гэж бодно. Хожим нь нягт ажиглахнаан ч худал хуурмагийн зүйлд мэдэх болой. Тийм учраас, мэргэн ухаантнууд нь эдгээр юмс бүгд нь үнэмлэхүй бус мөн чанартайг мэдэж, ямар мэт үзэгдэж сонсогдохноон ч хуурмаг төдий тэдгээрийн утгыг жишин, үгийн томъёололд шүтээд үнэмлэхүй утгыг мэдэн үйлдэх төдийд барагдана. Үнэмлэхүй утга нь тэр мэт биш болой хэмээнэ. Бас Их Эсрээн, эгэл төрөлхийтөн буюу ертөнцөөс хэтэрсэн хутагтын билгүүний нүдийг эс олсон тэдгээр нь, эдгээр юмс бүгдийн мөн чанар өгүүлшгүйг ч үл мэдэж, алин үзсэн, сонссон хийгээд хуран үйлдсэн, эс хуран үйлдсэн юмс бүгд ямар мэт харагдах тэр дагуу үнэхээр бүтсэн гэж илтэд шунах тул, юмсын мөн чанар өгүүлшгүй үнэмлэхүй утгын ёс түүнийг мэдэж үл чадмой. Харин хутагт нар алин болгоож, сонссон ба хуран үйлдсэн, хуран эс үйлдсэн юмс бүгдийн алин хүч хийгээд үйл мэт эд, мөн түүнд үнэн болой хэмээн илтэд үл шунах бөгөөд хуран үйлдсэн юм ч үнэн бус, хуран эс үйлдсэн юм ч үнэн бус, үнэмлэхүй бус бодлоор нэрийдсэн төдийд, хуран үйлдсэн хийгээд хуран эс үйлдсэн юмсын мөн чанар нь ч нэр төдий л болохоос үнэн мөн чанарт бүтээгүй.

Тиймээс хутагт нар янагуух нэр томъёонд тулгуурлан үнэмлэхүй үнэний утга түүнийг номлож үйлдэнэ. Эсрэнгийн хаантаан, мөн алин хутагт нар нь хутагтын билгүүн хийгээд хутагтын ухаарснаар юмсын мөн чанар өгүүлшгүй тэр мэтээр хуран үйлдсэн ба хуран эс үйлдсэн юмс ч мөн адилаар янагуух утганд нэр ба бэлэгт тулгуурлан бусдад номлож үйлддэг юм.

Чингээд Их Эсрэн бээр бас бодьсатва Ратна-арчи-д ийн хэмээн өгүүлэв: “Хэдий төдий амьтад энэхүү гүнзгий номыг онох ба мэдэж чадах вэ?”

Өгүүлэв: “Их эсрэн, алин олон хувилгаант сэтгэл болон сэтгэлээс гарснаар гүнзгий ном үүнийг үнэнхүү мэдэх болсон тэд бээр мэдэх болой.”

Эсрэнгийн хаан асуув: “Хувилгаан тэдгээрт ч мөн чанар байгаа бус болбоос тэдгээрийн сэтгэл болон сэтгэлээс гарсан хаанаас төрөх вэ?”

Өгүүлэв: “Алин номын чанар байгаа ч бус, байхгүй ч бус гэдгийг үнэнхүү мэдсэн тэдгээр бээр гүнзгий түүний утгыг мэдэж чадах болой” гэв.

Тэгээд Их Эсрэн бээр Ялж төгс нөгчсөн бурханд ийн хэмээн айлтгав: “Ялж төгс нөгчсөөн, энэ бодьсатва Ратна-арчи нь сэтгэшгүй гайхамшигтай. Учир нь гүн гүнзгий гол ном үүнд мэргэжсэн байна.” гэв.

Бурхан багш зарлиглав: “Тэр тийм болой. Тэр ямар мэт Их Эсрэн таны өгүүлсэн тэр мэт юм. Энэ бодьсатва Ратна-арчи бээр танд ямар мэт үзүүлсний дагуу шамдан бүтээгтүн. Үл төрөхүйн номонд тэвчээрийг олох болно.” хэмээв.

Тэгээд тэнгэрийн хаан Их эсрэн болон бусад эсрэнгийн нөхөд тэд суудлаасаа босоод дээд хувцсаа нөг мөрөндөө буулгаж, баруун өвдгөө газарт сөхрөөд, алгаа хавсран бодьсатва Ратна-арчи-ийн хоёр өлмийд оройгоороо мөргөөд, үг үүнийг өгүүлэв: “Өнөөдөр их төрөлхтөн таньтай учирч, бид нар дээдийн ном энэ мэтийг сонсох болсон нь ихэд гайхамшигтай байна.”

Тэгээд Ялж төгс нөгчсөн бурхан Их эсрэнд хандан: “Бодьсадва Ратна-арчи энэ бээр ирээдүй цагт Ратна-прабха-шри-гарба (*мон: Их эрдэнийн гэрэл цогийн зүрхэн*) нэрт Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн, ухаан ба өлмий төгөлдөр, амгалан заларсан, ертөнцийг болгоогч, дээр үгүй төрөлхтөнийг гэгээрүүлэх жолоог залуурдагч, тэнгэр ба хүний багш, ялж төгс нөгчсөн бурхан болно” хэмээн зарлиглав.

Тийнхүү зарлиглах тэр цагт түм гурван мянган бодьсадва бээр дээр үгүй үнэнхүү төгсгөсөн бодиос эргэн үл буцах болов. Нэг түм найман мянган тэнгэрийн хөвгүүд хийгээд хаан, түшмэл тэргүүтэй хэмжээлшгүй тоолшгүй нар тоос үгүй ба тоосноос хагацсан номд нэн ариун номын нүдийг олоод мөн хурсан нөхөд тэдний дотор тавин түмэн гэлэн, бодьсадын явдалд хичээгч, бодийн сэтгэлээс эргэн үл буцахыг санагч тэдгээр ч бодьсадва Ратна-арчи энэхүү номыг номлохыг сонсоод бодийн сэтгэл нь хойшид улам батжиж, сэтгэшгүй, дээр үгүй ерөөлийг бүрэн гүйцээгээд дахин бодь сэтгэлийг үүсгэж, тус тусдаа өөр өөрийнхөө өмссөн хувцсыг тайлаад бодьсадвад өргөж, дээр үгүй дээдийн дээд сэтгэлийг үүсгээд ерөөлийг ийнхүү соёрхов: ‘Бид нар буяны суурь юу байгаа тэд бүгдийгээ дээр үгүй үнэнхүү төгсгөсөн бодид бүрэн зориулмой’ хэмээн ерөөл тавив.

“Их Эсрээн, эдгээр гэлэнгүүд тэрхүү буяндаа шүтээд ямар мэт өгүүлснээрээ шамдан бүтээгээд ерэн их галвын дараа орчлонгоос огоот гэтлэхийн оюун мэдэл төрөх болно.” Тэгээд Ялж төгс нөгчсөн бурхан тэдгээр гэлэнгүүдэд зарлиглав: “Гэлэнгүүдээ, та нар тоолшгүй гучин галав өнгөрсөний хойно дээр үгүй, гэгээрсэн бурхан болох бөгөөд галвын нэр нь Дур-жаяа-прабха-ража (*мон: Ялахад бэрхтэй гэрэлийн хаан*) хэмээх ба орны нэр нь Хир үгүй гэрэл хэмээгчид нэг цагт бүгдээр дээр үгүй, үнэнхүү төгсгөсөн бодид илтэд гэгээрсэн бурхан болох болно. Тэд бүгд ч алдар нь Ерөөлийг нэн байгуулсан хаан хэмээн эрдмийн арван алдрыг бүрэн гүйцээх болно” хэмээн эш бошиг үзүүлэв.

“Бас Их Эсрээн, дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан үүнийг алин сонсох хийгээд сэтгэлдээ барих тэдгээр нь хүч

болон их сүр жавхлан төгөлдөр болно. Үлгэрлэвээс, хэн нэгэн бээр төгөлдөр бус аргаар зургаан чанадад хүрэхээр найман мянган их галавт хичээснээс, алин язгуурын хөвгүүн юмуу, язгуурын охин хэн нэгэн бээр дээд *Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* үүнийг сударт бичээд сарын хагасын хагаст нэгэн үзүүрт сэтгэлээр уншваас, урьдах буяны цогц тэр нь буяны цогц үүний зуун хувьд нь ч хүрэх үгүй, тоонд тоолох хийгээд үлгэрлэн жишиж ч чадахгүй болой. Их эсрээн, тийм учраас та үргэлжид сэтгэлдээ бясалгаж, шамдан бүтээх хийгээд сэтгэлдээ барьж бусдад ч үнэнхүү агуу ихээр номлож үйлдээрэй. Тэр юуны тулд хэмээвээс, урьдын өнгөрсөн цагт би бодьсадын явдалд хичээхдээ, ямар мэт баатарлаг төрөлхтөн байлдаанд амь биеэ үл хайхардаг мэт, би ч судрын аймгийн эрхэт хаан үүнийг сэтгэлдээ барих, санах, унших хийгээд бусдад ч агуу ихээр үзүүлэхэд торолтгүй болсон болой. Их эсрээн, үлгэрлэвээс Хүрдэн урвуулагч хаан ертөнцөд хэдий оршихыг хүртэл долоон зүйлийн их эрдэнэ ч үгүй болохгүй болой. Хэрвээ хаан эс оршвоос долоон зүйлийн их эрдэнэ ч тэр даруйд үгүй болно. Их эсрээн, тэр мэт түүнчлэн дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан энэ ертөнцөд хэзээ оршихыг хүртэл ханьцашгүй ном их эрдэнэ бүгдээр ч доройтохгүй болно. Энэхүү судрын аймгийн хаан нь хэзээ үгүй болбоос бусад нь ч доройтох болно. Тийм учраас судрын аймгийн хаан үүнийг нэгэн үзүүрт сэтгэлээр сонсох, барих, унших, бусдад агуу ихээр номлох, үсгэнд бичихээр оруулах хийгээд амь биендээ харамлалгүй, алжаал зүдрэлийг гэвчих, хичээнгүйн чанадад хүрэхэд шамдаж үйлдэх бөгөөд буяны дотроос дээд нь мөн гэж миний нөхдүүд ч тэр мэт суралцах хийгээд шамдаж үйлдээрэй.” хэмээв.

Эсрэнгийн их хаан тэргүүтэн тоолшгүй Эсрэнгийн нөхөд, тэнгэрийн эрхэт Хурмаст хийгээд Дөрвөн их хаан, бас Ягчисын хаан тэргүүтэн тэд бүгд суудлаасаа босоод дээдийн хувцсыг нэг мөрөндөө буулгаж, баруун өвдгөө газарт сөхрөөд, алгаа хавсран бөхийж, Ялж төгс нөгчсөн бурханд ийн хэмээн айлтгав: “Ялж төгс нөгчсөн бурхаан, бид нар ч дээд *Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* үүнийг сахих хийгээд бүрэн дэлгэрүүлж үйлдэнэ. Энэхүү номыг номлохын цагт зэтгэр болон саад бүхнийг арилгаж, буян болох хийгээд өнгө ба хүч бүрэн гүйцэж, торолтгүй самбаа, бие болон

сэтгэлийн амгалантай болмой. Түүний нөхөд шавь нар ч амгаланг амсах хийгээд алинд оршсон орон тэнд ч зуд турхан, дайсны аюул, хүмүүн бусын хөнөөл нэг байхнаан ч тэнгэр бидний нөхдүүд бүрэн сахих учраас тэнд амгалан жаргалантай болж, хорлол саад гарахгүй болно. Тэд ч тэнгэр бидний хүчийг эрж үйлдэнэ. Хэн нэгэн бээр судар аймаг үүнийг тахин хүндэлж үйлдвээс түүнийг бид нар Ялж төгс нөгчсөн бурхан адил тахин хүндэлж үйлдэнэ.”

Тэгээд Ялж төгс нөгчсөн бурхан бээр тэнгэрийн хаан Их Эсрэн тэргүүтэй тэдгээр тэнгэрийн нөхөд хийгээд Дөрвөн их хаан ба Ягчисын хаан тэргүүтэн нарт сайн болой хэмээн зарлиглав: “Сайн болой, сайн болой! Язгуурын хөвгүүн та, гүнзгий дээдийн ном үүнийг ч сонсож, судрын аймгийн хаан энэ болон үүнийг баригчийг сахих хийгээд аврахын сэтгэлийг үүсгэсэн түүгээр хэмжээлшгүй буяны ялгамжаа төгөлдөр болж үтэр түргэн дээргүй, үнэнхүү, төгсгөсөн бодид илтэд гэгээрч бурхан болно.”

Ялж төгс нөгчсөн тийн хэмээн зарлиглахад Эсрэнгийн хаан тэргүүтэн бурхан багшийн зарлигийг илтэд магтав.

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлгөн судраас*

*”Хоосон чанарт шүтээд санаагаа бүрэн цүйцээх” хэмээх  
аравдугаар бүлэг болой.*

\* \* \*

*ХI бүлэг: Их дөрвөн хаан тэнгэр болон  
хүмүүнд нэн харсан*

Тэгээд их хаан Вайшравана (*мон: Нэн сонсогчийн хөвгүүн, түвд: Намсрай*) болон их хаан Дргараштра (*мон: Орныг сахигч*), их хаан Вирудака (*мон: Хутагт төрөлт*), их хаан Вирупакша (*мон: Мэлмий сайн бус*) нар суудлаасаа босоод дээдийн хувцсыг нэг мөрөндөө буулгаад баруун өвдгөө газарт сөхөрч, Бурхан багш хаана буй тэр зүгт алгаа хавсран бөхийж бурхан багшид ийн хэмээн айлтгав: “Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* энэ нь Түүнчлэн заларсан бүгдийн зарлиг, Түүнчлэн заларсан бүгдийн болгоол, Түүнчлэн заларсан бүгдийн таалал, бодьсадын чуулган бүгдээр огоот барьсан, тэнгэрийн чуулган бүгдээр мөргөл үйлдсэн, тэнгэрийн чуулган бүгдээр тахьсан, тэнгэрийн хаадын чуулган бүгдээр илтэд магтсан, ертөнцийг тэтгэгч бүгдээр тахих хийгээд сайшаасан буюу. Өгүүлэн машид хүндэлсэн, тэнгэрийн орд харш бүгдийг гийгүүлэн үйлдсэн, амьтан бүгдэд дээдийн амгалан бүгдийг машид өгч үйлдсэн, амьтны там хийгээд адгуусны төрөл, эрлэгийн ертөнцийн зовлон бүгдийг хатаагч, бүх аюулын үргэлжлэлийг таслагч, чанадын цэргийн чуулган бүгдийг машид буцаагч, ган зудын гамшиг бүгдийг машид амирлуулан үйлдэгч, өвчний гамшиг бүгдийг машид амирлуулан үйлдэгч, гариг эрхэсийн хорлол бүгдийг арилгаж дээдэд амирлуулан үйлдэгч, гаслан ба нисванис бүгдийг машид амирлуулан үйлдэгч, элдэв янзын хорлолыг машид амирлуулан үйлдэгч, буман хорлолыг машид даран үйлдэгч болой.

“Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг нөхдийн дунд агуу ихээр үнэнхүү машид номловоос, номыг сонссон, номын рашааны шим үүгээр их хаан бидний өмөг болон зарц сэлт тэнгэрийн бие энэ их сүр жавхлангаар нэн арвидах болно. Бидний биенд хичээл хийгээд хүч чадал ч төрөх

болно. Сүр жавхлан ба цог хотол чуулган ч бидний биенд орох буюу.

“Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, их дөрвөн хаан бид нар ном төгөлдөр, номыг өгүүлэгч, номын хаан больюу. Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, бид нар номоор тэнгэр, лус, ягчис, асар, гарьд, үнэр идэшт, миамжи, их дочэ нарын хаан болно. Тэсэшгүй адын чуулган, нигүүлсэл үгүй бусдын сүр жавхланг булаагч нарыг буцааж үйлдэнэ.

“Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, дөрвөн их хаан бид нар ягчисын аймгийн хорин найман их ноён хийгээд олон буман ягчистай хамт цаг үргэлжид нэн ариун, хүнээс хэтэрсэн тэнгэрийн нүдээр бүх замбуу тивийг харж үйлдэнэ. Сахиж үйлдэнэ. Огоот тэтгэж үйлдэнэ.

“Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, түүний тулд дөрвөн их хаан бид нарыг ‘ертөнцийг тэтгэгч’ хэмээн нэрийдсэн болой. Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, алин хэн нэгэн бээр, энэхүү замбуу тивд чанадын цэргийн чуулганаар орон эзлэгдсэн юмуу, ган, зуд, өвчний гамшиг юмуу, элдэв зуун хорлол хийгээд мянган хорлол, буман хорлолоор хөнөөгдөх болбоос, ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, их дөрвөн хаан бид нар *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* үүнийг баригч гэлэн, номыг өгүүлэгч тэдгээрийг хүндлэн үйлдэнэ.

“Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, хэзээ их дөрвөн хаан бид нар рид хувилгаан адистэдээр номыг өгүүлэгч гэлэн тэдгээрийг хүндлэвээс, орон алин хийгээд алинд байгаа *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* үүнийг орон тэр хийгээд тэдгээрт агуу ихээр үнэнхүү номлох болоод элдэв зуун хорлол хийгээд элдэв мянган хорлол тэдгээр оронд гарсан энэ мэт эдгээр нь машид амирлах болно.

“Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, хүний хаан хэн нэгний улсад судрын аймгийн эрхэтийг баригч, номыг өгүүлэгч гэлэн тэдгээр байх болбоос тэдгээр оронд *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* бээр үүнийг ч бясалгаж болно.

“Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, хэзээ хүний хаан бээр *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* үүнийг анхааран сонсоод, судрын аймгийн эрхэт үүнийг баригч тэдгээр гэлэнг гадны

эсэргүүцэл бүгдээс хэзээд сахиж үйлдэнэ. Бүрэн аврах хийгээд бүрэн хамгаалж, бүрэн тэтгэж үйлдвээс, ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, их дөрвөн хаан бид нар хүний хаан түүний орон бүгдэд орших амьтан бүгдийг хэзээд сахиж, бүрэн аварч, бүрэн хамгаалж, бүрэн тэтгэж, амирлангуй хийгээд амгалан сайн болгож үйлдэнэ.

“Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, хүний хаан бээр хэзээ нэгэн гэлэн юмуу гэлэнмаа, гэнэн юмуу, гэнэнмаа *судар аймгийн эрхэтийг* баригчид амгалангийн учрал бүгдээр амгаланг үйлдвээс, ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, их дөрвөн хаан бид нар хүний хаан түүний орон бүгдэд орших амьтан бүгдэд амгалангийн хэрэгсэл бүгдээр амгалан хийгээд эд бүгдийн хотол чуулганыг үйлдэх болно.

“Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, хэзээ нэгэн хүмүүний хаан гэлэн юмуу гэлэнмаа, гэнэн юмуу гэнэнмаа *судар аймгийн эрхэт* үүнийг баригчид хүндэтгэн үйлдэн дээдэд үйлдэн өргөмжилж, үйлдэн тахиваас ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, их дөрвөн хаан бид нар хүний их хаан түүнд бүх хаадаас илүү ихэд хүндэтгэж илүү ихээр дээдлэж, илүү ихээр өргөмжилж, илүү ихээр тахиж үйлдэх бөгөөд орон бүгдэд ч машид сайшааж үйлдэнэ.

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлгөн судраас*

*“Их дөрвөн хаан тэнгэр болон хүмүүнд нэн харсан”  
хэмээх арван нэгдүгээр бүлэг болой.*

\* \* \*

[Зургадугаар хэсэг]

*XII бүлэг: Дөрвөн их хаан бээр орон улсыг  
бүрэн тэтгэх*

Чингээд Ялж төгссөн бурхан дөрвөн махаранзад сайн хэмээн өгүүлж: “Их хаадаа, сайн болой, сайн болой. Их хаад та нар бас сайн болой, сайн болой. Ийн буюу: Та нар болбоос урьдын бурхадад үлэмж сайн үйлдвэр үйлдсэн, буяны үндсийг үүсгэсэн, олон буман, түг түмэн голди бурхадад тахил өргөсөн, номонд төгөлдөр, номыг өгүүлэгч, номын хаан, номоор тэнгэр, хүний хаан болсон болой.

“Ийн хэмээн: Та нар бээр өнө уртад хамаг амьтанд туслах сэтгэл төгссөн, жаргаах хийгээд асрахуй сэтгэлтэй, хамаг амьтанд туслах хийгээд жаргуулж үйлдэх үлэмж сэтгэлд оршсон, үл туслах бүгдийг хорьсон, хамаг амьтанд хамаг жаргалыг түргэн бүтээн өгөхөд хичээгчид буй заа.

“Их хаадаа! Та дөрөв бээр хүний хаан, *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг тахих хийгээд хүндлэн үйлдэхэд хичээгч тэдгээрийг бүхэнд сахин үйлдэгтүн. Огоот аврах хийгээд сайтар даган бариад, сайтар ивээгээд, амирлангуй хийгээд амгалан сайн болгож үйлдэгтүн. Тэгэх аваас их хаад өмөг хийгээд зарц, олон буман ягчис лугаа сэлт та дөрөв өнгөрсөн ба ирээдүй, одоо цагт заларсан бурхан Ялж төгс нөгчсөнүүдийн номын ёсыг бүхэнд сахих болно. Сайтар тэтгэж сайтар даган барих ч болно.

“Тийм учраас их хаад өмөг хийгээд зарц, олон буман ягчис сэлт та дөрөв тэнгэр хийгээд асурт байлдан үйлдвээс ялах болно. Асур нар ялагдах болно. Энэ мэт *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* чанадын цэргийн чуулган бүгдийг номхотгон үйлддэг. Иймийн тул гэлэн юмуу гэлэнмаа, гэнэн юмуу гэнэнмаа судар аймгийн эрхэтийг баригч тэдгээрийг бүхэнд сахин үйлдэгтүн. Огоот аврах

хийгээд сайтар даган бариад сайтар ивээгээд, амирлангуй хийгээд амгалан сайн болгож үйлдэгтүн.”

Тэгээд их хаан Вайшравана (*мон: Нэн сонсогчийн хөвгүүн*) хийгээд их хаан Дртараштра (*мон: Орныг сахигч*) хийгээд их хаан Вирудака (*мон: Үлэмж төрөлхтөн*) хийгээд их хаан Вирупакша (*мон: Мэлмий сайн үгүй*) дөрөв суудлаасаа босоод дээдийн хувцасыг нэгэн мөрөндөө буулгаад баруун өвдгөө газарт сөхөрч Ялж төгс нөгчсөн бурхан хаана байгаа тэр зүгт алгаа хавсран сөгдөөд Ялж төгс нөгчсөнд ийн хэмээн айлтгав: “Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, ирээдүй цагт *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг шилтгээн юм уу, хот, балгас, улс орон, хааны ордны орчим алинд унших хийгээд хүмүүний хаан алин хийгээд алины оронд уншиж болно. Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, хүний хаан болсон хэн нэгэн ‘Тэнгэрийн эрхэтийн тангараг’ хааны судар үүгээр хаан төрийг барих болон үргэлжид тасралтгүй *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг сонсох юмуу хүндлэх буюу. Гэлэн хийгээд гэлэнмаа, гэнэн хийгээд гэнэнмаа алин судар аймгийн эрхэт хааныг баригч тэдгээрт ч хүндлэн үйлдэж, биширч үйлдэж, асарч үйлдэх хийгээд тахиад цаг үргэлжид *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хааныг* сонсвоос номыг сонссоны мөрний усаар, номын рашааны дусал түүгээр бид их хаад өмөг хийгээд зарц сэлт дөрөв, олон буман ягчис тэнгэрийн бие эдгээрийн их сүр жавхлан нэн арвижих больюу. Бидэнд хичээнгүй хийгээд хүч чадал ихийг ч өгөх болно. Бидний сүр жавхлан хийгээд цог хотол чуулган ч нэн арвидах болой.

“Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, их хаад бид дөрөв өмөг хийгээд зарц сэлт олон буман ягчис нар биеэ үл үзүүлэн үйлдээд одоо хийгээд ирээдүй цагт шилтгээн, хот, балгас, орон ордны орчим алин нэгэнд *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг уншиж байгаа тэдгээрийн дэргэд хүрч үйлдэнэ. Хүний хаан бээр *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг сонсох хийгээд хүндлэн үйлдсэн, тахиж үйлдсэн, тэдгээрийг бүхэнд сахин үйлдмой. Огоот аврах хийгээд сайтар даган барьж, сайтар тэтгэж, шийтгэлийг няцааж, амирлангуй хийгээд амгалан сайн

болгож үйлдэнэ. Хааны ордны орчим хийгээд орон тэдгээрийг ч бүхэнд сахиж үйлдэнэ. Огоот аврах хийгээд сайтар даган барьж, сайтар тэтгэж, шийтгэлийг няцааж, амирлангуй хийгээд амгалан сайн болгож үйлдэнэ. Орон тэдгээрийг ч аюул ба хорлол, хямрал бүгдээс огоот гэтэлгэж үйлдэнэ. Чанадын цэргийн чуулганыг ч жич буцааж үйлдэнэ.

“Хүний хаан алин нэгэн *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг сонсох хийгээд хүндэлж үйлдсэн ба тахиж үйлдсэн түүний тэнсэх дайсан ойр орчмын хаан бусад нэг байхнаа ч, Ариун санваартан Ялж төгс нөгчсөөн, ойр орчмын тэнсэх дайсан түүний хаан тэр: ‘Би өмөгийн чуулган дөрвөн гишүүн лугаа хамтран тэр оронд очоод орон түүнийг нэн эвдсүгэй’ хэмээх бодлыг үүсгэвээс, Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, тэр цагийн тэр үест *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүний сүр жавхлангийн хүчээр ойр орчмын тэнсэх дайсны хаан тэр бээр бусад хаад лугаа хатгалдан үйлдэх болно. Өөрийн оронд буцсан ч орон нь хямрах болно. Хааны хямрал барагдашгүй гарах болно. Орон улсад гариг хийгээд өвчин ч гарах болно. Орон улсад элдэв хуйвалдаан үймээн ч олон гарах болно. Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, хэзээ нэгэн цагт ойр орчмын тэнсэх дайсны хаан тэр өөрийн оронд буцваас элдэв хорлол олон хийгээд элдэв үймээн олон энэ мэт гарах болой. Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, ойр орчмын тэнсэх дайсан түүний хаан тэр дөрвөн гишүүнт цэргээ хураагаад чанадын цэргийн чуулганд халдахын тулд өөрийн орноос гараад дөрвөн гишүүнт өмгийн чуулган лугаа хамт тэр оронд эрэн одох хийгээд алинд *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүний оршсон орон тэр нэн ялагдах болбоос Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, бид дөрвөн их хаад өмөг хийгээд зарц сэлт олон буман ягчис лугаа хамт биеэ үл үзэгдүүлээд тэнд очиж үйлдэнэ. Чанадын цэргийн чуулган тэр оршин эзэлсэнийг ч тэр ямагтаас нь буцааж үйлдмөй. Элдэв үймээн олнуудыг ч даруй бүтээж үйлдэнэ. Хоригийг ч үйлдэнэ. Ийн хэмээн тэр оронд чанадын цэргийн чуулган тэр ирж үл чадваас, орныг эвдэж үйлдэх хаанаас байх вэ дээ.”

Тэгээд Ялж төгс нөгчсөн дөрвөн их хаан тэдгээрт ч сайн болой хэмээн сайшааж: “Их хаадуудаа! Сайн, сайн! Их хаадууд та ч сайн болой! Та тоолшгүй түг түмэн голди олон буман галавт ч үнэнхүү бүтээсэн тэнцэшгүй үнэнхүү төгсгөсөн бодь үүний тулд хүмүүний хаан бээр *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг сонссон хийгээд хүндлэн үйлдсэн, тахиж үйлдсэн тэдгээрийг бүхэнд сахиж үйлдэгтүн. Огоот аврах хийгээд сайтар даган барьж, сайтар тэтгэж, шийтгэлийг няцааж, амирлангуй хийгээд амгалан сайн болгож үйлдэгтүн. Хааны ордны орчим тэдгээр хийгээд их хот тэдгээр, ойрын орон тэдгээр, орон тэдгээрийг ч бүхэнд сахигтун. Огоот аврах хийгээд сайтар даган барьж, сайтар тэтгэж, шийтгэлийг няцааж, амирлангуй хийгээд амгалан сайн болгож үйлдэгтүн. Орон тэдгээрийг ч аюул хийгээд хорлол хямрал бүгдээс огоот гэтэлгэж үйлдэгтүн. Чанадын цэргийн чуулгануудыг буцааж үйлдэгтүн. Замбуу тив бүхэнд оршсон хүний хаан тэдгээр үл дайтах хийгээд хоригийг эс уудалж, үл тэмцэлдэх хийгээд ялгалгүй үйлдэхэд дурлаж үйлдэгтүн. Их хаад өмөг хийгээд зарц сэлт та дөрөв замбуу тив энд хэзээ найман түм дөрвөн мянган их хот тэдгээрт найман түм дөрвөн мянган хаан тэдгээр өөр өөрийн оронд илтэд баясах хийгээд хаан төрийн эрхэт баялаг түүгээр илтэд баясах хийгээд өөрийн эдийн цогцоор харилцан нэн үл хөнөөх хийгээд харилцан нэн хөнөөхийг үл үүсгэх хийгээд өөрөө ямар мэт урьдын хураасан үйлээр хааны язгуурыг олсон өөрийн хаан төрийн эрхэт баялгаар баясах хийгээд харилцан орныг эвдэж үл үйлдэх хийгээд орныг эвдэхийн тулд чанадыг үл хорлох хийгээд хэзээ нэгэн замбуу тив энд найман түм дөрвөн мянган их хотуудад тэдгээр найман түм дөрвөн мянган хаад харилцан асрахуй сэтгэлтэй болж, асрангуй сэтгэл хийгээд тусч сэтгэлтэй болоод харилцан үл байлдаж, хоригийг үл уудалж, үл тэмцэлдэж, үл ялгаж өөр өөрийн орнуудад баясах болбоос түүний тулд их хаад өмөг ба зарц сэлт та дөрөв замбуу тив үүнийг дэлгэрүүлэх болно, жил сайхан болно, анхааран баясах болно, төрөлхтөн хийгээд олон хүмүүсээр дүүрэх болно, газар үржил шимтэй болно, цаг ба сар, хагас сар, жилийн эргэн тойронд бүгдэд ч үнэнхүү цаг лугаа төгөлдөр болно. Гариг хийгээд од, сар, нар ч өдөр шөнөд сайтар орчих болно. Хурын үргэлжлэл ч газарт цаг цагтаа буух болно.

Замбуу тивд оршигч бүх амьтан эд хийгээд үр тариа бүгдээр баялаг болно. Төгс эдлэл ихтэй хийгээд харамгүй болно. Өгөхийн сэтгэлээр төгөлдөр болж, арван буяны үйлд ч төгөлдөр болно. Ихэнхдээ сайн заяа өндөр язгуурын ертөнцөд төрөх болно. Тэнгэрийн орон гэрүүд ч тэнгэр ба тэнгэрийн хөвгүүдээр дүүрэх болно.

“Их хаадаа! Хэн нэгэн хүний хаан болсон тэр *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг сонсоод хүндлэн үйлдэж, тахин үйлдэж, гэлэн болон гэлэнмаа юмуу, гэнэн юмуу гэнэнмаа судар аймгийн эрхэтийг барьсан тэдгээрт ч шүтэн үйлдэж, дээдлэн үйлдэж, хүндлэн үйлдэж, тахин үйлдэх хийгээд их хаад та дөрөв өмөг хийгээд зарцын хамт олон буман ягчист нигүүлссэний тул үргэлжид *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг сонсвоос номыг сонсохын мөрөн, номын рашааны дусал түүгээр та нарын бие эдгээр нь цэнгэх болно. Та нарын тэнгэрийн бие эдгээрийн сүр жавхлан ч нэн арвидах болно. Та нарт хичээнгүй хийгээд хүч чадал ч төрөх болно. Та нарын сүр жавхлан цог заль хотол чуулган ч нэн арвидах болно. Хүмүүний хаан тэр Түүнчлэн заларсан, Дайснаа дарсан, Үнэнхүү төгсгөсөн бурхан Шагжамуни надад ч санаанд багташгүй агуу их сэтгэшгүй олон тахилыг үйлдсэн болно. Хүмүүний хаан тэр өнгөрсөн, ирээдүй, одоо цагт гарсан түүнчлэн заларсан түг түмэн голди олон буман бурхадад ч санаанд багташгүй сэтгэшгүй агуу их эд зүйлс бүхнээр тахиж үйлдсэн болно. Тийм учраас хүний хаан түүнийг ихээр сахиж үйлдэх болой. Тиймээс хүний хаан түүнийг бүхэнд сахиж хийгээд огоот аврах хийгээд сайтар даган барьж, сайтар тэтгэж, шийтгэлийг няцааж, амирлангүй хийгээд амгалан сайн болгож үйлдэх болно. Хааны ордны орчимд орших тэнгэр бүгд ч ихэд сүр жавхлан төгөлдөр их хүч төгс, амгалан хийгээд сэтгэлийн амгалан санаанд багташгүй лугаа төгс болно. Элдэв баясгаланг амсах болно. Хот тэдгээр хийгээд ордон тэдгээрийг ч бүхэнд сахиж болно. Сайтар тэтгэх болно. Хорлол үгүй болно. Дайсан үгүй болно. Чанадын цэргийн чуулган бүгдээр ч эс ялагдах хийгээд хөнөөл үгүй, хямрал үгүй болох болой.”

Тийн хэмээн зарлигласан хийгээд Ялж төгс нөгчсөнд их хаан Вайшравана ба их хаан Дртараштра, их хаан Вирудака, их хаан

Вирупакша тэдгээр бээр ийнхүү айлтгав: “Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, хүний хаан хэн нэгэн *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг сонсох болбоос өөртөө ч их сахиусыг үйлдэх болно, дээд хатан хийгээд хан хөвгүүд ба хааны гүнж нар болон гүнжийн нөхдийн чуулган бүгдэд ч их сахиусыг үйлдэх болно. Хааны ордны орчим тэр бүхэнд ч амирлангуй хийгээд сайн амгалан болж, ихэд санаанд багташгүй үлэмж дээд ялгамжаатай ханьцашгүйг үйлдэх болно. Энэ насандаа өөрийн хаан төрийн эрхэт баялаг ихэд санаанд багташгүйгээр нэн арвидан үйлдэх болно. Хаан өөрөө санаанд багташгүй лугаа төгөлдөр болно. Буяны цогц хэмжээлшгүйг ч сайтар хураах болой. Миний орон бүгдийг ч бүхэнд сахиу болно. Огоот тэтгэх болно. Өөрийн оронд хорлол үгүй хийгээд дайсан үгүй, чанадын цэргийн чуулганд үл ялагдах ба халдварт өвчин үгүй, хямрал үгүй болгож үйлдэх болно. Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, хүмүүний хаан тэр бээр үл алгасрах сэтгэл хийгээд бишрэлт сэтгэл, хүндэтгэх лугаа сэлтээр *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг биширч хүндлээд сонсож үйлдэх болой. *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг сонсохын тулд хүний хаан тэр ордноо үлэмж ялгамжаатай болгож үйлдэнэ. Тийнхүү болгоод хааны ордныг үнэрт ус элдэв олноор сүрчих хийгээд цэцгийн баглаа элдэв янзаар чимж үйлдэнэ. Элдэв үнэрт усаар сүрчиж талбисан түүндээ номын ширээ өндөр ба элдэв чимгээр сайтар чимэглэснийг бэлдэж үйлдэнэ. Тэр зүгт шүхэр ба ялгуулсаны тэмдэг, элдэв дузаар сайтар чимэглэж үйлдэнэ. Хүний хаан тэр биеэ угааж үйлдэнэ. Машид сайхан үнэртэй үзэсгэлэнт шинэ хувцсыг өмсөөд элдэв чимгээр чимж үйлдэнэ. Өөрийнхөө суудлыг машид доор засаж үйлдээд, суудал түүн дээрээ суугаад хааны омог дээрэнгүйгээ орхих болно. Тэр бээр хаан төрийнхөө эрхэт баялагт эс тачаана. Омог хийгээд дээрэнгүй бүгдийг нэн тэвчсэн сэтгэлээр *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг сонсож үйлдэнэ. Номыг өгүүлэгч гэлэн түүнд ч бурхан багшийн хуран мэдлийг үүсгэнэ. Хүний хаан тэр бээр тэр үеийн тэр цагт дээд хатан хийгээд хан хөвүүд, гүнж нар болон гүнжийн нөхдийн чуулгануудад туслахаар харж үйлдэнэ. Дээд хатан хийгээд хан хөвгүүд, хааны гүнж нарт яруу үгийг өгүүлж үйлдэнэ. Гүнжийн нөхдийн чуулган

бүгдэд ч яруу үгийг өгүүлж үйлдэнэ. Номыг сонсохын тулд элдэв янзын тахилыг бэлтгүүлж үйлдэнэ. Санаанд багташгүй, зүйрлэшгүй баясгалангаар өөрөө цэнгэж үйлдмой. Санаанд багташгүй баясгалангаар жаргаж үйлдмой. Эрхтэн амирлаж үйлдэнэ. Машид их баясгаланг төрүүлээд, номыг өгүүлээчийг угтаж үйлдэнэ.”

Тийнхүү айлтгасан хийгээд Ялж төгс нөгчсөн их хаадад ийн хэмээн зарлиглав: “Их хаадаа, тэр цагийн тэр үест хүний хаан тэр бүхэлдээ цагаан, шинэ, үзэсгэлэнтэй хувцсыг өмсөж үйлдэнэ. Унжлага хийгээд элдэв чимгээр өөрийгөө сайтар чимэглэж үйлдэх болно. Цагаан шүхрийг ч барьж үйлдэх болой. Хааны их баатрууд хийгээд хааны их бараа бологчид элдэв янзын өлзийт чимгийг бариад хааны ордон тэндээс гарч номыг өгүүлээчин түүнийг угтахын тулд тэр зүгт одож үйлдмой. Тэр юуны тулд вэ? хэмээвээс, хүний хаан тэр зүгт хэдийчинээ алхсан төдийчинээ түг түмэн голди буман галваар орчлонгоос эргэн буцах болно. Тэр ямагтаар загарвардын хааны язгуурыг түг түмэн голди буман удаа олох болно. Тэр зүгт алхам хэдий төдий алхсан төдийчинээгээр энэ насандаа хаан төрийн эрхэт баялаг санаанд багташгүй ихээр арвидах болно. Түг түмэн буман голди олон галавт орон уужим хийгээд агуу их тэнгэрийн шилтгээн долоон янзын их эрдэнээр бүтээгдсэнүүдийг олох болно. Хүний хааны язгуур хийгээд тэнгэрийн агуу их орон олон бумыг олох болно. Төрөл бүхэндээ их эрхэт баялгийг олох болно. Урт наслах болно. Өнө удаан амьдрах болно. Авхаалж самбаа төгөлдөр болж үгийг нь дагаваас зохистой болно. Алдар төгөлдөр болж, өгүүлсэн нь машид агуу их болно. Тэнгэр хүний амгалан агуу их хийгээд агуу ихийг олох болно. Хүч чадал ихтэй болж, маш их хүч чадал төгөлдөр хийгээд дүрс сайтай болно. Үзэсгэлэнтэй хийгээд харваас гуа сайн өнгө дэлгэрсэн дээд төгөлдөр болно. Төрөл бүхэндээ Түүнчлэн заларсантай учрах болно. Буяны садангуудыг олох болно. Буяны цогц хэмжээлшгүйг огоот барих болно. Их хаадаа, тус эрдэм энэ адилуудыг сонсоод хүний хаан тэр нэгэн бээр алсаас номыг өгүүлээчийг угтаж үйлдэнэ. Зуун бээр хийгээд мянган бээрээс ч угтаж үйлдэнэ.

“Бас тэрбээр ийн хэмээн: ‘Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхан Шагжмуни өнөөдөр миний хааны ордон үүнд залрах болно. Өнөөдөр Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхан Шагжмуни миний хааны ордон энд зоог барих болно. Өнөөдөр Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхан Шагжмунийн ном бүх ертөнцтэй үл зохилдсоныг сонсох болно. Өнөөдөр би ном сонссоны буян үүгээр дээр үгүй, үнэнхүү төгсгөсөн бодиос эргэн үл буцах болно. Өнөөдөр би бээр олон буман түг түмэн голди Түүнчлэн залрагсадыг баясгаж үйлдэх болно. Өнөөдөр би бээр өнгөрсөн ба ирээдүй, одоо цагт заларсан Ялж төгс нөгчсөн бурхадад санаанд багташгүй их тахил уужим хийгээд агуу ихийг үйлдэх болно. Өнөөдөр би тамын амьтан, адгуусны төрөлт, эрлэгийн ертөнцийн зовлон бүгдийн урсгалыг машинд таслах болно. Өнөөдөр би Эсрэнгийн эрхэт хааны биеийг олон буман түг түмэн голди удаа олох буяны үндсийн үрийг тарих болно. Өнөөдөр би Хурмаст тэнгэрийн биеийг олон буман түг түмэн голди удаа олох буяны үндсийн үрийг тарих болно. Өнөөдөр би Хүрдэн эргүүлэгч хааны биеийг олон буман түг түмэн голди удаа олох буяны үндсийн үрийг тарих болно. Өнөөдөр би олон буман түг түмэн голди галав орчлонгоос огоот гэтэлж үйлдэх болно. Өнөөдөр би буяны цогц хэмжээлшгүй, дээр үгүй, энгүй хийгээд агуу их, санаанд багташгүйг сайтар хураах болно. Өнөөдөр би хатны нөхдийн чуулган бүгдэд их сахиусыг үйлдэх болно. Өнөөдөр би бээр хааны ордны ойр орчим энд амирлангуй ба сайн амгалан санаанд багташгүй, машинд ялгамжаатай үлэмж, дээр үгүйг үүсгэж үйлдэх болно. Өнөөдөр би эдгээр орон бүгдийг бүхэнд сахих болно. Сайтар тэтгэх хийгээд хорлол үгүй, дайсан үгүй, чанадын цэргийн чуулган бүгдээрт үл эзлэгдэх, халдварт өвчингүй, хямралгүй болох болно хэмээн сэтгэлийг үүсгэж үйлдэнэ’ санах болно.”

“Их хаадаа, гэлэн болон гэлэнмаа юмуу, гэнэн болон гэнэнмаа дээд *Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг баригч тэдгээрт хүний хаан тэр бээр дээдийн номонд биширсэн тэр адилаар биширч үйлдэнэ, дээдэлж үйлдэнэ, хүндэлж үйлдэнэ, тахиж үйлдэх хийгээд их хаан та дөрөв, өмөг болон зарц сэлт хийгээд тэнгэрийн чуулган тэдгээр болон олон буман ягчисуудад мэдэл оюунаар

дээдийг өгвөөс хүний хаан түүний буян илтэд хурж үйлдэх хийгээд буян илтэд хуран үйлдсэн тэр лүгээ энэ насны хаан төрийн эрхэт баялаг санаанд багташгүйгээр нэн арвижих болно. Энэ насандаа хааны сүр жавхлан санаанд багташгүй ихээр төгөлдөр болно. Цог хийгээд хотол чуулган сүр хүчээр ч чимэглэгдэх болно. Чанадын эсэргүүцэгч бүгд болон дайсан бүгдийг номын ёсоор машид эслэн шийтгэх болно.”

Тийн хэмээн зарлигласан хийгээд Ялж төгс нөгчсөн бурханд дөрвөн махаранз тэдгээр ийн хэмээн айлтгав: “Ариун санваарт Ялж төгс нөгчсөн бурхаан, хэн нэгэн хүний хаан болсон тэр бээр номонд тэр адилын сүсэг бишрэлээр *судар аймгийн эрхэт хаан буюу дээд Алтангэрэлт* үүнийг сонсоод судар аймгийн эрхэт хаан үүнийг баригч гэлэн болон гэлэнмаа, гэнэн болон гэнэнмаа тэдгээрт ч биширч, дээдэлж, хүндэлж, тахиж үйлдэх хийгээд их хаад бид нарын тулд хааны ордон түүнийг машид ариусган цэвэрлэж үйлдээд, үнэрт ус элдвээр сүрчлэг сайтар талбиж их хаад бид дөрөвтэй хамт нийтээрээ гайхамшигт ном түүнийг сонсох хийгээд өөр болон тэнгэр бүгдийн тусад буяны ёзоорын өлзий өчүүхэн нэгийг өгч үйлдвээс, Ариун санваарт Ялж төгс нөгчсөн бурхаан, номыг айлдагч гэлэн тэр номын суудалд суусан даруйд хүний хаан тэр их хаад бид дөрвийн тусын тулд хүжийг асааж, өргөсөн даруйд элдэв янзын үнэртнүүдээс үнэрт ба хүжний ороонго мод элдэв олноор гараад, тэдгээр агшин хором төдийд их хаад бид дөрвийн өөр өөрийн байшингийн дээд агаарт үнэрт ба хүжний ороонго мод элдэв олны шүхэр болон орших болно. Хүжийн үнэр агуу ихээр анхилах болно. Алтны өнгө мэт үзэгдэл гарах болох хийгээд үзэгдэл түүгээр бидний байшин бүгд ч гэрэлтэн гийх болно. Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, үнэрт ба хүжний ороонго мод элдэв янзууд агшин хором төдийд тэсэшгүй орны эзэн Эсрэн (*санс: Брахма*) хийгээд тэнгэр нарын эрхэт Хурмаст (*санс: Индра*) хийгээд их охин тэнгэр Сарасвати (*мон: Эгшиглэнт*); их охин тэнгэр Дрда (*мон: Бат-эх*); Шри (*мон: Цогт*); ягчисын аймгийн ноён Самжняяа (*мон: Үнэмлэхүй мэдэгч*) хийгээд ягчисын аймгийн хорин найман их ноён; тэнгэрийн хөвгүүн Махешвара (*мон: Эрхэт баялаг*); их ягчисын аймгийн их ноён Ваджрапани (*мон: Мутартаа очирт*); ягчисын аймгийн их ноён Манибадра (*мон:*

*Сайн эрдэнэ*); Харити (*мон: булаагч эх*) таван зуун хүү нөхөр сэлт; их лусын хаан Анаватапта, их лусын хаан Сагара (*мон: Далай*) хийгээд тэдгээрийн тус тусын байшингийн дээрх огторгуйд гараад үнэрт ба хүжний ороонго мод элдвийн шүхрийн байдлаар орших болно. Хүжийн үнэр агуу ихээр ч анхилах болно. Байшин бүгдийн дотор алтан гэгээ гарах хийгээд гэгээ түүгээр орон бүгд гэрэлтэн гийх болно.”

Тийн хэмээн айлтгасан хийгээд Ялж төгс нөгчсөн бурхан дөрвөн махаранзад ийн хэмээн зарлиглав: “Их хаадаа, их хаан та дөрвийн өөр өөрийн байшингуудын дээрх огторгуйд хүж хийгээд элдэв үнэрт ороонго мод тэдгээр шүхрийн байдалтай оршсон төдий бус юм. Тэр юуны тулд вэ? хэмээвээс, Их хаадаа, хүний хаан тэр *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг тахьсаны тулд юм. Элдэв хүж тэдгээр шүхэрлэх даруйд гартаа хүжний сав нэгийг барьсан түүнээс хүж хийгээд элдэв үнэртний ороонго мод багшран гараад тэдгээр нь агшин хором нэг төдийд гурван мянган их мянган ертөнцийн орон тэдгээр бүгдэд алин зуун голди сар, зуун голди нар, зуун голди их далай, зуун голди уулын хаан сүмбэр уул ба сүмбэр уулын ойр орчим болон зуун голди их ойр орчим, зуун голди дөрвөн их тивт ертөнцийн орон, зуун голди дөрвөн махаранзын язгуурын тэнгэр, зуун голди гучин гурван тэнгэрээс эхлээд зуун голди хуран мэдэл үгүй, хуран мэдэл үгүй бус түүнд ойр одсоныг хүртэлх тэнгэр хийгээд гурван мянган их мянган ертөнцийн орон тэдгээр бүгдэд Гучин гурван тэнгэрийн язгуур зуун голди бүгдэд тэнгэр, лус, ягчис, үнэр идэштэн, гарьд, асур, миамжи, их дочэгийн чуулгануудын тус тусын гэрүүдийн дээрх огторгуйд хүж болон элдэв үнэртний ороонго мод шүхэрчлэн орших болно. Хүжний үнэр агуу ихээр ч анхилах болно. Тэнгэрийн байшингуудад алтны өнгө мэт гэгээ ч гарах болох хийгээд гэгээ түүгээр ч тэнгэрийн байшингууд гэрэлтэн гийх болно. Их хаадаа, энэ мэт гурван мянган их мянган ертөнцийн оронд тэнгэрийн байшин бүгдийн дээрхи огторгуйд хүж хийгээд үнэртний ороонго мод тэдгээр шүхэрчлэн орших тэр мэт *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* үүнийг тахихын тул хүний хаан тэр бээр элдэв хүж тэдгээрийг асаасан даруйд *Дээд Алтангэрэлт*

*буюу судар аймгийн эрхэт хаан* үүний сүр жавхлангийн хүчээр хүж хийгээд элдэв үнэртний ороонго модууд багшран гарна.

“Агшин хором нэг төдийд, арван зүгийн ертөнцийн орон бүхэнд Ганга мөрний элсний тоотой тэнцэхүйц түг түмэн буман голди бурханы оронд, Ганга мөрний элсний тоот түг түмэн буман голди Түүнчлэн заларсаны огторгуйд хүж хийгээд элдэв үнэрт ороонго модууд нь шүхэрчлэн орших болно. Тэдгээр нь ч түг түмэн буман голди олон бурханы оронд хүж хийгээд элдэв үнэртэн агуу их хийгээд хэмжээлшгүй их анхилах болно. Алтны өнгө мэт гэгээ гарах болох хийгээд гэгээ түүгээр ч Ганга мөрний элсний тоот түг түмэн буман голди олон бурханы орон гэрэлтэн гийх болно. Их хаадаа, их рид хувилгаан тэр мэт тэдгээр гарсан даруйд Ганга мөрний элсний тоогоор тэнцэхүйц түг түмэн буман голди олон Түүнчлэн заларсан нугууд номыг өгүүлэгч түүнд баясан: ‘Дээд төрөлхтөөн! Сайн болой, сайн болой. Дээд төрөлхтөн та *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* ёс үүнд гүнзгий утга энэ мэт, гүн үзэгдэл энэ мэт, эрдэм санаанд багташгүй энэ мэт лугаа үүнийг агуу ихээр үнэнхүү сайтар номлохыг хүссэн та ч бас сайн болой хэмээн сайшаалыг өгөх болой. Хэн нэгэн адаглаад *судар аймгийн эрхэт хаан буюу дээд Алтангэрэлт* үүнийг сонссон тэдгээр амьтад ч бага сага буяны үндэс төгөлдөр төдий үл болох болбоос алин нэгэн сэтгэлдээ барьсан ба хадгалсан, номлосон, уншсан, бүхнийг багтааж үйлдсэн, нөхөлдөө агуу ихээр үнэнхүү машинд заасан түүнийг өгүүлэх хэрэг юу байна? Тэр учир юу вэ? хэмээвээс, дээд төрөлхтөн *судар аймгийн эрхэт хаан буюу дээд Алтангэрэлт* үүнийг сонсоод сонссон даруйдаа түг түмэн олон буман голди бодьсадва нар дээр үгүй, үнэнхүү төгс бодиос эргэн үл буцах болдог тул болой.’

“Тэгээд арван зүг бүхэнд түг түмэн буман голди Ганга мөрний элсний тоо ямагт бурханы оронд түг түмэн олон буман голди Түүнчлэн залрагсад өөр өөрийн бурханы оронд оршин буй тэдгээр тэр цагийн тэр үест нэг үг хэл нэг авиагаар номын ширээн дээр суусан, номыг өгүүлээч гэлэн түүнд ийн хэмээн зарлиглав: ‘Дээд төрөлхтөн та бээр ирээдүй цагт бодийн зүрхэнд одох болно. Дээд төрөлхтөн та бодийн зүрх дээдийн дээдэд одоод хаан модны өмнө суугаад, гурван

ертөнц бүгдээс ялгамжаатай илүү амьтан бүгдээс машид хэтэрсэн дүр байдал хийгээд хатуужилт явдлын хүчийг үүсгэсний адистэдээр олон буман түг түмэн голди бэрх явдлуудыг үзүүлэх болно. Дээд төрөлхтөн та бодийн шимийг сайтар чимэглэн үйлдэх болно. Дээд төрөлхтөн та гурван мянган их мянган ертөнцийг огоот аврах болно. Дээд төрөлхтөн та хаан модны өмнө суугаад санаанд багташгүй дүрс нь машид аймшигтай болсон, гуа бусыг үзүүлсэн, муухай дүрст элдэв янз шулмасын аймгуудыг ялах болно. Дээд төрөлхтөн та бодийн зүрх дээдийн дээдэд одоод, дээр үгүй үнэнхүү төгсгөсөн бодь үлгэр үгүй машид амирласан, тоос лугаа хагацсан, гүнзгий илтэд төгсгөсөн бурхан болно. Дээд төрөлхтөн та очир суудлын зүрхэнд багтай суугаад бурхан бүгдээр илтэд сайшаасан номын хүрд машид гүнзгий, дээр үгүй арван хоёр зүйлийг машид эргүүлэх болно. Дээд төрөлхтөн та дээр үгүй номын их хэнгэргийг дэлдэх болно. Дээд төрөлхтөн та дээр үгүй номын цагаан лавайг үлээх болно. Дээд төрөлхтөн та номын их ялгуулсаны тугийг мандуулах болно. Дээд төрөлхтөн та дээр үгүй номын зулыг бадруулан үйлдэх болно. Дээд төрөлхтөн та дээр үгүй номын хурыг буулгах болно. Дээд төрөлхтөн та олон буман нисванисын дайсныг ялах болно. Дээд төрөлхтөн та түг түмэн олон буман амьтдыг машид аймшигтай их аюулын далайгаас гэтэлгэх болно. Дээд төрөлхтөн та түг түмэн олон буман амьтдыг орчлонгийн эргүүлгээс огоот гэтэлгэн үйлдэх болно. Дээд төрөлхтөн та түг түмэн олон голди бурхадуудыг баясган үйлдэх болно.”

Тийн хэмээн зарлиглавай. Мөн Ялж төгс нөгчсөн бурханд дөрвөн махаранз тэдгээр ийн хэмээн айлтгав: “Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, хүний хаан бээр *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хааны* эрдэм, энэ нас хийгээд ирээдүй хойшид гарах энэ мэт эдгээрийг үзэж олон буман бурхадад буяны ёзоорыг үүсгэж, буяны цогц хэмжээлшгүйг огоот барихыг үзээд нигүүлсэнгүйн тулд Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, өөр өөрийн гэрт орших дөрвөн махаранз бид нар, өмөг хийгээд зарц сэлт, олон буман ягчис нар хүж хийгээд элдэв үнэртний ороонго моднуудын шүхрээр хөтлөгдөөд биеэ үл үзүүлээд хүний хаан түүний арчиж цэвэрлэсэн олон давхар байшин, сайтар цэвэрлэсэн, үнэрт ус элдэв янзаар сайтар сүрчсэн,

элдэв чимгээр сайтар чимэглэсэн хааны ордон хаана буй тэнд номыг сонсохын тулд одож үйлдэнэ.

“Тэсэшгүйн эзэн Эсрэн; тэнгэрийн эрхэт Хурмаст; их охин тэнгэр Сарасвати; их охин тэнгэр Шри; газрын охин тэнгэр Дрда; хийгээд ягчисын аймгийн их ноён Самжнаяя, ягчисын аймгийн хорин найман их ноён; тэнгэрийн хүү их Махешвара; ягчисын аймгийн их ноён Ваджрапани; ягчисын аймгийн их ноён Манибадра; Харити-н хүү таван зуун нөхдийн хамт; лусын хаан Анаватапта; лусын хаан Сагара түг түмэн олон буман голди тэнгэрүүд биеэ үл үзэгдүүлээд элдэв чимгээр чимэглэгдсэн хийгээд номыг өгүүлээч түүний номын сэнтий машид өндөр, элдэв чимгээр сайтар чимэглэгдсэн, цэцгийн баглааг бэлдсэн тэрхүү хүний хааны ордон газарт номыг сонсохын тулд одох болно.

“Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, их хаад бид дөрөв өмөг хийгээд зарцын хамт олон буман ягчис тэдгээр бүгд зохилдон үйлдээд, буяны нөхрийг үйлдсэн, буяныг олж үйлдсэн, дээр үгүй номын их өглөгийг өгсөн хүний хаан түүнд номын рашааны шим үүгээр цэнгэх болох тэр даруйд хүмүүний хаан түүнийг бүхэнд сахьж үйлдэнэ. Бүрэн аврах хийгээд бүрэн хамгаалж, бүрэн тэтгэж, амирлангуй ба амгалан сайн болгож үйлдэнэ. Хүмүүний хааны орд харш, их хот, улс түүнийг ч бүхэнд сахьж үйлдэнэ. Бүрэн аврах хийгээд бүрэн хамгаалж, бүрэн тэтгэж, амирлангуй ба амгалан сайн болгож үйлдэнэ. Шийтгэлийг тэвчихийг ч үйлдэнэ. Тэрхүү улсыг аюул, хорлол, халдварт өвчин, хямрал бүгдээс бүрэн гэтэлгэж үйлдэнэ.

“Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, алин хэн нэгэн хүний хаан болоод хүний хаан түүний улсад *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* энэ гарч, Ариун санваарт ялж төгс нөгчсөөн, хүний хаан тэр гэлэн юмуу гэлэнмаа, гэнэн юмуу гэнэнмаа *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг баригч нарт үл хүндлэх, үл дээдлэх, үл өргөмжилж, үл тахиваас, дөрвөн их хаан бид нар хийгээд олон буман түг түмэн голди ягчис нарт энэхүү номыг сонсох хийгээд номын рашааны шим үүгээр үл цэнгүүлэх, үл хүндлэх, тэнгэрийн бие эдгээрийн сүр жавхлан ч нэн арвижиж үл үйлдэнэ. Бидний хичээнгүй хийгээд хүч чадал ч үл төрж бидний

биенд сүр хүч цог ба хотол чуулган ч нэн арвижиж үл үйлдэх болно. Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, өмөг хийгээд зарц сэлт дөрвөн их хаан бид нар болон олон буман түг түмэн голди ягчис нар орон түүнийг хясалд орхино. Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, бид нар орон түүнийг хясалд орхивоос тэр оронд орших тэнгэрийн чуулган бүгд ч орон түүнийг хясалд орхих болно. Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, тэнгэр нар орон түүнийг хясалд орхивоос тэр оронд улс нь нэн хямрал элдэв янз гарах болно. Хааны хямрал барагдашгүй олон гарах болно. Алин оронд оршсон амьтан бүгд ч тэмцэлдэх хийгээд хоригийг уудалж хямралдах болно. Гариг хийгээд өвчин элдэв янз тэр улсад гарах болно. Зүг тал талаас одны сум унах болно. Гариг хийгээд одууд ч харилцан үл зохилдох болно. Өвлийн сар ургаваас нар мэт байх болно. Сарны гараг хийгээд нарны гараг гарах болно. Нар хийгээд сар огторгуйд оршихноон ч цаг үргэлжид хиртэх болно. Цаг цагт огторгуйд солонгын өнгө мэт хуйлрах болно. Газар ч хөдлөх болно. Газарт оршсон худаг ч дуу гарган дуурсах болно. Орон нутагт хүчтэй салхи ч гарах болно. Их үер буух болно. Орон нутагт ган зудын аюул гарах болно. Чанадын цэргийн чуулганаар улс дарагдах болно. Улс тэр нь доройтох болно. Амьтан тэдгээр нь нисванис ихтэй болно. Тэр орон баясгалангүй болно. Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн!, өмөг зарц сэлт дөрвөн их хаан бид нар хийгээд олон буман ягчис, оронд орших тэнгэр, лус нар орон түүнийг орхивоос тэр улсад энэ мэт элдэв янзын олон зуун хорлол хийгээд олон мянган хорлол гарах болно.

“Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, алин хэн нэгэн хүний хаан болоод тэр өөрийгөө бүхэнд ихэд сахиж үйлдэхийг хичээх болно. Хааны элдэв амгаланг өнө удаан амсахыг хичээх болно. Амгалан бүгдийг эдлэх сэтгэлийн хаан болохыг хичээх болно. Улсдаа харъяалагдах амьтан бүгдийг амгалантай болгохыг хичээх болно. Чанадын цэргийн чуулган бүгдийг ялан үйлдэхийг хичээх болно. Орон бүгдэд өнө удаан бүрэн тэтгэхийг хичээх болно. Номын хаан болохыг хичээх болно. Өөрийн улсыг ч аюул хорлол, халдварт өвчин, хямрал бүгдээс бүрэн гэтэлгэж үйлдэхийг хичээх болбоос Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, хүмүүний хаан тэр дамжиггүй *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг сонсож үйлд.

Гэлэн юмуу гэлэнмаа, гэнэн юмуу гэнэнмаа судар аймгийн эрхэтийг баригч тэдгээрийг ч хүндэлж үйлд, дээдэлж үйлд, өргөмжилж үйлд, тахиж үйлд. Өмөг хийгээд зарц сэлт дөрвөн их хаан бид нар ч номыг сонсохын буяны үндсийг хураасан энэ хийгээд номын рашааны шим үүгээр цэнгэж үйлдэнэ. Бидний тэнгэрийн бие эдгээрийн их сүр жавхлан ч нэн арвидаж үйлдэнэ. Тэр юуны тулд вэ? хэмээвээс, Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, хүний хаан тэр дамжиггүй *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг сонсож үйлдсэн буюу. Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* энэ нь Эсрэнгийн хаан ертөнцөд хийгээд ертөнцөөс хэтэрсэн элдэв янзын шастир хэдийчинээ номлосон, тэнгэрийн хаан Хурмаст элдэв янзын шастир хэдийчинээ номлосон, таван илт мэдэлт арш элдэв янзууд тэдгээр амьтны тусын тулд ертөнц ба ертөнцөөс хэтэрсэн элдэв янзын шастир хэдийчинээнийг номлосноос их дээд ялгамжаатай илүү.

“Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, тэдгээр буман эсрэнгийн хаан, олон буман түг түмэн голди хурмаст, олон буман түг түмэн голди таван илт мэдэлт арш бүгдээс их дээд, их ялгамжаатай илүүг Түүнчлэн заларсан бээр амьтан бүгдийн тусын тулд агуу ихээр үнэнхүү машид номлосон болой. Юу болохноо ч, бүх замбуу тивд орших хүмүүсийн хаад бээр хааны үйлийг хийх, юу болбоос амьтан бүгд амгалантай болох, юу болбоос өөрийн улс орон бүхнээ сахих, бүрэн тэтгэх, юу болбоос орон бүгдэд хорлол болон дайсан үгүй болох, юу болбоос чанадын цэргийн чуулганыг ялаад гэдрэг буцаах, юу болбоос тэдгээр оронд халдварт өвчин үгүй, хямралгүй болох, юу болбоос орон бүгд номоор хямралгүй, хуваагдахгүй болох, юу болбоос хүний хаан тэдгээр өөр өөрийн улс оронд номын их зулыг бадрааж үйлдэх, гийгүүлэн үйлдэх, юу болбоос тэнгэрийн орд харш бүгд тэнгэрүүд ба тэнгэрийн хөвгүүдээр дүүрэх, юу болбоос өмөг хийгээд зарц сэлт дөрвөн их хаан бид нар, олон буман ягчис, замбуутивд орших тэнгэрийн чуулган бүгдээр цэнгэх хийгээд өргөл хүндлэлийг үйлдэх, юу болбоос бидний тэнгэрийн бие эдгээр их сүр жавхлангаар нэн арвижих, юу болбоос бидний биед хичээнгүй ба хүч чадал бий болох, юу болбоос бидний биед сүр хүч цог заль хотол чуулган машид орох, юу болбоос замбуу тив бүгдэд жил сайн

болох, баяр баясгалантай төрөлхтөн ба олон хүмүүнээр дүүрэх, юу болбоос замбуу тив бүгдэд орших амьтан бүгд амгалантай болох, элдэв баясгаланг амсах, юу болбоос амьтан бүгд олон буман түг түмэн голди галавт тэнгэр ба хүний амгалан агуу их хийгээд агуу ихийг амсах, Ялж төгс нөгчсөн бурхадтай хамт нэг дор орших, ирээдүй цагт дээр үгүй, үнэнхүү төгсгөсөн бодид илтэд гэгээрсэн бурхан болох болой. Ялж төгс нөгчсөн, түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхан бээр олон буман түг түмэн голди эсрэнгийн хаанаас үлэмж илүү их нигүүлсэнгүй сэтгэлийн хүч төгөлдөр адистэд, олон буман түг түмэн голди Хурмаст тэнгэрийн ухаанаас үлэмж илүү Түүнчлэн заларсаны билгүүн дээр үгүй, олон буман түг түмэн голди элдэв янзын таван илт мэдэлт аршийн чуулган бүгдээс үлэмж илүү адистэд тэд бүгдээр одоо Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхан бээр амьтан бүгдийн тусын тулд *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг энэхүү замбуу тивд агуу ихээр үнэнхүү машид номлосон болой.

“Хүний хааны үйл хэрэг, хааны шастир, хааны үйлдвэр бүх замбуу тивд байгаа алин нэгэн хийгээд алин нэгнээ эдгээр амьтан бүгдийг амгалантай болгосон тэдгээр бүгд Ялж төгс нөгчсөн, түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхан бээр *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг чухалчлан номлож, бүрэн өгүүлж, үнэнхүү сайтар номлосны хүч юм. Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, тэрхүү уг тэрхүү шалтгаанаар хүмүүний хаан тэр дамжиггүй *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг бишрэнгүйгээр сонсож, бишрэнгүйгээр хүндэлж, бишрэнгүйгээр тахиж үйлдсэн болой.

Тийн хэмээн соёрхсон хийгээд Ялж төгс нөгчсөн бурхан дөрвөн их хаанд ийн хэмээн зарлиглав: “Тиймийн тул, Их хаан та дөрөв, өмөг болон зарц нарын хамтаар дамжиггүй хүний хаан *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг сонссон, хүндлэн үйлдсэн, тахиж үйлдсэн тэдгээрийг бүхэнд сахихын тул баясал дуршил агуу ихийг төрүүлэгтүн. Их хаадаа, гэлэн юмуу гэлэнмаа, гэнэн юмуу гэнэнмаа алин судар аймгийн эрхэт хаан үүнийг барьсан тэдгээрийг

ч бурханы зохиолыг барихад оруулагтун. Тэд тэнгэр, хүн, асур нарын энэ ертөнцөд бурханы зохиолыг үйлдэх болно. *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг агуу ихээр үнэнхүү машид номлох болно. Их хаан та дөрөв юу боловч судар аймгийн эрхэт хааныг барьсан гэлэн юмуу гэлэнмаа, гэнэн юмуу гэнэнмааг сахих хийгээд хорлол үгүй өвчин үгүй, хямрал үгүй, сэтгэлийг амгалан болгох хийгээд *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хааныг* үнэнхүү машид номлоход гэлэн юмуу гэлэнмаа, гэнэн юмуу гэнэнмаа судар аймгийн эрхэтийг баригч тэдгээрийг бүрэн сахиж үйлд, бүрэн аварч, бүрэн хамгаалж, бүрэн тэтгэж, амирлангуй ба амгалан сайн болгож үйлдээрэй.”

Тэгээд их хаан Вайшравана суудлаасаа босоод ийнхүү айлтгав: “Ялж төгс нөгчсөөн, надад ‘Хүслийг хангагч чандмань эрдэнэ’ хэмээх тогтоол буй. Хэн нэгэн үүнийг барих хийгээд хадгалахыг хүссэн тэдгээр амьтанд буян хэмжээлшгүй болох хийгээд, би өөрөө үргэлжид тэр хүнийг сахих ба аврах тул, түүний бүх зовлон нь арилан амгалан орших болно. Буян болон билгүүний чуулганыг ч үүсгэж үйлдмой. Тарни тогтоол үүнийг барихыг хүссэн хэн нэгэн бээр биеэ сахихын тулд өмнө нь энэхүү тарнийг өгүүлж үйлдээрэй:

НАМУ ВАЙШАРАМАНАЯ МАХАРАЖАЯ ТАДЯТА  
РАРА РАРА КУНО КУНО КУНО КУНО РУНО РУНО САБА  
САБА КАРА КАРА МАХА ВИКАРАМА МАХА ВИКАРАМА  
МАХА КАЛА МАХА РАЖА РАКЧА РАКЧА ТУ МАМ САРВА  
САТВАНАНА ЧА СУХА

“Ялж төгс нөгчсөөн, энэхүү тарнийг цагаан утсанд нэг удаа үлээхдээ нэг зангилаа зангидаж тэр мэт долоон удаа үйлдээд өвдгөндөө зүүвээс тэр хэрэг нь магадтай бүтэх болно. Тэгээд аглаг зэлүүд байшингийн дотор угаал сайн үйлдэж, цэвэрхэн хувцсыг өмсөөд гүгэл, зандан, гавар, дүрүга, агар, бойгар тэргүүтэн эдгээрийг тэнцүү найруулсан хүжээр тахиж, энэхүү тарнийг тоолж их хаан Вайшравана-г урин залж үйлдээрэй:

НАМУ ВАЙШАРАВАНАЯЭ МАХА ДАНДАЯ  
ЧАНДЭШВАРАЯ АКАРАША АПАРАМИТА ЧАНДЭШВАРА

ПАРАМА КАРУНИКА САРВА САТВА ХИТА ЧИНТА МАМА  
ДАНА БАРДО ПАРЯЭША СВАЯАМАМА КАРИША СУХА

“Энэхүү тарнийг долоон удаа тоолсны дараа үндсэн тарнийг тоолж үйлдээрэй. Энэ тарнийг унших үест чухаг дээд гурав болон их хаан Вайшравана-д эхлээд мөргөл үйлдэнэ. Их хаан Вайшравана нь амьтан бүгдийн сэтгэлийг хангах хийгээд эдийг өгч, амьтан бүгдийг амгалантай болгох тул ‘Хүслийг хангагч чандмань эрдэнэ’ хэмээх тарни үүнийг тоолбоос тэдгээр амьтад хүссэнчлэн амгаланг олох болно. Тэгээд тэнгэрийн хаан Вайшравана Ялж төгс нөгчсөн бурханы мэлмийн өмнө ‘Хүслийг хангагч чандмань эрдэнэ’ хэмээх тарнийн зүрхэн үүнийг өгүүлсэн юм:

НАМУ РАТНА ТРАЯАЯА НАМУ ВАЙШАРАМАНАЯЭ  
МАХАРАЖАЯА ТАДЯАТА СИМИ СИМИ СҮМҮ СҮМҮ  
ЧАНДА ЧАНДА ЧАРА ЧАРА САРА САРА КАРА КАРА КИЛИ  
КИЛИ КҮРҮ КҮРҮ МУРУ МУРУ ЧУРУ ЗУРУ САНДАЯА  
АДАМАНАМА НИДДЯАНА АНАДАРАДАТУ СУХА. НАМУ  
ВАЙШРАВАНАЯЭ СУХА. ДАНАДАЯЭ СУХА. МАНОРТА  
ПАРИ ПУРАЯА СУХА.

“Энэхүү тарнийг эхлээд мянган удаа тоолсны дараа аглаг байшингийн дотор хигээст хот мандал жижигхэн нэгийг үйлдээд идээ юу байгаагаараа тахиж үйлд. Дээд хүжийг шатаасны утааны үргэлжлэлийг таслалгүй өдөр шөнийн турш нэгэн үзүүрт сэтгэлээр тарнийн зүрх үүнийг сонсогдох төдий тоолон үйлдэнэ. Тэгээд их хаан Вайшравана-гийн хөвгүүн Зинарашаба хэмээгч залуу хүний дүрээр түүний дэргэд ирээд миний эцэгт юу айлтгах вэ хэмээн асууж үйлдэнэ. Тэгэхэд тэрээр: “Би чухаг дээд гурвыг тахирын тул эд эрдэнэ нэгийг айлтгаж байна, хайрлагтун” хэмээн өгүүл. Тэгээд хүү Зинарашаба бээр эцэгтээ: “Нэгэн дээд төрөлхтөн чухаг дээд гурвыг тахирын тулд эд эрдэнэ нэгийг айлтгаж байна” хэмээн айлтгана. Чингээд эцэг бээр: “Чи түргэн одож, нэг өдөрт зуун гаршабана өгөгтүн” хэмээн зарлиглана. Тэгээд тарнийг бүтээгч тэр шинж тэр мэтийг үзээд хүссэн хэрэг бүтэхийг мэдэж аглагийн орон түүндээ өөрөө ганцаараа хүжийг шатааж, унтах үедээ дэрэндээ үнэрт хайрцаг нэгийг тавиад унтаж үйлдэнэ. Түүнээс хойш өглөө болгон

түүний дотроос эд юу гарсан эд түүнийг, тэр өдөрт чухаг дээд гурвыг тахих эд зүйл, цэцэг, хүж, амны идээ тэргүүтэнд зарцуулах хийгээд садан төрөл үгээгүй ядууст ч өгөн, барж дуусгаж үйлдээрэй. Амьтан бүгдэд асрахыг сана. Уур хийгээд амьжиргааны санаа төрвөөс тэр доройтох болох учраас уурын сэтгэлийг төрүүлэлгүй үргэлжид сахиж үйлдээрэй. Тэгээд бас энэхүү тарнийг баригч тэр өдөр бүр тэнгэрийн хаан Вайшравана ба бас хүү хийгээд охин нөхөр сэлтийг үргэлжид санаж магтах хийгээд сайшааж үйлдээрэй. Үргэлжид арван буяны үйлийн мөрөөр явах хийгээд тэнгэр тэргүүтний хүч ба буян илтэд арвижих болох хийгээд буян дэлгэрэх хийгээд дээр үгүй бодийг ч олох болно. Тэнгэр тэдгээр тэр мэт үйлдэх түүнийг үзээд бүгд баясах хийгээд биширч ирэн түүнийг сахиж аварч үйлдэнэ. Тарничин тэр ямагт ч нас сүүдэр хэмжээлшгүй орших хийгээд гурван муу заяаг огоот тэвчиж зэтгэр саад бүгд ч үгүй болно. Сэтгэлчлэн бүтээх чандмань эрдэнэ энэ хийгээд гуу сан бусдыг ч олох болно. Рид хувилгааныг эрхэндээ урвуулж санасан бүгд нь ч бүтэх болно. Хэрвээ эд баялгийг хүсвээс сэтгэлчлэн бүтэх хийгээд шувуу болон араатны хэл бүгдийг ч мэдэх болно. Ялж төгс нөгчсөөн, тарни бүтээгч тэр намайг үзэхийг хүсвээс шинийн найман юмуу арван тавны өдөр цагаан даавуун дээр Ялж төгс нөгчсөний лагшингийн дүрсийг гавидатай найруулсан будгаар элдэв чимгээр чимж, зураач нь сэргээн ариусгах найман гишүүнт сахилыг хүртэж, бурханы зүүн талд Цогт охин тэнгэрийн дүрсийг зур, бурханы баруун талд их хаан Вайшравана намайг хүү нөхөр сэлттэй нь зураад тэр орондоо дэлгээд элдэв цэцэг олон янзын үнэртэн зулын дээд элдэв янзын амны идээгээр өдөр шөнө үргэлжид тасралтгүй тахиж үйлдээрэй. Энэхүү тарнийг тоолохдоо сэтгэлээ алгасралгүй үйлдэх хийгээд их хаан Вайшраваныг урин залах энэхүү тарнийг тоолж үйлд:

НАМУ ШИРИ ГАНАТАЯА БУДДАЯА НАМУ  
ВАЙШАРАВАНАЯА ЯАКЧА РАЖАЯА МАХА РАЖАЯА  
АТИ РАЖАЯА НАМА ШРИЯАЯЭ МАХА ДЭВИЯА  
ТАДЯАТА ТАРА ТАРА ТУРУ ТУРУ БАРА БАРА СУШУДДО  
СУШУДДО ХАНА ХАНА МИНИ КАНАКА ВАЖРА  
ВАЙДУРЯА МУГГАТИКА АЛАНКРИТА ШАРИРАЯЭ  
БО САРВА САТА ТИКАМА ТАКАМА ВАЙШАРАВАНА

ШРИЯА ДЭВИ ПРАБАЯА ЭХИ ЭХИ МАВИЛАМБА ГУРНА  
ГУРНА БАРАСЯА БАРАСЯА ДАХИ ХАМАМА ДИРАШАНА  
КАМСЯА ДАРИ ШАНАМА МАМА МАНА ПРАБАДАЯА  
СУХА.

“Ялж төгс нөгчсөөн, би тарнийг урих тэр хийгээд тахил агуу ихийг үзээд би асрахуй хийгээд баясахын сэтгэл төрөөд түүний өмнө эгэл нялхсын дүрээр юмуу аль эсвэл хөгшин өвгөн эсвэл гэлэнгийн дүрээр гаргаа чандмань эрдэнэ алтан сав сэлтийг бариад хот мандалын дотор ороод биеэрээ бишрэлийг үзүүлж бурханы алдар нэгийг өгүүлээд тэрхүү тарничид ийн хэмээн өгүүлнэ: “Та юу хийгээд юу гуйсан тэдгээр бүгдийг бүтээж үйлдэх буюу. Аглаг ой цэцэрлэгт одохыг хүссэн юмуу, их эрдэнэ хүссэн юмуу, олон хүний сэтгэлд зохистойг хүссэн юмуу, алт мөнгө тэргүүтэй эд хүссэн юмуу, бусад тарнийг бүтээх шид бүтээл хүссэн юмуу, рид хувилгаан илт мэдэл урт насыг хүсэх хийгээд эмийн шимийг авахыг хүсэх тэргүүтэн санаа бүгдийг нь сэтгэлчлэн бүтээж үйлдэнэ.” Би тэдгээр юмс тэргүүтнийг товч төдий нэгийг өгүүлсэн юм. Тэрнээс өөр бусад нэгийг хүсэхнээн ч бүгдийг сэтгэлчлэн огоот бүтээж үйлдэх бөгөөд их эрдэнийн барагдашгүй уурхай хийгээд буян цаглашгүй лугаа төгөлдөр болгоно. Үлгэрлэвээс, нар, сар энэ газарт унах хийгээд эх газар энэ нь бусдад урвах цаг байсан ч энэхүү үнэн үг энэ нь хэзээ ч хуурмаг болохгүй тул үргэлжид амгалантай хийгээд сэтгэлдээ жаргалтай төгс эдлэлийг олох болно.

“Бас Ялж төгс нөгчсөөн, судар аймгийн хаан үүнийг хэн нэгэн барих ба хадгалах, унших болохноон ч, тарни үүнийг бүтээхнээн ч төвөг багаатайгаар түргэн бүтээх болно. Ялж төгс нөгчсөөн, би бээр, хоосон ядуугийн зовлонгоор хохирсон амьтдын тулд тарни үүнийг номлосон учир тэр бээр элбэг баян, дээд амгалан, хотол чуулгантай нэг насандаа учрах болно. Би бээр ч түүнийг бүрэн сахих хийгээд аврах тул даган тэтгэж хорлол ба хөнөөл бүгдийг үгүй болгож үйлдэнэ. Бас *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* түүнийг барих хийгээд дэлгэрүүлэн үйлдэгч энэхүү тарнийг хадгалсан бодьгал түүнийг зуун алхамын дотор гэрлээр гийгүүлэн үйлдээд миний нөхөр мянган ягчис нар бээр ч үргэлжид түүний

зарцыг хийх бөгөөд боолын ажлыг санааны дагуу үйлдэн оршино. Миний үнэн үг энэ хуурмаг үгүйг ч Ялж төгс нөгчсөн бээр таалан соёрх.”

Их хаан Вайшравана бээр тарнийг тийнхүү өгүүлсэн хийгээд Ялж төгс нөгчсөн бурхан сайн болой, сайн болой хэмээн зарлиглаад: “Их хаан та бээр амьтан бүгдийг шуналаар энэлэх зовлонгийн тор бүгдээс хагацуулж элбэг баян ба амгалантай болгохын тул тарни үүнийг өгүүлсэн хийгээд бас судар аймаг үүнийг ертөнцөд огоот дэлгэрүүлэхийн тул тарни үүнийг номлосон нь сайн болой, сайн болой.”

Тэгээд дөрвөн их хаан суудлаасаа босоод дээдийн хувцасыг нэг мөрөндөө буулгаад, баруун өвдгөө газарт сөхрөөд, алгаа хавсран сөгдөж, хоёр өлмийд нь оройгоороо мөргөөд тэр цагт илтэд ёсонд зохилдсон шүлэг эдгээрээр Ялж төгс нөгчсөнийг илтэд магтав:

Ялгуусан хиргүй сар мэт лагшин;  
Ялгуусан мянган гэрэлт нарны гэрэл;  
Ялгуусан хиргүй лянхуа мэт мэлмий;  
Ялгуусан цомирлог мэт тоосгүй шүд;

Ялгуусаны эрдэм далай адил бөгөөд  
Элдэв эрдэнэ гарахын орон мөн.  
Ялгуусан далай билгүүний усаар дүүрсэн.  
Олон зуун мянган самадигаар машид дүүрсэн.

Ялгуусаны өлмий нь хүрдээр хээлсэн адил,  
Эргэн тойрны хүрээ түүнчлэн мянган хигээс,  
Өлмий ба мутар нь тороор хэлхэгдсэн бөгөөд  
Өлмийн тор нь галууны хааных мэт.

Алтан уул мэт машид үзэсгэлэнтэй.  
Арилсан хиргүй алтан сүмбэр уул,  
Эрдэм бүгд сүмбэр уул адил бөгөөд  
Ариуссан бурхан сүмбэр уулын хаанд мөргөө.  
Түүнчлэн заларсаны сар усны сар адил

Тэр мэт бас огторгуй лугаа ч адил.  
Илбэ зэрэглээ мэт хүсэл тачаал үгүй  
Эндүүрлийн хиргүй бурхан танд мөргөө.

Тэгээд Ялж төгс нөчсөн бурхан, дөрвөн их хаанд шүлэг үүнийг зарлиглав:

Арван хүчээс үүссэн ариун дээд *Алтангэрэлт*  
Эрхэт судар аймгийн хаан эрхэм дээд үүнийг  
Эрх хүчит ертөнцийг тэтгэгч та нар бээр  
Их баттай хичээлээр тэтгэн сахиж үйлд.

Энэ мэт судар аймаг ховор дээд гүнзгий  
Эх болсон амьтдад амгаланг өгөгч энэ  
Энгүй олон амьтдын тус амгалангийн тулд  
Энэ замбуу тивд өнө удаан орших болно.

Энэ мэт гурван мянган, их мянган  
Энэ ертөнц бүхэнд муу заяаны зовлон хийгээд  
Амьтны тамын зэрэг хамаг амьтан бүгдийн  
Аливаа зовлон бүгд амирлан үйлдэх болно.

Энэхүү замбуу тивийг эзлэн оршсон  
Их хаад хэн мөн бүгд  
Машид их баясгаланг төрүүлээд,  
Магад орон улсаа тэтгэж үйлдэнэ.

Алин бээр замбуу тив энд амгалан хийгээд  
Жил машид дэлгэрч хамаг бүгд баясч  
Аяа замбуу тив бүгдэд ч  
Амьтан бүгд амгалантай болж үйлдэнэ.

Энэ нь хүний хаан алин бүгд  
Орон улсаа баясгаж, өөрөө амгалан баясал хийгээд  
Хаан төрийн нэн доривжилгоо баясгалан түүгээр  
Судар аймгийн эрхэт үүнийг сонсож үйлдэнэ.

Судар аймгийн эрхэт энэ дээд буяныг үүсгэнэ.  
Сөргөлдөх чанадын дайсныг үнэнхүү дарж үйлдэнэ.

Дотлох цэргийн чуулганыг буцаан үйлдэгч буянт,  
Дээд аюул хоосролыг нэн арилган үйлдэгч.

Үлгэрлэвээс үзэсгэлэнт их эрдэнийн галбирваасан мод  
Эрдэм бүгд гарахын орон өөрийн гэрт байгаа мэт,  
Эрдмийг хүсэгч их хаад нар бээр ч  
Энэхүү судрын дээдийг тэр мэт үз.

Үлгэрлэвээс цангааг тайлагч сэрүүн усыг  
Үлэмж халууцан зүдэрсэн тэр олсон мэт,  
Эрдмээр цангасан их хаан түүнд  
Энэхүү судрын дээд тэр мэт мөн.

Үлгэрлэвээс их эрдэнэ бүгд гарахын орон  
Эрдэнийн хайрцаг алган дээр байгаа мэт,  
Хамаг хүний хаадад *дээд Алтангэрэлт*  
Хаан судрын дээд энэ тэр мэт мөн.

Үүнийг тэнгэрийн чуулган бээр илтэд тахиж,  
Үлэмж судрын хаанд хурмаст мөргөсөн тул  
Ертөнцийг тэтгэгч их рид хувилгаант  
Тэр дөрөв бээр бүхэнд сахисан мөн.

Хамаг зүгт бурхад нар бээр ч  
Хаан судар үүнийг үргэлжид таалж,  
Хаан судар үүнийг номлох аваас  
Хамаг бурхад бээр сайн хэмээн магтмуй.

Зуун мянган голди ягчис нар бээр ч  
Зүг бүхэнд орныг ч сахин үйлдэнэ.  
Сайтар баясах ба машид бишрэх сэтгэлээр  
Судар аймгийн хаан үүнийг сонсож үйлдмүй.

Тийнхүү замбуу тивд оршин буй  
Тэнгэрийн чуулганууд санаанд багташгүй  
Тэнгэрийн чуулган тэд бүгд ч машид баясан  
Тийнхүү судрын хаан үүнийг сонсож үйлдмүй.

Судар номыг сонсон үйлдсэн үүгээр  
Сүр жавхлан ба хүч хичээнгүйг олмуй.  
Сүр хүч ихээр тэнгэрийн бие нь  
Сайтар дэлгэрч нэн арвидах болмуй.

Тэгээд дөрвөн их хаан бээр Бурхан багшаас шүлэг энэ мэт эдгээрийг сонссон даруйд алмайран, гайхан баясаад тэд номын хүчээр нэгэн агшинд уйлаад, нулимсаа арчиж, тэдгээрийн бие нь арвидаж, гишүүн нь дэлгэрч, баясал амгалан сэтгэлийн амгалан санаанд багташгүй төгөлдөр болоод дахин Бурхан багшид тэнгэрийн цэцэг мандарвагаар тахин илтэд баясгав. Илтэд баясгаад, суудлаасаа босож, дээд хувцасыг нэг мөрөндөө буулгаад, баруун өвдгөө газарт сөхөрч, бурхан багш хаана буй тэр зүгт алгаа хавсран бөхийж Ялж төгс нөгчсөнд ийн хэмээн айлтгав: “Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, дөрвөн их хаан бид нар их хаан тус тусдаа ч, тав таван зуун ягчистай хамт номыг өгүүлэгч түүнийг сахих хийгээд бүрэн тэтгэхийн тулд үргэлжид номыг өгүүлэгч гэлэн түүнийг сүүдэр мэт дагах болно. Хэрвээ сударын аймаг үүнээс үгийн утга зарим нэгийг өгүүлэх болохноо ч, бид нар түүнд дурьдал хийгээд үл мартаж дээдийн тогтоол номын тийн тоог бүрэн гүйцээж үйлдэнэ. Судар аймгийн эрхэт эдгээр хаана орших орон тэдгээрийн амьтад бээр бүрэн дэлгэрүүлж үйлдсэнээр хэзээ ч үл доройтох болмуй.”

Тэгээд Ялж төгс нөгчсөн бурхан бээр хурсан нөхөд тэдгээрт номын тийн тоо үүнийг номлохын цагт тэдгээр амьтад бээр билгүүн болон оюуны самбаа, буяны чуулган хэмжээлшгүйг олж, нисванисыг тэвчихийн амгалан төгөлдөр болоод шастир бүгдэд мэргэжиж орчлонг бүрэн тэвчээд дээр үгүй бодиос эргэн үл буцахыг түргэн олсон болой.

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлгөн судраас*

*“Дөрвөн их хаан бээр орон улсыг бүрэн тэтгэх бүлэг”  
хэмээх арван хоёрдугаар бүлэг болой.*

\* \* \*

[Долдугаар хэсэг]

### *XIII бүлэг: Тачаал үгүй тогтоол*

Тэгээд Ялж төгс нөгчсөн бурхан бээр нас төгөлдөр Шарадудийн хүүд (*Шарипутра*) зарлиглав: “Шарипутра энэ мэт буюу. ‘Тачаал үгүй тогтоол’ хэмээх номын тийн тоо энэ нь, ном бүгдийг бясалгагч бодьсатва нарын эх адил бөгөөд бодьсадын урьдын явдал хийгээд бодьсадыг огоот баригч мөн болой.”

Тийн хэмээн зарлигласан хийгээд Бурхан багшид насан гавъяат Шарипутра ийнхүү айлтгав: “Ялж төгс нөгчсөөн, тогтоол нь оронд үл оршино, зүгт үл орших аваас, Ялж төгс нөгчсөөн, тогтоолыг мэдэн үйлдэгч тогтоолын үг утга тэр хаана буй?”

Ялж төгс нөгчсөн бурхан бээр насан гавъяат Шарипутрад ийн хэмээн зарлиглав: “Шарипутра, чи ямар мэт их хөлгөнд оршсон хийгээд, их хөлгөнд сүжиглэсэн, их хөлгөнд үлэмж үйлдвэр үйлдсэн мөн бөгөөс, Шарадудийн хүү минь! Чи ямар мэт тогтоол нь оронд үл орших, зүгт үл орших, ном ч бус, ном бус нь ч бус, өнгөрсөн ч бус, ирээдүй ч бус, одоо гарсан ч бус, бодитой ч бус, бодитой үгүй нь ч бус, шалтгаанаас гарсан ч бус, шалтгаан үгүйгээс гарсан ч бус, одохоос гарсан ч бус, одох үгүйгээс гарсан ч бус, юм алин бээр төрсөн ч бус, хорьсон ч бус гэж номлосон болон бодьсатва нарт тусалж үйлдэхийн тул энэ мэт бурханы эрдэм хийгээд бурханы шагшаавад, бурханы суртгаал, бурханы таалал, бурхан гарах энэ мэт болсон ‘Тачаал үгүй тогтоол’ хэмээгч номын тийн зүйлийг бүтээх мөрийн ухаан ба хүчний орныг үзүүлсэн сайн болой, сайн болой” хэмээн зарлигласан болой.

Насан гавъяат Шарипутра Ялж төгс нөгчсөнд ийн хэмээн айлтгав: “Бурхан багшаа, энэ мэт буюу. Тогтоолыг олж алинд оршвоос бодьсатва нар дээр үгүй, үнэнхүү төгсгөсөн, бодиос эргэн үл буцах, үнэнхүү андгайлах, шүтээн үгүй номын мөн чанарын самбаатай

багш болох, мөрд машинд орших тогтоолын номын тийн тоог номлон соёрх оо. Амгалан заларсан минь, номлон соёрх оо!” хэмээн айлтгав.

Ялж төгс нөгчсөн бурхан бээр насан гавъяат Шарипутрад ийн хэмээн зарлиглав: “Шарадудийн хүү минь! Сайн болой, сайн болой. Шарипутра тэр тэр мэт буюу. Тогтоолыг олсон бодьсадва түүнийг бурхан адил өгүүлэх буюу. Шарипутра, хэн нэгэн тогтоолыг олсон бодьсадваг хүндэлж үйлдсэн, дээдлэж үйлдсэн, өргөмжилж үйлдсэн, тахиж үйлдсэн тэрээр бурханд хүндлэл үйлдсэн болно. Шарипутра, хэн нэгэн тогтоол үүнийг сонсож үйлдсэн, алин нэг тогтоол үүнийг номлож үйлдсэн, алин нэгэн сүсэглэн үйлдсэн тэд нар бодьсадва нараас үл хагацсанаар бурханыг ямар мэт тахьсан тэр адил болно. Шарипутра, тогтоол тэр нь энэ мөн юм:

ТАДЯАТА САНАДАРНИ УДАТАРАННИ СУСАМА  
ПРАТИШТИТИ СУНАМА СУ-ПРАТИШТАТА  
ВИЖАЯАВАЛА САДАТА ПРАТИГЯА СУ-АРОХА ГЯАНА-  
ПАТИ УДАВАДАНИ АВАНАВАНИ АБХИ-ШЭНЯЧАНИ  
АБХИ-ВЯАХАРА ШУБХАХАТЭ СУДИСАШРИТА БАХУ  
ГУМАБА АБХИ-ВАДА СУХА

“Шарипутра, ‘Тачаал үгүй тогтоол’-ын үг үүнийг бодьсадва алин бээр машинд оршиж, сайтар барин, хадгалан үйлдсэн тэрээр галав юмуу, галваас илүү мянган галав болон, зуун мянган галавт ч ерөөл нь үл барагдах болно. Түүний бие нь мэсээр үл хөнөөгдөх болно. Хор ба хорт могойгоор үл хөнөөгдөх болно. Тэр ямар учраас вэ? хэмээвээс, Шарипутра, ‘Тачаал үгүй тогтоол’ энэ нь урьд заларсан бурхадын эх, ирээдүйд залрах бурхадын эх, одоо заларсан бурхадын эх мөн бөгөөд энэ мэт ‘Тачаал үгүй тогтоол’ хэмээгч номын тийн зүйл мөн болой. Шарипутра, хэн нэгэн бээр, арван буман, тоолшгүй гурван мянган, их мянган ертөнцийн орныг долоон янзын их эрдэнээр дүүргээд Ялж төгс нөгчсөн бурхадад харамжинд өргөх хийгээд тэдгээр Ялж төгс нөгчсөн бурхадыг тоолшгүй галавт хувцас хийгээд амны идээ элбэг баялгаар оршоон үйлдсэнээс, хэн нэгэн бээр ‘Тачаал үгүй тогтоол’-ын номын тийн зүйл үүнээс, нэг үг төдий барин үйлдсэн тэдгээр амьтан түүнээс ихэд олон их буяныг төрүүлэх

болно. Тэр ямар учраас вэ? хэмээвээс, Шарипутра энэ ‘Тачаал үгүй тогтоол’-ын номын тийн зүйл нь бурхан бүгдийн эх мөн болой.”

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлгөн судраас*

*”Тачаал үгүй тогтоол” хэмээх  
арван гуравдугаар бүлэг болой.*

\* \* \*

## *ХIV бүлэг: Хүслий хангагч эрдэнийн тогтоол*

Тэгээд Ялж төгс нөгчсөн бурхан бээр насан гавъяат Анандад зарлиглав: “Анандаа, аянга [цахилгаан] бүгдийг буцаагч тус тусад нь баригч урьдын үнэнхүү төгсгөсөн бурхадын зарлигласан түүнийг ч одоо номлож үйлдье, чи бээр сэтгэлдээ барихтун. Анандаа, зүүн зүгт Ирэгч хэмээх аянга байна. Анандаа, урд зүгт Зуун хэлт хэмээх аянга бий. Анандаа, баруун зүгт Гэрэл гийгүүлэгч хэмээх аянга бий. Анандаа, хойд зүгт Дамжлагын эзэн хэмээх аянга буй бөгөөд Анандаа, хэн нэгэн эдгээр аянгуудын нэрийг мэдэх болон нэн орших зүгийг мэдсэн түүнд аянгын аюул бүгд үл гарахыг мэдэж үйлдээрэй. Аянгын нэр эдгээрийг үсгэнд буулгаад орон хаана хаана тавьсан тэдгээр газарт аянга бүгд үл бууна.”

Мөн тэр цагт Ялж төгс нөгчсөн бээр “Давида”-ын нууц тарнийн үг эдгээрийг зарлиглав:

“ЭНЭ МЭТ МӨН, НИМИ НИМИ НИМИН ДАРЭ, ГУРВАН  
ЕРТӨНЦИЙГ ГИЙГҮҮЛЭН ҮЙЛДЭГЧ МУТАРТАА СЭРЭЭТ  
БЭЭР ЭНЭ ЗҮГТ АЯНГА БҮГДЭЭС НАМАЙГ САХИХТҮН  
САХИХТҮН СУХА.”

Бас тэр үед бодьсадва махасадва хутагт Жанрайсиг ванчүг тэдгээр нөхдийн дунд хуран сууж байсан тэр бээр Ялж төгс нөгчсөнд ийн хэмээн айлтгав: “Ялж төгс нөгчсөөн, би ч бас номын тийн тоо үүнд Давида-ын нууц тарнийн үгүүдийг өгүүлж үйлдье:

“ЭНЭМЭТМӨН.ХАТЭВИХАТЭНИХАТЭПРАТЯАРЭТХАКА  
ПРАТЯ-НИЯИТРЭ ШУДДЭ МУГУТЭ ВИМАЛЭ ПРАБА  
СВАРЭ АНАДАРЭ АНАДАРЭ ВАНДАРЭ ШВЭТЭ ВАНДАРА  
ВАСИНИ ХАРИ КАРАТИ БИДГАЛА ЧЭДХИ МУКИ.  
ЦАГ БУСЫН ҮХЭЛ БҮГДЭЭС НАМАЙГ САХИХТҮН  
САХИХТҮН. ХУТАГТ ЖАНРАЙСИГ ВАНЧҮГИЙН СҮР

ХҮЧЭЭР БИ ЦАГ БУСЫН ҮХЭЛ БҮГДИЙГ ЭС ҮЗЭХ  
БОЛОХТУН СУХА.”

Мөн нууцын эзэн Ваджрапани (*мон: Мутартаа очирт*), Ялж төгс нөгчсөн хаана буй тэр зүгт алгаа хавсран сөгдөөд Ялж төгс нөгчсөнд ийн хэмээн айлтгав: “Ялж төгс нөгчсөөн, би ч бас номын тийн зүйл үүнд тогтоолын үгсийг үйлдье:

ЭНЭ МЭТ МӨН. МУНИ МУНИ МУНИ РИРЭ МУНА МАТИ  
МАТИ СУМАТИ МАХА МАТИ ХА ХА ХА ХА ЧИ ХИЛЭНЦ  
ҮГҮЙ ТУЛ БҮҮ АЙХТУН ХЭМЭЭН МУТАРТААН ОЧИРТ  
(ВАЖРАПАНИ) ӨГҮҮЛМҮЙ ДРИВИДА СУХА.

“Ялж төгс нөгчсөөн, миний сахиус бусдад үл чадагдах үүнийг хэн зүрхэндээ барьсан юмуу үсгэнд буулгасан тэдгээрийг үргэлжид аюул бүгдээс сахиж үйлдэнэ. Цаг бусын үхэл бүгдээс гэтэлгэж үйлдэнэ.”

Мөн бас Тэсэшгүй ертөнцийн эзэн Эсрэн бээр Ялж төгс нөгчсөнд ийнхүү айлтгав: “Ялж төгс нөгчсөөн, би ч бас амьтан бүгдийн хэрэг хийгээд тус амгаланг үүсгэхийн тулд номын тийн зүйл үүнд нууц тарнийн тогтоолын үг эдгээрийг өгүүлж үйлдье:

ЭНЭ МЭТ МӨН. ХИЛИ МИЛИ ЧИЛИ СУХА. БРАХМА САРЭ  
СУХА. БРАХМА ГАРБЭ ПУШПА САНСТАРЭ СУХА.”

“Ялж төгс нөгчсөөн, энэ нь миний сахиус ‘Эсрэнгийн цааз’ хэмээгч бөгөөд цаг бусын үхэл бүгдээс огоот аварч хилэнц бүгдийг машид амирлуулан үйлдэгч болой.”

Мөн бас тэнгэрийн хаан Хурмаст бээр Ялж төгс нөгчсөн хаана буй тэр зүгт алгаа хавсран сөгдөөд, Ялж төгс нөгчсөнд ийнхүү айлтгав: “Ялж төгс нөгчсөөн, би ч бас номын тийн тоо үүнд нууц тарнийн тогтоолын үгсийг өгүүлж үйлдье.

ЭНЭ МЭТ МӨН. НИВА РАНИ БАНДА МАДАНАТЭ МАТИТИ  
ТИТИ ГОРИ ГАНАДАРИ ЧАНАДАЛИ МАТАДАГИ БАРА  
НАЛЭ ХАНА МАДЯА МА ДАРИНИ МАЛАНИ ДАЛА  
МАДАДЭ ЧАКРА ВАКРИ ШАВАРИ ШАВАРИ СУХА.

“Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, энэ нь миний арвис тарни ‘очир хэлийг буулгагч’ хэмээгч бөгөөд аюул бүгдээс гэтэлгэн үйлдэж цаг бусын үхэл бүгдээс огоот аврах болой.”

Мөн бас их хаан Дртараштра хийгээд Вирудака, Вирупакша, Вайшравана нар Ялж төгс нөгчсөн хаана буй тэр зүгт алгаа хавсран сөгдөөд Ялж төгс нөгчсөнд ийн хэмээн айлтгав: “Ялж төгс нөгчсөөн, бид нар ч бас олон төрөлхийтөнд туслах хийгээд олон төрөлхийтөнд амгалан болон орчлон ертөнцөд нигүүлсэнгүйн тулд номын тийн тоо үүнд нууц тарнийн тогтоолын үгсийг өгүүлж үйлдье:

ЭНЭ МЭТ МӨН. ПУШПА ПУШПА ДУМБАРИ ХАРИ АРЯА  
ПРАШАСТЭ НИРМУГАТЭ МАНГАЛЭ ТУ СТЭСТА ВИТЭ  
СУХА.

“Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, энэ нь их дөрвөн хаан бидний сахиус ‘аюул үгүй’ хэмээгч бөгөөд аюул бүгдээс авран үйлдэж, насыг тэтгэж цаг бусын үхэл бүгдээс огоот аврах болой.”

Тэгээд бас лусын хаан Сагара (*Далай*) хийгээд лусын хаан Видяут-прабха (*Аяндын гэрэл*), лусын хаан Анаватапта (*Илчгүй*), лусын хаан Аяндын оч, лусын хаан Шата-рашми (*Зуун гэрэлт*) нар Ялж төгс нөгчсөн хаана буй тэр зүгт алгаа хавсран сөгдөөд Ялж төгс нөгчсөнд ийн хэмээн айлтгав: “Ялж төгс нөгчсөөн, бид нарын их сахиус ‘хүслийг бүтээгч эрдэнэ’ хэмээгч аянга бүгдийг буцааж цаг бусын үхэл бүгдээс аварч, хорт сэтгэлийг амирлуулан үйлдэж, эрлэгийн элч, хараалч, боссон хүүр, өлзий бусыг эвдэн үйлдэгч мөн тул, Ялж төгс нөгчсөөн, лус бид нарын лусын төрлийн орон эндээс гарах хийгээд хармыг тэвчихийн тулд нигүүлсэнгүйгээр таалан соёрх. Тэр юуны тулд хэмээвээс Ялж төгс нөгчсөөн, лус бид нар харамч бөгөөд хармын сэтгэлээр хүрээлэгдсэн байдаг болой:

ЭНЭ МЭТ АРЯА ЖЭ АМАРЭ АСМИТА АКЧАЯЭ ПУНЯА  
ПАРЯАБА САРВА ПАПА ПРАШАМАНИЯЭ СУХА.

“Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, нууц тарнийн үг эдгээрийг эрэгтэй юмуу, эмэгтэй хэн нэгэн хэлэндээ уншиж, үсгэнд буулгасан түүнд аяндын аюул бүгд үгүй болохыг бид мэдэж үйлдье. Үндсэн

хор юмуу соёоны хор юмуу гол хор, алин бусад гишүүнээс гарсан хор тэдгээрээр хорлогдон үхэхгүй болой. Аюул бүгд хийгээд хорлол бүгдээс аврагдан амгалантай болох болтугай.”

Тэгээд Ялж төгс нөгчсөн бурхан Хурмаст, Эсрэн, ертөнцийг тэтгэгч, лусын хаан тэдгээрт сайн болой хэмээн магтаал хайрлаад: “Үзэсгэлэнт танар олон төрөлхтөнд туслах хийгээд олон төрөлхтөний амгалангийн тулд айлтгаад, номын тийн зүйл үүнийг даган огоот барихын тулд ‘дала бид’- н нууц тарнийн үгсийг номлосон сайн болой, сайн болой. Зүг бүгдэд унтсан болон согтсон, машид согтсон нарыг сахих болно.”

Ялж төгс нөгчсөн бээр тийнхүү зарлиглахад, тэдгээр гэлэнгүүд ба хурмаст, эсрэн, ертөнцийг тэтгэгч тэд хийгээд лусын хаад болон тэнгэр, хүн, асар, үнэр идэшт сэлт ертөнц бүгдээр Ялж төгс нөгчсөн бурханы зарлигт даган баясч илтэд магтвай.

*Хутагт Атлангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлгөн судраас*

*”Хүслий хангагч эрдэнийн тогтоол”  
хэмээх арван дөрөвдүгээр бүлэг болой.*

\* \* \*

*ХV бүлэг: Сарасвати (мон. Эшиллэнт)  
охин тэнгэрийн бүлэг*

Тэгээд Сарасвати охин тэнгэр бээр дээдийн хувцсыг нэг мөрөндөө буулгаад, баруун өвдгөө газарт сөхрөөд, Ялж төгс нөгчсөн хаана буй тэр зүгт алгаа хавсран бөхийж бурхан багшид ийнхүү айлтгав:

“Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, Их охин тэнгэр Сарасвати би бээр ч номыг өгүүлээч гэлэн түүний үгийг чимэхийн тулд оюуны самбааг чухал бүтээж үйлдэнэ. Тогтоолыг ч хайрлаж үйлдэнэ. Магадлах үгээр өгүүлэхийг бүхэнд агуулж үйлдье. Номыг өгүүлээч гэлэн түүнд мэдлийн их гэгээ төрнө. Дээд *Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнээс үг юмуу үсэг алин нэгнийг бид огоот анхаарах болох юмуу болбоос би бээр номыг өгүүлээч гэлэн түүний магадлах дуу, үг, үсэг тэдгээр бүгдийг бүтээж үйлдэнэ. Юу болохноо ч олон буман Ялж төгс нөгчсөн бурханд буяны үндсийг үүсгэсэн тэдгээр амьтны тусын тулд Дээд *Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг замбуу тивд өнөд удаан оршоох хийгээд түргэн үл доройтох хийгээд олон амьтад бээр дээд *Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг сонсоод билгүүн нь санаанд багташгүй хурц болж, билгүүний цогц санаанд багташгүйг олох хийгээд энэ насандаа нас хотол чуулганыг машид олох болж, аминд тус хүргэх хийгээд буяны цогц хэмжээлшгүйг машид барих болно. Элдэв аргаар машид эрж шастир бүгдэд мэргэжих болно. Элдэв янзын урлах үйлийг хотол чуулган болгоно. Доройтуулж үйлдэхгүйн тулд түүнд тогтоолыг ч хайрлаж үйлдэнэ.

“Номыг өгүүлээч гэлэн тэр хийгээд номыг сонсогч амьтан тэдгээрийн тусын тулд тарни болон эм лугаа төгөлдөр угаалын үйлийг өгүүлж үйлдэх бөгөөд гариг, од эрхэс, төрөх, үхэхийн хорлол хийгээд тэмцэлдэх, зөрчилдөх, хямралдах, хөнөөлдөх, муу зүүд болон уруу татагчийн хорлол бүгд хийгээд хараал болон боссон хүүр бүгд машид

амирлах болно. Алин бээр мэргэд нар угаал үйлдэхэд зориулсан эм ба тарни нь эдгээр юм: (1) вача, (2) горочана, (3) спррка, (4) шириса, (5) шамяака, (6) шами, (7) индрабаста, (8) махабага, (9) жнамака, (10) агару, (11) твач, (12) шривештака, (13) саржа-н давирхай (14) шаллаки, (15) гүүгүлү, (16) тагара, (17) пагра, (18) шайлея, (19) чандана, (20) манахшила, (21) сарочана, (22) кушта, (23) кункума, (24) муста, (25) саршапа (26) налада, (27) чавяа, (28) сукшмайла, (29) ушира хийгээд (30) нагакесара.

Эдгээрийг хувь тэнцүү найруулж

Эзнийг хаан одонд үйлдэж

Талханд нь тарины үг үүнийг

Зуун удаа илтэд талбин үйлд:

ТАДЯАТА СУКРИТЕ КРТА КАМАТАЛИ НАЛИ ЖАНА  
КАРАТЭ/ ХАДАКАРАТЭ ИНДРАЖАЛИНИ/ ШАМКРАДРЭ  
БАШАНТРИ/ АБАРТИКА СИКЭНА КУТРАКУ/ КАПЭЛА  
КАПЭЛА МАТИ/ ШИЛА МАТИ/ БАНДЭ ДУДУМАВАТИ/  
ШИРИ ШИРИ/ САДДЯАСТХИТЕ СУХА

Аргалаар хот мандалыг үйлдээд

Цэцгийн баглааг дэлгэж үйлд.

Алтан сав ба мөнгөн саванд

Бэлтгэсэн шүүсийг тавьж үйлд.

Төрөлхтөн хөө хуяг өмссөн дөрвийг

Тэр өдөр ч бас бэлдэж үйлд.

Машид чимэглэсэн дөрвөн охиныг

Бумба бариулан бэлдэж үйлд.

Үргэлжид гүүгүлийг уугиулж үйлд.

Таван янзын хөгжмийг дуурсгахад хичээ.

Шүхэр дуаз ялгуусаны тэмдгээр

Охин тэнгэр түүнийг сайтар чимэглэ.

Завсар завсарт нь толь тавь.

Сум, хурц үзүүрт жадыг бэлд.

Тэгээд хүрээ татаж үйлд.  
Түүний дараа хэргээ эхэл.

Тарнийн үйл эдгээрээр  
Хөл хорихыг ч туурвиж үйлд:

СЯТЭДАНА АРАКЭ/ НАЯАНИ/ ХИЛЕ/ МИЛЭ/ КИЛЭ/  
КИКИЛЕ СУХА

Ялж төгс нөгчсөний хажууд угаалыг үйлдээд тарни үүнийг тоолж  
үйлдвээс угаалаар амирлангуйд учирна:

ТАДЯАТА САГАТА/ ВИГАТА ПИГАТА ПАТИ СУХА

Дөрвөн зүгт алин оршсон  
Од гариг миний насыг сахихтун.  
Төрсөн одны хорлол хийгээд  
Цогцосын үйлийн аюул хийгээд  
Махбодийн орнууд хямарч үйлдэх  
Барагдашгүй аюул амирлах болтугай!

ТАДЯАТА САМЭ ВИШАМЭ СУХА/ САГАТЕ ВИГАТЕ СУХА/  
САГАРА САМАБУТАЯА СУХА/ СКАНАДА МАТАЯА СУХА/  
НИЛА ГАНТАЯА СУХА/ АПАРАЖИТА ВИРЯАЯА СУХА/  
ХИМАВАТ САМБУДАТАЯА СУХА/ ИНИБИЛАБАГТРАЯА  
СУХА/ НАМУБАГАВАТЕПРАМАНЕ/ НАМА САРАСВАТЯАЙ  
ДЭВАЙ СИДАДЯНАТУ МАНТРАВАТА/ ТАМ БРАХМА  
ДУМНЯАТУ СУХА.

Номыг өгүүлэгч гэлэн, түүнийг сахих хийгээд номыг сонсогч тэдгээр  
болон үсгэнд буулгагч тэдгээрийн тусын тулд угаалын үйл үүгээр би  
тэнд очиж үйлдэнэ. Тэнгэрийн чуулган бүгдээр хамтдаа хот юмуу,  
тосгон, хийд оронд өвчин бүгдийг машид амирлуулж үйлдэнэ. Юу  
болохноон ч, гэлэн юмуу гэлэнмаа, гэнэн юмуу гэнэнмаа судар  
аймгийн эрхэтийг баригч тэдгээрийн аминд тус хүргэх хийгээд  
хорвоогоос гэтлэхийг олох, дээр үгүй, үнэнхүү төгсгөсөн бодиос  
эргэн үл буцах хийгээд түргэн дээр үгүй үнэнхүү төгсгөсөн бодид  
илтэд гэгээрч бурхан болох, гариг эрхис хямрал, зөрчил зэрэг одны

хорлол, муу зүүд болон уруу татагчийн хорлол бүгд хийгээд хараал ба боссон хүүр бүгд нэн амирлаж үйлдэнэ.”

Тэгээд Ялж төгс нөгчсөн бээр Сарасвати охин тэнгэрт: “Их охин тэнгэр Сарасвати, та олон төрөлхтөнд туслах хийгээд олон төрөлхтөнд амгалангийн тул айлтгасан бөгөөд та бээр тарни ба эм төгөлдөр үг энэ мэтийг номлосон нь сайн болой, сайн болой!” хэмээн магтсан бөгөөд Сарасвати охин тэнгэр бээр Ялж төгс нөгчсөний өлмийд мөргөөд нэгэн зүгт суувай.

Мөн бас эшлэлийг үзүүлэгч бярман Каундинья багш бээр Сарасвати охин тэнгэр түүнийг дуудав:

“Их охин тэнгэр Сарасвати тахихад зохист их тэвчээрт,  
Энэ ертөнц бүгдэд тийн зүйл, дээдийг өгөгч, их эрдэмт,  
Үзүүрт оршсон үзэсгэлэнт дурва өвсөөр хувцсыг хэлхсэн,  
Дурва өвсөн хувцсыг өмссөн нэг хөлөөрөө оршигч,  
Тэнгэр бүгд цуглаад ийнхүү үгийг өгүүлээд  
Амьтан бүгдэд ариун үгийг номло, хэлээ соёрхохтун!

САЯА ТИДАНА МУРИЧИРЭ/ АВАЖА АВАЖАТИ/  
ХИДАГУЛЕ МИНГУЛЭ/ ПИНГАЛОВАТИ/ МУДГУШЕ/  
МАРИЧИ/ СВА МАТИ/ ДИША МАТИ/ АГРИ ТАМА ГРИ/  
ТАРИ ЧИТАРА/ ЧАВАТИ ЧАЧИРИ ШИРИ МИРИ/ МИРИЧИ  
ПРАНЯО ЛОКАЖА ШРИ ЛОКА ШРИ ШРА/ ЛОКА ПРИЯЭ  
САДАДЭ ПРАТЕ/ БРИМА МУКИ ШУЧИ ЧАРИ/ АПРАТИ  
ХАТА/ БУДДЭНА МУЧИ/ МАХА ДЕВИ ПРАТИ ГРИНА  
НАМАСКАРАН

Миний оюун торолтгүй болох болтугай.

ТАДЯАТА МАХА ПРАБАБА/ ХИЛИ ХИЛИ/ МИЛИ МИЛИ

Ялж төгс нөгчсөн эх Сарасвати охин тэнгэрийн хүчээр, би нэн ялах болтугай!

КАРАТЕ КЕЯУРА/ КЭЯУРА МАТИ/ ХИЛИ МИЛИ/ ХИЛИ  
МИЛИ

Бурханы үнэн хийгээд номын үнэн хийгээд хуврагийн үнэн, эрхэтийн үнэн, усны тэнгэрийн үнэнээр Их охин тэнгэрийг дуудаж үйлдье. Хэн нэгэн ертөнцийн үнэнийг өгүүлэгч тэдгээрийн үнэн хийгээд үнэн үгээр Их охин тэнгэрийг дуудаж үйлдье.

### ТАДЯАТА ХИЛИ МИЛИ/ ХИЛИ МИЛИ/ ХИЛИ МИЛИ

Би нэн ялах болтугай! Ялж төгс нөгчсөн эх, Сарасвати охин тэнгэрт мөргөмүй! Надад нууц тарнийн үгс бүтэх болтугай!”

Тэгээд Охин тэнгэр тарнийн үг түүнийг өгүүлээд бас бярман Каундиняа-д ийн хэмээн өгүүлэв: “Их төрөлхтөн та амьтан бүгдэд дээдийн самбаа хийгээд рид хувилгаан, илт мэдэл, их билгүүн, эд эрдэнэ тэргүүтнийг өгсөнөөр туслах хийгээд түргэн дээргүй бодийг олон үйлдэх сайн болой, сайн болой! Судар аймаг үүнийг барихын зан үйлийг үзүүлэхийн тулд шүлэг эдгээрийг өгүүлэв:

Энэхүү тогтоолыг анхлан хэн уншихдаа  
Эрдэнэт чухаг дээд гуравт мөргөөд,  
Эндүүрэл үгүйгээр тоолон үйлдвээс  
Эрхэм шид бүтээлийг олох болно.

Бурхад болон дээдийн ном  
Брадигабуд ба шарвага,  
Эсрэн тэнгэр ба Хурмаст тэнгэр,  
Их дөрвөн хаанд мөргөх ба  
Үргэлжид ариун явдлыг ч  
Үнэлэн биширч санаад  
Амирлангуй аглагийн оронд  
Дууг үүсгэж тогтоол ба магтаалыг өгүүл.

Хэдий чинээ бурхан тэнгэр лусад  
Төдий чинээ тахилыг ихээр бэлд  
Олон язгуурын төрөлхтөнд  
Энэрэнгүй сэтгэлийг ч төрүүлж үйлд.  
Алтан өнгөт Ялж төгс нөгчсөнийг  
Алгасралгүй сэтгэлээр бясалгаж үйлд.

Эрхэм зарлиг дээдийн номын номоор  
Эрхтэн тус тус магадлан зохиох  
Түүний үгийг авч сайтар санаад  
Хоосон чанарыг бүтээхэд оршиж үйлд.

Нийт бурхадыг сэтгэлдээ илт  
Нэгэн үзүүрт сэтгэлээр бясалган үйлдвээс  
Туст самади билгүүн хийгээд  
Тогтоол дээдийг олох болно.

Бурханы цогт дуулал ном зарлигаар  
Дээдийн эгшгээр шавь нарыг номхотгоно.  
Хэлээр гурван мянган ертөнцийг бүрхэн зохиож,  
Тус тусад нь юу зохистой гайхамшигийг үзүүлнэ.

Тэр мэтийн зарлигийн дээд дор  
Үргэлжид санаж аюулыг тэвч.  
Санаанд багташгүй хэлний билэгийг  
Сэтгэшгүй ерөөлийн эрхээр олно.

Юмсыг байхгүй гэж үзүүлэн зохиосон  
Ямар мэт огторгуйд үл торох адил  
Бурханы хэлний билэг зарлиг дуу  
Түүний санааг цаглашгүй ерөөлөөр бүтээнэ.

Эгшиглэнтийг хэн нэгэн илтэд тахих юмуу  
Эсвэл шавь бээр увьдас мэт  
Эшлэлийн дагуу ном түүнийг бүтээвээс  
Эрхэм хүндлэлийн дээдийг олох болно.

Хэн нэгэн билгүүн дээдийг бүтээхнээн ч  
Нэгэн үзүүрт сэтгэлээр ном үүнийг барь.  
Буян билгүүн чуулганыг арвидуулж  
Магадлан бүтээхэд тээнэгэлзээг тэвч.

Хэн нэгэн эдийг бүтээсэн эд лугаа төгөлдөр  
Ашиг хийгээд алдар нэрийг ч түүнчлэн бүтээнэ  
Гарахыг хүссэн ч нэн гэтэлгэхэд  
Магад бүтээлээр хоёр сэтгэлийг тэвчинэ.

Эрдэм олон хэмжээлшгүйг ч  
Санааны дагуу бүгдийг бүтээснээр  
Үүнд ёсчлон алин оршсон  
Магадтай бүтээж хоёр сэтгэлийг тэвчинэ.

Аглагт ариун хувцсыг өмсөөд  
Хот мандал юу таарахыг бүтээсэн тэрбээр  
Дэлгэрүүлэгч дөрвөн бумбыг тавих бөгөөд  
Тэр цагт цэцэг, хүжээр тахь.

Дуаз, шүхэр, унжлагыг унжуулж  
Чихмэл хөөмлөөр дэлгэрэнгүй чимэглэ.  
Бурхан ба Сарасвати-г тахь  
Тэнгэр түүнийг үзэхийг хүсвээс үзэх болно.

Сарасвати охин тэнгэр түүний өмнө  
Гурван долоо хоног тарнийг тоолоод,  
Хэрвээ тэнгэр түүнийг эс үзвээс  
Баттай сэтгэлээр ес хоног тоол,

Түүний шөнө нь ч эс үзвээс  
Бусдаас мэдэхийн орныг хайгаад,  
Ёсчлон охин тэнгэрийн дүрсийг зурж  
Тахих хийгээд тоолохыг бүү тасал.

Өөрт болон бусдын тус цаглашгүйд  
Өдөр шөнө үргэлжид хичээж үйлд  
Түүний үр бусдад хүч  
Тэрний санаа бүтэх болно.

Тэрний санаа эс бүтвээс  
Гурав зургаа есөн сар  
Эсвэл хичээлээр бүтэн жил тоолвоос  
Илт мэдэл зургаа тэргүүтнийг ч олно.”

Тэгээд бярман Каундиня тийнхүү номлохыг сонсоод баясал бишрэл хэмжээлшгүй төрөөд хурсан нөхөд тэдгээрт ийнхүү өгүүлэв: “Тэнгэр, хүн тэргүүтэй нөхөд бүгд алгасрал үгүй намайг сонсогтун. Би янагуух үнэнд тулгуурлан Сарасвати охин тэнгэр

дээдийг магтахын тулд шүлэглэн өгүүлж үйлдье:

Мөргөе их хүчит охин тэнгэрт  
Ертөнц орон энд эрхийг олсон  
Урьдын арш бээр номлосон учраас  
Учир иймд би таныг магтъя.

Цог төгөлдөр сэтгэл нь амгалантай хийгээд  
Үл мартагч үзэсгэлэнт алдар төгөлдөр  
Энэ ертөнцийг үүсгэсэн эх нь ч мөн  
Үргэлжид цогт их хичээлийг эдлэгч.

Эхийн орноос үргэлжид ялсан,  
Нигүүлсэн тэсэж, номхруулж үйлдэх,  
Эрлэгийн охин мангаст биеийг үзүүлсэн,  
Үргэлжид хөх торгон дээлийг эрхшээсэн.

Үзэсгэлэнт, үзэсгэлэнт бус лагшинг үзүүлсэн,  
Хэн нэгэн үзвээс уур төрөх,  
Хэмжээлшгүй явдал нь ертөнцөөс хэтэрсэн,  
Хэн ч авралд эрвээс даган барина.

Завсарын уул ба хаданд оршино,  
Завсарын агуй ба усны захад  
Эсвэл мод ой цэцэрлэг,  
Орон тэдгээрийг охин тэнгэр шүтнэ.

Тийнхүү уул хаданд хүмүүс бээр  
Тогосны өдөөр шүхрийг хийж  
Үргэлжид охин тэнгэр түүнийг тахьваас  
Үес бүгдэд ертөнцийг аварна.

Бар ба арслан эргэн үйлдэж,  
Баавгай ба шувуу ч түүнийг шүтнэ.  
Их хонхны дууг илтэд дуурсгаснаар  
Их Биндүүн ууланд цуурайтах болно.

Мутаргаа driшүл, толгойдоо тоорцог  
Мөн эсвэл нар сарны далбааг барьж,

Хуучрах сарны арван нэгэн юмуу  
Есний өдөр тахилыг үйлд.

Байлдааны үед нигүүлсэнгүй сэтгэлээр  
Бүх ертөнцийг болгоохын тулд  
Охин тэнгэр эд барааны дүрсийг үзүүлснээр  
Охин тэнгэрийн дээд бөгөөд зүйрлэшгүй болой.

Баясгалант малчны дүрийг үзүүлэх хийгээд  
Тэнгэрүүд тэмцэлд үргэлжид ялна.  
Өнө удаан ертөнц амгалантай оршиж  
Заримдаа уурлаж заримдаа амирлана.

Бярманы өгүүлэх нь дөрвөн ном хийгээд  
Рид хувилгаан нууц тарни бүхэнд мэргэжиж  
Тэнгэрийн эрхийн аршийг олсоноор  
Их газар энэ лугаа хөрөнгийг үйлдэнэ.

Охин тэнгэр хурах цаг үед ч  
Далайн давалгаа магадтай гарна.  
Ягчис Гүла тэргүүтэн бүгдийн  
Голлон үйлдэгчийг номхотгож чадна.

Эмс бүгдийн ариун явдлын дээд  
Энэ ертөнцийн эрхмүүдэд эрхшээсэн,  
Ялгуусаны оронд ч лянхуа мэт  
Гол мөрөнд ч онгоц ба гүүр.

Арван тавны саран мэт нигуур нь дэлгэрсэн.  
Олонтаа сонсох төгөлдөр шүтээнийг ч үйлдэнэ  
Уулын үзүүр мэт үлэмж самбаа  
Санаагаар тив хийгээд хамгийг ч үзүүлнэ.

Асар нарт уужим тэнгэр нар бээр  
Бүгдээр эрдмийг магтан сайшаасан.  
Мянган мэлмийт тэнгэрийн хаан хурмаст ч  
Бишрэхийн сэтгэлээр нигуураа үзүүлсэн.

Амьтан алин юу хүссэн  
Тэр бүгдийн санааг түргэн хангасан  
Ухаан түргэн сонссоныг барих нь ч  
Их газар орон энд бүхний дээд.

Арван зүгийн ертөнцийн орон бүгдэд  
Үргэлжид их зулыг гийгүүлэн үйлдсэн,  
Араатан жигүүртэн бирдүүдийн ч  
Бүгдийн санааг огоот хангасан.

Эхнэрийн дээд сүмбэр уул мэт  
Энэ ертөнцөд уул мэт орших арш  
Охин тэнгэр залуу боловч хүсэл лугаа хагацсан  
Тэсэшгүйн эзэн мэт үнэн өгүүлэгч.

Ертөнцтэй зохилдсон дүрсийг үзүүлсэн  
Хүсэлт орны тэнгэрийн оронд ч  
Та охин тэнгэрийн эрхэм мөн учраас  
Түүнээс дээд амьтан үгүй.

Хэрвээ байлдаан аймшгийн орон  
Галт гуунд унах юмуу  
Гол мөрөн хясаа зэрлэг хүмүүсийн  
Аюул түүнээс гэтэлгэн зохионо.

Хааны цаазаар хүлэгдэх юмуу  
Эсвэл дайсанд алагдах болохноон ч  
Сүсэглэсэн сэтгэл нь үл алгасарваас  
Зовлон тэдгээрээс гэтэлгэх болно.

Буян хийгээд нүгэл бүхэнд аварна  
Асрал хийгээд энэрлээр өмнө оршино  
Иймийн тул би сэтгэлээрээ сөгдөөд  
Их охин тэнгэрт мөргөх болой.”

Тэгээд бас эшийг үзүүлэгч бярман Каундинья багш бээр их охин  
тэнгэр Сарасвати-г шүлэг эдгээрээр илтэд магтвай:

Адын чуулган бүгд намайг сонсож үйлд!  
Тэнгэр хийгээд үнэр идэшт тэнгэрийн хаан сэлт ертөнцөд  
Бүсгүйн дээд охин тэнгэр дээдийн дээд алин мөн  
Дээд охин тэнгэрийн ихэд үзэсгэлэнтэй нүүрийг магтъя.

Эрдэм элдэв янзыг хурааснаар гишүүнийг чимсэн  
Сарасвати хэмээх мэлмий уужим буян нь бадарсан  
Хиргүй билгүүн эрдэм мэдлээр нэн чимэглэсэн  
Олон янзын их эрдэнэ мэт харагдах тул  
Машид дээд таны эрдэм үлэмжийг магтмой.

Дээдийн дээд шид бүтээлийг үйлдэгч хийгээд  
Үнэнхүү сайшаасан эрдмийг үйлдэгч хийгээд  
Хиргүй дээд лянхуаг бадраагч хийгээд  
Дээд мэлмий ба мэлмийн дээд хийгээд

Буяны орон хийгээд буяныг үзэх хийгээд  
Эрдэм санаанд багташгүй чимэгт хийгээд  
Саран адил хиргүй гэрэлт хийгээд  
Билгүүн гарахын орон дурьдлын дээд хийгээд

Арслангийн дээд ба хүнийг унасан хийгээд  
Найман мутраа нэн чимэглэхүй  
Нум сум богино жад, илд, цэргийн сүх хийгээд  
Шийдэм, төмөр, хүрд, цалмыг барьсан.

Наран саран мэт гэрэлт царай  
Сэтгэлд зохистой яруу эгшиг  
Гүнзгий билгүүн лугаа төгөлдөр бөгөөд  
Их хэргийг бүтээгч амьтдын дээд хийгээд

Тэнгэр асарын хаадууд тахин үйлдсэн  
Тэнгэр асарын чуулган бүгд орныг өгүүлсэн  
Адын чуулганы орныг үргэлжид тахихын тул  
Сваха бид нар охин тэнгэр үүнд мөргөө.  
Надад ялгамжаат эрдмийн мөрөнг хайрлахтун  
Хэрэг бүхэнд шид бүтээлийг надад хайрла  
Дайсны дотор намайг үргэлжид сахь.

Үсгийг гүйцээсэн үгийг дэлгэрүүлсэн эдгээрийг  
Маргааш босоод ариун өгүүлж үйлд.  
Санаа хийгээд эд тариа бүгдийг олно.  
Шид бүтээл буян агуу ихийг олох болно.

Тэгээд Ялж төгс нөгчсөн бээр бярман Каундинья-д сайн болой хэмээн зарлиглаад: “Чи бээр амьтан бүгдэд тус хийгээд амгалангийн тулд Сарасвати охин тэнгэрийг магтах хийгээд шид бүтээлийн дээдийг гуйсан нь хэмжээлшгүй буян төгөлдөр болой” хэмээв.

[Наймдугаар хэсэг]

Тэгээд багш эшийг үзүүлэгч бярман Каундинья бээр магтаал хийгээд нууц тарнийн үгээр Сарасвати охин тэнгэрт соёрхоод бас тэдгээр нөхөддөө өгүүлэв: “Төрөлхтөн та Сарасвати охин тэнгэрийг урин залж, түүний нигүүлсэлээр аврагдах хийгээд энэ насандаа торолтгүй самбаа хийгээд сонссоныг барих их билгүүн төгөлдөр болж, судар бүгдэд мэргэжиж, үгийг найруулахын чимгийг тодруулах хийгээд торолтгүй бүтээхийг хүсвээс магад санаа ба бишрэхийн сэтгэлээр Сарасвати охин тэнгэрийг урин залах үг үүнийг өгүүлж үйлдээрэй.

Бурханд мөргөмүй  
Номд мөргөмүй  
Хуврагт мөргөмүй  
Бодьсадва хийгээд шарвага, брадигабуд тэргүүтэй өнгөрсөн,  
ирээдүй, одоо заларсан хутагт бүгдэд мөргөмүй.

Арван зүгийн бурхан Ялж төгс нөгчсөн, үнэнхүү үнэн зарлигт оршсон, тус тусын эрхтэн зохилдсон, үнэнийг үзүүлэхэд хуурмаг үгүй зарлигт хэмжээлшгүй голди галавт үнэнхүү үнэний үгийг үргэлжид үзүүлсэн хийгээд зарлиг тэдгээрт даган баясмой. Үнэнийг зарлигласнаар уужим урт хэлийг дэлгэж, замбуу тив, дөрвөн махаранз нэг мянган, хоёр мянган, гурван мянган ертөнцийн орон хийгээд арван зүгийн ертөнцийн орон хэмжээлшгүй бүгдэд дэлгэрэн дүүрсэн нисванисын энэлэл бүгдийг арилгасан Ялж төгс нөгчсөн бурхан бүгдэд биеэрээ сөгдөөд мөргөх болой. Хэлний билгийн дээд тэр адил болон хэмжээлшгүй самбаа төгөлдөр болох болтугай би.

Мөргөө, Ялж төгссөн эгшиглэнт дээд  
Их бодь эгшиглэнт дээд  
Хутагт брадигабуд эгшиглэнт дээд  
Хос дөрөв, сондгой найм, эгшиглэнт дээд

Дөрвөн үнэнийг зарлигласан эгшиглэнт дээд  
Үнэнхүү болгоосон эгшиглэнт дээд  
Арш эсрэнгийн нөхөр эгшиглэнт дээд  
Охин тэнгэр Ума эгшиглэнт дээд

Хатаан үйлдэгч тэнгэр ч эгшиглэнт дээд  
Сүр жавхлант лус ч эгшиглэнт дээд  
Шөнийн охин тэнгэр эгшиглэнт дээд  
Дөрвөн махаранз эгшиглэнт дээд

Амгалан орших тэнгэрийн хөвгүүн эгшиглэнт дээд  
Очир нууцын эзэн эгшиглэнт дээд  
Түгэн орогч тэнгэр ч эгшиглэнт дээд  
Охин тэнгэр Балму эгшиглэнт дээд

Чуулганы эзэн тэнгэр ч эгшиглэнт дээд  
Цогт охин тэнгэр эгшиглэнт дээд  
Цогт оюун эгшиглэнт дээд  
Хири үсгийг хадгалагч эгшиглэнт дээд

Маму бүгдийн дээд эгшиглэнт дээд  
Булаагч эх ч эгшиглэнт дээд  
Ягчис бүгд ч эгшиглэнт дээд  
Арван зүгийн хаан эгшиглэнт дээд

Надад үйлийн дээд бүгдийн хүч хязгаарлашгүй эгшиглэнт  
дээдийг олон зохио.

Хуурмаггүйд мөргөмүй.  
Нэн гэтэлсэнд мөргөмүй.  
Шуналаас хагацсанд мөргөмүй.

Хүлээсийг тасалсанд мөргөмүй.  
Нэн сэтгэлд мөргөмүй.

Гэрэл үзэгдлийн зохиолд мөргөмүй.  
Үнэн үгийг зарлигласанд мөргөмүй.

Тоосноос хагацсанд мөргөмүй.  
Үнэмлэхүй оршсонд мөргөмүй.  
Олон нөхдийн эрхэнд мөргөмүй.  
Эгшиглэнт тэнгэрт мөргөмүй.

Би торолтгүй өгүүлэн зохио.  
Миний санаа юу байгаа  
Бүгдийг түргэн бүтээн зохио.  
Өвчин үгүй үргэлжид амгалан хийгээд  
Урт насыг ч олох болтугай.

Ухааны орнуудад мэргэжих хийгээд  
Бодийн мөрд хичээх болон  
Олон төрөлхтөнд тус бүгдийг зохио  
Бүх горилыг нь түргэн ханга.

Миний үнэмлэхүй үнэн үг ба  
Миний хуурмаггүй үгийг өгүүлсэн  
Дээд эгшиглэнт охин тэнгэр бээр  
Миний хэргийг бүтээн зохио.

Охин тэнгэр энд залран соёрх  
Миний үг торолтгүйг зохио  
Бие ба хэлэнд түргэн орших хийгээд  
Түргэн сэтгэлийн самбааг гүйцээн зохио.

Аяа миний хэлний эрхтэнд  
Амгалан заларсаны самбаа төрж,  
Үгийн сүр жавхлангийн хүчээр  
Амьтан бүгдийг номхотгон зохио.

Би үг юуг өгүүлсэн  
Бүх хэрэг бүтэх болтугай.  
Үгэнд нь бүгд бишрэн хүндэтгэж  
Үйлдвэр бүхэн үл шамшаагдмуй.

Хэзээ нэгэн миний хүсэл санаа  
Хэрэг тэр эс бүтэх болбоос  
Охин тэнгэр таны үнэн үг  
Оргүй бүгд хуурмаг болно.  
Завсаргүй таван хилэнц үйлдсэнийг  
Зөвхөн бурханы зарлигаар номхотгоно

Алин дайснаа дарагчид хийгээд  
Үйлийг урлах үгсүүд ба  
Шарипутра ба Мудгальяана  
Шавь нөхдийн эрхэм дээд  
Тэр бүгдийн үнэн үг ч  
Бүгд надад бүтэх болтугай.

Бурханыг шарвага шавь нарын хамт  
Би бээр өнөөдөр энд урин залъя.  
Миний горилыг хангахын тул  
Бүгд түргэн залран соёрх.  
Чин үнэн үгийг соёрхсон  
Чухам бүгд хуурмаггүй болтугай.

Алин орчлонгийн үзүүрээс доош  
Ариун орон бүгд хийгээд  
Эсрэн их эсрэн түшмэл хийгээд  
Эсрэнгийн хааны нөхөд бүгд  
Гурван мянган орчлон болон  
Тэсэшгүй ертөнцийн эрхэм дээд  
Тэр болон түүний нөхөд  
Тэд бүгдийг өнөөдөр энд урин залъя.  
Нигүүлсэнгүйгээр намайг тэтгэн зохио.  
Нигүүлсэнгүйгээр бүгдийг авран зохио.

Бусдын хувилгааныг эрхэнд үйлдэх тэнгэрүүд ба  
Бас ч Хувилгаанд баясагч тэнгэрүүд хийгээд  
Төгс баясгалант огторгуйн олон тэнгэр  
Төгс гэгээрсэн Майдар бурханы орон  
Тэмцлээс хагацсан орны тэнгэрүүд хийгээд

Түүнчлэн Гучин гурван тэнгэрийн орны тэнгэрүүд,  
Их дөрвөн хааны орны тэнгэрүүд,  
Өөр бас тэнгэрийн нөхөд бүгд,  
Шороо, ус, гал, хийн тэнгэрүүд,  
Сүмбэр ууланд орших тэнгэрүүд хийгээд  
Долоон мөрөн уулын тэнгэрүүд хийгээд  
Тэд бүгд нөхөд лугаа сэлт,  
Таван шанхат эдийг дэлгэрүүлэгч болон  
Тэрчлэн нар, сар, гариг од хийгээд  
Энэ тэргүүтэй дээд тэнгэрүүд ба  
Энэ ертөнцийн амгаланг эдлэх орон,  
Тэр тэргүүтэй тэнгэр бүгд,  
Аливаа хилэнцийг үл хүсэгч,  
Ариун бурханд бишрэхийн эх,  
Маш залуу хүүд асрах хийгээд  
Мөн тэнгэр, лус, ягчис нар,  
Үнэр идэшт ба асар нар,  
Өөр бас миамжи нар,  
Их Дочэ тэргүүтэн нар,  
Эд бүгдийг ч бурханы хүчээр  
Өнөөдөр энд би урин залъя.  
Нигүүлсэнгүй энэрэнгүй сэтгэлээр  
Надад торолтгүй самбааг төрүүл.

Бас тэнгэр ба хүмүүс бүгдийн  
Бусдын сэтгэлийг болгоогч нар  
Бүгдийн хүчээр адислах хийгээд  
Надад самбааны дээдийг хайрлаач.

Хэдий чинээ огторгуйн эцэст тулах  
Хоосон чанарын эцэс хязгааргүйд  
Хамаг амьтан тэд бүгд бээр  
Надад самбааны дээдийг хайрлаач.

Тийнхүү Сарасвати охин тэнгэрт бярман Каундиняа тийн хэмээн айлтгасан хийгээд охин тэнгэр бээр их төрөлхтөн түүнд буян болой хэмээн өгүүлээд: “Алин язгуурын хүү юмуу язгуурын охин хэн нэгэн

бээр энэ шүлгээр магтах хийгээд тарнийн үг тэдгээрийг хадгалах болон барих, чухаг дээд гуравт авралыг одуулж, дур сэтгэлээ даган зоригдож, юу хүссэн хэргээ зан үйлийн дагуу бүтээвээс үл шамшаагдах болно. Бас дээд *Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* машид нарийн хийгээд гүнзгий үүнийг сэтгэлдээ барих ба хадгалах, хурсан, уншсан түүний санаа бүгд түргэн бүтэх болно. Сэтгэл алгасарч үйлдвээс үл бүтнэ.”

Тийн хэмээн өгүүлсэн бөгөөд бярман Каундинья машид баясаж, сэтгэлд нь амгалан төрөөд, алгаа хавсран үйлдээд даган барьсан болой.

Тэгээд Ялж төгс нөгчсөн бурхан Сарасвати охин тэнгэрт сайн болой хэмээн зарлиглав: “Охин тэнгэр та, дээдийн ном үүнийг огоот сахих хийгээд огоот дэлгэрүүлж үйлдэх ба энэхүү судрыг барьсан амьтан бүгдэд ном энэ мэтийг үзүүлсэнээр амгалан, буян, самбаа хэмжээлшгүй арвидах болоод алин бодь сэтгэлийг үүсгэсэн бүгд ч түргэн дээр үгүй, үнэнхүү төгсгөсөн бодийг олж үйлдэх сайн болой, сайн болой.”

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлгөн судраас*

*”Сарасвати охин тэнгэрийн бүлэг”  
хэмээх арван тавдугаар бүлэг болой.*

\* \* \*

## XVI бүлэг: Шри (мон: Уот) охин тэнгэрийн бүлэг

Мөн тэр үед Ялж төгс нөгчсөн бурханд их охин тэнгэр Шри бээр ийн хэмээн айлтгав: “Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, Их охин тэнгэр Шри би бээр юу болохноо ч, номыг өгүүлээч гэлэн түүнийг хотол чуулган болгох эд зүйл бүгд хийгээд барилдлага хоосон үгүйг олох, сэтгэлийн зөнг олгох, сэтгэл амгалантай болгому хийгээд, *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнээс байдал тусдаа, үг болон үсэгнүүдийг сонсон мэдэж, сэтгэлдээ санаж, үнэнхүү өгүүлэх хийгээд зуун мянган бурхадад буяны үндсийг үүсгэсэн тэдгээр амьтны тусын тулд, *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* энэ замбуу тивд өнө удаан орших болж, түргэн үл доройтно. Амьтан төрөлхтөн ч *дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг сонсож, олон буман түг түмэн голди галавт тэнгэр ба хүний амгаланг амсах хийгээд, ган зуд үгүй болж, жил сайхан болж, амьтан бүгд ч амгалангийн учрал бүгдээр амгалантай болж, Түүнчлэн заларсан лугаа нөхөрлөх болж, ирээдүй цагт дээр үгүй, үнэнхүү төгсгөсөн, бодид илтэд гэгээрч бурхан болох хийгээд амьтны там ба адгуусны төрөл, эрлэгийн ертөнцийн зовлон бүгдийн үргэлжлэл машид тасрах болох энэ мэт буюу. Хувцас, идээ, орон байр, суудал, өвчнийг анагаах эм, эмийн зүйл, эд хэрэглэл, багаж зэмсэгийн зүйлүүдээр ч номыг өгүүлэгч гэлэн түүнийг үл дутааж үйлдмой.”

Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхан Ратна-кусумагуна-сагара-вайдурья-канакагир-суварна-канчана-прабасашри (мон: *Их эрдэнийн цэцэг, эрдмийн далай биндэръяа хийгээд Алтан уул сайн өнгөт, гэрэлд үзэгдэхийн цог*) хэмээгч түүнд их охин тэнгэр Шри бээр буяны үндсийг үүсгэсэн бөгөөд тэр бээр одоо зүг алин хийгээд алинд сэтгэх, зүг алин хийгээд алинд харах, зүг алин хийгээд алинд одохын зүг тэр хийгээд түүнд олон буман, түг түмэн голди амьтад амгалангийн найруулга бүгдээр

амгалантай болж, идээ, ундаа, эд, үр тариа хийгээд худалдаачид алт эрдэнэ, сувд, биндэрьяа, дун, болор, шүр, мөнгө, шижир алт хийгээд эд зүйл бусдаар ч үл хоосрох болох хийгээд тэдгээр амьтанд эд зүйл бүгдийг учруулах болно. Их охин тэнгэр Шри-гийн хүчээр Түүнчлэн заларсан түүнд тахил өргө, хүж цэцэг үнэртнийг ч өргөж үйлд. Их охин тэнгэр Шри-гийн нэрийг гурван удаа өгүүлэх хийгээд түүнд үнэртэн хүж цэцэг өргөж, элдэв амтыг ч өргөвөөс түүний үр тарианы их цогц нэн арвидах болно. Түүнд ийн хэмээсэн бөгөөд:

Газарт газрын шимүүд нэн арвидна;  
Тэнгэрүүд үргэлжид машид баясах болно.  
Үр жимс, үржилт модны тэнгэрүүд  
Элдэв сайн цэцэг жимсүүд ч дэлгэрнэ.

*Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хааны нэрийг өгүүлсэн тэдгээр амьтныг их охин тэнгэр Шри санах болно. Тэдэнд их цоггийг үйлдэх болно.*

Тэгээд Ялж төгс нөгчсөн бээр, их охин тэнгэр Шри-д сайн болой хэмээн зарлиглав: “Сайн болой, сайн болой! Охин тэнгэр та бээр урьд үйлдсэнийг даган дурьдсанаар түүнчлэн заларсанд тахих хийгээд хэмжээлшгүй амьтан бүгдэд туслах ба амгалангаар тэтгэх хийгээд судар аймгийг ч огоот дэлгэрүүлж үйлдэхийн барагдашгүй буян төгөлдөр болов.”

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлөн судраас*

*“Шри охин тэнгэрийн бүлэг”  
хэмээх арван зургадугаар бүлэг болой.*

\* \* \*

*ХVII бүлэг: Их Охин тэнгэр Шри бээр  
эдий олоот арвидуулах*

Тэгээд Их Шри (*түвд: Лхамо Балчэнмо*) охин тэнгэр бээр Ялж төгс нөгчсөнд ийнхүү айлтгав: “Ялж төгс нөгчсөөн, эндээс хойд зүгт холгүй нэгэн газарт тэнгэрийн хаан Вайшраванын Адака-вати (*мон: Бургасны навчит*) ордны орчимд, Пунья-кусума-прабха (*мон: Дээд буяны цэцгийн гэрэл*) хэмээх нэрт жаргалангийн цэцэрлэгт долоон янзын их эрдэнээс бүтсэн дээд байшин Суварна-дважа (*мон: Алтан дуазат*) хэмээгчид би орших бөлгөө. Хэн нэгэн хүн үр тарианы цогцыг арвижуулахыг хүссэн тэр бээр өөрийн гэрийг сайтар цэвэрлэж, угаалыг сайтар үйлдэж, цэвэр ариун цагаан хувцасыг өмсөж, машид сайхан үнэртэй дээлийг асааж үйлдээрэй. Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхан Ратна-кусумагуна-сагара-вайдурья-канакагир-суварна-канчана-прабасашри түүнд мөргөх хийгээд алдрыг нь ч гурвантаа өгүүл. Их охин тэнгэр Шри-гийн гараас Түүнчлэн заларсанд тахилыг үйлд. Цэцэг, хүж, үнэртнийг ч өргө. Элдэв янзын амттан шимтгэнийг ч өргө. *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хааны* нэрийг ч гурван удаа өгүүл. Үнэн үгийг ч өгүүл. Их охин тэнгэр Шри-д ч тахих ба цэцэг хүжийг ч өргө. Элдэв сайхан амттаны дээжийг ч өргөвөөс *дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүний хүчээр тэр цагт их охин тэнгэр Шри тэр гэрийг сэтгэлдээ анхаарч, түүний үрийн их цогцыг ч арвидуулах болно. Их охин тэнгэр Шри-г дуудахыг хүссэн хэн нэгэн бээр ухааны нууц тарни эдгээрийг санаж үйлдээрэй:

Өнгөрсөн ба ирээдүй, одоо цагт заларсан бурхан бүгдэд  
мөргөмүй!

Бурхан хийгээд бодьсатва бүгдэд мөргөмүй!

Ялж төгс нөгчсөн, Түүнчлэн заларсан Ратна-шикхин

(*мон: Их эрдэнийн үснэрт*)-д мөргөмүй!

Ялж төгс нөгчсөн, Түүнчлэн заларсан Вималож-жвала-ратна-  
рашми-прабасакету (*мон: Хиргүй бадарсан их эрдэнэ гэрэл  
үзэгдэлийн охь*)-д мөргөмүй.

Түүнчлэн заларсан Суварна-жамбудва-жаканчанаба (*мон:  
Замбуун алтан дуазат алтад үзэгдэхүй*)-д мөргөмүй.

Түүнчлэн заларсан Суварна-басагарба (*мон: Алтанд  
үзэгдэхийн зүрхэн*)-д мөргөмүй.

Түүнчлэн заларсан Суварна-шатарашми-прабаса-кету (*мон:  
Зуун нарны гэрэл үзэгдэлийн зүрхэн*)-д мөргөмүй.

Түүнчлэн заларсан Суварна-ратна-каракча-тракута  
(*мон: Алтан уул их эрдэнэ гарахын орон давхар шүхэр*)-т  
мөргөмүй.

Түүнчлэн заларсан Суварна-пушпож-жвала-рашми-кету  
(*мон: Алтан цэцэг бадарсан гэрлийн охь*)-д мөргөмүй.

Түүнчлэн заларсан Маха-прадипа (*мон: Их зул*)-д мөргөмүй.

Түүнчлэн заларсан Ратна-кету (*мон: Их эрдэнийн охь*)-д  
мөргөмүй.

Зүүн зүгийн түүнчлэн заларсан Акшобья (*түвд: Минтүгва*)-д  
мөргөмүй.

Өмнө зүгийн түүнчлэн заларсан Ратна-кету (*мон: Их эрдэнийн  
охь*)- д мөргөмүй.

Баруун зүгийн түүнчлэн заларсан Амитаба (*түвд: Цэвагмэд*)  
түүнд мөргөмүй.

Хойд зүгийн түүнчлэн заларсан Дундубисвара  
(*мон: Хэнгэрэгийн дуу*) -д мөргөмүй.

Бодьсадва Майтреяа-д мөргөмүй!

Бодьсадва Ручира-кету (*мон: Үзэсгэлэнгийн охь*)-д мөргөмүй!

Бодьсадва Суварна-басоттама (*мон: Дээд алтангэрэлт*)-д  
мөргөмүй!

Бодьсадва Суварна-гарба (*мон: Алтан зүрх*)-д мөргөмүй!

Бодьсадва Сада-прарудита (*мон: Үргэлжид уйлагч* )-д  
мөргөмүй!

Бодьсадва Дармодгата (*мон: Үлэмж номт*)-д мөргөмүй!

Бодьсадва Пратишта (*мон: Машид оришгч*)-д мөргөмүй!

Тэдгээрт мөргөөд, ухааны тарни эдгээрийг давтаж үйлд.  
Энэхүү ухааны тарни надад учрах болтугай!

СЯДАЯАТЭДАНА / ПРАТИ-ПУРНА-ЧАРЕ / САМАНТА-  
ДАРШАНЕ / МАХАВИХАР ГАТЕ / САМАНТА ВИМАНА  
ГАТЕ / МАХА-КАРЯА ПРАТИ ПРАМАНЕ / САТТВА АРТА  
САМАНТА-АНУПРАПУНЕ / АЯАНА-ДАРМАТА МАХА-  
БОГЭНЭ / МАХА-МАЙТРЭ- СУПАСАМХИТЕ / МАХА-  
КЛЭШЭ СУСАМГРИХИТЭ / САМАРТА-АНУ ПАЛАНИ  
СУХА

Эдгээр нь оройгоос авшиг хүртээх жам ёсны нууц тарнийн үг, хоосон чанарыг үнэнхүү бүтээсэн өглөг, хуурмаггүй утгын үг мөн. Завсарын явдалт амьтад, гэм хилэнц үгүй буяны үндсүүдээр, тарнийг долоон жил хүсэн барих болон найман гишүүнт мацаг барих сахилыг сахиад өөр болон бусад бүх амьтдыг бүхнийг болгоогч билгүүнийг огоот гүйцээхийг бүрэн төгсгөж үйлдэхийн тул үдээс хойш болон өмнө бурхан бүгдийг цэцэг ба хүжээр тахиад: “Түүгээр миний энэхүү санаа бүтэх болтугай. Түргэн бүтэх болтугай!” хэмээнэ.

Орон хийд юмуу аглаг орон ч байсан гэр түүнийгээ машид цэвэрлэн ариутгаж, аргалаар хот мандал бүтээгээд хүж ба үнэртнээр ариулж үйлд, ариун суудлыг ч дэлгэж үйлдээрэй. Газарт нь цэцгийн баглаа дэлгээд үзэсгэлэнтэй болговоос тэр агшинд их охин тэнгэр Шри ирээд тэнд саатах болно. Тэрнээс хойш гэр юмуу, тосгон юмуу, их хот юмуу, хот, номын сүм, хийд оронд хэзээ ч хоосон ядуугийн зовлон үгүй болно. Зочин ба алт, их эрдэнэ, үр тариа, эд зүйл бүгд учрах хийгээд амгалангийн найруулга бүгдээр амгалантай болно. Буяны үндэс алиныг үйлдсэн тэдгээр бүгдээс их охин тэнгэр Шри-д оюун ухаанаар дээдийг өгч үйлд. Тэгвээс тэр хэдий амьдрахыг хүртэл тэнд оршиж, үл хоосрох болно. Тэдгээрийн санаа бүгд бүрэн гүйцэх болно.

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлгөн судраас*

*“Их охин тэнгэр Шри бээр эдийг огоот  
арвидуулах” хэмээх арван долдугаар бүлэг болой.*

*XVIII бүлэг: Газрын Охин тэнгэр  
Дрда (мон: Бат-Эх)-ийн бүлэг*

Мөн тэр цагт Ялж төгс нөгчсөн бурханд газрын охин тэнгэр Дрда (*түвд: Саей.Лхаму.Данма*) бээр ийн хэмээн айлтгав: “Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* энэ одоо болон ирээдүй цагт тосгон ба хот, их хот, орон улс, аглаг хийд, уулын эмийн орон, ордны хүрээ алинд орших болоход хот, их хот, орон улс, аглаг хийд, уулын эмийн орон, ордны хүрээ түүнд, Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, газрын охин тэнгэр Дрда би сахьж үйлдэнэ. Бурхан багшаа, хаана *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг агуу ихээр үнэнхүү сайтар номлох хийгээд алин нэгэн газарт номыг номлогч гэлэн түүний номын ширээг бэлдэх ба хаа нэгэнтээ номыг өгүүлээч суудалдаа суугаад *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг агуу ихээр үнэнхүү сайтар номлож буй тэр газарт, Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, газрын охин тэнгэр Дрда би тэр болон тэдгээр газарт хүрэлцэн очно. Биеэ нууцлан номын ширээний доор оршоод, биеийн дээд толгойгоороо номыг өгүүлээч гэлэн түүний хөлийн улнаас нь түшиж үйлдэнэ. Бид нар ном сонсох хийгээд номын рашааны шим үүгээр цэнгэх болно. Машид хүндэлж сайтар тахиж үйлдэнэ. Би цэнгэх болж, өргөл хүндлэлийг үйлдэж, машид баясаад, жаран найман мянган бээр газрын цогц эндээс газрын очирт сууринд тулахыг хүртэл газрын шимээр нэн арвидуулан үйлдэнэ. Үнэнхүү хүндлэлийг үйлдэж огоот гүйцээж үйлдэнэ. Хөрсөн дээр ч, далайн захыг хүртэл газрын хот мандал үүнийг газрын шим тосоор чийглэж үйлдэнэ. Их газар энэ машид сүр жавхлан төгөлдөр болно. Тэгээд энэхүү замбуу тивд өвс хийгээд найлзуур мод, эмийн ургамал, ой цэцэрлэгүүд сүр жавхлан машид төгөлдөр ургах болно. Баясгалангийн цөөрөм, цэцэрлэг, галбирваасан мод бүгд хийгээд навч, цэцэг, үр жимс элдэв янз бүгд ч машид үзэсгэлэн

төгөлдөр болж, үнэр нь машинд анхилж, шим нь сайтар боловсорч, сайхан амттай болж харваас сэтгэлд машинд их гуа болно. Амьтан тэдгээр бүгд ч элдэв янзын идээ ундаа тэдгээрийг эдлээд нас, хүч, өнгө зүс бие эрхтэн нь нэн арвидах болно. Сүр жавхлан, хүч чадал, өнгө дүрс төгөлдөр болоод газарт байгаа олон буман элдэв янзын өөр өөр ажил хэргүүдийг үйлдэх болно. Хичээх болно, шамдах болно. Хүчтэй үйлүүдийг үйлдэх болно. Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, нөхцөл түүгээр замбуу тив бүгдэд амар амгалан хийгээд жил сайжрах хийгээд дэлгэрч баяр баясгалантай болно. Төрөлхийтөн хийгээд олон хүмүүсээр дүүрэх болно. Замбуу тивийн амьтан бүгд амгалантай болж, элдэв янзын баяр баясгаланг амсах болно. Амьтан тэдгээр сүр жавхлан, хүч чадал, өнгө дүрс төгөлдөр болно. *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* үүний тулд гэлэн юмуу гэлэнмаа, гэнэн юмуу гэнэнмаа судар аймгийн эрхэтийг баригч тэдгээр номын ширээ суудлын дээр залрах болно.

“Тийнхүү залраад, машинд тунгалаг сэтгэлээр амьтан бүгдийн хэрэг тус амгалан хийгээд *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* үүнийг агуу ихээр үнэнхүү номлож үйлдэхийн тулд номыг өгүүлээч тэдгээрт соёрхол тавих болой. Тэр ямар учраас вэ? хэмээвээс, Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, *Дээд Алтангэрэлт буюу судар аймгийн эрхэт хаан* үүнийг сайтар номловоос, газрын охин тэнгэр Дрда би боол зарц сэлт машинд сүр жавхлан хийгээд машинд хүч төгөлдөр болно. Бидний биенд хүч чадал хичээл хийгээд сэтгэлийн их хүч төрөх болно. Бидний биенд сүр жавхлангийн цог хийгээд хотол чуулган ч буй болно. Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, газрын охин тэнгэр Дрда би номын рашааны шим үүгээр цэнгэх болно. Сүр жавхлан хүч чадал хичээнгүй хийгээд сэтгэлийн их хүчийг олоод их газар долоон мянган бээрийн замбуу тив үүнийг газрын их шимээр нэн арвидуулах болно. Их газар сүр жавхлан машинд төгөлдөр болно. Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, газарт шүтсэн эдгээр амьтан бүгд ч арвижих хийгээд дэлгэрч уужим, агуу их болно. Газарт оршсон тэдгээр амьтад их болоод төгс эдлэл элдэв янзыг эдлэх болно. Түүнийг би ч амсах болно. Тэд бүгд идээ ундаа элдэв янз хийгээд хувцас, ор дэвсгэр, суудал, орон байшин, орд харш, баясгалангийн цэцэрлэг, горхи, цөөрөм, булаг шанд, нуур,

усан оргилуур энэ мэт амгалангийн эд элдэв янз оршиж газраас гарсан, газарт шүтсэн эдгээрийг эдлэх болно. Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, уг шалтгаан түүгээр тэдгээр амьтан бүгд миний ачийг хариулах болно. Дамжиггүй *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* үүнийг хүндлэн үйлдэж, сонсон үйлдэж, өргөмжлөн үйлдэж, дээдлэн үйлдэж тахиж үйлдмэй.

“Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, тэдгээр амьтан номыг өгүүлээчийн дэргэд байхын тулд, өөр өөр язгуур, өөр өөр гэрээс гаран одоод *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* үүнийг сонсох болно. Сонсоод ч өөр өөрийн язгуур хийгээд гэр, тосгон, хот тус тусдаа оршоод, өөр өөрийн гэртээ оршихдоо харилцан ийн: ‘Би өнөөдөр гүнзгий номыг сонссон, өнөөдөр бид нар санаанд багташгүй буяны цогц хураасан, бид нар номыг сонссоны буян түүгээр олон буман, түг түмэн голди түүнчлэн заларсан бурхадыг баясган үйлдсэн. Өнөөдөр бид нар номыг сонссоны буян үүгээр амьтны тамаас огоот гэтэлсэн. Адгуусны төрөл ба эрлэгийн ертөнц, бирдийн орноос огоот гэтэлсэн. Өнөөдөр бид нар номыг сонссоны буян үүгээр ирээдүй цагт олон буман төрөлдөө тэнгэр ба хүний төрлийг огоот барих болно’ хэмээн үг хэлэлцэх болно. Тус тусын гэрт оршин буй тэдгээр амьтан бусдад *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* үүнээс адаглаад нэгэн үлгэр төдийг өгүүлэх юмуу, *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* үүнээс нэг бүлэг юмуу, удиртгал нэг юмуу, эсвэл бодьсадвын нэр юмуу, түүнчлэн заларсаны алдар нэг юмуу, адаглаад дөрвөн мөрт шүлэг нэг юмуу, үг нэгийг тэдгээр амьтанд сонсгож үйлдэх юмуу, адаглаад *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* үүний алдар нэрийг машид үзүүлэх юмуу, Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, аль нэгэн газарт элдэв янзын амьтан тэдгээр өөр өөр зүгт судар аймгийн элдэв янзын нотлох үг энэ мэт эдгээрийг нэг нэгэндээ өгүүлэх юмуу, сонсгож үйлдэх юмуу, түүх болгон яриваас, Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, тэдгээр бүх газар машид сүр жавхлан төгөлдөр болж, машид шимтэй болно. Тэдгээр газруудад амьтан тэдгээр бүгдийн тулд газрын шим, элдэв янз хийгээд эд зүйл бүгд дэлгэрэх болно. Нэн арвидаж, машид дэлгэрч тэдгээр амьтан бүгд ч

амгалантай болно. Эд их төгс эдлэл их хийгээд өглөгт дурлах болно. Чухаг дээд гуравт илтэд сүжиглэх болно.”

Ийн хэмээн айлтгав. Ялж төгс нөгчсөн бурхан бээр, Газрын охин тэнгэр Дрда-д ийн хэмээн зарлиглав: “Газрын охин тэнгэрээ, номт хэн нэгэн *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* үүнээс адаглаад нэгэн үгийг сонсвоос, тэдгээр нь хүний ертөнц үүнээс үхэн егүүдээд Гучин гурван тэнгэрийн дотор тэнгэрийн язгуур алин нэгэнд төрөх болно. Газрын охин тэнгэрээ, хэн нэгэн амьтад *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* үүнийг тахихын тулд орон тэдгээрийг сайтар чимэглэн үйлдэх юмуу, адаглаад шүхэр нэг юмуу, дуаз нэг юмуу, ам даавуу нэгээр бүтээвээс газрын охин тэнгэрээ үргэлжид чимэглэсэн орон тэдгээр хүсэл эдлэгч тэнгэрийн долоон язгуур эдгээрт долоон янзын тэнгэрийн их эрдэнийн орд харш чимэг бүгдээр сайтар чимэглэгдсэн тэдгээрт орших болно. Алин цагт тэдгээр амьтад хүний ертөнц үүнээс үхэн егүүдээд долоон янзын их эрдэнийн орд харш тэдгээрт төрөх тэр цагт, Газрын охин тэнгэрээ, долоон янзын их эрдэнийн орд харш нэжгээд нэжгээдэд ч долоо долоон удаа төрөх болно. Тэнгэрийн амгалан санаанд багташгүй олныг ч амсах болно.”

Тийн хэмээн зарлигласан хийгээд Ялж төгс нөгчсөн бурханд газрын охин Дрда бээр ийн хэмээн айлтгав: “Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, тийм учраас газрын охин тэнгэр Дрда би, номыг өгүүлээч гэлэн номын ширээн дээр суусан түүний номын суудлын доороос зүг тэдгээрт оршиж үйлдэнэ. Юу болохноо ч, олон буман бурханд буяны үндсийг үүсгэсэн тэдгээр амьтны тусын тулд *дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* үүнийг Замбуу тивд өнө удаан орших хийгээд түргэн үл доройтох болно. Амьтан хүн бүгдээр ч *дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* үүнийг сонсох болох хийгээд ирээдүй цагт олон буман түг түмэн голди галавт тэнгэр болон хүний амгалан санаанд багташгүйг амсах болох хийгээд Түүнчлэн заларсан лугаа нөхөрлөх болж, ирээдүй цагт дээр үгүй, үнэнхүү төгсгөсөн, бодид илтэд гэгээрч бурхан болох хийгээд амьтны там болон адгуусны төрөл, эрлэгийн ертөнцийн зовлон бүгд

машид тасрах болохыг биеэ нууцлан үйлдэх бөгөөд номыг өгүүлэгч гэлэн түүний хөлийг биений дээд тэргүүнээрээ хүндлэн үйлдэнэ.

Тэгээд газрын охин тэнгэр Дрда ийн хэмээн айлтгав: “Ялж төгс нөгчсөнд зүрхэн тарни нэг байгаа үүнийг тэнгэр хийгээд хүн бүгдэд туслах ба амгалантай болгох буюу. Эрэгтэй, эмэгтэй дөрвөн нөхөр алин нэгэн намайг илтэд үзэхийг хүссэн хийгээд, эд, эрдэнэ, үнэт эдлэл тэргүүтнийг хүсэх хийгээд, сайн эмээр урт настай, өвчингүй байхыг хүсэх хийгээд, чанадын дайсан бүгд ба гадны эсэргүүцэч бүгдийг ялахыг хүсвээс л, аглаг оронд хот мандлыг бүтээгээд угаал үйлдэж, шинэ хувцсыг өмсөж, дурва өвсөн дээр, чандарласан лагшингийн өмнө суух юмуу, чандарт суварганы өмнө цэцэг хийгээд элдэв янзын хүж, амны идээ, зоогоор тахиад, хаан одтой тохиосон шинийн найманд нэгэн үзүүрт сэтгэлээр тогтоол тарни үүнийг тоолж урин залах буюу. Тарни нь:

ТАДЯАТА ЧИЛИ ЧИЛИ ЧУЛУ ЧУЛУ КУРУ КУРУ КУДЯА  
КУРУ ТОДЯА ТОДЯА БАХА БАХА ШАПАРИ ШАПАРИ  
СУХА

“Ялж төгс нөгчсөөн, дөрвөн нөхөр хэн нэгэн намайг урин залахын тулд тарнийн үг үүнийг зуун найман удаа тоолбоос, би түүний дэргэд очих болно. Мөн бас Ялж төгс нөгчсөөн, амьтан хэн нэгэн надтай уулзах хийгээд өгүүлэхийг хүсвээс зан үйл урьдахын ёсоор бэлдээд тарни үүнийг тоолж үйлдээрэй:

ТАДЯАТА АНЧАНИКЯА ЛИКШАНИ ШИШИДАРИ ХА ХА  
ХИ ХИ КУРУ БАРЭ СУХА

“Ялж төгс нөгчсөөн, тарнийн үг үүнийг зуун найман удаа тоолоод урьдах тарнийг тоолж үйлдвээс түүний өмнө биеэ үзүүлээд магадтай санааг нь гүйцээж үйлдэнэ. Хэн нэгэн энэхүү тарнийг тоолохыг хүсвээс урьд нь биеэ сахихын тулд тарни үүнийг өгүүлнэ.

ТАДЯАТА НИШИРИ БАША КАТИ ДАТИ ШУДТИ БУТА  
БУТЭРИ ТИТИ ВАТИ ГУГУТИ КАВАЧИЛИ СУХА

“Ялж төгс нөгчсөөн, тогтоол тарни үүнийг бүтээх зан үйл нь таван өнгийн утсанд тарнийг нэг удаа талбиж зангилаа нэг нэгийг талбих

болой. Тэр мэт хорин нэгэн удаа уншаад, зүүн гартаа зүүвээс аюул бүгд арилж бие сахих болой. Сэтгэл алгасралгүйгээр тарни үүнийг тоолбоос санаа бүгд бүтэх бөгөөд миний үг энэ хуурмаг үгүй болохыг бурхан чухаг дээд хийгээд ном, хувраг чухаг дээдүүд надад илтэд болгоох хийгээд таалан соёрх оо.”

Тэгээд Ялж төгс нөгчсөн бээр, Газрын охин тэнгэрт сайн болой хэмээн зарлиглаад: “Алин чиний үнэн тарнийн үг үүгээр судрын аймгийн эрхэт энэ хийгээд номыг өгүүлээч үүнийг сахин үйлдсэн нь сайн болой, сайн болой. Тиймийн тул та өөрөө ч хэмжээлшгүй буяны чуулган төгөлдөр болно.”

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлөн судраас*

*“Газрын охин тэнгэр Дрда-ийн бүлэг”  
хэмээх арван наймдугаар бүлэг болой.*

\* \* \*

*ХИХ бүлэг: Ягчисын хаан*  
*Самжняяа* (мон: Үнэнхүү мэдэл)-ийн бүлэг

Мөн түүний дараа Ягчисын аймгийн их ноён Самжняяа (*түвд: Ноджинжалбуу*), хорин найман ягчисын аймгийн их ноёны хамт суудлаасаа босоод, дээд хувцсыг нэгэн мөрөндөө буулгаад, баруун өвдгөө газарт сөхрөөд, Ялж төгс нөгчсөн хаана буй тэр зүгт алгаа хавсран сөгдөөд, Ялж төгс нөгчсөнд ийн хэмээн айлтгав:

“Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, өдгөө болон ирээдүй цагт *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* үүнийг тосгон юмуу хот, их хот орон улс, аглагийн зүг хүмүүний эмийн орон, орд харшийн орчим алинд гарах болох тэнд ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, ягчисын аймгийн их ноён Самжняяа би, хорин найман ягчисын аймгийн их ноён тэдгээрийн хамт тосгон юмуу хот, их хот, орон улс, аглагийн газар, уулын эмийн орон, орд харшны орчим тэнд очиж үйлдэнэ. Биеэ нууцлаад номыг өгүүлэгч гэлэн түүнийг сахиж үйлдэнэ. Бүрэн аварч, бүрэн хамгаалж, бүрэн тэтгэх хийгээд аюулыг тэвчих хийгээд амирлангуй ба сайн амгалантай болгож үйлдэнэ. Эрэгтэй юмуу эмэгтэй, хүү юмуу охин, номыг сонсогч тэдгээр бүгд хийгээд хэн нэгэн *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* үүнээс адаглаад дөрвөн мөрт шүлэг нэгийг сонсох болон, эсвэл нэгэн үг юмуу, эсвэл *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* үүнээс бодьсадвын нэр нэг юмуу бурханы алдар нэгийг сонсох болоод барьсан хийгээд, аль эсвэл *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* үүний нэрийг сонсох болоод барьсан тэдгээр бүгдийг бүхэнд сахиж үйлдэнэ. Огоот аврах хийгээд бүрэн хамгаалж, амирлангуй хийгээд сайн амгалантай болгоно. Язгуур тэдгээр хийгээд гэр тэдгээр болон, хот тосгон тэдгээр ба хааны ордны нөхөд тэдгээрийг ч бүхэнд сахиж үйлдэнэ. Бүрэн аварч, бүрэн хамгаалж, бүрэн тэтгэх хийгээд аюулыг тэвчиж амирлангуй болон сайн амгалантай болгоно.

“Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, уг шалтгаан алинаар би ягчисын аймгийн их ноён Самжнаяа хэмээх нэрийг олох болов? хэмээвээс, энэ нь ариун санваарт Ялж төгс нөгчсөн танд ил бөгөөд ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, би юм бүгдийг эрэх болой. Юм бүгдийг огоот эрэх болой. Юм бүгдийг дотроо багтаах болой. Янагуух үнэний юм бүгд хийгээд үнэмлэхүй үнэний юм бүгд болон орон алин байгаа хийгээд юмс бүгд алин байгаа юмс бүгдийн язгуур алин байгаа хийгээд ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, юм бүгд надад илт болой. Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, юмс үзэгдэл бүгдэд миний билгүүний үзэгдэл санаанд багташгүй, билгүүний гэгээ санаанд багташгүй, билгүүний гүйлт санаанд багташгүй, билгүүний цогц санаанд багташгүй болой. Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, юмс үзэгдэл бүгдэд миний билгүүний оронд орохуй санаанд багташгүй болой. Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн би юмс үзэгдэл бүгдийг үнэнхүү бүрэн эрсэн, үнэнхүү бүрэн ажигласан, үнэнхүү бүрэн эрсэн, үнэнхүү нэн харсан, үнэнхүү дотроо багтаасан шалтгаан түүгээр Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, би ягчисын аймгийн их ноён Самжнаяа хэмээх нэрийг олсон.

“Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, би бээр номыг өгүүлэгч гэлэн түүний үгийг чимж үйлдэхийн тулд самбааг нь чухал бүтээж үйлдэнэ. Юу болсон ч номыг өгүүлэгч түүний биеийг алжаах үгүй болгох хийгээд биений эрхтэнг амгалантай болгож, машинд баясгаланг төрүүлэх хийгээд алин олон буман бурхадад буяны үндсийг үүсгэсэн амьтдын тусын тулд *дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* энэ Замбуу тивд өнө удаан орших хийгээд түргэн үл доройтох болоод амьтан бүгд ч *дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* үүнийг сонсох болж, билгүүний цогц санаанд багташгүйг олох болж, билгүүн лугаа төгөлдөр болж, буяны цогцыг машинд барих болж, ирээдүй цагийн түг түмэн буман голди галавт тэнгэр болон хүмүүний амгалан санаанд багташгүй олныг амсах болох хийгээд Түүнчлэн заларсан лугаа нөхөрлөх болоод ирээдүй цагт дээр үгүй үнэнхүү төгсгөсөн бодид илтэд гэгээрсэн бурхан болох хийгээд амьтны там адгуусны төрөлт, эрлэгийн ертөнцийн зовлон бүгдийг машинд амирлуулж үйлдэхийн тулд түүний шар үсний нүхүүдэд сүр жавланг хайрлах болно. Түүний биенд хүч хийгээд чадал, их

хичээнгүйг үүсгэж үйлдэнэ. Түүний билгүүний гэгээ санаанд багташгүй болно. Түүний дурьдлыг дотроо багтааж үйлдэнэ. Тэр ихэд дэвшиж үйлдэнэ.”

Тэгээд ягчисын их эзэн Самжнаяа ийн хэмээн айлтгав: “Ялж төгс нөгчсөөн, надад тарни тогтоол нэг байгаа үүнийг амьтан бүгдэд туслах хийгээд энэрэхийн тул, Ялж төгс нөгчсөний мэлмийн өмнө би бээр тарни үүнийг уншиж үйлдье. Тарни нь:

НАМУ БУДДАЯА НАМУ ДАРМАЯА НАМУ САНГАЯА  
НАМУ БРАХМАЯА НАМУ ИНДРАЯА НАМА ЧАТУР  
МАХАРАЖАНАНА ТАДЯАТА ХИЛИ ХИЛИ МИЛИ  
МИЛИ ГАУРИ МАХА ГАУРИ ГАНДАРИ МАХА ГАНДАРИ  
ДРИМИДИ МАХА ДРИМИДИ ДАНДА КУКУНДЭ ХА ХА  
ХА ХА ХА ХИ ХИ ХИ ХИ ХИ ХУ ХУ ХУ ХУ ХУ ХАЛО  
ДАМЭ ГУДАМЭ ЧА ЧА ЧА ЧА ЧИ ЧИ ЧИ ЧИ ЧУ ЧУ ЧУ  
ЧУ ЧАНДЭШВАРА ШИКАРА ШИКАРА УТТИШТА ХЭ  
БАГАВАНА САМВИДА ГЯАЯА СУХА

“Алин нэгэн бээр ухааны тарни үүнийг хадгалах хийгээд бариваас, би түүнд амьжиргааны эд зүйл өдрийн зоог, хувцас, цэцэг, үр жимс, эд эрдэнэ тэргүүтэн бүгдийг хайрлаж үйлдэнэ. Алин нэгэн охин, хүү хийгээд эр, эм зарц хийгээд алт, мөнгө, үнэт эрдэнэ хийгээд чимэг тэргүүтэн эд зүйлийг хүсвээс ч, би түүнд хүссэнчлэн тус тусад нь хайрлаж үйлдэнэ. Энэхүү ухааны тарни нь хүч хийгээд их сүр жавхлан төгөлдөр тул, энэхүү тарнийг уншихын цагт би үтэр түргэн түүний дэргэд очиж юуг ч торолтгүй бүтээж үйлдэнэ. Нууц тарни үүнийг бүтээх зан үйл нь эхлээд ягчисын их эзэн Самжнаяагийн дүрсийг уртааш нь дөрөв юмуу таван барим, гартаа байлдааны сүх барьснаар зурсаны өмнө дөрвөлжин хот мандлыг бүтээсний дөрвөн талд нь бал юмуу бурамтай усаар дүүрсэн дөрвөн бумбыг тавьж түрхлэг хийгээд, талх ба хүжийг уугиулж цэцгийн эрхсээр ч тахиж үйлдээрэй. Бас хот мандал түүний өмнө өглөгийн түллэгийн тулга байгуулж, утаагүй галын дотор тос хийгээд юнгарыг хольж тарни нэжгээдийг уншиж тулга түүний дотор өглөгийн түллэгийг үйлдэнэ. Тэр мэт зуун найман удаа түлэх даруйд би түүнд биеэ илтэд үзүүлээд, Чи юу хүсэж байна? хэмээн асууж үйлдэнэ. Тэгээд

бүтээлчин тэр бээр ч, юу хүссэн түүнийгээ өгүүлэхийн зэрэгцээ юу хүссэн түүнийг өгч үйлдэнэ. Алин алт мөнгийг хүсэх хийгээд, уурхайг эрэхийг хүссэн хийгээд, тэнгэрийн аршийг хүссэн ч тэр нь бүтээд огторгуйд нисэн одно. Бас тэнгэрийн нүд хийгээд бусдын сэтгэлийг мэдэх тэргүүтэн илт мэдэл бүгдийг ч олж үйлдэнэ. Амьтан бүгдийг сэтгэлчлэн эрхшээх хийгээд нисванис бүгдийн үргэлжлэлийг таслаад нэн гэтлэхийг олох болно.”

Тэгээд Ялж төгс нөгчсөн бурхан бээр, ягчисын аймгийн их ноён Самжная-г, сайн болой хэмээн сайшаасан бөгөөд: “Сайн болой, сайн болой! Алин та бээр амьтан бүгдэд туслах хийгээд амгалантай болгох дээдийн ном үүнийг огоот сахихын тулд тарнийн үг үүнийг өгүүлснээр хэмжээлшгүй буян арвидах болно.”

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлгөн судраас*

*”Ягчисын хаан Самжная-гийн бүлэг”  
хэмээх арван есдүгээр бүлэг.*

\* \* \*

## XX бүлэг: Хааны шастир ‘Тэнгэрийн Эрхэтийн тангараг’

Тэндээс Газрын охин тэнгэр Дрда хэмээгч тэр тэдгээр олон нөхдийн дундаас суудлаасаа босоод, Ялж төгс нөгчсөн бурхан багшийн өлмийд оройгоороо мөргөж, алгаа хавсран сөгдөөд, ийн хэмээн айлтгав: “Ялж төгс нөгчсөөн, хэн нэгэн нутаг орондоо хүмүүний хаан болсон тэрээр үнэнхүү номыг эс үйлдвээс, төр улсаа барих хийгээд олон амьтныг жаргуулах, өөрийн биеийг мандуулах, өндөр суудалд өнө удаан оршиж чадахгүй учир их нигүүлсэнгүй төгөлдөр Ялж төгс нөгчсөн та үнэмлэхүй хааны шастираар төр улсыг хэрхэн барихыг номлон соёрх. Түүнийг сонсоод хүмүүний хаадууд, ном тэр мэтээр ертөнцийг тэтгэж хааны дээд суудалд өнө удаан оршноор, амгалантай болох хийгээд, нутаг орны иргэд тэд бүгд ч огоот амгалантай болох юм.”

Тэгээд Ялж төгс нөгчсөн бурхан чуулсан олон нөхдийн дунд Газрын охин тэнгэр түүнд ийн хэмээн зарлиглав: “Газрын охин тэнгэрээ, тийн болбоос чи машид сайн сонсогтун. Эрт урьдын өнгөрсөн цагт Балендра-кету (*мон: Хүчийн эрхэт охь*) хэмээх хаанд Ручира-кету (*мон: Үзэсгэлэнгийн охь*) нэрт хан хүү байжээ. Түүнийгээ хаан ширээ залгамжлуулаад өнө удалгүй нэгэн цагт: ‘Дээд эцэг Варендра-кету (*мон: Эрхэтийн охь*) хаанаас уламжилсан Тэнгэрийн эрхэтийн тангараг хэмээгч хааны шастир нэгэн байсан ба, би урьд нь Тэнгэрийн эрхэтийн тангараг хааны шастир түүгээр хоёр түмэн жилийн турш хаан төрийг барьсан бөгөөд урьдын тэр цагт адаглаад, сэтгэлийн нэг хором төдий ч ном бусын зүйл юуг ч бодож байгаагүй. Хүү минь ээ! Тэнгэрийн эрхэтийн тангараг хэмээх хааны шастир тэр нь алин бэ? хэмээвээс’

“Язгуурын охин тэнгэрээ, тэр цагийн тэр үед Балендра-кету бээр, хан хүү Ручира-кету-д Тэнгэрийн эрхэтийн тангараг хэмээгч хааны

шастирыг эдгээр шүлгээр агуу ихээр, үнэнхүү машид үзүүлсэн болой:

Амьтан бүгдэд туслагч,  
Эргэлзээ бүгдийг таслагч,  
Хамаг гэмийг эвдэгч,  
Хааны шастирыг номлосугай.

Бүх хаадууд тус бүртгээ  
Баясангуй сэтгэлийг төрүүлж,  
Тэнгэрийн эрхэтийн тангараг бүгдийг  
Алгаа хавсран сонсож үйлд.

Эрхэт уул Вадра-кара (*мон.Хувиршигүй орон*) энд  
Хурмастын хаан чуулсаны дотроос  
Эрхэт хаад нар босож  
Эсрэн тэнгэрээс ийн асуув:

‘Та тэнгэрийн эрхэм эсрэн билээ;  
Та тэнгэр нарын эрхт баялаг билээ;  
Та бидний эргэлзээг таслагч билээ;  
Тиймээс бидний сэжгийг таслан соёрх.

Хүн болж төрсөн хаан түүнийг  
Хэрхэн юунд тэнгэр хэмээн өгүүлнэ?  
Ямар учраас хүний хааныг  
Ямагт тэнгэр хэмээн хүндлэх болов?  
Хэрвээ тэнгэр нь ямар мэт  
Хүний ертөнц энд төрж,  
Хүний эзэн болж хүмүүсийн  
Хаан нь болж үйлддэг юмуу?’

Эрхэм дээдсүүд Эсрэн тэнгэрээс  
Ийнхүү огоот асуусан хийгээд  
Тэнгэрийн эрхэн эсрэн тэр бээр  
Тэдгээр хаадад ийн хэмээн өгүүлэв:

Тэр мэт ертөнцийг тэтгэгч нар бээр  
Тийнхүү надаас асуусан учир

Амьтан бүгдэд туслахын тулд  
Агуу шастирыг би номлосугай.  
Хүний оронд мэндлэн төрсөн  
Хаан бологсодын төрөл хийгээд  
Ямар шалтгаанаар орон тэдгээрт  
Ялгуусан хаан болдогийг номлоё.

Хүчит тэнгэрүүдийн адистэдээр  
Хүний оронд төрдөг буюу;  
Тэнгэр урьд нь адистэдлээд,  
Түүний хойно умайд ордог болой.

Хүний ертөнцөд төрөөд тэр,  
Хүмүүний эзэн болох бөлгөө.  
Тэнгэрээс төрсөн учраас түүнийг,  
Тэнгэрийн хөвгүүн хэмээн өгүүлдэг.

‘Та бол тэнгэрийн хүү мөн’ хэмээн  
Гучин гурван тэнгэрийн хаан бээр  
Хааны хувийг түүнд өгөөд  
Хүний эзэнд өргөмжлөх болой.  
Нүгэлт үйл бүхнийг хорьж,  
Ном бусыг тэвчих хийгээд  
Амьтан бүгдийг сайн үйлэнд байгуулан,  
Ариун тэнгэрийн орон мэт болгохын тул

Хүний хаан тэр заримдаа хүн дүрээр,  
Хааяа тэнгэр болон хааяа үнэр идэшт,  
Хааяа зандалчин ба мангасын ч дүрээр,  
Хилэнцэт үйлийг буцааж үйлдэнэ.

Харин сайн үйлийг үйлдэгч нарт  
Хаан тэрбээр эцэг эх мэт  
Тийн боловсорсон үрийг үзүүлэхэд  
Тэнгэр бээр хааныг адисласан болой.

Энэ насандаа сайн үйл хийсэн ба  
Элдэв гэмийг үйлдэгч нарын

Тийн боловсорсон үрийг үзүүлэхэд  
Тэнгэр бээр хааныг адисласан болой.

Харьяа улсад нь гэмт үйлүүд буй атал  
Хэрвээ хаан бээр эс хайхарч,  
Хилэнцийг үйлдэгч төрөлхтөн нарыг  
Хувь зохилдсон цаазаар эс тасалж,  
Тэрсүүд үйлүүдийг зөнд нь орхивоос  
Тэр цагт ном бус машинд арвидна.

Тэмцэл болон башир хэргүүд  
Тэр улсад хойшид ихэсч,  
Гучин гурван тэнгэрийн оронд  
Тэнгэрийн эрхт хямрах болно.

Харьяа улсад нь гэмт үйлүүд оршивч  
Хэрвээ хаан бээр эс хайхарваас,  
Тэр цагт барагдашгүй башир хуурмаг  
Тэсвэрлэшгүй олноор улс эвдрэх болно.  
Тэрсүүд дайснууд довтлон халдаж,  
Тэрхүү улсыг нэн түйвээнэ.  
Төгс эдлэл болон язгуур ч эвдэрнэ.  
Хураасан хөрөнгө алин байхнаа ч  
Хуурамч баширтай олон үйлээр  
Харилцан нэг нэгнээсээ булаах болно.

Аль нэгэн аргаар хаан өөрөө  
Амирлуулж түүнийг эс үйлдвээс,  
Их заанууд цөөрмийг эвдэх мэт  
Өөрийн орныг нэн эвдэнэ.

Аймшигт догшин салхи босож;  
Аюулт их үер бууна;  
Нар ба саран болон;  
Гариг одууд догшрох болно.

Хаан нь хайхралгүй зөнд нь орхивоос,  
Хөрөнгө, ногоо, үр жимс

Гүйцэд эс боловсрох хийгээд  
Ган зуд үргэлжлэх болно.

Харьяа улсад нь гэмт үйлүүд оршивч,  
Хэрвээ хаан бээр эс хайхарваас,  
Тэр цагт тэнгэрүүд ордондоо  
Сэтгэл нь баясгалан үгүй болно.

Эрхт тэнгэрийн хаан тэд бүгд  
‘Энэ хаан ном төгөлдөр бус бөгөөд  
Эгнэгт ном бусын зүгт оршиж байна’ хэмээн  
Өөр хоорондоо хэлэлцэх болно.

Тэр хаан бээр өнө удалгүй  
Тэнгэр нарыг хямруулах болно.  
Тэнгэр нар машид хямарсанаар  
Түүний улс нь нэн эвдэрнэ.

Зохисгүй зүйлүүд тэр оронд гарч,  
Зэвсэг мэсээр ч эвдрэх болно.  
Өөдгүй башир ба тэмцэл хийгээд  
Өвчин ч бүхэнд тархах болно.

Тэнгэрийн эрхэтүүд машид уурлаж,  
Тэтгэхээ болин хясалд орхино.  
Тэр орон нь аюулд нэрвэгдэж,  
Тэрхүү хаан бээр гасланг амсана.

Ах дүү юмуу эсвэл хүү,  
Асралт садан лугаа хагацах болно.  
Үзэсгэлэнт эхнэр лугаа хагацах болно.  
Эсвэл охин нь үхэх болно.

Тэдний од нь ч унах больюу;  
Түүнчлэн наран адил гарах больюу.  
Гадны дайсны цэрэг хийгээд  
Ган зуд машид гарах больюу.

Түүний хайрт заан хийгээд  
Түшиглэх түшмэд нь ч үгүй болно.  
Түүний дараа хурдан хүлэг  
Энхрий тэд нь ч үхэх болно.  
Гэр болон эд зүйлсүүдийг ч  
Гэнэдүүлж харилцан булаалдах больюу.  
Газар газарт ирт мэсээр  
Гэнэт бие биенээ хөнөөх больюу.

Гэмт хэрүүл тэмцэл башир хуурмаг  
Газар нутаг бүрт гарах болж,  
Эргэн тойронд ад зэтгэр шургалж,  
Эдгэшгүй өвчнүүд ч гарах болно.

Түүний дараа өглөгийн орон нь ч  
Ном лугаа төгөлдөр бус болно.  
Түүний нөхөд болон түшмэдүүд нь ч  
Ном лугаа төгөлдөр бус болно.  
Түүний хойно ном лугаа төгөлдөр бус  
Төрөлхтөн тэдгээрийг тахих болно.  
Үнэнхүү ном төгс хүмүүсүүдийг  
Үргэлж цаазаар таслах болно.

Номгүй хуурамчуудыг өргөн хүндэлж,  
Номт мэргэдийг өшлөн цаазалсанаар,  
Тэрхүү нутагт ус, гариг, салхи  
Тэр гурав нэн хямрах болно.

Дээр нь номгүй төрөлхтөн эзэлсэн тул  
Дээдийн номын шимт туяа,  
Амьтны өнгө, зүс, газрын шим  
Алин тэр гурав нэн эвдэрнэ.

Саар муу төрөлхтөнийг машид хүндэлж,  
Сайн дээдсийг гүтгэн муулсан тул  
Гутамшигт үхэл, хэл ам, ган зуд  
Гурван зүйл тэр оронд гарах болно.

Үр тариа, жимс биеийн өнгө  
Үүний хойно үгүй болох больюу.  
Өвчинд нэрвэгдсэн олон амьтад  
Орон нутгуудаар гарах болно.

Амттай бөгөөд үржилтэй үр жимс  
Алин нутгуудад байх боловч  
Хяруу болон халуун наранд  
Хатан шамшаагдах ямагт болно.

Баясгалант тоглоом наадгай хийгээд  
Урьдын баясгалант бүх зүйлд  
Баясах нь доройтож үл баясах болж  
Олон нисванисаар нэн хямрах болой.  
Жимс хийгээд үр тарианы  
Шүүс тос нь барагдах тул  
Бие хийгээд махбод эрхтэн  
Шимтэн цэнгэх нь үл болох болой.

Хүн адгуус нь өнгө муу  
Хүч бага машид туранхай  
Хоол унд хичнээн идсэн ч  
Ханан цэнгэх байхгүй болно.  
Хүч чадал хичээл зүтгэл нь ч  
Түүний хойно үгүй болно.  
Хичээл доройтсон залхуу амьтад  
Тэдгээр нутагт гарах болно.

Элдэв өвчнөөр нэрвэгдсэн  
Эмгэгт амьтад олшрох болно.  
Элдэв мангасаас хувилсан  
Эрхэс од гаригууд гарах болно.

Ёс бусын зүгт машид оршоод  
Хаан бээр номыг эс дагаснаар,  
Ертөнц бүгдийн хүрээн дотор  
Гурван ертөнц нэн эвдэрнэ.

Алин цагт хаан зүгт оршоод  
Аймшигт хэргүүдийг хөсөр орхивоос,  
Энэ мэтийн олон гэм зэмүүд  
Өөрийн улсад нь гарах болно.

Эрхт тэнгэрүүд хэрэг алины тул  
Эзэн хааныг адисласан хэдий ч  
Хаан өөрөө үл үйлдэж  
Хамаг хэргийг хөсөр орхивоос

Сайн үйлийг үйлдсэн амьтан тэд  
Тэнгэрийн оронд тэнгэрт төрмүй.  
Саар мууг үйлдсэнээр бирд болон  
Там хийгээд адгуусанд төрмүй.

Алин цагт хаан бээр улс орондоо  
Аливаа хилэнцийг хөсөр орхивоос,  
Гучин гурван тэнгэрийн орноос  
Гэмт үйлээр унах болно.

Хаан өөрөө үл үйлдвээс  
Хүү нь ч бас эс үйлдэнэ.  
Тэнгэрийн хаан эцэг нарын  
Оронд гэм лугаа сэлт болно.

Тэсэшгүй башир хуурмагаар  
Алин цагт улс нь эвдрэх болох,  
Тиймээс тэнгэрийн эрхт нар бээр  
Хүний хаан түүнийг адислах болно.

Саар үйлүүдийг амирлуулахын тул  
Сайн үйлэнд оруулах болон,  
Улсын номын хэргийн төлөө  
Энэ насанд нь амьтан бүгдэд  
Үр дагаврыг амсуулж үйлдэгч  
Эрхт тэр нь хаан мөн.

Тустай болон гэмт үйлийн  
Тийн боловсрох үр дагаврыг

Тус тусад нь үзүүлэхийн тулд  
Тушаагч түүнийг хаан гэмой.

Өөрийн тус болон бусдын тус,  
Улсын ном хэргийн тухайд  
Тэнгэрийн чуулган бээр түүнийг адислав.  
Тэнгэр нар ч даган баясав.  
Хамаг улсын албат иргэн  
Хилэнцгэн баширтаныг номхотгох хийгээд  
Улсын ном хэргийн тухайд  
Амь болон хаан төрөө ч өгөх болой.

Мунхаг үйлсийг тэсэн өөгшүүлж,  
Мэдэмсэрийг хясалд орхих болвоос  
Улс оронд барагдашгүй их аймшиг  
Угтаа тэрнээс өөр байхгүй болой.

Башир хуурмаг ямар мэт гарахад  
Баширлан үйлдэгчийг цаазаар эс шийтгэвээс,  
Орон улсад машид барагдашгүй  
Өөдгүй башрууд хойшид гарах болно;  
Их бүрдийг эвдэх зааны сүрэг мэт  
Орон түүнийг нэн эвдэнэ.

Тэнгэрийн эрхэтүүд ч хямрах болно,  
Тэнгэрийн орон нь нэн эвдэрнэ;  
Харьяа улсад юм бүхэн  
Харгис мунхагт урвах тул

Гэмт хилэнцийг үйлдэгч нарыг  
Гэмийнх нь хэмжээгээр шийтгэн үйлд.  
Номоор орон улсаа тэтгэж үйлд.  
Ном бусыг тэтгэж бүү үйлд.

Хайртай амиа ч бүү хайхар,  
Харин гэмийг бүү өмгөөл.  
Ураг садан болон бусад төрөлхтөн  
Улс орны бүх төрөлхтөнд

Эзэн хаан бээр ижил тэгш ханд  
Эс бөгөөс ‘зүгт унах’ болно.

Агуу номт хаан түүний  
Алдар нь гурван ертөнцөд дуурсаж,  
Гучин гурван тэнгэрийн оронд  
Тэнгэрийн хаан баясах болоод:

‘Эдүгээ Замбуу тивд бидний хүү  
Энэ мэт ном төгс хаан мөн.  
Номын төр улсыг тэнд тогтоож  
Нэн гарахуйд төрөлхтөнийг байгуулмой.

Хаан эзэн нь сайныг үйлдсэнээр  
Хамаг төрөлхтөн нь энд баясаад,  
Тэнгэр болон тэнгэрийн хөвгүүдээр  
Тэнгэрийн орон дүүрмой’ хэмээмой.

Номын ёст төр түүнийг үзүүлсэнээр  
Эзэн хаадууд нь нэн баясмой.  
Хурмаст тэнгэр машид баясаад,  
Хүмүүний хаан түүнийг сахимой.  
Орчлонгийн нар, сар мөн түүнчлэн  
Од гариг сайтар зорчих болно.  
Хий ч цагтаа босох хийгээд  
Хур бороо ч цагтаа буух болно.

Дээд тэнгэрийн орон болон мөн  
Дэлхийн орнуудад ч жил сайхан гарч,  
Тэнгэр болон тэнгэрийн хөвгүүдээр  
Тэнгэрийн орнууд дүүрэх болой.

Энэ мэт учир эзэн хаан бээр  
Өөрийн хайртай амиа золихноо ч  
Алин бээр ертөнцийг амгалантай болгох  
Авралт ном бурханыг үл орхих бөгөөд  
Эрдэм олноор өөрийгөө чимэглэсэн  
Номт дээдсийг шүтэж үйлд.

Өөрийн албатуудаа үргэлж баясгаж,  
Нүгэл хилэнцийг нэн тэвч.

Номын ёсоор улс орноо тэтгэж үйлд.  
Номыг ч үнэн зөвөөр номлож үйлд.  
Сайн үйлт амьтдыг оруулагтун.  
Саар үйлээс тэднийг буцаагтун.

Ямарваа хилэнц үйлдэгч нарыг  
ёсчлон номхруулж үйлдэхийн цагт  
Орон улсад жил сайхан дэлгэрч,  
Эзэн хаан сүр жавхлантай болно.  
Хааны алдар ч бадрах хийгээд  
Хамаг ардуудыг ч амгалангаар тэтгэнэ.

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлөн судраас*

*"Хааны шастир 'Тэнгэрийн эрхэтийн тангараг'"  
хэмээх хорьдугаар бүлэг болой.*

\* \* \*

[Есдүгээр хэсэг]

*XXI бүлэг: Сусамбава (мон: Сайн гарсан)-ийн бүлэг*

Мөн тэр цагт Ялж төгс нөгчсөн бурхан бээр шүлэг эдгээрийг зарлиглавай:

Эрт цагт Хүрдээр урвуулагч хаан болж,  
Эх дэлхий болон далай сэлт бүгдийг  
Эрдэнээр дүүрсэн дөрвөн тив сэлтийг ч  
Урьдын бурхан бүгдэд би өргөсөн.

Ариун номын лагшинг бүрнээ олохын тулд  
Алин сэтгэлд зохистой ба эдлэхэд хайран  
Аливаа зүйл бүгдийг би өргөсөн.  
Асар хайртай амиа ч олон галавт өгсөн.  
Эрт урьдын сэтгэшгүй галавын тэртээ  
Ратнашикхин (мон: Их эрдэнийн үснэрт) амгалан заларсан.

Тэсэшгүй гаслангаас нөгчсөн, амгалан заларсан  
Түүний шашинд Сусамбава хэмээх хаан гарав.  
Түүнийг дөрвөн тивийг эрхшээсэн Хүрдээр урвуулагч  
хэмээн

Тэнгэс далайг хүртэлх бүх газарт машид үзүүлэгч,  
Түүнчлэн заларсан бурхан эш бошгийг үзүүлсэн.

Тэр цагт дээдэс хаан харшдаа нойрсож байхад  
Нойрсогч түүний зүүдэнд Бурханы эрдэм сонсогдож  
Номыг номлогч Ратнокчаяа (мон: Их эрдэнэ хураагч)  
зүүдэнд нь

Нэн илхэн судар аймгийн хаан үүнийг  
Нягт нарийн номлон суухыг үзэж гэнэ.

Өглөө нь хаан тэр бээр нойрноосоо сэрэхэд,  
Өөрийн бүх бие баясгалангаар дүүрч,

Сүсэглэн бишрээд хааны ордноосоо гарч,  
Шарвага дээд хуврагийн оронд очив.

Эрхэм бурханы хуврагуудад тахилыг өргөн үйлдээд  
‘Энэ хутагтуудын дунд Ратнокчая,  
Эрдэм төгөлдөр гэлэн хаана буй?’ хэмээн  
Номыг өгүүлэгч Ратнокчая-г бүхнээс асуув.

Тэр цагт Ратнокчая тэр нь  
Түүнээс өөр нэгэн агуйд суугаад,  
Агуу гайхамшигт судрын хаан үүнийг бясалгаж  
Амны уншлага болгон машинд амгалантай сууж байжээ.

Номыг өгүүлэгч гэлэн Ратнокчая тэр  
Нэн хотол чуулган сүр жавхлангаар бадарч,  
Тэртээх агуйд сууж байсан тэр  
Тэр цагт хаан түүний дэргэд ирэв.

Энд номыг өгүүлэгч Ратнокчая энэ,  
Эрхэм хааны явдал гүнзгийг бариад;  
Судрын дээд *Алтангэрэл* хэмээх  
Судрын хааныг үргэлжид номлон үзүүлэв.

Ратнокчая-гийн өлмийд сөгдөн мөргөөд,  
Эрхэмсэг хаан Сусамбава ийн айлтгав:  
‘Судрын дээд *Алтангэрэл* судрын хаан  
Сар, нарны нуур адилаар номлон соёрх’.

Эрхэмсэг хаан Сусамбава түүний айлтгалыг  
Ратнокчая хувраг ч хүлээн зөвшөөрсөн тул  
Гурван мянган ертөнц бүгдэд орших  
Тэнгэр бүгд машинд баясах болов.

Харин тэр цагт хүний хаан бээр газар дэлхийн  
Хамгийн гайхамшигт ариун дээд нутаг тэнд  
Эрдэнийн ус ба үнэрт усаар чийглэн сэрүүцүүлж,  
Элдэв цэцгийн баглааг дэлгэн ширээ засаад,

Ширээ түүнийг шүхэр болон дуаз хийгээд  
Шинэ торго олон мянгаар сайтар чимж,  
Тэрхүү ширээндээ дээд ариун зандан ба  
Төрөл бүрийн сайхан үнэртнийг илтэд цацав.

Тэнгэр, лус, асар болон миамжи,  
Тэсэшгүй ягчис түүний хаан, дочэ,  
Тэнгэрийн цэцгийн мандаравагийн хурыг  
Тэр ширээн дээр илтэд машид буулгажээ.

Сонсохыг хүссэн түг түмэн мянган голди тэнгэр нар,  
Санаанд багташгүй алин тэд огторгуйд цуглан багширч,  
Ратнокчаяа хувраг илтэд залрах үест  
Эх газарт элдэв цэцгийг илтэд цацан тахив.

Номыг өгүүлэгч, Ратнокчаяа тэр өөрөө ч  
Нэн сайтар угаал үйлдэн ариун хувцсыг өмсөөд,  
Ариун номын ширээ түүнд ойртоод,  
Алгаа хавсарч залбиран мөргөлийг үйлдэв.

Хурмаст ба тэнгэр болон тэнгэрийн охид,  
Хуран чуулж, агаар мандлаас мандарава цэцгийн  
Хурыг буулган, зуун мянган яруу дуут  
Хөгжмийн аялгуу санаанд багташгүйг машид дуурсгав.

Ариун санваарт, номыг өгүүлэгч Ратнокчаяа тэр  
Арван зүгийн мянган голди бурхан  
Тоолшгүй олон тэднийг дурьдан бясалгаад,  
Тэрхүү ширээн дээр илтэд залран суув.  
Амьтан бүгдэд энэрэнгүй сэтгэлийг үүсгэж,  
Асар нигүүлсэнгүй сэтгэлийг ч үнэнхүү төрүүлээд,  
Сусамбава нэрт тэрхүү хаанд  
Судрын аймаг үүнийг тэр цагт номлов.

Эзэн хаан алгаа хавсран сөгдөөд,  
Элэгсэг үгээр түүнд даган баясаад,  
Энгүй номын хүчээр нулимс нь мэлмэрч  
Энэ бие нь баясгалангаар түгэн дүүрэв.

Судар аймаг үүнийг тахихын тул  
Сусамбава хаан бээр тэр цагт  
Хүслийг хангагч чандмань эрдэнийг авч,  
Хамаг амьтны төлөө ерөөлийг ийнхүү тавив:

‘Их долоон эрдэнэ төгөлдөр чимгүүд хийгээд  
Энэ замбуу тивийн хамаг амьтан бүгдийг  
Амар амгалантай болгох ховор нандин эрдэнийн  
Асар арвин хур өнөөдөр замбуу тивд буулаа.’

Гэтэл тэр цагт долоон их эрдэнэ,  
Гар, хоолой, чихний дээд чимэг,  
Тэрчлэн хоол, хувцас, ундаанууд ч  
Дөрвөн тивд хур мэт буувай.

Эзэн хаан Сусамбава Замбуу тивд  
Их эрдэнийн хур буусан түүнийг үзээд,  
Их эрдэнээр дүүрсэн дөрвөн тивийг  
Ратнашикхин түүний шашинд өргөв.

Түүнчлэн заларсан Шагжамуни би,  
Тэр цагт Сусамбава хаан болоод  
Эрдэнээр дүүрсэн дөрвөн тив буюу  
Энэ газрыг би бээр огоот өргөсөн.

Тийнхүү хаан Сусамбава түүнд  
Тэр цагт судар үүнийг машинд үзүүлсэн  
Ратнокчаяа хэмээх номлогч гэлэн тэр  
Эдүгээ цагийн Акшобьяа бурхан болой.

Эртний тэр цагт судар үүнийг би сонсож,  
Элэгсэг үгээр түүнд даган баясаад,  
Миний буяны үйл тэр ямагт хийгээд  
Номыг сонсон даган баясаж үйлдсэнээр,  
Үзэсгэлэнт өнгө ба олон буяны тэмдэг,  
Үзвээс гуа бөгөөд нүднээ илт үзэсгэлэнтэй,  
Хамаг тэнгэрүүд машинд баясан үйлдэх,  
Хүмүүс харваас баясах биеийг үргэлжид олсон.

Зуун голди ерэн есөн мянган галавт  
Хүрдээр урвуулагч хаан болсон билээ.  
Олон зуун мянган галавын турш ч  
Орны хаан болсон юм би.

Сэтгэшгүй олон галавт Хурмаст болов.  
Сэтгэлчлэн Эсрэнгийн хааныг мөн адил  
Хэмжээс алин нь хэзээ ч үл байх  
Хэмжээлшгүй арван хүчийг би баясгасан.

Алин миний судрыг сонсож даган баяссан,  
Ариун буяны цогц нь тэр мэт хэмжээлшгүй олон  
Ямар мэт хүссэнээр би бээр бодийг олсон  
Ялгуулсан номын лагшин дээдийг ч би олвой.

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлгөн судраас*

*"Сусамбава-ийн бүлэг."  
хэмээгч хорин нэгдүгээр бүлэг болой.*

\* \* \*

## XXII бүлэг: Ялчисын орон хэмээгч бүхэнд сахихын бүлэг

“Цог төгөлдөр Шри охин тэнгэрээ, алин нэгэн чин сүсэгт язгуурын хөвгүүн болон язгуурын охин өнгөрсөн, ирээдүй, одоо цагийн Ялж төгс нөгчсөн бурхадад эд зүйл бүгдээр их тахилыг машид дэлгэрэнгүй хийгээд агуу их, сэтгэшгүйгээр үйлдэхийг хүссэн ба өнгөрсөн, ирээдүй, одоо цагийн Ялж төгс нөгчсөн бурхадын бурханы гүн гүнзгий явдлын орныг огоот мэдэхийг хүссэн тэр бээр, тахилын сүм юмуу аль нэгэн хийдэд ч юмуу хаана *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* үүнийг агуу ихээр үнэнхүү машид номлосон тэр газарт номыг хүсэгч тэд магад алзалгүй очоод алгасрал үгүй сэтгэлээр чихээ сайтар тосож, *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* үүнийг сонсож үйлдээрэй.”

Тэгээд Ялж төгс нөгчсөн бурхан энэхүү утгыг нөхөддөө дэлгэрэнгүй айлдахын тул тэр цагт шүлэг эдгээрийг зарлигласан болой:

Хэн нэгэн гэгээрсэн бурхан бүгдэд  
Хэмжээлшгүй тахилыг үйлдэхийг хүсэж,  
Гэгээрсэн бурхадын явдлын орон юу  
Гүнзгийг машид мэдэхийг хүсвээс,  
Хийд юмуу тахилын орон  
Хаана *дээд Алтангэрэл* хэмээх  
Дээд судар үүнийг номлосон  
Тэр газарт хүрэлцэн оч.

Энэ судар нь санаанд багташгүй  
Эрдмийн хязгааргүй далай юм.  
Хүсэшгүй олон зовлонгийн далайгаас  
Хамаг амьтдыг гэтэлгэж үйлдэнэ.

Энэхүү судраас эхэн хийгээд  
Эцэс болон дундыг үзнэ  
Зарлигийн эрхэт, машид гүнзгий

Зүйрлэх жишээ үүнд байхгүй:  
Ганга мөрөн, газар дэлхий,  
Гадаад далай болон огторгуйд  
Оршин буй тоос алин ч  
Онцолж түүнийг жишиж чадахгүй.

Төгс чанарт орохыг хүсвээс  
Тэр цагт орж үйлд.  
Номын мөн чанарт их суварга  
Машид баттай алин мөн.

Суварга түүний төв голд нь  
Шагжамуни бурхан үзэгдэнэ.  
Сэтгэлд зохистой аялгуу эгшгээр  
Судар үүнийг машид номлоно.  
Тоолшгүй бөгөөд санаанд багташгүй  
Түмэн олон галвын турш  
Тэнгэр болон хүн төрөлхтний  
Таатай амгалан бүгдийг амсана.  
Мөнхүү судар үүнийг сонсож  
Миний хураасан буяны цогц  
Тоолшгүй их бүтлээ хэмээн  
Тэр цагт түүгээр тэр мэт мэд.

Элчит галын гуугаар зуун бээрт  
Эргэн тойрон хүрээлснээс гэтэлж,  
Шаналал мэдрэлийг тэсэж үйлдээд,  
Судрын аймгийг сонсож чадах  
Сүм дуган хийд оронд  
Сүслэн орсон тэр даруйд  
Хилэнц түйтгэр үгүй болно.  
Олиггүй муу зүүд хийгээд  
Огторгуйн гариг одны хорлол,  
Шившлэг хараал барагдашгүй ад ч  
Сүслэн орсон тэр даруйд  
Бүгд бусдад зүглэх болно.

Сайн зүгийн лусын хаадууд  
Шөнийн зүүдийг үзүүлсэн юу адил  
Тэнд лянхуа адил ширээ  
Тэр мэтийг ч бэлдэн үйлд.  
Тэрхүү ширээн дээр завилан суугаад  
Энэхүү судрыг сайтар номло.  
Үсгэнд бичсэнийг уншиж үйлд.  
Утгыг ёсчлон мэдэж үйлд.  
Өндөр ширээ түүнээс буугаад  
Өөр оронд одох болохноо ч  
Ширээ түүн дээр байхад үзэгдсэн  
Рид хувилгаанууд үзэгдэх болно.

Хааяа тэр нь ном номлооч  
Хүний дүрээр үзэгдэх болно.  
Заримдаа гэгээрсэн бурханы дүрээр,  
Заримдаа гэтэлгэгч бодьсадва,

Заримдаа бодьсадва Самантабадра,  
Заримдаа бодьсадва Манжушри,  
Заримдаа бодьсадва Майтрея-гийн дүрээр ч  
Ширээ түүн дээр үзэгдэх болно.

Заримдаа зөвхөн гэрэл үзэгдэнэ;  
Заримдаа тэнгэрүүд үзэгдэх болно,  
Агшин нэгд тэдгээр үзэгдээд,  
Асар удалгүй үзэгдэхгүй болно.

Бурханыг үзвээс сайшаах болно.  
Бүгдийг ч бас бүтээж үйлдэнэ.  
Цог эрдэм өлзий хутгийн чуулган,  
Цөм бүгд бурханы хувилгаан мөн.

Цог, ялалт, алдрыг олж,  
Чанадын эсэргүүцлийг ч буцаах болно.  
Гадны дайсныг машинд дарж,  
Дайснууд тулаанд ялагдах болно.  
Муу зүүд бүгдийг амирлуулж,

Муу үйлийг машид дарна.  
Хилэнц бүгдийг машид амирлуулж,  
Хамгаалах тулаанд ялуулж үйлдэнэ.

Энэ Замбуу тив даяар  
Алдар нь машид түгэх болно.  
Түүний өштөн дайсан бүгд нь  
Төвөггүй машид доройтох болно.

Хамаг дайсныг үргэлжид дарж  
Хамаг хилэнцийг машид тэвчинэ.  
Тэмцэл нүүрлэхээс нэн ялж,  
Дайснаас хагацаж дээдэд баясна.

Эсрэн тэнгэр, Хурмаст тэнгэр,  
Энэ ертөнцийг тэтгэгч нар,  
Важрапани, ягчисын хаан,  
Манлайлагч хаан Самжная,  
Анаватапта нэрт лусын хаан,  
Мөн түүнчлэн Сагара хийгээд  
Миамжи болон Асурын хаан,  
Мөн түүнчлэн Гарьдын хаан,  
Тэдгээр тэргүүтэй бусад амьтад,  
Тэнгэр тэдгээр бүгд ч гэсэн  
Сэтгэшгүй номын ариун суварганд  
Үргэлжид тахилыг үйлдэх болно.

Хавь ойрын хамаг амьтад,  
Харан үзэж баясах болно  
Эрхэт дээд тэнгэрийн хаадууд,  
Ийн хэмээн сэтгэх болно:

‘Хамаг тэнгэр тэд бүгд  
Харилцан дотроо өгүүлэлдэж үйлдэв.  
Буян цог сүр жавхлангууд  
Бүхнийг хураасан тэднийг хар.  
Алин гүнзгий судар үүнийг  
Анхааран сонсохоор энд ирсэн.

Бүх хүмүүс нь машид судалсан  
Буяны үндсээр энд ирсэн болой.

Нэн сүжиг сэтгэшгүй ихээр  
Номын суварганд бишрэн үйлдэж,  
Тэд ертөнцөд нигүүлсэнгүй төгөлдөр  
Тэд амьтанд тусыг үйлдэнэ.  
Тэд гүнзгий дээдийн номын  
Амтат рашааны ариун сав,  
Төгс чанарт орсон хэмээвээс  
Тэдгээр машид орсон мөн.’

Алин нэгэн дээд судар  
*Алтангэрэлийг* сонссоны буянаар  
Урьд цагийн гэгээрсэн бурхан  
Олон мянгыг тахьсан мөн.

Сайн буяны ёзоор үүгээр  
Судар үүнийг сонссон тэдгээрт  
Эрхт тэнгэрийн хаад хийгээд  
Сарасвати мөн түүнчлэн  
Шри хийгээд Вайшравана ба  
Цогт дөрвөн Махаранз хийгээд  
Олон мянган ягчис болон  
Их хүчит рид хувилгаантнууд  
Суух орных нь дөрвөн зүгээс  
Сахин хамгаалахыг сайтар үйлдэнэ.

Эрхэт саран ба Эрлэг хийгээд  
Хий болон усны тэнгэр  
Сканда, Вишну, Сарасвати хийгээд  
Пражапати ба төрөлхтөн бүгд,  
Их хүчит Хуташана (*мон: Чанадыг дарагч*),  
Энэ ертөнцийг тэтгэгч бүгд ч  
Өдөр шөнө алгасрал үгүйгээр  
Өөрсдөө тэднийг сахиж үйлдэнэ.

Их хүчит ягчисын хоёр хаан  
Нараяна (*мон: Их эрх баялагт*) ба Махешвара  
(*мон: Шуналгүйн хөвгүүн*),

Самжная тэргүүтэн зэрэг  
Мөн бас хорин найм хийгээд  
Олон мянган ягчис нар  
Их хүч рид хувилгаантнууд  
Түгшүүрт аюул аймшиг бүгдээс  
Тэдгээр бүгдийг сахиж үйлдэнэ.

Ягчисын хаан Важрапани хийгээд  
Ягчисын хөвгүүн таван зуу ба  
Аврагч бодьсадва бүгдээр ч  
Алин тэдгээрийг сахиж үйлдэнэ.

Ягчисын хаан Манибадра (*мон: Сайн эрдэнэ*)  
Ямар мэт Пурнабадра (*мон: Сайн дүүрэн*) хийгээд  
Кумбира (*мон: Юун аюул*) болон Атавака  
(*мон: Аглагт оршигч*)

Пингала (*мон: Улаан шар*) болон Капила (*мон: Шаравтар*),  
Ягчисын хаан нэг нэгээрээ  
Таван зуун ягчис нөхдөө дагуулаад,  
Хэн нэгэн судар үүнийг сонссон  
Тэд бүгдийг сахин үйлдэх болно.

Элдэв үнэр идэштэний аймаг,  
Эрхэм дээд манлайлагчийн хаан,  
Маниканта (*мон: Магад хоолойт*) ба Никанта  
(*мон: Эрдэнийн хүзүүт*)

Мөн бас Варшадипати (*мон: Хурын эзэн*)  
Махаграса (*мон: Их гүжир*) болон Махакала  
(*мон: Хар өнгөтэй*)

Алт адил Суварнакеша (*мон: Шаргал үст*)  
Панчика (*мон: Таван цэнгэлт*) ба Чагалапада  
(*мон: Ямаан чөмөгт*)

Түүнчлэн бас Махабага (*мон: их галав*)

Праналин (мон: *Бөх нойрт*) хийгээд Дармапала  
(мон: *Номыг тэтгэгч*)  
Марката (мон: *Бич*) болон Вали (мон: *Ороон үйлдэгч*)  
Сучирома (мон: *Өргөс үст*) хийгээд Суряамитра  
(мон: *Буяны садан*)  
Өөр бас Ратнакеша (мон: *Эрдэнийн үст*)  
Махапраналин (мон: *Их оронт*) ба Накула (мон: *Гэр үгүй*)  
Камашрешта (мон: *Хүслийн дээд*) ба Чандана (мон: *Зандан*)  
хийгээд  
Нагаяана (мон: *Хүч ихт*) ба Хаймавата (мон: *Цастан*) хийгээд  
Сатагири (мон: *Амгалангийн уул*) зэрэг мөн түүнчлэн  
Их хүчээр чанадыг дарагч  
Рид хувилгаант тэд бүгд ч  
Энэхүү сударт баясан бишрэгч  
Тэдгээр бүгдийг сахин үйлдэнэ.

Анаватапта нэрт лусын хаан  
Мөн түүнчлэн Сагара (мон: *их далай*)  
Мучилинда (мон: *Өглөгийг баригч*) ба Елапатра  
(мон: *Элаан-навчит*),  
Упанандака (мон: *Ойр-баясагч*), Нанда (мон: *Баясагч*) хоёр  
Олон мянган лус нар  
Их хүч рид хувилгаантнууд,  
Түгшин айх аюул бүгдээс  
Тэдгээр бүгдийг сахин үйлдэнэ.

Их хүчит Намучи (мон: *Аймшигийг үл өгөгч*),  
Вемачитра (мон: *Зэс уул*) хийгээд Самвара  
(мон: *Дээд амгалант*),  
Прахлада (мон: *Машид цэнгэгч*) хийгээд Карасканда  
(мон: *Ширүүн атаархагч*),  
Мөн түүнчлэн асурын хаан,  
Олон зуун мянган асур,  
Их хүч рид хувилгаантнууд,  
Түгшүүрт аюул гарах болбоос  
Тэдгээр бүгдийг сахин үйлдэнэ.

Адын мам Харити (мон: Булаагч эх),  
Аюулт таван зуун хүүгийн хамт ч  
Суух хэвтэх согтохын цагт,  
Сахиж тэднийг хамгаалан үйлдэнэ.

Чанда (мон: Зандалчин эм) ба Чандалика (мон: Догшин эм)  
Зарим Якшини Чандика (мон: ягчис Хорлогч эм)  
Кунти (мон: Лавайт) хийгээд Кутаданти (мон: Давхар соёот)  
Амьтан бүгдийн сүрийг булаагч  
Их хүчээр чанадыг дарагч  
Рид хувилгаант тэд бүгд ч  
Хамаг зүг зовхис бүгдээс  
Хамгаалан тэднийг сахиж үйлдэнэ.

Сарасвати тэргүүтэй охин тэнгэр,  
Эглийн санаанд багташгүй олон  
Өөр бас Шри тэргүүтэй  
Охин тэнгэр бүгд хийгээд  
Тэрчлэн газрын охин тэнгэр,  
Тариа үр ойн тэнгэр,  
Олон баясах мод суварган дор  
Оршигчид болон салхин тэнгэр,  
Олон тэнгэрүүд бүгд энд  
Онцгой машид баясах сэтгэлээр  
Хэн судрын аймаг үүнд биширсэн  
Тэд бүгдийг сахин үйлдэнэ.

Нас, зүс, хүч чадалд  
Нигүүлсэж тэднийг учруулж үйлдэнэ;  
Цог буян, сүр хүч  
Цогцлон чуулсанаар үргэлжид чимнэ.  
Гариг од эрхэсийн хорлол  
Гай тэд бүгдийг амирлуулж үйлдэнэ.  
Хамаг гутамшиг хилэнц муу зүүд,  
Харуусалт бүгдийг амирлуулж үйлдэнэ.

Гүн хийгээд их хүч төгөлдөр  
Газрын охин тэнгэр тэр өөрөө  
Сүслэн биширч *Дээд Алтангэрэл*  
Судрын хаан үүний амтаар цэнгэнэ.

Зуу зуун бээрээр тоолбоос  
Жаран найман мянган бээрийн тэртээгээс  
Очирт суудалд тулахыг хүртэлх  
Орны шим нь машид арвидна.  
Хэдэн зуун бээрийн хэмжээтэй  
Хөрснөөс доош шим нь арвидаад,  
Гэдрэг тэр нь эргэн буцаад  
Газрын дээд хөрсийг шимтэй болгоно.

Ховор судрыг сонссон хүчээр  
Хамаг тэнгэр тэд бүгд ч  
Сүслэн биширч *Дээд Алтангэрэл*  
Судрын хаан үүний амтаар цэнгэнэ.

Машид сүр жавхлан төгөлдөр болно,  
Машид самбаа төгөлдөр болно,  
Магад амгалантай цэнгэх болно,  
Энэ Замбуу тивд байгаа  
Үр тариа ойн тэнгэрүүд  
Элдэв амтаар цэнгэх бөгөөд  
Энгүй ихээр баясах болно.

Энэ судрын амтаар цэнгээд,  
Үр тариа жимс ногоонууд  
Элдэв янзын цэцэг хийгээд  
Элдэв үрийн галбирвасан модууд ч  
Ихэд сайн төлжин ургана.

Бүх үрийн галбирвасан модууд  
Баясгалант бүрд болон ой цэцэрлэгт  
Алаг цэцгүүд түгэн дэлгэрч,  
Анхилуун үнэр нь машид ханхална.  
Элдэв янзын цэцэг дэлгэрч,

Элдэв олон үр боловсорсон  
Өвс ургамал ой цэцэрлэгүүд  
Өвч газрыг бүрхэх болно.

Сац энэхүү Замбуу тивд  
Санаанд багташгүй лусын охид  
Нэн баясгалангаар сэтгэл нь урваад  
Нуур цөөрмийн дэргэд одохуйд  
Үтэр цөөрөм тэд бүгдэд  
Үзэсгэлэнт гүмүда бас лянхуа  
Удвал болон мөн түүнчлэн  
Элдэв цагаан лянхуа дэлгэрнэ.

Харин огторгуйд утаа хийгээд  
Халхлах үүлгүй нэн цэлмэж,  
Харанхуй болон тоос үгүй болж,  
Хамаг зүгт гэрэл машид цацарна.

Түмэн гэрэл төгөлдөр нар ч  
Торон гэрлээр илчээ түгээнэ.  
Гүнзгий арилсан үзэгдлүүдээр  
Гайхамшигт баясал ургах болно.

Эрхэт наран нэрт тэнгэрийн хөвгүүн,  
Энэ замбуу тивийн алт мэт  
Эрдэнийн харшид суугаа тэр ч  
Энэхүү судраар нэн цэнгэнэ.  
Эрхэт наран машид баясаад,  
Энэ замбуу тивд урган мандана.  
Хязгааргүй гэрлийн олон цацрагаар  
Хамаг бүгдийг гийгүүлж үйлдэнэ.

Алин тэр ургасан төдийгөөр  
Алтан цацрагаа харамгүй өгнө.  
Нуур цөөрөм элдвийг бүчсэн  
Лянхуа цэцгүүд ч дэлбээгээ нээнэ.

Энэ замбуу тив бүгдэд  
Элдэв эм, үр цэцэг,  
Үнэнхүү огоот боловсрон үйлдэж,  
Газар бүгдийг баясгах болно.

Орчлонгийн нар саран хоёр ч  
Онцгой үлэмж гэрэлтэх болно.  
Од гариг ёсоороо гарах хийгээд  
Салхи ч ёсоороо босох болно.

Замбуу тивийн газар бүхэнд  
Жил улирал сайн болоод;  
Хаана энэхүү судар байна  
Тэр орон нь үлэмж ялгамжаатай.

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлгөн судраас*

*"Ялчисын орон хэмээгч бүхэнд сахихын бүлэг"  
хэмээх хорин хоёрдулаар бүлэг болой.*

\* \* \*

### XXIII бүлэг: Тэнгэрийн хөвцүнд эш бошгийг үзүүлсэн нь

Бурхан багш тийнхүү зарлигласан бөгөөд Ялж төгс нөгчсөн бурханд язгуурын охин тэнгэр Бодисаттва-самукчаяа (мон: *Бодийг үнэнхүү хураагч*) бээр ийн хэмээн айлтгав: “Ариун санваарт, Ялж төгс нөгчсөн бурхаан, Жваланан-гаратежоража (мон: *Ялгамжит, сүр жавхлант, бадруулагч хаан*) тэргүүтэй нэг түмэн тэнгэрийн хөвгүүд бээр, ямар уг, ямар шалтгаан, буяны ёзоор юу адил хийгээд юу үйлдэн хурааснаар эдгээр гурван дээд төрөлхтөн дээд бодид эш үзүүлэхийг сонсоод одоо, Гучин гурван тэнгэрийн орноос буун, Ялж төгс нөгчсөн бурханаас номыг сонсохын тулд ирэв ээ?”

“Энэ мэт. Бодьсадва, дээд төрөлхтөн Ручира-кету, энэ бээр ирээдүй цагт тооноос хэтэрсэн, тоолшгүй, түг түмэн олон буман голди галвын тэртээ Суварна-прабасита (мон: *Алтан үзэгдэл*) хэмээх нэрт ертөнцийн оронд дээр үгүй, үнэнхүү төгсгөсөн бодид илтэд гэгээрч бурханы хутгийг олоод, Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн, ухаан болон өлмий төгөлдөр бурхан, амгалан заларсан, ертөнцийг болгоогч, төрөлхтөнийг номхотгон жолоодогч, дээр үгүй, тэнгэр хүмүүний багш, ялж төгс нөгчсөн бурхан Суварна-ратна-каракча-тракута (мон: *Алт эрдэнэс гарахын орон Давхар шүхэр*) хэмээгч бурхан болж ертөнцөд заларна. Нэгэн цагт Ялж төгс нөгчсөн, Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхан Суварна-ратна-каракча-тракута тэр, гаслангаас огоот нөгчөөд, дээдийн ном доройтоод, түүний шашин байгаа бүгд доройтох болох тэр үед Рупья-кету (мон: *Мөнгөн охь*) нэрт энэ хөвгүүн бээр түүнчлэн заларсан түүнийг залгамжлаад Виарадважа (мон: *Тоос үгүй дуаз*) нэрт ертөнцийн орон тэнд Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхан Суварна-жамбудва-жакан-чанаба (мон: *Алтан замбуу алтан дуазын гэрэл*) хэмээгч болж ертөнцөд залрах болой. Хэзээ нэгэн цагт Түүнчлэн заларсан, дайснаа дарсан,

үнэнхүү төгсгөсөн бурхан Суварна-жамбудва-жакан-чанаба тэрээр огоот гаслангаас нөгчөөд, түүний шашин байгаа бүгд нь доройтоход хүрэхийн цагт Рупяа-праба (*мон: Мөнгөн гэрэл*) нэрт энэхүү хөвүүн бээр Түүнчлэн заларсан түүний хойчийг залгамжилж, Виараджа нэрт ертөнцийн орон тэнд дээр үгүй, үнэнхүү төгсгөсөн бодид илтэд гэгээрч бурханы хутгийг олоод, Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхан, ухаан ба өлмий төгөлдөр, амгалан заларсан, ертөнцийг болгоогч, төрөлхтөнийг номхруулах жолоог залуурдагч, дээр үгүй, тэнгэр болон хүмүүний багш, ялж төгс нөгчсөн Суварна-шата-рашми-прабаса-кету (*мон: Зуун алтангэрэлд гэрэлтсэн зүрх*) хэмээгч бурхан болон ертөнцөд залрах болой” хэмээн Ялж төгс нөгчсөн бурхан бээр тэдгээрийг тийнхүү дээр үгүй үнэнхүү төгсгөсөн бодид эш бошгийг үзүүлсэн болой.

Тэгээд Ялж төгс нөгчсөн бурханд язгуурын охин тэнгэр Бодисаттва-самукчаяа бээр ийн хэмээн айлтгавай: “Ариун санваарт Ялж төгс нөгчсөн минь ээ, Жваланан-гаратежоража тэргүүтэй нэг түмэн тэнгэрийн хөвгүүд тэдгээр нь, тэр төдийд бодьсадвын явдал агуу ихийг туурвиагүй ч, урьд нь зургаан чанадад хүрэхүйд ихэд хичээсэн нь ч үгүй, урьд гар, хөл, нүд зэрэг бие эрхтний дээд толгой зэргээ, үр хүүхэд, эхнэр, охин зэрэг хайртай зүйлүүдээ огоот ихээр өгсөн нь ч үгүй, урьд эд, үр тариа, зочилгоо, алт эрдэнэ, сувд, биндэрьяа, дун, мана, шүр, мөнгө, шижир алт зэрэг их эрдэнүүдийг огоот өгсөн нь ч үгүй, урьд идээ ундаа, уналга, хувцас, дэвсгэр олбог, гэр байшин, орд харш, баясгалангийн хүрээ, цөөрөм бүрд зэргийг огоот өгсөн нь ч үгүй, урьд их заан, үхэр, эмнэг морьд, элдэв зарц шивэгчин нарыг ч огоот өгсөн нь үгүй. Гэтэл тоолшгүй олон буман түг түмэн голди бодьсадва тэдгээр нь, Ялж төгс нөгчсөн бурхадуудаас Түүнчлэн заларсаны нэрд эш бошгийг үзүүлэхийг олохыг хүртэл, эрт урьдын тоолшгүй олон буман түг түмэн голди галвын тэртээгээс тэдгээр нь тоолшгүй олон буман түг түмэн голди бурхадад санаанд багташгүй олон буман элдэв төрлийн тахил хийгээд эд зүйл бүгдээр тахиж огоот өргөж, бодитой бүхнээ бүрнээ өргөж, гар болон хөл, нүд, гишүүний дээд толгой, хүү, эхнэр, охин зэрэг өргөж болох бүхнээ ч бүрнээ өргөсөн, эд, үр тариа, зочилгоо, алт эрдэнэ, сувд, биндэрьяа, дун, мана, шүр, мөнгө, шижир алт зэрэг өргөж болох

бүхнээ ч бүрнээ өргөсөн, идээ ундаа, уналга, хувцас, дэвсгэр олбог, гэр байшин, орд харш, баясгалангийн хүрээ, аз жаргалын цэцэрлэг, цөөрөм бүрд, их заан, үхэр, эмнэг морьд, элдэв зарц шивэгчин зэрэг өргөж болох бүхнээ ч бүрнээ өргөсөн хийгээд чанадад хүрэх зургаан дэс дараачлан бүгдийг огоот гүйцээн үйлдэж, дэс дараачлан зургаан чанадад хүрэхүй гүйцээж үйлдэж байж, олон буман амгаланд ч учрах байдаг.

“Ариун санваарт Ялж төгс нөгчсөөн, гэтэл ямар уг, ямар шалтгаан, буяны ёзоор юу адил нэгийг судалсанаар, Жваланан-таратежоража хаан тэргүүтэй нэг түмэн тэнгэрийн хөвгүүд эдгээр Ялж төгс нөгчсөн бурханд номыг сонсохын тулд ирэв? Эдгээрийг Ялж төгс нөгчсөн бээр энэ мэт ирээдүй цагт тоолшгүй олон буман түг түмэн голди галавт Салендра-дважагравати (*мон: Шижир эрхэт өндөр дуаз төгөлдөр*) хэмээгч нэрт ертөнцийн орон тэнд язгуур хийгээд яс үндэс болон нэр нэгтэйгээр дэс дараачлан дээр үгүй, үнэнхүү төгсгөсөн бодид илтэд төгсгөсөн бурхан болох буюу Прасанна-ваданотпала-гандакута (*мон: Машид тунгалаг нуур удвалын үнэрийг давхарласан*) хэмээгч нэг түмэн бурхан ертөнцөд залраад, ухаан ба өлмий төгөлдөр, амгалан заларсан, ертөнцийг болгоогч, төрөлхтөнийг номхруулах, жолоог залуурдагч, дээр үгүй, тэнгэр болон хүмүүний багш, ялж төгс нөгчсөн бурхан болох болой хэмээн одоо дээр үгүй үнэнхүү төгсгөсөн бодь олох эш бошгийг үзүүлж байна?”

Хэмээн айлтгасанд Ялж төгс нөгчсөн бурхан бээр, язгуурын охин тэнгэр Бодисаттва-самукчаяа-д ийн хэмээн зарлиглавай: “Язгуурын охин тэнгэрээ, Жваланан-таратежоража тэргүүтэй нэгэн түмэн тэнгэрийн хөвгүүн эдгээр нь юуг үйлдэж хурааснаар, ном сонсохын тулд өнөөдөр Гучин гурван тэнгэрийн орноос энд ирсэн түүний буяны ёзоор нь ариун байна. Түүний уг байгаа, түүний шалтгаан нь ч байгаа. Язгуурын охин тэнгэрээ, дээд төрөлхийтөн энэ гурав бээр, бодид эш бошгийг үзүүлсэн энэ нь үүнийг, *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* үүнийг сонсоод, сонссон даруйдаа үүнийг машид сүжиглэж, баясал бишрэлийг олсон болой. Тэр төдийгөөр хир үгүй биндэрьяа мэт нэн ариун сэтгэл төгөлдөр болж,

хиргүй тунгалаг, машид дэлгэрэнгүй, агуу их, машид тунгалаг огторгуй мэт уужим сэтгэл төгөлдөр болов. Хэмжээлшгүй буяны цогцосыг огоот ихээр хураав. Язгуурын охин тэнгэрээ, Жваланан-таратежоража тэргүүтэй нэг түмэн тэнгэрийн хөвгүүн эдгээр тэр төдийд *Дээд Алтангэрэлт буюу судрын аймгийн эрхэт хаан* үүнийг сонссон даруйдаа, үлэмж биширч, машид сүжиглэхийг олоод тэр төдийд хиргүй биндэрьяа мэт огоот ариун сэтгэл төгөлдөр болсон тул эш бошгийг даган үзүүлсэн болой. Язгуурын охин тэнгэрээ, номыг сонссон буяны ёзоор энэ хийгээд урьдын ерөөлийн хүчээр Жваланан-таратежоража тэргүүтэй нэг түмэн тэнгэрийн хөвгүүд эдгээрийг өнөөдөр дээр үгүй, үнэнхүү төгсгөсөн бодид эш бошгийг үзүүлсэн болой.”

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлгөн судраас*

*”Тэнгэрийн хөвүүнд эш бошийг үзүүлсэн бүлэг”  
хэмээх хорин уравдугаар бүлэг болой.*

\* \* \*

## XXIV бүлэг: Өвчин бүгдийг машинд амирлуулан үйлдсэн нь

“Язгуурын охин тэнгэрээ, урьдын ерөөл тэдгээр алин бэ? Эрт урьдын өнгөрсөн цаг тоолшгүй, их тоолшгүй, санаанд багташгүй, дэлгэрсэн, хэмжээлшгүй болсон галвын тэртээх тэр үед Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхан ухаан ба өлмий төгөлдөр, амгалан заларсан ертөнцийг болгоогч, төрөлхтөнийг номхруулах жолоог залуурдагч дээр үгүй, тэнгэр болон хүмүүний багш Ялж төгс нөгчсөн бурхан Ратна-шикхин (мон: *Их эрдэнийн үснэрт*) хэмээгч ертөнцөд заларсан болой.

“Язгуурын охин тэнгэрээ, тэр цагийн тэр үед Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхан Ратна-шикхин тэр гаслангаас огоот нөгчөөд, дээдийн ном доройтож, дээдийн ном ёс төдий зүйл болох үед, Сурешвара-прабха (мон: *Тэнгэрийн эрхэт баялгийн гэрэл*) нэрт номт хаан, номын хаан, номоор хаан төрийг тэтгэгч, ном бусыг үл баримтлагч, орон бүгдэд орших амьтдыг эцэг эх мэт үзэгч нэгэн гарчээ.

“Язгуурын охин тэнгэрээ, тэр цагийн тэр үед Сурешвара-прабха нэрт хааны улсад худалдаачны ноён Жатимдара (мон: *Шанхыг баригч*) нэрт анагаах ухааны оронд нэвтэрхий мэргэн оточ эмч, аюурведийн ухааны найман гишүүнт дамжлага төгөлдөр нэг гарсан болой. Аяа! Язгуурын охин тэнгэрээ!, Тэр цагийн тэр үед худалдаачны ноён Жатимдара хэмээгч түүний хүү Жалавахана (мон: *Ус буулгагч*) нэрт үзэсгэлэнт сайхан дүрст, үзвээс гуа сайхан өнгөтэй, дэлгэрэнгүй дээд төгөлдөр, элдэв шастирт мэргэн, шастир бүгдийг дотроо багтааж оносон, үсэг, тоо, гарын хээ, зурхай зэрэгт машинд суралцсан нэгэн байсан.

“Язгуурын охин тэнгэрээ, тэр цагийн тэр үед Сурешвара-праба хаан түүний улс гүрний олон буман амьтан элдэв өвчнөөр нэрвэгдэх болов. Элдэв янзын өвчнөөр огоот өвчилж, тэсэшгүй хатуу ширүүн зовлон, сэтгэлд зохисгүй нажод эдлэх болов. Язгуурын охин тэнгэрээ, тэр цагийн тэр үед худалдаачны хүү Жалавахана тэр бээр элдэв янзын өвчнөөр өвчилж нэрвэгдсэн олон буман амьтад тэдгээрийн тусын тулд их нигүүлсэнгүй сэтгэлийг үүсгэв: ‘Олон буман амьтад тэдгээр нь элдэв янзын өвчнөөр өвчлөн нэрвэгдээд тэр мэт тэсэшгүй хатуу ширүүн зовлон сэтгэлд зохисгүй нажод амсаж байх энэ цагт, миний эцэг худалдаачны ноён Жатимдара анагаах ухааны оронд нэвтэрхий мэргэн эмч, аюурведийн найман гишүүний дамжлага төгөлдөр энэ эцэг минь хөгширч ядарч зүдрэхийн мөрд оршиж, насны эцэст хүрч, таяг тулан бэдэрч, тосгон хот гацаа улс орон, хааны ордны нөхдүүдэд очиж үл чадах зэрэг болсон учраас, элдэв янзын өвчнөөр өвчилж нэрвэгдсэн олон буман амьтад тэдгээрийг элдэв өвчнөөс нь огоот гэтэлгэж үйлдэхийн тулд, би өөрөө өөрийн эцэг Жатимдара-гийн дэргэд очиж өвчнийг анагаахын тулд махбодын оронд мэргэжиж үйлдэхийг асуух ба махбодын оронд мэргэжиж үйлдэхийг асуусан түүгээрээ би, тосгон хот гацаа улс орон хааны ордны бараа болооч нарт очиж үйлдье. Очоод элдэв өвчнөөр өвчлөн нэрвэгдсэн олон буман амьтдыг элдэв өвчнөөс нь огоот гэтэлгэж үйлдье’ хэмээв.

“Язгуурын охин тэнгэрээ, тэр цагийн тэр үед худалдаачны хүү Жалавахана өөрийн эцэг Жатимдара хаана буй тэнд очоод өөрийн эцэг Жатимдара-гийн хөлд оройгоороо мөргөөд алгаа хавсран нэгэн зүгт суувай. Нэгэн зүгт суугаад худалдаачны хүү Жалавахана бээр өөрийн эцэг Жатимдара-д шүлэг эдгээрээр махбодын оронд мэргэжихийг ийн асуув:

Ямар мэтээр эрхтэн эвдрэх вэ?

Ягаад махбод нь ч огоот хувирна вэ?

Аль үед амьтдын бие махбодод

Өвчний язгуурууд гарах болох вэ?

Цаг ба цаг бусын идээг идсэнээр

Цаашид хэрхэн амгалантай болох вэ?

Алин нь бие махбодын дотор  
Үлдэж, биед хорлол үл болох вэ?

Хийнээс болсон ба шараар болсон  
Хурсанаас болсон ба бадганаас болсон  
Өвчин тэдгээрийг амирлуулахын тулд,  
Ямар аргаар анагааж үйлдэх вэ?

Хүний биед хорлол болох  
Хий аль цагт хөдлөх вэ,  
Ямар цагт шар хөдлөх вэ,  
Бадгана бас ямар цагт хөдлөх вэ?

“Тэгээд худалдаачны ноён Жатимдара бээр худалдаачны ноёны  
хүү Жалавахана-д эдгээр шүлгүүдээр махбодын оронд мэргэжин  
үйлдэхийг нэн үзүүлэв:

Гурван сар нь зун, гурван сар нь намар,  
Гурав нь өвөл бөгөөд гурав нь хавар мөн.  
Тэр мэт сарны дарааллаар зургаан цаг  
Тийнхүү жилд арван хоёр сар байнам.

Гурав гурваараа улиралд хураагдахыг мэд;  
Хоёр хоёроор цаг болохыг үзүүлсэн.  
Идээ ундаа нь тэр мэт шингэх болно,  
Эмч, махбод, цагийг ч бас үзүүлсэн.

Эрхтэн ба махбодууд тэдгээр бүгд нь  
Нэг жилийн доторх улирал улирлаар урвана.  
Эрхтэнүүд нь огоот урван өөрчлөгдөх үед  
Элдэв өвчин амьтдын биед гарна.

Энд эмч бээр гурван сараар дөрвөн  
Улиралд хуваах ба зургаан цагуудад  
Зургаан махбодод мэргэжихийг мэдэж үйлд.  
Зоог, ундаа, эмүүд дэс дараачлан:

Хий ихэдсэн өвчин нь зуны цагт босно;  
Харин намар болбоос шар хөдөлнө;

Өвлийн цагт хурмал өвчин ихэснэ;  
Бадгана ихэдсэн өвчин хавар босно.

Зуны цагт тослог, илчлэг, давслаг ба исгэлэн;  
Намар цагт амтлаг, тослог, сэрүүн төдий;  
Өвлийн цагт амтлаг, тослог, исгэлэн төдий;  
Хаврын цагт халуун, ширүүн амт.

Бадгана ихдэх нь идсэн даруйд босно,  
Шар ихдэх нь шингэхийн үед босно,  
Хий ихдэх нь шингэсэн даруйд босно;  
Гурван махбод хөдлөх нь тэр мэт юм.

Хийн өвчнийг шимт зүйлээр анагаана;  
Угаах эмээр шарыг арилгаж үйлдэнэ;  
Хурмал нь гурвууланг хүч төгөлдөр ахуйд,  
Бадганы үе бууваас бөөлжих эмийг өг.

Хий ихдэх хийгээд шар, хурмал болон  
Бадгана ихдэхийн үесийг мэдэж үйлд.  
Ямар цагт ямар махбод бие нь ямар байгаа,  
Түүний эм хийгээд идээ ундааг үзүүлж үйлд.

“Тэгээд худалдаачны ноёны хүү Жалавахана, махбодод мэргэжих энэ мэтээр тэр төдий нэгийг огоот мэдсэн тэрбээр, аюурведийн найман гишүүн бүгдийг мэдэх болов.

“Язгуурын охин тэнгэрээ, тэр цагийн тэр үед худалдаачны ноёны хүү Жалавахана, Сурешвара-прабха хааны улсад тосгон, хот гацаа, орон улс хааны ордны бараа бологч бүгдэд очиж, элдэв янзын өвчнөөр өвдөж нэрвэгдсэн олон буман амьтад тэдгээрт: ‘Би болбоос эмч байна, би эмч байна’ хэмээн өөрөө андгайлаад, ‘Би та нарыг элдэв өвчнөөс чинь ангижруулж үйлдэнэ’ хэмээн өгүүлсэн билээ.

“Язгуурын охин тэнгэрээ, худалдаачны ноёны хүү Жалавахана-гийн энэхүү үгийг өгүүлэхийг сонссон даруйд олон буман амьтан бүгд машинд ихээр баясал төрөв. Тэрхүү үгийг сонсоод баясаж, амгалант болж, сэтгэшгүй сэтгэлийн амгалан төгөлдөр болов. Тэр цагийн тэр үест элдэв янзын өвчнөөр өвдөж нэрвэгдсэн олон буман амьтад

элдэв өвчнөөсөө огоот гэтэлж өвчин үгүй болов. Өвчин үгүй болоод урьдах шигээ хүч чадал, хичээл зүтгэл төгөлдөр болов.

“Тэр цагийн тэр үед элдэв өвчнөөр өвдөж нэрвэгдсэн олон буман амьтад тэдгээрийн дотроос хэн нэгэн хүчтэй өвчнөөр нэрвэгдсэн тэд бүгд худалдаачны хүү Жалавахана хаана буй тэнд хүрч очиход, элдэв өвчнөөр өвдөж нэрвэгдсэн олон буман амьтан тэдгээрт худалдаачны ноёны хүү Жалавахана бээр эм жор алин юу таарахыг үзүүлсэнээр тэдгээр амьтан бүгдийн бүх өвчин нь машид илааршив. Өвчин үгүй ба өвчин бага болж, урьдахын адил хүч чадал, хичээл зүтгэл төгөлдөр болов.

“Язгуурын охин тэнгэрээ, тэр цагийн тэр үед Сурешвара-прабха хааны улсад тосгон хот гацаа орон, эргэн тойрон, хааны ордны ойр орчим бүгдэд элдэв янзын өвчнөөр өвдөж нэрвэгдсэн олон буман амьтан тэдгээр бүгдийг худалдаачны хүү Жалавахана элдэв өвчнөөс нь огоот гэтэлгэж үйлдсэн болой.”

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлгөн судраас*

*“Өвчин бүгдийг машид амирлуулан үйлдсэн”  
хэмээх хорин дөрөвдүгээр бүлэг болой.*

\* \* \*

*XXV бүлэг: Жалавахана-гийн  
номхруулсан загасны урьдын цадиг*

“Язгуурын охин тэнгэрээ, бас Сурешвара-прабха хааны улсад худалдаачны хүү Жалавахана амьтан бүгдийг өвчин үгүй болгосноор өвчин багасаж, хүч төгөлдөр биетэй болгов. Сурешвара-прабха хааны улсад амьтан бүгд баясгалан хийгээд хайр энэрлээр баясах болж, өглөгүүдийг ч өгч буяныг үйлдэх болов. Худалдаачны хүү Жалавахана-д ‘Худалдаачны хүү Жалавахана ялах болтугай, ялах болтугай. Эмийн хаан, амьтан бүгдийн өвчнийг анагаагч, магадтай илтэд бодьсадва, аюур ведийн найман гишүүн бүгдийг мэдэгч’ хэмээн илтэд магтан үйлдсэн юм.

“Язгуурын охин тэнгэрээ, худалдаачны хүү Жалавахана тэрээр Жаламбу-гарба (*мон: Усны лянхуан шим*) нэрт нэгэн эхнэртэй байв. Жаламбу-гарба тэр хоёр хүү төрүүлжээ. Нэг нь Жаламбара (*мон: Усны хувцас*) хэмээх нэртэй, нөгөө нь Жалагарба (*мон: Усны шим*) хэмээх нэртэй бөлгөө. Язгуурын охин тэнгэрээ, нэгэн удаа худалдаачны хүү Жалавахана хоёр хүүгийн хамт тосгон, хот, гацаа, орон нутаг, ойр орчим, хааны ордны бараа болоочийн газарт аялан очив. Тэгж явтал, махан идэшт нохой, чоно, үнэг, турлиах, бусад махчин шувуунууд нэгэн хадан хавцлын цөөрөм байгаа тэр зүгт гүйхийг үзээд тэр ийн хэмээн бодов: ‘Юуны тулд махан идэшт нохой, чоно, шувуу хүртэл эдгээр амьтад энэ зүгт гүйх болов’ хэмээв. Тэгээд бас ийн бодов: ‘Би нохой, чоно, үнэг, турлиах шувуунуудын аль зүгт гүйсэн тэр зүгт очъё’. Язгуурын охин тэнгэрээ, тэгээд худалдаачны хүү Жалавахана алгуур яван явсаар хадан хавцлын дунд нэгэн цөөрөм байгаа тэнд хүрч ирэв.

“Их цөөрөм тэнд нэг түмэн загас амьдарч байжээ. Тэр бээр тэнд олон зуун загас уснаас хагацсаныг үзээд, их нигүүлсэнгүй сэтгэл төрсөн хийгээд мөн тэнд модноос тал биеэ цухуйлгах нэгэн охин тэнгэрийг

үзэв. Охин тэнгэр тэр бээр худалдаачны хүү Жалавахана-д ийн хэмээн өгүүлэв: ‘Язгуурын хөвгүүнээ! Сайн, сайн болой. Ямар ч байсан Жалавахана, Ус буулгагч хэмээгч та бээр, эдгээр загаснуудад ус өгөгтүн. Хоёр шалтгаанаар Жалавахана гэж нэрийдсэн билээ. Нэг утга нь ус буулгагч хийгээд нөгөө утга нь ус өгөгч болой. Тийм учраас өөрийн нэртэйгээ зохилдсон үйлийг үйлдэгтүн’. Ус буулгагч бээр хариу өгүүлэв: ‘Охин тэнгэрээ, энд хичнээн загас байна вэ?’. Охин тэнгэр бээр өгүүлэв: ‘Нэг түмэн загас байгаа.’ Язгуурын охин тэнгэрээ, тэр үед худалдаачны хүү Жалавахана машид их нигүүлсэнгүй сэтгэл төрсөн юм.

“Язгуурын охин тэнгэрээ, тэр цагт хадан хавцлын дотор байгаа тэрхүү их цөөрөмд өчүүхэн төдий ус үлдсэн байсан учир, нэг түмэн загас үхлийн үүдэнд очиж, уснаас хагацсан тэдгээр загас нэн тарчилж байв. Язгуурын охин тэнгэрээ, тэгээд худалдаачны хүү Жалавахана бээр дөрвөн зүгт нь гүйсэн хийгээд түмэн загас тэдгээр худалдаачны хүү Жалавахана аль зүгт одно, тэр зүгт Жалавахана-г хөөрхийлөлтэйгөөр харж байв. Язгуурын охин тэнгэрээ, худалдаачны хүү Жалавахана бээр дөрвөн зүгт гүйн ус хайсан ч тэндээс ус эс олов. Дөрвөн зүгт харваас хэтэрхий холгүй нэгнээ олон том мод байхыг үзэв. Тэдгээр модонд авираад, модны мөчрүүдийг таслаад, модны мөчир тэдгээрийг аваад, их бүрдэн дээр ирж модны мөчрүүдээр түмэн загас тэдгээрт машид сэрүүн сүүдрэвчийг барив.

“Язгуурын охин тэнгэрээ, худалдаачны хүү Жалавахана тэрхүү цөөрөмд цутгах усыг дөрвөн зүгт гүйн хайвч хаанаас ч цутгах усыг эс олов. Тэндээс түргэнээс түргэн усны урссан хуурай замаар одов. Хадан хавцалд байгаа тэр цөөрөмд Жалагама (*мон: усыг буулгагч*) хэмээх их мөрөн түүнээс тэнд ус цутгадаг боловч, тэр цагт тэрхүү мөрнийг нэгэн хилэнцэт амьтан бээр боож, түмэн загас тэдгээрийг хөнөөхийн тулд гадна талаас тэдгээр загасанд яавч ус үл буух болгосныг үзжээ. Тэр түүнийг үзээд, ‘олон мянган хүн байсан ч энэ мөрөн усыг тэр зам руу урсгаж чадахгүй учир би ганцаараа урсгаж хаанаас чадах вэ?’ хэмээн бодоод эргэн буцав.

“Язгуурын охин тэнгэрээ, худалдаачны хүү Жалавахана яаран сандран, Сурешвара-прабха хаан хаана байгаа тэнд очоод,

Сурешвара-прабха хааны хөлд оройгоороо мөргөөд нэгэн зүгт суугаад эдгээрийг үргэлжлүүлэн өгүүлэв: ‘Би бээр тэнгэр дээдсийн тааллын дор тосгон, хот, гацаа бүгдэд амьтдын өвчнийг амирлуулсан ч, ийм нэгэн хадан хавцалд байдаг газар нэгэн цөөрөм түүнд нэг түмэн загас уснаас хагацаад энэлэн шаналж байна. Хэрхэн хүмүүс бидэнд заяасан шиг адгуусны төрлийг олсон тэдгээрт ч амиа хайрлах сэтгэл байгаа. Тиймээс тэнгэр дээдсээ, хорин их заан надад хайрлан соёрхоо.’ хэмээн айлтгав. Сурешвара-прабха хаан: ‘Оточ их хаанд хорин их зааныг өгөгтүн!’ хэмээн түшмэдүүддээ тушаав. Түшмэдүүд бээр: ‘Их хүмүүнээ, их хорин зааныг хөтлөөд, олон амьтанд тусыг хүргэж амгаланг өгөгтүн’ хэмээн өгүүлэв.

“Худалдаачны хүү Жалавахана өөрийн хүү Жаламбара хийгээд Жалагарба хоёрын хамт их хорин зааныг хөтлөөд их зааны хариулагчаас зуун үхрийн ширэн тулмыг аваад эргэв. Жалагама хэмээгч их хүрхрээний дэргэд очоод, тэдгээр тулмаа усаар дүүргээд их зааны нуруунд усаа ачив. Түргэнээс түргэн хадан хавцлын дунд байгаа тэрхүү цөөрөм дээр хүрч, их зааны дээрээс усаа буулгаж, дөрвөн талаас нь цөөрмийг усаар дүүргэж тойрон явахад, худалдаачны хүү Жалавахана хаана одно тэр зүгт түмэн загас даган сэлэв.

“Язгуурын охин тэнгэрээ, худалдаачны хүү Жалавахана ийн ‘Юуны тулд эдгээр түмэн загасууд намайг хаана байна тэр зүгт хуйлрав?’ хэмээн бодов. Тэр бас ‘эдгээр түмэн загас өлсөхийн галаар огоот хохирч надаас хоол гуйсан нь магадтай. Би хоолыг өгч үйлдье’ хэмээн бодов.

“Худалдаачны хүү Жалавахана өөрийн хүү Жаламбара-д ийн хэмээн өгүүлэв: ‘Хүү минь ээ, их заан бүгдийн дотроос хамгийн хурдныг унаад өөрийн гэртээ үтэр түргэн очиж худалдаачны ноён өвөөдөө: “Аяа өвөг эцэг минь, Жалавахана эцгийн захиснаар энэхүү гэрт буй эцэг эх, садан төрөл, үр хүүхэд, зарц шивэгчин үйл үйлдээч бүгд найруулсан амны идээ алин байгаа бүгдийг нэгтгэн нийлүүлээд их зааныг унасан Жаламбара-гийн гарт түргэн илгээгтүн” хэмээж байна хэмээн үйлдэгтүн’.

Тэгээд хүү Жаламбага их зааныг унаад үтэр түргэн машид хурдалж өөрийн гэр хаана буй тэнд очоод тэдгээрийг дэс дараачлан нягт өгүүлсэн бөгөөд хүү Жаламбага урьд өгүүлсэн найруулсан идээ тэдгээр бүгдийг их зааны нуруунд ачаад их заанаа унаж хадан хавцалын цөөрөм хаана буй тэнд ирэв. Жалавахаана өөрийн хүү Жаламбага-г үзээд баясан биширч хүүгээс идээг аван жижиглээд тэрхүү цөөрөмд цацахад түмэн загас тэдгээр цэнгэн үйлдэв. Бас ‘Урьд нэгэн цагт би бээр нэгэн хийдэд их хөлгөний номлогч нэгэн гэлэнгээс, хэн нэгэн үхэхийн цагт Түүнчлэн заларсан Ратна-шикхин бурханы алдрыг сонсвоос тэр өндөр язгуурын сайн заяанд төрдөг хэмээн сонссон билээ. Би тэдгээр загаснуудад шүтэн барилдан гарахын гүнзгий номыг ч номлоё. Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхан Ратна-шикхин түүний алдрыг ч дуурсгаж үйлдье’ хэмээн бодов.

“Тэр цагт энэхүү Замбуу тивд, амьтдад хоёр янзын үзэл байв. Зарим нэг нь их хөлгөнийг илтэд магтаж, заримууд нь муулж байсан. Тэгээд худалдаачны хүү Жалавахаана тэр цагт тэрхүү цөөрөмд хоёр хөлнийхөө өвдөгийг далдлах төдийд ороод, ‘Ялж төгс нөгчсөн, Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхан Ратна-шикхин түүнд мөргөмү!’ хэмээн тухайлан өгүүлэх түүгээр тухайлан өгүүлэв. Түүнчлэн заларсан Ратна-шикхин урьд бодьсадвын явдалд хичээхдээ, “Арван зүгт хэн ч байсан үхэхийн цагт, миний нэрийг сонссон тэдгээр амьтад, тэндээс үхэн егүүдээд Гучин гурван тэнгэрийн оронтой хувь тэнцүү төрөх болтугай” хэмээн ерөөлийг тийнхүү тавьсан юм.

“Чингээд худалдаачны хүү Жалавахаана адгуусны төрөлд төрсөн тэдгээрт ном үүнийг номлов: ‘Энэ мэт буюу. Энэ байваас энэ гарна. Энэ төрвөөс энэ төрөх бөгөөд энэ мэт мунхагийн шалтгаанаар хуран үйлдэгчид, хуран үйлдэгчийн шалтгаанаар тийн мэдэл, тийн мэдлийн шалтгаанаар нэр дүрс, нэр дүрсийн шалтгаанаар зургаан төрөн түгэхүй. Зургаан төрөн түгэхүйн шалтгаанаар хүрэлцэхүй, хүрэлцэхүйн шалтгаанаар мэдрэхүй, мэдрэхүйн шалтгаанаар шунал, шуналын шалтгаанаар авахуй, авахуйн шалтгаанаар сансар, сансарын шалтгаанаар төрөл, төрлийн шалтгаанаар хөгшрөх, үхэх

хийгээд газлан, харуусал зовлон, амгалангүй сэтгэл, хямрал зэрэг гарах болно. Тэр мэт зовлонгийн их цогц эдгээр нь гарах болно. Энэ мэт буюу. Мунхагийг хааснаар хуран үйлдэгчид хаагдах болох бөгөөд тэр мэт зовлонгийн их цогц энэ нь ч хаагдах болох болой’ хэмээхийг хүртэл номлосон юм.

“Язгуурын охин тэнгэрээ, тэр мэт тэр цагийн тэр үед худалдаачны хүү Жалавахана адгуусны төрөлд төрсөн тэдгээрт ном төгөлдөр энэхүү үгийг өгүүлээд, өөрийн хүү Жаламбара болон Жалагарба хоёрын хамт өөрийн гэрт эргэн ирэв.

“Тэрнээс хойш нэгэн цагт худалдаачны хүү Жалавахана их баярын идээг зооглож, дарсанд согтоод дэвсгэр дээр амрах тэр үеийн тэр цагт, их шинж тэмдэг гарч: Тэр шөнийг өнгөрөхөд түмэн загас тэдгээр үхэхийн цаг нь болоод Гучин гурван тэнгэрийн оронд хувь сайт болон төржээ. Төрсөн даруйдаа тэдгээр нь энэ мэт ёсыг эргэцүүлэх сэтгэл нэн төрж: ‘Бид ямар буяны үйлээр Гучин гурван орны дотор төрөв өө?’ хэмээн бодов. Тэдгээр ч ийн хэмээн бодов: ‘Бид Замбуу тивд нэг түмэн загас болоод адгуусны төрөлд төрөхөд минь худалдаачны хүү Жалавахана бээр, их ус хийгээд идээний дээдээр цэнгүүлэн үйлдэв. Мөн бидэнд шүтэн барилдан гарахын гүнзгий номыг ч үзүүлж, Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхан Ратна-шикхин-ий алдарыг ч дуурсгаснаар буяны номын уг тэр болон шалтгаан түүгээр бид тэнгэрийн дотор төрсөн байна. Бид худалдаачны хүү Жалавахана хаана буй тэнд хүрээд түүнд тахил өргөө.’ хэмээв.

“Нэг түмэн тэнгэрийн хөвгүүд тэдгээр Гучин гурван тэнгэрийн дотроос үл үзэгдэх болж, худалдаачны хүү Жалавахана ийн гэрт ирэхэд тэр цагт худалдаачны хүү Жалавахана дэвсгэр дээрээ нойрсон байхуйд, тэнгэрийн хөвгүүд тэдгээр нэг түмэн сувдан зүүлтийг тэргүүнийх нь харгалдаа тавьж, нэг түмэн сувдан зүүлтийг хөлнийх нь дэргэд тавьж, нэг түмэн сувдан зүүлтийг баруун талд нь тавьж, нэг түмэн сувдан зүүлтийг зүүн талд нь тавив. Өвдөг далдартал мандарва цэцгийн их хурыг ч буулгаж, тэнгэрийн хөгжмийг ч эгшиглүүлэхэд замбуу тивийнхэн бүгд нойрноосоо сэрж худалдаачны хүү Жалавахана ч мөн сэрсэн болой. Тэгээд нэг

түмэн тэнгэрийн хөвгүүд тэдгээр ч огторгуйд нисч хөөрөв. Тэдгээр тэнгэрийн хөвгүүд Сурешвара-прабха хааны улс орон хийгээд, бусад улс оронд ч мандарваа цэцгийн хурыг буулгав. Ой шугуйд байгаа их цөөрөм хаана буй тэнд очоод их цөөрөм тэнд мандарваа цэцгийн их хурыг илтгэд буулгав. Тэр даруйдаа үл үзэгдэх болж дахин тэнгэрийн орондоо очжээ. Тэнд хүслийн таван эрдмээр баясан наадаж, баясал цэнгэлийн цог болон сайн хувийг амсан эдлэв.

“Замбуу тивд үүр цайхын цагт, Сурешвара-прабха хаан бээр зурхайчид болон их түшмэд тэдэндээ өгүүлэв: ‘Юуны учир эдгээр гайхамшигт шинжүүд гарав?’. ‘Тэнгэр дээдсээ болгоон соёрх. Худалдаачны хүү Жалавахана-гийн гэрт дөрвөн түмэн сувдан зүүлтийн хур буусан хийгээд мандарваа цэцгийн хур ч буусан байна’ хэмээн тэдгээр өгүүлэхэд: ‘Та нар өнөөдөр худалдаачны хүү Жалавахана-г яруу үгээр дуудагтун!’ хэмээн зарлиглав. Зурхайчид болон их түшмэдүүд Жалавахана-гийн гэр хаана буй тэнд очоод худалдаачны хүү Жалавахана-д, ‘Сурешвара-прабха хаан таныг дуудсан болой’ хэмээн өгүүлэв.

“Тэгээд худалдаачны хүү Жалавахана их түшмэдийн хамт Сурешвара-прабха хаан хаана буй тэнд бараалхахад хаан бээр: ‘Жалавахана аа, энэ мэтийн гайхамшигт шинж гарсан энэ юуны шинж болохыг мэдсэн үү?’ хэмээн асуув. Худалдаачны хүү Жалавахана Сурешвара-прабха хаанд: ‘Тэнгэр дээдсээ, би мэдэж болно. Нэг түмэн загас тэдгээр үхсэн нь гарцаагүй болов уу?’ хэмээн айлтгав. Хаан: ‘Яаж мэдэх вэ?’ хэмээн асуув. Жалавахана: ‘Тэнгэр дээдсээ, Жаламба-г тэрхүү бүрдэнд нэг түмэн загас тэдгээр үхсэн, эс үхсэнийг үзүүлэхээр илгээнэ үү’ хэмээн өгүүлэв. Хаан бээр: ‘Тэр мэт үйлдэгтүн’ хэмээн зарлиглав. Худалдаачны хүү Жалавахана бээр өөрийн хүү Жаламба-даа ийн хэмээн захив: ‘Хадан хавцалын дунд байгаа бүрдний нэг түмэн загас тэдгээр үхсэн эс үхсэнийг үзэгтүн’. Тэндээс хүү Жаламба үтэр түргэн хадан хавцлын дунд байгаа их бүрд хаана буй тэнд очиход нэг түмэн загас тэдгээр үхэхийн цагийг үйлдсэн болоод мандарваа цэцгийн их хур буусныг ч үзээд гэдрэг буцан ирж аавдаа, ‘загаснууд үхсэн байна’ хэмээн өгүүлэв.

“Худалдаачны хүү Жалавахана хүү Жаламба-гийн тэрхүү үгийг сонсоод Сурешвара-прабха хаан хаана буй тэнд хүрэв: ‘Тэнгэр дээдсээ болгоон соёрх: Нэг түмэн загас тэдгээр бүгд үхээд Гучин гурван тэнгэрийн дунд төржээ. Тэдгээр нь миний хүчээр төрж, гайхамшигтай тэр мэт буяны шинж тэдгээрийг гаргасан бөгөөд миний гэрт ч дөрвөн түмэн сувдан зүүлт, тэнгэрийн мандарваа цэцгийн хурыг ч буулгасан байна’ хэмээн тэдгээрийг дэс дараачлан нарийн нягт айлтгахад хаан тэр бишрэн даган баяссан юм.”

Тэгээд Ялж төгс нөгчсөн бурхан, язгуурын охин тэнгэр Бодисаттва самукчаяа-д ийн хэмээн зарлиглав: “Язгуурын охин тэнгэрээ, тэр цагийн тэр үед, Сурешвара-прабха хэмээгч хаан болсон тэр нь, бусад нэг мөн хэмээн чи санаваас, тэр нь тэр мэт биш юм. Учир юу вэ? хэмээвээс, Дандапани (*мон: Гартаа бэрээт*) Шагжа нь тэр цагт Сурешвара-прабха хэмээгч хаан байсан юм. Язгуурын охин тэнгэрээ! Тэр цагийн тэр үед худалдаачны ноён Жатимдара хэмээгч тэр нь, өөр нэгэн мөн хэмээн чи санаваас, тэр нь тэр мэт биш юм. Учир юу вэ? хэмээвээс Шуддодана (*мон: Сайн идээт*) хаан нь тэр цагийн тэр үед худалдаачны ноён Жатимдара хэмээгч байсан юм. Язгуурын охин тэнгэрээ, тэр цагийн тэр үед худалдаачны хүү Жалавахана хэмээгч тэр нь, өөр нэгэн мөн хэмээн чи санаваас, тэр нь тэр мэт биш юм. Учир юу вэ? хэмээвээс, би бээр тэр цагийн тэр үед худалдаачны ноён Жатимдара-гийн хүү Жалавахана хэмээгч байсан юм. Язгуурын охин тэнгэрээ, Тэр цагийн тэр үед эхнэр Жаламбу-гарба хэмээгч тэр нь, өөр нэгэн мөн хэмээн чи санаваас, тэр нь тэр мэт биш юм. Учир юу вэ? хэмээвээс, Шагжаан охин Гопа (*мон: Газар тэтгэгч эх*) бээр тэр цагийн тэр үед худалдаачны ноёны хүү Жалавахана-гийн эхнэр Жаламбу-гарба хэмээгч байсан юм. Раху баригч тэр цагийн тэр үед хүү Жаламба хэмээгч байсан юм. Ананд нь тэр цагийн тэр үед хүү Жалагарба хэмээгч байсан юм. Язгуурын охин тэнгэрээ, тэр цагийн тэр үед нэг түмэн загас болсон тэдгээр нь, өөр нэгэн мөн хэмээн чи санаваас, тэр нь тэр мэт биш юм. Учир юу вэ? хэмээвээс, Жваланан-таратежоража хаан тэргүүтэй нэг түмэн тэнгэр тэдгээр нь тэр цагийн тэр үед нэг түмэн загас байсан. Би ус болон идээний дээдээр цэнгүүлж, шүтэн барилдан гарсан гүнзгий номыг ч үзүүлж, Түүнчлэн заларсан,

дайснаа дарсан, үнэнхүү төгсгөсөн бурхан Ратна-шикхин-ий алдрыг ч дуурсгасан зэрэг тэрхүү буяны үйлийн шалтгаанаар миний дэргэд энд ирсэн бөгөөд тиймээс өнөөдөр дээр үгүй, үнэнхүү төгсгөсөн бодид эш бошгийг үзүүлсэн болой. Машид баясгалан, машид сүжиг, дээд баясгалан бишрэлтэйгээр номыг сонссоноор, бүгд эш бошгийг үзүүлсэн хэмээх нэрийг олсон болой. Язгуурын охин тэнгэрээ, тэр цагийн тэр үед модны охин тэнгэр болсон тэр нь, өөр нэгэн мөн хэмээн чи санаваас, тэр нь тэр мэт биш юм. Учир юу вэ? хэмээвээс, Язгуурын охин тэнгэр чи, тэр цагийн тэр үед модны охин тэнгэр хэмээгч байсан юм.

“Язгуурын охин тэнгэрээ, энэ мэт орчлонд эргэхийн цагт би ямар мэт олон амьтныг бодийн хутагт огоот боловсруулан үйлдэж, тэдгээр бүгдийг дээр үгүй, үнэнхүү төгсгөсөн бодид эш бошгийг үзүүлэх газрыг олох болсоныг мэдэж үйлдээрэй.”

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөмөн судраас*

*”Жалавахана-гийн номхруулсан загасны цудит”  
хэмээх хорин тавдугаар бүлэг болой.*

\* \* \*

[Аравдугаар хэсэг]

*XXVI бүлэг: Эм баранд биеэ огоот өгсөн нь*

“Язгуурын охин тэнгэрээ, бас бодьсатва нь бусдад туслахын тулд биеэ огоот өгдөг болой. Тэр юу вэ?”

“Хир үгүй, машид дэлгэрсэн, элдэв олон янзын эрдмийн гэрэл гэгээ болон тэнгэрийн оронд нэн цацарсан, торолтгүй билгүүнээр үзэх хүчээрээ чанадыг дарсан, Ялж төгс нөгчсөн бурхан бээр, мянган гэлэнгээр хүрээлүүлж, Панчалас (*мон: Таван цогцосыг авах*) нутагт цуван одож, нэгэн ой цэцэрлэгт залран авай. Тэрбээр тэнд хөхөрсөн зөөлөн хөхөмдөг зүлэгний дээр элдэв янзын сайхан үнэрт цэцгээр машид чимэглэгдсэн нэгэн газрыг болгоосон болой. Болгоогоод, Ялж төгс нөгчсөн бурхан бээр насан гавьяат Анандад зарлиглав: ‘Анандаа, энэхүү газар нь үзэсгэлэнтэй бөгөөд түүхэн газрын тэмдэг байгаа учир одоо Түүнчлэн заларсаны суудлыг дэвсэгтүн.’

Тэрбээр, Ялж төгс нөгчсөний зарлигчлан суудлыг засав. Суудлыг засаад Ялж төгс нөгчсөн бурханд ийн хэмээн айлтгав:

Ямагт хүмүүст дээдийг хайрлаж, орчлонгийн хүлээснээс  
гэтэлгэгч,

Ялж төгссөн эрхэм дээд багш минь таны суудлыг бэлдэв.

Залран саатаж хүмүүст, зовлонгоос гэтэлгэх эм болох

Зарлиг захиас дээдийн рашаанаа айлтган соёрх оо.

Тэгээд Ялж төгс нөгчсөн суудалдаа залраад гэлэнгүүдэд зарлиглав: ‘Гэлэнгүүдээ, та нар бэрх хатуужилт үйлийг үйлдсэн бодьсатвын цогцосыг үзэхийг хүсч байна уу?’

Тийн хэмээн зарлигласан хийгээд Ялж төгс нөгчсөн бурханд тэдгээр гэлэнгүүд ийн хэмээн айлтгав:

Төгс гэгээрсэн арш минь ээ, их хүмүүний шим болсон  
Тэвчээр хийгээд их хичээнгүй, амирлангуй, номхон дөлгөөн,  
Оюун, дурьдал, баясал хэмжээлшгүй эрдмийн орон болсон  
Цогцосыг бид харах цаг болбоос тэр сайн билээ.

“Чингээд Ялж төгс нөгчсөн бурхан бээр толиондоо мянган хигээст хүрдэн хээтэй өлмий болон гамала цэцэг дэлбээгээ нээх мэт зөөлөн мутраараа газрын хөрсөн дээр дарж хатгасан төдийд, газар дэлхий зургаан янзаар хөдлөөд, эрдэнэ болон алт мөнгөөр урласан нэгэн суварга гарч ирэв. Тэгээд Ялж төгс нөгчсөн бурхан насан хутаг төгөлдөр Анандад зарлиглав: ‘Анандаа, энэ суваргыг нээгтүн’. Насан гавьяат Ананд бурхан багшийн зарлигийг сонсоод суварга түүнийг нээхэд алтан гэрэл цацарсан, эрдэнэ болон сувдаар бүрхсэн нэгэн алтан хайрцаг түүний дотор байхыг үзэв. Түүнийг үзээд бурхан багшид ийн хэмээн айлтгав: ‘Ялж төгс нөгчсөөн, нэгэн алтан хайрцаг байна’. Бурхан багш бээр, ‘Эрдэнийн долоон хайрцаг бүгдийг нээгтүн’ хэмээн зарлиглав. Зарлигийн дагуу бүгдийн амыг нээхэд цасан цагаан өнгөтэй гүмүдэ цэцэг мэт нэгэн яс түүний дотор байхыг үзэв. Үзээд бурхан багшид, ‘Ялж төгс нөгчсөөн, хэсэг яс байна’ хэмээн айлтгав. Бурхан багш бээр, ‘Анандаа, их төрөлхийтний цогцосыг авч ирэгтүн’ хэмээн зарлиглав. Насан гавьяат Ананд тэдгээр яснуудыг аваад Ялж төгс нөгчсөн бурханд өргөхөд бурхан багш хуврагуудын өмнө яснуудыг мутартаа бариад:

Эдгээр яс нь машид дээд эрдмийн чуулган төгөлдөр,  
оюуны дээд,

Энгүй их тэвчээр, хичээл, шагшаабад, даяан, алдарын дээд  
бөгөөд

Ухаан төгөлдөрүүдэд, хойшид үргэлжид, бодь хутаг түүнд  
Улам хичээл, сүсэг, оюуны дээдийг өгөх тул баясан  
үйлдэхтүн.

хэмээн зарлиглав.

“Тэгээд Ялж төгс нөгчсөн бурхан бээр: ‘Гэлэнгүүдээ, шагшаабад хийгээд эрдмээр огоот халдсан, машид үзэхэд бэрх, буяны орон болсон бодьсатвагийн цогцос эдгээрт мөргөгтүн’ хэмээн гэлэнгүүдэд

зарлиглав. Тэдгээр гэлэнгүүд алгаа хавсраад, үнэн сүжигт сэтгэлээр тэдгээр яснуудад мөргөв.

“Тэр цагт насан гавъяат Ананд алгаа хавсраад, бурхан багшид ийн хэмээн айлтгав: ‘Ялж төгс нөгчсөн бурхан, Түүнчлэн заларсан нь бүх ертөнцөөс үлэмж илүү хамаг амьтны мөргөлийн орон атал, ямар учраас Та өөрөө эдгээр ясанд мөргөл үйлдэв?’

“Бурхан багш Анандад ийн хэмээн зарлиглав: ‘Анандаа, эдгээр ясны хүчээр би, энэ мэт үтэр түргэн, дээр үгүй, үнэнхүү төгсгөсөн бодид илтэд гэгээрч бурхан болсон юм. Анандаа, эрт урьдын өнгөрсөн цагт Махарата (*мон: Их замыг гаргагч*) хэмээх нэрт уналга, хүч чадал төгөлдөр, торолтгүй хүчээр чанадыг дарагч нэгэн хаан байсан. Түүнд идэр залуу тэнгэр адил гурван хүү байсан бөгөөд Махапранада (*мон: Их дуут*), Махадева (*мон: Их тэнгэр*), Махасаттва (*мон: Их чин зоригт*) нэртэй байжээ.

“Хаан зугаацахын тулд жаргалангийн цэцэрлэгээр аялсан хийгээд залуу хөвгүүд жаргалангийн цэцэрлэг түүний үзэсгэлэнд шохоорхож, цэцэгнээс цэцгэнд дамжин нааш цааш гүйлдсээр арван хоёр их цэцэрлэгийн гүн рүү орж явчихжээ. Хан хөвгүүдийн бараа болооч нар ч хан хөвгүүдийг дуудан нааш цааш хайх, сахин хамгаалахын тулд баясгалангийн цэцэрлэгийн арван хоёр их шугуйн гүнд оржээ. Тэгээд Махапранада хоёр дүүдээ: ‘Миний сэтгэлд айдас төрж байна. Биднийг араатан алахаар энд ирж магадгүй, одоо буцагтун’ гэж өгүүлэв. Махадева бээр өгүүлэв: ‘Надад айх нь үгүй боловч, энхэр хайртай хүнээсээ хагацах совин төрж байна’. Махасаттва өгүүлэв:

Бурхан бээр сайшаасан аглаг цэцэрлэг энд,

Би айх үгүй зовлон ч үгүй байна.

Машид их хэргийг олох байх хэмээн

Миний сэтгэлд машид баясгалан төрж байна.

“Ийнхүү өгүүлэлдээ идэр залуу тэдгээр хаан хөвгүүд арван хоёр цэцэрлэг тэдгээрийн дотор одов. Гэтэл зулзагалаад зургаа юмуу долоо хоногоос хэтрээгүй, өлөгчин эм бар таван зулзагаараа хүрээлүүлээд, өлсөж ундаасан туйлдаж, бие нь машид доройтсон тэр мэт нэгийг үзэв. Түүнийг үзээд Махапранада бээр: ‘Аяа! Аймшигт

энэ амьтан төрөөд зургаа юмуу долоо хоногоос хэтрээгүй боловч, хоол олдохгүй бол аль эсвэл өөрийн зулзагаа идэх, аль эсвэл өлссөөр үхэх болно доо’ хэмээн өгүүлэв.

“Махасаттва бээр, ‘Аймшигт энэ амьтны хоол нь юу вэ?’

“Махапранада бээр, ‘Энд шинэ мах, нойтон цус байваас тэр нь бар, хар гөрөөс, баавгай, өтөг, арслан нарын хоол мөн болой’ хэмээн хэлэв.

“Махадева бээр: ‘Энэ аймшигт амьтан өлсөж, цангаж туйлдсан тул амьдрах хугацаа өчүүхэн төдий нэг үлдсэн байна. Машид өлдөж ядарсан энэ амьтан энэ шугуйд идээ ундаа хайж чадахгүй учир, үүний амийг аврахын тулд хэн нэгэн өөрийн биеэ бүрнээ өгөх болтугай’ хэмээв.

“Махапранада өгүүлэв: ‘Аяа, өөрийн биеийг огоот өгөхөд бэрх болой.’

“Махасаттва бээр өгүүлэв: ‘Бид мэтийн амь биендээ илтэд тачаадаг өчүүхэн оюунтнуудад энэ ёсыг үйлдэхэд бэрх биз ээ. Биднээс өөр, биеэ огоот өгөхөд орогчид, бусдад туслахыг хичээгч дээд төрөлхийтөн нарт үйлдэхэд бэрх бус болой.

Энэрэл нигүүлсэлээс гарсан хутагт бодьсадва нар  
Энэ газар болон тэнгэрийн оронд биеийг олно хэмээн  
Бусдын амь насны төлөөх зохилдон баясах сэтгэлээр  
Буцалт үгүйгээр энд олон янзаар энэрсэн буй.

“Тэгээд залуу хан хүү тэр машид гуниглаж эм барс түүнийг нүдээ цавчилгүй холоос харсаар одов. Тэр үед Махасаттва ийн хэмээн бодов: ‘Одоо би энэхүү биеийг огоот өргөх цаг нь болжээ. Тэр юуны тулд вэ? хэмээвээс,

Эвдэрч сарних жамтай, эцэстээ хагацах, эцэстээ муудах,  
идээ бээрт  
Энэхүү биеийг идээ унд, ор дэвсгэр, унаа унш зэрэг  
Их зохистой зүйлээр өнө удаан сахисан ч,

‘урьд үгүй’ гэх өөрийн жамтай тул орхихгүй гэвч  
арга үгүй мөн.

Бас бүгд ариун бус болох учраас, тийн амьдрах нь утга үгүй. Тиймээс би үүнийг илүү сайн үйлэнд учруулж үйлдье. Тэгж чадваас энэ бие минь намайг төрөх хийгээд үхэхийн далайгаас гэтэлгэх их завь мэт болно.

Үр шимгүй, усны хөөс мэт, олон хорхойгоор дүүрсэн  
эцэстээ үрэгдэн одох,  
Үр адилын олон зовлон төгөлдөр өтгөн шингэнээр  
дүүрсэн үүнийг өгөөд  
Гаслан үгүй, урвалт үгүй, гутамшиг үгүй, хир үгүй, даяан  
тэргүүтэн эрдмээр  
Гүйцэд дүүрсэн номын лагшин болгож, олон эрдмээр  
баялаг, тоосноос хагацсан түүнийг олонтаа үйлдье.

“Тэр дээд их нигүүлсэнгүйн утга төгөлдөр сэтгэлээр өөрийгөө тэр мэт сургаад: ‘Та хоёр ажран соёрх. Би өөрийн нэгэн үйлийн тулд арван хоёр их цэцэрлэгийн дотор орох болой’ гээд тэр хоёрыг явуулжээ. Тэгээд залуу хан хүү Махасаттва тэрээр ойгоос гэдрэг буцаж, барын дэргэд очоод модны мөчирт хувцсаа өлгөөд, ийн ерөөл тавив:

Би амьтанд туслахын тулд адилгүй бодийн амгаланг  
олохыг хүсээд  
Бусдын өгөхөд бэрхтэй биеийг урвалтгүй оюун  
нигүүлсэнгүй сэтгэлээр өгье.  
Би бодьсадва нарын хүсдэг гэм үгүй бодийг өнө удалгүй  
олох болтугай.  
Би машид аймшигтай орчлонгийн далайгаас гурван  
ертөнцийг гэтэлгэж үйлдье.

“Тэгээд Махасаттва бээр эм барын өмнө хэвтэхэд, тэр асрал төгөлдөр бодьсадвад хорлол юуг ч эс үйлдэв. Бодьсадва бээр, ‘Аяа энэ амьтан ядарч зүдэрсэн тул идэж чадахгүй байна’ хэмээгээд, нигүүлсэнгүй сэтгэлээр хутга мэсийг хайхад хаанаас ч мэс олдсонгүй. Гэрэлт модны зуун жил болсон хатуу мөчир нэгийг аваад өөрийн хоолойг

таслаж эм барын өмнө хэвтжээ. Бодьсадваг хэвтсэн даруйд, нуурын дунд хөвөх завийг салхи туух мэт, тэрхүү цагт газар дэлхий зургаан янзаар хөдлөв. Нар ч гэсэн хиртсэн мэт их гэрэл нь үзэсгэлэнгүй болов. Тэнгэрийн үнэртэн үйрмэг холилдсон цэцгийн хур ч буув. Нэгэн тэнгэр машид гайхан биширсэн сэтгэлээр бодьсадваг ийнхүү магтав:

Сайн оюунт та энд ямар мэт нигүүлсэнгүйгээр хамаг  
амьтныг энэрч,  
Хүний эрхт машид баясангуйгаар ямар мэт лагшингаа  
огоот өгсөнөөр  
Төрөл болон үхэхийн утгаас хагацаж амирлангуй  
оршихын дээд болсон  
Амирлангуй болж, ариун та бээр энд төвөггүй, өнө  
удалгүй бодийг олно.

“Тэгээд эм бар тэрбээр бодьсадвагийн биенээс цус асгарахыг үзээд агшин төдийд мах цусыг идэж, яс төдий нэгийг үлдээжээ.

“Тэр үед Махапранада тийнхүү газар хөдлөхийг мэдээд Махадева-даа ийн хэмээн өгүүлэв:

Ямар мэт арван зүгийн далайн чанадыг хүртэл  
Энэ газар машид хөдөлж, нарны гэрэл нь үгүй болов.  
Цэцгийн хур буух хийгээд миний сэтгэл ч хямарч буй тул  
Өнөөдөр миний дүү өөрийн биеийг өгсөн биш байгаа.

“Махадева өгүүлэв:

Тэр ямар мэт нигүүлсэнгүй үгийг өгүүлсэн ба,  
Өлсөж цангасан олон зовлонгоор нэрвэгдсэн  
Машид доройтож өөрийн үр зулзагаа ч  
Идэхэд шахамдсаныг түүнийг хараад би ч сэжиг төрсөн.

“Тэгээд хоёр хан хүү машид айдас төрж, нүд нь нулимсаар дүүрч, тэр замаараа эргэн буцаж эм барын өмнө хүрэхэд, бүх хувцсаа гэрэлт модны мөчирт өлгөж, хамаг яс нь таран бутарч, халуун цус нь шороотой холилдож, сэвлэг үс нь зүг бүрт хийссэнийг үзэв. Түүнийг үзээд муужирч, бутарсан ясны дээр тэрийн унаад, хэсэг хугацааны

дараа ухаан орж босоод, хоёр гараа өргөн харуусал гаслангийн дууг гаргав:

Эвий хөөрхөн дүү минь ээ!  
Энхрий хүүгээ элбэрэн хайрлах  
Хаан эцэг, хатан ээждээ юу гэж хэлэх вэ, бид?  
‘Өдгөө цэцэг адил сормууст  
Үр минь хаана байна?’ гэж  
Ээж минь лавтай асууна даа.  
Аяа! бид хоёр энэ л газартаа  
Үхвээс сайн биз, яаж амьд явах вэ.  
Махасаттва чи үгүй болохоор  
Эцэг эх минь яаж биднийгээ хайрлах вэ?

“Тэгээд хоёр хан хүү нигүүлсэнгүй сэтгэлээр олон удаа уйлан дуулахад залуу хан хүүдийн бараа болооч нар ч тэднийг эрэх хийгээд зүг зовхис бүгдэд хайж нэг нэгийгээ үзээд: ‘Залуусаа, яасан бэ? хөвгүүд минь, яасан бэ?’ хэмээн асуув.

Тэр цагт хатан орондоо нойрсох зүүдэндээ хайртай хүүгээсээ хагацахыг зүүдлэв. Хоёр хөх тасрах, шүд унах, хөхөөний өхөөрдөм гурван ангаахай олсон ч нэгийг нь харцага авлаа хэмээн зүүдэлжээ. Тэгээд хатан бээр газар хөдлөхөд сэтгэл түгшиж тэр даруйдаа сэргж, бодол болов:

Амьтны суурь - “далайн хувцаст” энэ бүхэн яагаад машид  
их хөдлөв?

Нарны гэрэл үгүй болсноор миний сэтгэлд гаслан болов.

Миний бие мятарч, нүдний зовхи татаж, өөрийн хөх  
тасрав хэмээн зүүдлэв.

Миний хөвүүд ой цэцэрлэг энд тоглож наадахаар явсан  
юмсан, сайн байгаа болов уу ?

“Түүний шивэгчин ч сэтгэл түгшин ирээд, хатанд айлтгав: ‘Их хатан минь, хөвгүүдийн бараа болооч нар хөвгүүдийг хайж байна. Дээдэс алга боллоо хэмээж байна’ гэхэд түүнийг сонссон даруйдаа хатан зүрх чичирч, нүүр нүд нь нулимсаар дүүрээд, хааны дэргэд очоод өгүүлэв: ‘Тэнгэр дээдсээ! Миний хайрт хүү осолдов хэмээн

сонслоо.’ гэхэд, Хаан ч сэтгэл түгшин машид сандарч, “ Аяа, би хайрт хүүгээсээ хагацав уу” хэмээн өгүүлэв.

“Тэгээд хаан, хатнаа тайвшруулахын тулд: ‘Одоо хөвгүүдээ эрж олохоор шамдсугай! Хатан минь, гасалж бүү үйлдэгтүн’ хэмээв. Хөвгүүдийг олохоор олон хүмүүс хэсэг хэсэг болоод хайсанд өнө удалгүй хаан хоёр хүүг алсаас ирэхийг үзэв. Үзээд ийн өгүүлэв: ‘Хөвгүүд маань ирэвч бүрэн биш байна. Аяа! Хүүгээсээ хагацав’ хэмээн шаналан зовов:

Аяа, үрээсээ хагацна гэдэг ямар их зовлон бэ.  
Хүмүүс хүүтэй болоод хичнээн их баярладаг билээ.  
Хүүгээ алдсан, үхүүлсэн нь жаргадаг юмуу,  
Амьд авч яваа нь жаргадаг юм уу?

“Хатан машид харуусан гасалж, ингэн тэмээ буйлах мэт энэлсэн их дууг хадаав:

Тэр мэт гурван хүү минь бараа болоочдын хамт  
Цэцгээр дүүрсэн ой шугуйн дотор зугаалсан ч,  
Миний энхрий бага хүү тэр минь эргэн үл ирэв  
Миний зүрх лугаа адил бага хүү тэр минь хаачив?

“Ингээд хоёр хүүг ирэхэд хаан аав нь хөвгүүдээс: ‘Бага хүү хаачив?’ хэмээн асуув.

“Тэд харуусан гасалж нүд нь нулимсаар дүүрч, тагнай уруул ам шүд нь хатаад, юу ч хэлж чадсангүй. Хатан өгүүлэв: ‘Миний хайрт бага хүү минь хаачив? Миний энэ зүрх хагарах болох нь ээ. Бие минь тэсэшгүй машид зовж байна. Миний ухаан балартах нь, түргэн өгүүлээч’.

“Хоёр хүү бээр ямар мэт болсон явдлыг нэг бүрчлэн өгүүлэв. Түүнийг сонссон даруйдаа хаан, хатан хоёр муужран унаж, ухаан сэргээд, хайр энэрлийн дуугаар уйлан, тэр зүгт явав. Хаан, хатан хоёр мах цус шөрмөсгүй тэдгээр яснууд хийгээд ийш тийш хийссэн үснүүдийг үзээд салхинд унасан мод мэт унав. Ноёд түшмэл бараа болооч нар тэр мэт болохыг үзээд ус ба Малаяа уулын зандангийн



татаал, уур хилэн, мунхагийн харанхуйгаас бүрэн гэтлээгүй тэр цагт ч там тэргүүтэй амьтны зовлонгоос би амьтан бүгдэд тусыг хүргээд гэм бүхнээс хагацаж, Үнэнхүү төгсгөсөн бурхан болсоныг одоо өгүүлэх хэрэг юу байна. Тэр мэт амьтан нэг бүрчлэнгийн тулд ч амьтны тамд галвын турш оршихыг хичээсэн хийгээд төрөлхтөнийг хүрднээс нэн гэтэлгэсэн юм. Амьтны төлөө машид үйлдэхэд бэрхтэй элдэв янзын олон үйлээр хамаг амьтанд тусыг хүргэсэн.

“Тэгээд Ялж төгс нөгчсөн бурхан тэр цагт эдгээр шүлгийг зарлигласан юм:

Дээд бодь үүнийг огоот эрж,  
Олон галавт би биеэ ч өгсөн.  
Ямар мэт хаан хийгээд хаан хүү болж,  
Тэр болгонд би биесийг огоот өгсөн.

Урьдын төрөл бүхнээ даган санахад,  
Махарата хэмээх хаан гарсан.  
Түүнд их өглөгч нэгэн хүү,  
Махасаттва хэмээгч дээдэс байсан.

Түүнд эрэмгий хоёр ах байсан,  
Махапранада болон Махадева хэмээх нэртэй.  
Садан нөхдүүд ой дунд одож,  
Тэдгээр өлссөн эм барыг үзсэн.

Түүнд, дээд төрөлхийтөн түүнд нигүүлсэнгүй сэтгэл төрж:  
‘Энэхүү эм бар өлсөж, цангахад нэрвэгдсэнээр  
Өөрийн зулзага тэдгээрийг идэх аюул ирнэ.  
Тиймээс би одоо биеэ өгье.’

Махарата-гийн хүү Махасаттва,  
Өлссөн барыг үзээд эх зулзага нарыг  
Гэтэлгэж үйлдэхийн тулд их нигүүлсэнгүй сэтгэлээр  
Уулын хавцлаас үсэрсэн хийгээд

Газар уул бүгд хөдөлж,  
Шувуудын чуулган нэн олон үзэгдэж,

Гөрөөсийн чуулган айн сандарч,  
Энэ ертөнцийг харанхуй нөмрөхөд

Түүний ах Махапранада хийгээд  
Түүнчлэн мөн Махадева тэр хоёр  
Их шугуй тэнд хайваас  
Махасаттва-г эс олоод,

Машид гаслангаар сэтгэл нь шаналж,  
Мансуурч ой дотуур нааш цааш гүйж,  
Бага дүү түүнийг огоот эрэн,  
Бархиран ой дундуур хэрэвч,

Махапранада болон Махадева  
Ах дүү тэдгээр хан хөвгүүд,  
Туйлдаж ядарсан эм барын үүр  
Тэнд ойртон очиж хартал,  
Эм бар болон түүний зулзага  
Өлсгөлөн тэдний хошуун дахь цус,

Хувхайрсан яс, үс гэзэг нь  
Хаа сайгүй бутарсаныг үзэв.  
Түүний цусны хэсэгхэн дусал  
Тэрхүү газарт шингэсэн байв.  
Улсын хааны хоёр том хүү,  
Улайрсан цус түүнийг үзээд,  
Гэнэт балмагдан тэрхүү газарт  
Гэдрэг харан муужран унав.  
Хамаг биенд нь шороо наалдаж  
Хамгийг мартан сэтгэл нь мансуурав.

Эрхэмсэг тэдгээрийн бараа болооч нар ч  
Ихэд харамсан уйлан гашуудав.  
Тэдгээр усыг машид цацлан  
Тэнгэр харан уйлан суув.

Тэднийг муужран унах үед  
Тэнгэрлэг дээд хатан эх

Олон эмс шивэгчнээр хүрээлүүлэн,  
Ордны дотор амран байтал,

Чинэсэн хоёр хөхний үзүүрээс  
Цус сүү холилдон гоожиж,  
Хамаг бие үе мөч бүхэн  
Хурц зүүгээр хатгах мэт өвдөж,

Сэтгэл нь машид гаслангаар дүүрч,  
Хагацал харууслын суманд оногдож,  
Эзэн хааны дэргэд очоод,  
Энэлэн харуусан машид түгшиж,  
Энэрлийн дуугаар ихэд уйлан  
Махарата хаанд ийн өгүүлэв:

‘Эрхт хүний хаан, намайг сонс:  
Энэ бие минь шаналлаар түлэгдэв;  
Миний хоёр хөхний үзүүрээс  
Муу цус сүү мэт гоожиж,

Зүүгээр хатгасан мэт бүх бие өвдөж;  
Зүрх минь ч бас хагарах шахав.  
Хайртай хан хөвгүүд минь  
Хойшид үл үзэгдэх муу ёр гарав.

Алаг үрсийг минь эрж хайгаач.  
Асарч нигүүлсэн, амь өршөөгөөч.  
Өнөөдөр бас миний зүүдэнд  
Өхөөрдөм хөхөөний гурван ангахай  
Олсон миний хөхөөдийн дотроос  
Онцгой хөөрхөн нэгэн байсан,  
Хөөрхий түүнийг үхлийн эзэн  
Харцага шувуу шүүрэн одсон.

Гайтай энэхүү зүүд надад  
Гаслан харууслыг сэтгэлд минь авчрав.  
Түгшсэн сэтгэл минь машид энэлж,  
Тун удалгүй би үхэх болов уу.

Энхрий хөвгүүдийг минь эрж олон,  
Энэрэн нигүүлсэж амийг минь авраач.’

Тийнхүү өгүүлээд эх хатан  
Тэр газарт муужран унав.  
Дурьдлын эрхтэн нэн доройтож  
Сэтгэл нь хоосорч, санамсаргүй болов.

Хатны бараа болооч шивэгчин бүгд ч  
Харуусан өрөвдөж машид уйлав.  
Тэнгэрлэг хатан ухаан алдаж,  
Тэр газарт унахыг үзээд,

Тэр даруйд эзэн хаан  
Хүүгээсээ хагацахын гасланд дарагдав.  
Түшмэл болон бараа болооч нар ч  
Түргэн хөвгүүдийг хайхаар одов.

Бүх хотын ард иргэд  
Бүгд тус тусын гэрээс гарч,  
Уйлан нүднээсээ нулимс асгаруулж,  
Махасаттва-г хаа сайгүй хайв:

‘Амьд юмуу аль эсвэл үхсэн  
Махасаттва тэр хаана одов?  
Бид өнөөдөр үзсэн билүү?  
Сэтгэлд зохистой амьтан зарим нэг  
Өнөөдөр яруу бусыг сонсох болов?’

Өнө удаан барагдашгүй гаслангаар огшив.  
Дуу үл хүрэх хийгээд хязгаарлашгүй,  
Хүчтэй дуугаар хашгиран хайв.

Махарата хаан  
Их гаслангаар гашуудан уйлж,  
Энхрий хатан газар унасныг  
Өөрөө усаар цацан сүрчиж,  
Хэдий сэргэн босох болох  
Төдий хүртэл усыг цацав:

‘Миний хөвгүүн үхсэн юмуу амьд юм уу?’ хэмээн  
Мятарсан сэтгэлээр асууж үйлдэв.

Эзэн хаан Махарата  
Эрхэм хатанд ийнхүү өгүүлэв:  
‘Түшмэд болон бараа болооч нар ч  
Тэднийг хайхаар гадагш одов.  
Чи машид сэтгэлээ хямруулж,  
Үргэлжид гаслан бүү зов’

Тэр мэт Махарата хаан  
Тийнхүү хатныг аргадан тайвшруулаад,  
Хааны орд харшнаас гарч,  
Харуусалд дарагдан уйлан уйлсаар  
Түшмэдийн чуулганаар огоот хүрээлэгдэн,  
Түгшин сандарч бие нь ч доройтов.

Олон зуун амьтад ч бас  
Уйлан харуусан тэднийг дагалдав.  
Хаан хүүдийг эрэхийн тулд  
Хот балгасаас холдон гарч,

Хаан гарч явахыг үзээд  
Хааны хойноос бүгд дагав.  
Махарата хаан тэр  
Их хотоос гарсан даруйдаа  
Хайртай хүүгээ харахын тулд  
Хурц нүдээр зүг бүр харав.

Толгойгоо бүтээж ядарч сульдсан  
Тоос бүх биеийг нь хувцас мэт бүрхсэн  
Нүүр нь нулимсаар дүүрч уйлан хайлсан  
Нэгэн хүн ирэхийг үзээд

Махарата-гийн зүрх сэтгэлд ч  
Ихэд барагдашгүй түгшүүр төрж,  
Нүүр нүдэнд нь нулимс хурж,  
Гараа өргөөд уйлан суув.

Тэгээд түүний нэгэн түшмэл  
Тэр холоос түргэн яаран ирж  
Их эзэн хүмүүний хаан  
Махарата-д ийн хэмээн айлтгав:

‘Тааллаа хямруулан бүү зохиогтун эзэн минь,  
Таны хөвгүүд сэтгэлд зохистой байна.  
Өнө удалгүй таны энэ оронд  
Өөрсдөө ирэхийг та болгоо!’

Хаан түр нэг цааш явахад  
Хоёрдогч их түшмэл хүрч ирэв;  
Хамаг хувцас нь хир тоос болсон тэр  
Хаандаа уйлан ийн айлтгав:

‘Эзэн хаан минь ээ, таны хоёр хүү  
Энэлэн машид гашуудаж байна.  
Эзэн таны нэг хүү алга  
Махасаттва мөнх бусыг үзүүлэв.

Эм бар зулзагалаад өнөд удаагүй ч  
Өөрийн зулзагуудаа идэхийг хүсэхийг үзээд  
Тэдгээрт залуу их хүмүүн тэр  
Тэсэшгүй их нигүүлсэнгүй сэтгэл төрөөд  
Арилсан бодид ерөөлийг ихэд тавиад:  
“Амьган бүгдийг би гэтэлгэж үйлдье,  
Асар гүнзгий агуу их бодид  
Асар удалгүй би хүрч үйлдье”.

Их хүн тэр хадан хавцал руу харайж;  
Өлссөн эм бар түүнийг босгоход  
Агшин төдийд биенд нь мах үгүй болгож,  
Энд тэнд хэдэн яс үлджээ.’

Машид аймшигтай үг түүнийг сонсоод,  
Махарата хаан муужраад,  
Газарт унаад сэтгэл нь ч хоосон болж,  
Гаслангийн гал машид барагдашгүй бадрав.

Хамаг нөхөд түшмэдүүд халагласан үгээр  
Харуусан гашуудаж эзэн тэдгээрийг ч  
Усаар сэрүүцүүлэн гараа өргөн машид уйлав.

Гурав дахь түшмэл хаанд өгүүлсэн нь:  
‘Би өнөөдөр хоёр залуу хүүг  
Их ой тэнд машид муужирч,  
Газарт унаж сэтгэл нь ч хоосорсоныг үзэв.

Ухаан нь сэргээд босохыг хүртэл  
Усаар бид нар машид сүрчиж,  
Дөрвөн зүг бүхнээс бадрахыг үзсэн;  
Агшин төдий сэргээд ахин газар унасан;  
Асар хөөрхийлөлтэйгөөр машид уйлан дуулсан;  
Үргэлжид гараа өргөн суугаад  
Дүү түүнийхээ сайшаалыг машид өгүүлсэн.’

Хаан тэнд машид сэтгэл хямарч,  
Хүүгээсээ хагацсанаар сэтгэл нь зовлонд дарагдав.  
Харуусан машид энэлж үглэн дуулав.  
Хаан тэр нь ийн хэмээн огоот сэтгэв:

‘Хайртай хүү, сэтгэлд зохистой нэг нь  
Хамаг амьтны тулд мөнх бусыг үзүүлэв.  
Миний хоёр хүү тэд ч  
Гаслангийн галаар амиа алдах вий дээ.  
Тиймээс би түргэн тэнд очоод  
Үзэхүй баясгалант хөвгүүдээ харж үйлдье.

Хурдан унаагаар хааны ордны  
Хааны харшид түргэн хөтөлж үйлдье.  
Тэдгээрийг төрүүлсэн эхийн зүрх  
Тэсэшгүй гаслангаар хагарах шахаж байгаа.  
Хоёр хүүгээ үзээд амирлахыг олох болоод,  
Амь наснаас хагацахгүй болох биз ээ.’

Хаан түшмэлийн чуулганаар хүрээлэгдээд,  
Их зааныг унаад хөвгүүдээ харахаар одов.

Хоёр хүү нь хөөрхийлөлтэйгөөр машид уйлан,  
Дүүгийнхээ нэрийг дуудан замаар ирэхийг үзэв.

Эзэн хаан тэр хоёрыг хөтлөөд,  
Машид уйлан гэртээ очоод,  
Тэрбээр зориглон түргэн яаран  
Их хатанд өөрийн хөвгүүдийг үзүүлэв.

Түүнчлэн заларсан Шакъяамуни би,  
Тэр цагийн Махарата хааны  
Махасатва хүү болж  
Алин бээр эм барыг амирлуулан үйлдсэн юм.

Эрхэт дээд хаан Шуддодана (*мон: ариун идээт*) тэр нь  
Махарата хэмээгч хаан байсан  
Хатан нь ч дээд хатан Маяа (*мон: Илбэ хувилгаант*) байсан юм.  
Махапранада нь Майтреяа байсан юм.  
Махадева нэрт тэрхүү ханхүү нь  
Энэ цагийн Манжушри мөн юм.  
Эм барс нь Махапражати (*мон: төрөлхтөн бүгдийн их эзэн*)  
Энхрий зулзаганууд нь таван гэлэн юм.

“Махарата хаан болон хатан ихэд гашуудан, хамаг чимгээ тайлж, олон нөхдийн хамт хүүгийн ясыг тахин үйлдээд, Махасаттва түүний яс эдгээрийг энэхүү газарт тавьсан бөгөөд долоон их эрдэнийн суварга үүнийг босгосон юм. Махасаттва тэр эм баранд биеэ өгөөд: ‘Биеэ огоот өгсөний буян түүгээр ирээдүй хойчийн цагт тооноос машид хэтэрсэн олон галавт хамаг амьтанд бурханы зохиолыг үзүүлнэ’ хэмээн ерөөлийг тийнхүү тавьсан.

“Сургаал үүнийг номлоход тэнгэр, хүмүүн зэрэг тоолшгүй хэмжээлшгүй олон амьтад дээр үгүй, үнэнхүү төгсгөсөн бодид сэтгэлийг үүсгэв. Суварга үүнийг энд үзүүлсэний уг нь энэ мөн шалтгаан нь ч энэ мөн болой.

“Тэрхүү суварга нь ч бурханы адистэдийн хүчээр тэрхүү газрын дотор оршин байгаа.”

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлгөн судраас*

*”Эм баранд биеэ олоот өгсөн нь“  
хэмээх хорин зургадугаар бүлэг болой.*

\* \* \*

## XXVII бүлэг: Бодьсадва бүрдээр магтсан нь

Тэгээд тэдгээр олон буман бодьсадва нар Түүнчлэн заларсан Суварна-ратна-каракчатракута (мон: Алт болон их эрдэнэ гарахын орон давхар шүхэр) хаана буй тэнд хүрч, очоод Ялж төгс нөгчсөн, түүнчлэн заларсан Суварна-ратна-каракчатракута-гийн өлмийд оройгоороо мөргөөд нэгэн зүгт суув. Нэгэн зүгт суунгуутаа тэдгээр олон зуун мянган бодьсадва нар алгаа хавсран залбирч, Түүнчлэн заларсан Суварна-ратна-каракчатракута түүнд шүлэг эдгээрээр магтаал өргөв:

Авралт бурханы лагшин шижир алт мэт  
Ариун тунгалаг бие нь тунамал алтан өнгөтэй.  
Алтан уул мэт сүрдэм бахдам лагшин,  
Алтан шаргал өнгөтэй чадагч цагаан лянхуа.

Аливаа сайн билгээр лагшин нэн чимэглэгдсэн;  
Элдэв сайн найргаар бие лагшин хээлэгдсэн;  
Нарны гэрэл мэт үзэсгэлэн нэн бадарсан.

Нэн амирлангуй хиргүй сүмбэр уул мэт,  
Эсрэнгийн дуу болон яруу эсрэнгийн эгшиг.

Арслангийн архираа болон дуурсах лууны хөг;  
Гайхамшигт жаран эрдэмт нисванис үгүй зарлиг;  
Гоёмсог тогос ба галбингаан яруу аялгуу;  
Буртаг хиргүй хилэнцээс хагацсан сүр жавхлан;  
Буяны олон билгээр чимэглэгдсэн бурхан.

Болгоогчийн далай хиргүй хилэнцгүйн дээд;  
Бурхан эрдэм төгс баялаг их уул мэт.  
Хамаг амьтанд туслах нигүүлсэнгүйн туйл  
Хамаг ертөнц бүхэнд амгаланг өгөхийн оргил.

Гагц бурхан та дээд утгуудыг үзүүлээд,  
Гаслангаас гэтэлсэн амгаланд оруулдаг билээ.

Үхэл үгүй амгаланг үргэлж хайрлагч бөгөөд  
Үнэн номын рашааныг машид үзүүлэгч юм.  
Харуусал үхэл үгүй их хотод хүргэгч,  
Хамаг амгалан гарах төгс жаргалангийн орон.

Амьтны зовлон зүдгүүрийг гэтэлгэн зохиогч бурхан,  
Аймшигт зовлонгийн далайгаас төрөлхтөн бүгдийг  
гэтэлгэгч;

Амирлангуйн замд төрөлхтөн бүгдийг машид оруулж,  
Амар амгалан бүгдийг төрөлхтөн бүгдэд хайрлагч.

Ямар ч жишээгээр таныг зүйрлэж үл чадна  
Ямарчлан татагчийн билгүүн эрдмийн далай,  
Амьтан бүгдэд таны нигүүлсэнгүй сэтгэл хийгээд  
Асрахуйн хүч болон арга хичээнгүй зэрэг.

Авралт бурхан таны эрдэм ухааны далайгаас  
Алин олон мянган голди галвын турш ч  
Дусал нэг төдий ч эрдмийг гүйцэд үзүүлэх  
Дээд тэнгэрийн дотор ч тийм чадал үгүй.

Эрдмийн их далайгаас эрдмийн дуслыг аваад  
Энэ мэт би товчлон хурааж номлов.  
Алин миний хураасан буян түүний хүчээр  
Амьтан тэд бүгд дээд бодид хүрэх болтугай.

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлийн судраас*

*"Бодьсадва бүгдээр маитсан бүлэг"  
хэмээх хорин долдугаар бүлэг болой.*

\* \* \*

*XXVIII бүлэг: Түүнчлэн заларсан бурхад бүгдийг  
магтсан*

Түүний дараа бодьсадва Ручира-кету (*мон: Үзэсгэлэнгийн охь*) суудлаасаа босоод номт хувцсаа нэг мөрөндөө буулгаж, баруун өвдгөө газарт хатгаад, Ялж төгс нөгчсөн бурхан хаана байгаа тэр зүгт алгаа хавсран сөгдөөд, эдгээр шүлгүүдээр Ялж төгс нөгчсөн бурханыг илтэд магтав:

Чадагчийн эрхт та, олон буяны билэг;  
Цогт мянган үзэсгэлэн эрдмийн чуулганаар чимэглэгдсэн;  
Агуу их өнгө дээд амирлангуйг үзүүлсэн;  
Алтан нар мэт гэрлийг нэн цацруулсан.

Олон гэрэл бадруулсан гэрлээр түгсэн.  
Элдэв өнгөөр дүүрэн их эрдэнэ мэт,  
Хөх, цагаан, шар биндэрьяа  
Зэс хийгээд цайвар болрын гэрэл мэтээр  
Очирт уул сүмбэр уулыг сүрээр дарах хийгээд  
Олон голди орныг гийгүүлэн зохиогч;  
Барагдашгүй хатуу зовлонг амирлуулан зохиогч;  
Барагдашгүй дээд амгалангаар цэнгүүлэн зохиогч.

Дүрс эрхтэн тодорхой харваас үзэсгэлэнт;  
Хараад ханашгүй хэн ч үзвээс баясах;  
Тэргүүний үс нь тогосны өд мэт үзэсгэлэнтэй;  
Түмэн зөгий дүүрсэн үүр мэт сонин.

Таалал нь нэн ариун тоолшгүй эрдмээр дүүрсэн.  
Төвлөрөл, асрахуй дээд буяныг хураасан.  
Сайн найраг элдэв өнгө төгөлдөр бөгөөд  
Самади бодийн гишүүн эрдмүүдээр чимсэн.

Машид цэнгүүлэн зохиогч тусыг үйлдэгч;  
Магад амгаланг өгөгч амгалан гарахын орон;  
Маш гүн гүнзгий олон эрдмээр чимсэн;  
Мянга мянган оронд ив илхэн заларсан.

Шөнийн галын гэрэл мэт гэрлээр үзэсгэлэнтэй,  
Сансар огторгуйд наран гүйцэд мандсан адил,  
Сүмбэр уул мэт эрдэм бүхэн төгөлдөр,  
Хамаг ертөнцийн орон бүхэнд түгсэн.

Цагаан гүмүда, тараг, сар мэт хийгээд  
Цасны өнгө ба сайн цагаан адил,  
Сайн галуунууд огторгуйд зэллэх мэт  
Шүдний эрхэс таны нүүрийг чимжээ.

Таны амирлангуй нүүрэнд сар мэт  
Баруун тийш хуйларсан дотроо багтаасан адил,  
Биндэрьяа адилын лагшингийн цагаан гэрлээр  
Огторгуйн төвд нар мэт үзэсгэлэнтэй.

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан  
хэмээх их хөлгөн судраас*

*"Түүнчлэн заларсан бурхад бүгдийг мaitсан"  
хэмээх хорин наймдугаар бүлэг болой.*

\* \* \*

## XXIX бүлэг: Төгсгөлийг хураасан

Тэгээд язгуурын охин тэнгэр Бодисаттва-самукчаяа (мон: Бодийг үнэнхүү хураагч) тэр цагт эдгээр шүлгүүдээр Ялж төгс нөгчсөн бурханыг магтав:

Машид ариун номонд самбаат оюуныг эрхшээсэн;  
Муу үйлийн мөрөөс хагацсан оюуныг эрхшээсэн;  
Сансар нирвааныг болгоосон ариуссан оюуныг эрхшээсэн;  
Сайтар нэн гэгээрсэн оюуныг эрхшээсэнд мөргөмөй.

Аяа, аяа! Бурхан хязгаарлашгүй сүр жавхлант.  
Аяа, аяа! Сүн далай ба сүмбэр уул мэт.  
Аяа, аяа! Бурханы мэдлийн орон хязгаарлашгүй.  
Удамбар цэцэг мэт машид нэн ховор.

Амьтан бүгдийг даган барин тэтгэхийн тулд  
Алин бээр судар аймгийн дээд энэ мэтийг машид номлосон,  
Аяа хүний эрхэт наран, Шагжаан эзэн, язгуурын охь,  
Аяа аяа, Түүнчлэн заларсан их нигүүлсэнгүйн эзэн.

Амирлангуй Түүнчлэн заларсан Шагжаан чадагчийн эрхэт,  
Амгалангийн дээд нирвааны хотод машид оршсон,  
Асар гүнзгий амирлангуй самади, тоосноос хагацсан,  
Авралт бурханы явдлын орон түүнд машид оршсон.

Хамаг шарвага тэд бүгдийн бие нь хоосон;  
Хоёр хөлтний дээд бурхадын орших нь ч хоосон.  
Хамаг юмс цөм бүгд хоосон болбоос  
Хамаг амьтад хоосон чанараас үл хэтэрмөй.

Ямар ч цагт бурханыг дурьдан санах бөлгөө.  
Ялгуусаныг эс үзвээс үргэлжид гансрах буй.  
Төгсгөсөн бурханы нар таныг үзэхийн тулд  
Цаг үргэлжид ерөөлийг машид тавьж үйлд.

Би үргэлжид байгаа газартаа өвдөг сөхрөн,  
Бурханы дүрийг бясалган машид санана.  
Татагдахын тулд нигүүлсэнгүй сэтгэлээр дуудаж үйлд;  
Би амгалан заларсаныг үзэхээр машид бясалгана.  
Гаслангийн галаар бүхэнд бадрах болно  
Үзэхийн сэрүүн усыг надад үргэлжид хайрла.

Би таны дүрсийг үзэж машид бясалгана.  
Нигүүлсэнгүйн усаар намайг машид цэнгүүлэн зохио.  
Татагч та надад нигүүлсэнгүйгээр авран соёрх.  
Амирлангуй дүрийг үзэхийг надад хайрлан соёрх.  
Та тэнгэр сэлт амьтдын аврагч билээ.

Энэ мэт шарвага нарын бие нь хоосон бөгөөд  
Амьтан бүгд нь зүүдний мөн чанартай тул  
Огторгуй мэт огторгуйн мөн чанартай байна.  
Илбэ зэрэглээ усанд туссан сар мэт  
Итгэлт багш та нас лугаа төгөлдөр мөн.

Тэгээд Ялж төгс нөгчсөн бурхан суудлаасаа босоод Эсрэнгийн дуугаар зарлиглав: “Язгуурын охин тэнгэр чи сайн болой, сайн болой! Та ч бас сайн болой!”

Бурхан багш тийн хэмээн зарлиглаад, Язгуурын охин тэнгэр Бодисаттва-самукчаяа, Их охин тэнгэр Сарасвати тэргүүтэн тэнгэрийн охид тэдгээр бүгд, их охин тэнгэр Шри тэргүүтэн охин тэнгэрийн чуулган тэдгээр бүгд, мөн Вайшравана тэргүүтэн тэнгэрийн хаан тэд бүгд бүх нөхөд болон тэнгэр, хүн, асур, үнэр идэшт зэрэг ертөнц бүгд даган баясаад Ялж төгс нөгчсөн бурханы зарлигийг илтэд магтав.

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан хэмээх их хөлгөн судраас “Төгсгөлийг хураасан” хэмээх хорин есдүгээр бүлэг болой.*

*Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан хэмээх их хөлгөн судар төгсвэй.*